




2023 ОН

# АЙМАГ, СУМ, БАГИЙН ЗАСАГ ДАРГА, ТӨРИЙН АЛБАН ХААГЧ НАРТ ЗОРИУЛСАН ХУУЛИЙН ЛАВЛАГААНЫ ЭМХЭТГЭЛ - ГАРЫН АВЛАГА



# АЙМАГ, СУМ, БАГИЙН ЗАСАГ ДАРГА, ТӨРИЙН АЛБАН ХААГЧ НАРТ ЗОРИУЛСАН ХУУЛИЙН ЛАВЛАГААНЫ ЭМХЭТГЭЛ - ГАРЫН АВЛАГА

Нэгтгэн боловсруулсан:

М.Алтаншагай  
М.Батчимэг

Энэхүү тус эмхэтгэл - гарын авлагыг Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газрын санхүүжилтээр хийж гүйцэтгэв.

## ГАРЧИГ

УДИРТГАЛ .....	6
<b>НЭГДҮГЭЭР ХЭСЭГ .....</b>	<b>7</b>
1.1. ХУУЛИЙН ЛАВЛАГААНЫ ЭМХЭТГЭЛ .....	7
МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ .....	1
МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ.....	2
АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ .....	7
АВТО ЗАМЫН ТУХАЙ .....	9
АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ.....	11
АГААРЫН БОХИРДЛЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ .....	12
АГААРЫН ТУХАЙ .....	13
АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ.....	14
АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ҮЕИЙН ХОРИО ЦЭЭРИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТУХАЙ.....	15
АМЬТНЫ ТУХАЙ.....	16
АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ТУХАЙ .....	18
АХМАД НАСТНЫ ТУХАЙ .....	19
АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ.....	20
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ.....	22
БАГШИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ .....	25
БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ .....	26
БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ .....	27
БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ .....	28
БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ.....	29
БАРИЛГЫН ТУХАЙ.....	34
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТУХАЙ .....	36
БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ .....	37
БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ.....	39
ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ .....	40
ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ .....	41
ГАЗРЫН ТУХАЙ.....	43
ГАЗРЫН ХЭВЛИЙН ТУХАЙ .....	52
ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ.....	54
ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ.....	55
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ .....	58
ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ .....	59
ГЭР БҮЛИЙН ТУХАЙ .....	61
ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ .....	63
ДАЙНЫ БАЙДЛЫН ТУХАЙ .....	65
ДАЙЧИЛГААНЫ ТУХАЙ .....	66
ДОНОРЫН ТУХАЙ.....	67

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ .....	ХООЛ 68
ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЖУРМЫН ТУХАЙ .....	69
ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ .....	70
ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ТУХАЙ .....	71
ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ .....	72
ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ.....	74
ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬ .....	75
ЗАХИРГААНЫ БОЛОН ИРГЭНИЙ ПРОЦЕССИЙН ХУУЛИУДАД .....	76
ЗӨРЧЛИЙН ТУХАЙ.....	77
ИННОВАЦИЙН ТУХАЙ.....	79
ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ .....	ГАРГАСАН 80
ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ .....	82
ИРГЭНИЙ ХУУЛЬ .....	83
МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ .....	84
МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ.....	86
МАЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТУХАЙ .....	87
МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ .....	88
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТУХАЙ .....	89
МОНГОЛ УЛСЫН ИРГЭНД ГАЗАР ӨМЧЛҮҮЛЭХ ТУХАЙ .....	90
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ.....	92
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ.....	93
МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ.....	94
МОНГОЛ ХЭЛНИЙ ТУХАЙ.....	95
МУЗЕЙН ТУХАЙ.....	96
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ.....	97
НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС СЭРГИЙЛЭХ ТУХАЙ.....	УРЬДЧИЛАН 98
НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯРЫН БОЛОН ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДИЙН ТУХАЙ.....	100
НОМЫН САНГИЙН ТУХАЙ .....	101
НЯЛХ, БАЛЧИР ХҮҮХДИЙН ХҮНСНИЙ ТУХАЙ .....	102
ОЙН ТУХАЙ.....	103
ОНЦ БАЙДЛЫН ТУХАЙ.....	106
ОРОН СУУЦНЫ ТУХАЙ .....	108
ОРОН СУУЦ ХУВЬЧЛАХ ТУХАЙ .....	109
ОЮУНЫ ӨМЧИЙН ТУХАЙ.....	110
ӨРИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ .....	111
СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ .....	112
СОЁЛЫН ТУХАЙ.....	115
СОНГУУЛИЙН АВТОМАТЖУУЛСАН СИСТЕМИЙН ТУХАЙ .....	116
СТАНДАРТЧИЛАЛ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТУХАЙ.....	117

СТАТИСТИКИЙН ТУХАЙ .....	118
СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦНЫ БАЙШИНГИЙН ДУНДЫН ӨМЧЛӨЛИЙН ЭД ХӨРӨНГИЙН ТУХАЙ .....	120
СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ .....	121
ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ .....	122
ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ .....	123
ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ .....	127
ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ .....	128
ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ .....	129
ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ .....	130
ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДГИЙН ТУХАЙ ХУУЛЬ .....	132
ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ .....	133
ТӨР, СҮМ ХИЙДИЙН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ .....	134
ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ .....	135
ТӨСВИЙН ТУХАЙ .....	136
ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ .....	139
ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ОРЧНЫ БҮСИЙН ТУХАЙ .....	140
ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ .....	141
ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ .....	143
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ХУУЛЬ .....	144
УЛСЫН НӨӨЦИЙН ТУХАЙ .....	145
УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ТУХАЙ .....	146
УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ .....	147
УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ .....	148
УСНЫ ТУХАЙ .....	149
УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ .....	152
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ .....	153
ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХ БОЛОН ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ ТУХАЙ .....	154
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ .....	155
ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ .....	156
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ .....	158
ХАРЬЯАТЫН ТУХАЙ .....	159
ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ .....	160
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ .....	162
ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ .....	164
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ .....	167
ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ .....	168
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ .....	169
ХӨРС ХАМГААЛАХ, ЦӨЛЖИЛТӨӨС СЭРГИЙЛЭХ ТУХАЙ .....	170
ХОРШООНЫ ТУХАЙ .....	172
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ .....	173
ХОТ, СУУРИН ГАЗРЫГ ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ ТУХАЙ .....	174

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ .....	176
ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ.....	176
ХОТ, ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ .....	177
ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ УЛСЫН ТООЛЛОГЫН ТУХАЙ .....	179
ХҮН АМЫН АМЬЖИРГААНЫ ДООД ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ ТУХАЙ.....	180
ХҮНИЙ ДАРХЛАЛ ХОМСДОЛЫН ВИРУСЫН ХАЛДВАР, ДАРХЛАЛЫН ХОМСДОЛООС СЭРГИЙЛЭХ ТУХАЙ.....	ОЛДМОЛ 181
ХҮНСНИЙ ТУХАЙ .....	182
ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ .....	183
ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ТУХАЙ.....	184
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ.....	185
ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ .....	186
ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ.....	187
ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ .....	188
ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ .....	189
ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ .....	190
ЦЭРГИЙН АЛБАНЫ ТУХАЙ.....	192
ШУУДАНГИЙН ТУХАЙ.....	193
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ.....	194
ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ .....	195
ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ .....	196
ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ .....	197
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ.....	199
ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ .....	201
ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ .....	202
1.2. ЗАСАГ ДАРГЫН ТЭРГҮҮЛДЭГ ЗӨВЛӨЛ, КОМИСС.....	203
1.3. ЗАСАГ ДАРГА БАТЛАХ (ТОГТООХ)-ААР ХУУЛИАР ЭРХ ОЛГОСОН ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ЖАГСААЛТ .....	205
1.4. ЗАСАГ ДАРГА ТОМИЛОХ БОЛОН ХОЛБОГДОХ АЛБАН ТУШААЛТНААС ЗАСАГ ДАРГАТАЙ ЗӨВШИЛЦӨХӨӨР ЗААСАН АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ: .....	208
<b>ХОЁРДУГААР ХЭСЭГ .....</b>	<b>213</b>
2.1. ЗАСАГ ДАРГЫН ШИЙДВЭРИЙН МӨН ЧАНАР, ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА.....	213
2.2. ЗАХИРАМЖИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХАД АНХААРАХ АСУУДАЛ, ЗӨВЛӨМЖ, ЗАХИРАМЖИЙН ТӨСЛИЙН ЗАГВАР .....	220
<b>ГУРАВДУГААР ХЭСЭГ .....</b>	<b>227</b>
3.1. ЗАХИРГААНЫ ХУВИЙН ХЭРЭГ БҮРДҮҮЛБЭР .....	227
3.2. ЗАХИРГААНЫ ШИЙДВЭР ГАРГАХАД АШИГЛАГДАХ БАРИМТЫГ ХЭРЭГЛЭХ ШААРДЛАГА, ЗААВАР ЗӨВЛӨМЖ, ЗАГВАРУУД.....	229
<b>ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ .....</b>	<b>236</b>
4.1. НИЙТЛЭГ АШИГЛАГДДАГ ГЭРЭЭНИЙ ЗАГВАРУУД .....	236

---o0o---

## УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу Засаг дарга нь тухайн нутаг дэвсгэртээ төрийн удирдлагыг хэрэгжүүлж, төрийн төлөөлөгчийн хувьд хууль тогтоомж, Засгийн газар, харьяалах дээд шатныхаа байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг хариуцдаг онцлогтой албан тушаалтан юм. Гэвч Засаг дарга нь хэмжээ хязгааргүй эрх мэдэлтэн биш бөгөөд гагцхүү хуульд заасан эрх хэмжээгээр түүний эрх мэдэл тодорхойлогдож, мөн хязгаарлагдана. Тиймээс төрийн үйл ажиллагааны хууль дээдлэх зарчмын хүрээнд тухайн албан тушаалтан хуулиар олгогдсон бүрэн эрх, чиг үүргээ мэддэг, аливаад гаргах шийдвэр, хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь хуульд нийцсэн байх шаардлага зүй ёсоор тавигдана.

Гэтэл хуульд Засаг даргад нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хуульчилж өгсөн боловч тэдний мэргэжил, ажлын туршлага, хууль, эрх зүйн талаарх мэдээлэл, мэдлэг харилцан адилгүй байна. Тухайлбал, 2020 онд томилогдсон Хөвсгөл аймгийн аймаг, сумын Засаг дарга нараас эрх зүйч мэргэжилтэй удирдлага огт байхгүй байна. Харин тус сумдын 128 багийн Засаг дарга нараас ердөө 3 багийн Засаг дарга л “эрх зүйч” мэргэжилтэй байна. Сумын Засаг даргын нарын 18 буюу 75% нь, багийн Засаг даргын 73 буюу 57% нь тус тус анх удаа томилогдон ажиллаж байна. Мөн Засаг даргыг шийдвэр гаргахад туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиг үүрэг бүхий тамгын газрын албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллахгүй байгаагаас шалтгаалан сургалт, зөвлөн чиглүүлэх ажлууд төдийлөн үр нөлөөтэй хүрч чадахгүй байна.

Ялангуяа сумдын түвшинд төрийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдаас хууль, эрх зүйн мэргэжилтэй албан хаагчийн орон тоо цөөн, зарим сумдад тус орон тоон дээр ажиллах хүний нөөцгүй байгаа нь орон нутаг, иргэдийн тулгамдсан асуудлыг хуулийн хүрээнд судалж, шийдвэрлүүлэх, аливаа шийдвэрийн төслийг хууль зүйн үндэслэлтэй боловсруулах, албан ёсны байдлыг хянах, удирдлагыг үндэслэл бүхий мэдээллээр хангахад анхаарах шаардлага тулгарч байна.

Иймд төрийн албанд томилогдсон Засаг дарга, холбогдох албан хаагч нарт тохиолддог асуудал, бэрхшээлийг хуулийн хүрээнд шийдвэрлэхэд туслах зорилгоор хуулийн лавлагааны эмхэтгэл, албан хэрэг хөтлөлтийн журам стандарт, жишээ шийдвэр, актын маягт, гэрээний загвараас бүрдсэн гарын авлагыг өөрсдийн ажлын туршлагад тулгуурлан боловсруулж хүргэхээр зорьлоо.

Бид бүхний тавьсан саналыг хүлээн авч, бүх талаар дэмжин, зөвлөн тусалсан Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгч ноён, Феликс Гленк, тус төслийн менежер хадагтай, С. Бүжинлхам, Хөвсгөл аймгийн Засаг дарга асан Ш.Идэрбаясгалан нарт гүн талархал илэрхийлье.

---o0o---

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

### 1.1. ХУУЛИЙН ЛАВЛАГААНЫ ЭМХЭТГЭЛ



*Аймаг, сум, багийн засаг даргын бүрэн эрх, чиг үүргийг тогтоосон 141 хуулийн талаар ...*

Монгол Улсад 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа нийт **860** хуулиас *аймаг, сум, багийн* Засаг даргын эрх хэмжээг тухайлан зохицуулсан **141** хууль байна. Эдгээр хуулиудаас Засаг даргын бүрэн эрх, чиг үүргийг тодорхойлсон хуулийн холбогдох зүйл, заалтыг хэсэгчлэн авч эмхэтгэлээ.<sup>1</sup>

Ингэснээр Засаг дарга нь хууль бүрээс өөрийн эрх хэмжээтэй холбоотой заалтыг нэг бүрчлэн хайх бус зөвхөн тухайн хуулиар зохицуулж байгаа харилцаанд Засаг дарга ямар эрх, үүрэгтэй болохыг мэдэх, үйл ажиллагаандаа ашиглах, хэрэглэх нөхцөлийг бүрдүүлснээрээ ач холбогдолтой гэж харж байна.

Түүнчлэн Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ хуулийн биелэлтийг хариуцдаг, тус чиг үүргээ холбогдох ажлын алба болох тамгын газар, зохих мэргэжлийн байгууллага (хөдөө аж ахуй, мал эмнэлэг, байгаль орчин, цагдаа, онцгой, татвар гэх зэрэг)-ын оролцоотойгоор хэрэгжүүлдэг учраас өөрийн эрхлэх хүрээний байгууллагатайгаа харилцах, хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, хамтран ажиллахад тухайн харилцааг зохицуулж буй хуульд заасан эрх хэмжээгээ мэдэх, түүний дагуу хэрэгжүүлэхэд дөхөм болно гэж үзэж байна.

Иймд энэ товхимлыг судлагч, ашиглагч **ТАНД**:

[1] орон нутгийн хөгжлийн, цаг үеийн шинжтэй олон талт тулгамдсан асуудлыг шийдэх;

[2] иргэн, хуулийн этгээд, төрийн бус байгууллагаас гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хуулийн хүрээнд шийдвэрлэх;

[3] дээд шатны байгууллага, албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэхтэй холбоотой зохион байгуулалтын холбогдох арга хэмжээг авах зэрэг аливаа нэгэн шийдвэрийг гаргахдаа тэдгээр асуудалтай холбоотой харилцааг зохицуулсан тухайн хуулиар олгогдсон эрх, үүрэгтэйгээ урьдчилж танилцсаны үндсэн шийдвэрлэж байхыг зөвлөж байна.

---o0o---

<sup>1</sup> Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (<https://legalinfo.mn/mn>)-ийг ашиглав.





## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ	<b>Жардугаар зүйл.</b>	1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хэрэгжүүлнэ.
	<b>Жаран нэгдүгээр зүйл.</b>	1. Засаг дарга тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт засаг төрийн төлөөлөгчийн хувьд харьяа нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газар, харьяалах дээд шатныхаа байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг Засгийн газар, дээд шатны Засаг даргын өмнө хариуцна. 2. Засаг дарга тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлын шийдвэрт хориг тавих эрхтэй.
	<b>Жаран гуравдугаар зүйл.</b>	2. Хурлын тогтоол, Засаг даргын захирамж нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрт нийцсэн байх бөгөөд түүнийг тус тусын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр дагаж мөрдөнө.

---о0о---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 12 сарын 24 өдөр

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай	<b>56 дугаар зүйл. Засаг дарга, түүнийг томилох</b>	56.1.Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн. Засаг даргыг томилуулахаар нэр дэвшүүлэх, тавигдах шаардлага, томилох, томилохоос татгалзах зэрэг асуудлыг тус хуулийн 56.2-56.9 дэх хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.
	<b>58 дугаар зүйл. Багийн Засаг даргын бүрэн эрх</b>	58.1.Багийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 58.1.1.хууль тогтоомж, Засгийн газар, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг хариуцах; 58.1.2.багийн иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх; 58.1.3.сургуулийн өмнөх насны хүүхдийг бүртгэж тухайн жилд сургуульд оруулах, сургууль завсардсан хүүхдийг сургалтад хамруулах арга хэмжээ авах; 58.1.4.асрамж, халамж шаардлагатай иргэнийг асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах саналыг хууль тогтоомжийн дагуу сумын Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх; 58.1.5.нутаг дэвсгэрийн хүн амын амьжиргааны түвшинг судалж, хууль тогтоомжид заасны дагуу нийгмийн халамж, үйлчилгээг зохион байгуулах; 58.1.6.гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон үед айл өрх, хүн, малыг нүүлгэн шилжүүлэх, тэдгээрийг зохих үйлчилгээгээр хангах, хуульд заасан тохиолдолд хүн хүч, тээвэр, холбооны хэрэгсэл, эд хөрөнгийг дайчлах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах; 58.1.7.хүн ам, өрхийн болон иргэний түр оршин суух бүртгэлийг зохих журмын дагуу бүртгэх; 58.1.8.гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах, энэ ажилд иргэдийг татан оролцуулах, санал, санаачилгыг нь дэмжих; 58.1.9.байгалийн баялгийг ашиглах, хууль тогтоомжийн биелэлтэд хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд хяналт тавих; 58.1.10.гал түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах; 58.1.11.иргэнийг шагнаж урамшуулах, иргэнд дэмжлэг, тусламж үзүүлэх тухай саналыг сумын Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх;

		<p>58.1.12.сумын Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан төрийн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах;</p> <p>58.1.13.бусдын эзэмшил, ашиглалтад олгоогүй хадлангийн болон тариалангийн талбай, бэлчээр, уст цэгийн хамгаалалт, ашиглалтын ажлыг зохион байгуулах.</p>
	<p><b>59 дүгээр зүйл. Сумын Засаг даргын бүрэн эрх</b></p>	<p>59.1.Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>59.1.1.хууль тогтоомж, Засгийн газар болон харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийг хэрэгжүүлэх;</p> <p>59.1.2.иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;</p> <p>59.1.3.сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төлөвлөгөө, хөтөлбөрийн төсөл боловсруулж сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулан хэлэлцүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;</p> <p>59.1.4.сумын төсвийн төсөл, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;</p> <p>59.1.5.сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх;</p> <p>59.1.6.сумын өмчийн эзэмшил, ашиглалтыг зохион байгуулж, сумын өмчийг бусдад эзэмшүүлэх, түрээслэх, худалдах, хувьчлах зэргээр захиран зарцуулах санал боловсруулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж шийдвэрлүүлэх;</p> <p>59.1.7.хууль тогтоомж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас энэ хуулийн 22.1-д заасан асуудлаар гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах;</p> <p>59.1.8.аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан төрийн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах;</p> <p>59.1.9.энэ хуулийн 22 дугаар зүйлд заасан асуудлаар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн төслийг боловсруулж, холбогдох тооцоо, үндэслэл бүхий саналыг сумын иргэдийн төлөөлөгчдийн Хуралд оруулж хэлэлцүүлэх;</p> <p>59.1.10.гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахиулах чиглэлээр холбогдох хуулиар олгогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлэх;</p> <p>59.1.11.хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах;</p> <p>59.1.12.байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх;</p> <p>59.1.13.нутаг дэвсгэрийнхээ газрыг зүй зохистой ашиглах, бэлчээр, газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих, үржил шимийг нь дээшлүүлэх, байгаль орчныг хамгаалах бусад арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулж Хуралд өргөн мэдүүлэх, батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>59.1.14.Хурлын шийдвэрийг үндэслэн тухайн нутаг дэвсгэрийн тусгай хэрэгцээний газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах тухай шийдвэр гаргах;</p> <p>59.1.15.сумын Засаг даргын олгосон газар эзэмших, ашиглах эрхийн талаарх иргэд, аж ахуйн нэгж, байгууллага хооронд үүссэн маргааныг Газрын тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх;</p>

		<p>59.1.16.холбогдох хууль тогтоомжид заасны дагуу газар олгох;</p> <p>59.1.17.нутаг дэвсгэрийнхээ байгалийн баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, эзэмших тухай иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийн талаар гарсан сумын Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;</p> <p>59.1.18.нутаг дэвсгэрт нь газар ашиглах, эзэмших, ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хууль тогтоомжид заасан үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих ажлыг зохион байгуулж, гарсан зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авах;</p> <p>59.1.19.нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>59.1.20.хуульд өөрөөр заагаагүй бол нутаг дэвсгэрийн боловсрол, соёл, эрүүл мэнд, биеийн тамир, спортын байгууллагууд эрх бүхий байгууллагаас тогтоосон стандарт, норм, нормативыг сахин мөрдөж байгаа эсэхэд тэдгээрийн харьяалал, өмчийн төрөл, хэлбэрийг харгалзахгүйгээр хяналт тавих;</p> <p>59.1.21.гамшиг, осол, аюулт үзэгдлийн үед эрэн хайх, аврах, нүүлгэн шилжүүлэх, гамшгийн хор уршгийг арилгахтай холбогдуулан тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд буюу түүний тодорхой хэсэгт түр хугацаанд дагаж мөрдөх журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тогтоох, хүн хүч дайчлах, төрийн болон орон нутгийн өмчийн үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын тээвэр, холбооны хэрэгсэл, хүнс тэжээлийн нөөцийг дайчлах;</p> <p>59.1.22.сумын Засаг даргын орлогч, тамгын газрын даргыг томилох, чөлөөлөх, огцруулах;</p> <p>59.1.23.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</p>
	<p><b>60 дугаар зүйл.</b> <b>Аймгийн Засаг даргын бүрэн эрх</b></p>	<p>60.1.Аймгийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>60.1.1.хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах;</p> <p>60.1.2.аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах;</p> <p>60.1.3.аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төлөвлөгөө, хөтөлбөрийн төсөл боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;</p> <p>60.1.4.аймгийн төсвийн төсөл, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;</p> <p>60.1.5.аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх;</p> <p>60.1.6.аймгийн өмчийн эзэмшил, ашиглалтыг зохион байгуулж, аймгийн өмчийг бусдад эзэмшүүлэх, түрээслэх, худалдах, хувьчлах зэрэг асуудлаар захиран зарцуулах санал боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулан шийдвэрлүүлэх;</p> <p>60.1.7.Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан гэрээний дагуу энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан төрийн зарим чиг үүргийг орон нутаг төлөөлөн хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах;</p> <p>60.1.8.энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасан асуудлаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн төслийг боловсруулж,</p>

		<p>холбогдох тооцоо, үндэслэл бүхий саналыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж хэлэлцүүлэх;          60.1.9.хууль тогтоомжид заасан журмын дагуу гадаад улсын зохих шатны нэгжтэй харилцаж, хамтран ажиллах;          60.1.10.нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах;          60.1.11.газар эзэмших, ашиглахтай холбогдсон маргааныг Газрын тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх;          60.1.12.газар нутгийнхаа тодорхой хэсгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах санал боловсруулан Хуралд оруулж шийдвэрлүүлэх, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;          60.1.13.гамшиг, осол, аюулт үзэгдлийн үед эрэн хайх, аврах, нүүлгэн шилжүүлэх, гамшгийн хор уршгийг арилгахтай холбогдуулан тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд буюу түүний тодорхой хэсэгт түр хугацаанд дагаж мөрдөх журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тогтоох, хүн хүч дайчлах, төрийн болон орон нутгийн өмчийн үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын тээвэр, холбооны хэрэгсэл, хүнс тэжээлийн нөөцийг дайчлах;          60.1.14.дотоод, гадаадад тухайн засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг төлөөлөх;          60.1.15.тухайн нутаг дэвсгэр дэх шүүх, прокурорын байгууллагад шаардлагатай дэмжлэг үзүүлэх;          60.1.16.аймгийн хэмжээний томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах арга хэмжээ авах;          60.1.17.сумдын үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд хяналт тавих;          60.1.18.энэ хуульд заасан үндэслэлээр аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг тараах саналыг Засгийн газарт оруулах;          60.1.19.төрийн дээд шагналд тодорхойлох;          60.1.20.аймгийн Засаг даргын орлогч, тамгын газрын даргыг томилох, чөлөөлөх, огцруулах;          60.1.21.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</p>
	<b>64 дүгээр зүйл.</b>	Засаг даргыг чөлөөлөх, огцруулах, огцрох, хариуцлага тооцохтой холбоотой зохицуулалтыг тус хуулийн 64, 65 дугаар зүйлээс дэлгэрэнгүй үзнэ үү.
	<b>66 дугаар зүйл. Засаг даргын шийдвэр</b>	<p>66.1.Засаг дарга энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өөрийн эрх хэмжээний хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн захирамж гаргана.          66.2.Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ нийтээр дагаж мөрдөх, хэм хэмжээ тогтоосон акт гаргасан бол Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.          66.3.Засаг даргын захирамж хууль тогтоомжид нийцээгүй бол өөрөө, эсхүл дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд хүчингүй болгоно.</p>
	<b>71 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн Засаг дарга Засгийн газартай харилцах</b>	<p>1.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга Засгийн газартай доор дурдсан журмаар харилцана:          71.1.1.жил бүр үйл ажиллагааныхаа тайланг Засгийн газарт хүргүүлэх бөгөөд Засгийн газар уг тайланг хуралдаанаараа хэлэлцэж үнэлэлт, дүгнэлт өгөх;          71.1.2.нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх талаар санал, шийдвэрийн төсөл боловсруулж тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлэх, эс дэмжвэл саналаа Ерөнхий сайдад уламжлах;</p>

		71.1.3.нутаг дэвсгэрийнх нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлыг хэлэлцэхэд Засгийн газрын хуралдаанд оролцож санал, байр сууриа илэрхийлэх.
	<b>72 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг дарга яам, агентлагтай харилцах</b>	72.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга яам, агентлагтай доор дурдсан журмаар харилцана: 72.1.1.хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа яам, агентлагтай хамтран ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах; 72.1.2.шаардлагатай гэж үзвэл Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан журмын дагуу харьяалах нутаг дэвсгэрийн салбарын болон салбар хоорондын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхдээ тухайн орон нутгийн хэрэгцээ шаардлагыг тусган хамтарсан шийдвэр гаргаж, биелэлтийг зохион байгуулах; 72.1.3.нутаг дэвсгэрийнхээ хөгжлийн асуудлаар яамтай хамтран хэрэгжүүлэх нэгдсэн бодлогын талаар Ерөнхий сайдтай шууд харилцах; 72.1.4.орон нутгийн хөрөнгөөр шийдвэрлэх боломжгүй нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэхээр Улсын Их Хурал, Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллагад саналаа уламжлах; 72.1.5.эдийн засаг, нийгмийн хөгжил, хот байгуулалт, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, төрөөс хүн амд үзүүлэх үйлчилгээтэй холбогдсон асуудлаар яам, агентлагт санал тавьж шийдвэрлүүлэх. 72.1.6.харьяалах нутаг дэвсгэртээ үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар төрийн захиргааны төв байгууллагатай гэрээ байгуулж хамтран ажиллах, хэрэгжилтийг дүгнүүлэх.
	<b>74 дүгээр зүйл. Засаг дарга иргэд, аж ахуйн нэгж, байгууллагатай харилцах</b>	74.1.Засаг дарга өөрөө, эсхүл эрх бүхий байгууллагаар дамжуулан харьяа нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагад хууль тогтоомжийг биелүүлэх талаар үүрэг даалгавар өгч, биелэлтийг шалгаж болно. 74.2.Засаг дарга хууль тогтоомжийг биелүүлэх зорилгоор харьяа нутаг дэвсгэрийн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай нийтийн эрх зүйн гэрээ байгуулж болно.
	<b>75 дугаар зүйл. гадаад хамтын ажиллагаа</b>	75.2.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд гадаад улсын адил түвшний, эсхүл олон улсын байгууллагатай гэрээ байгуулж болох бөгөөд гэрээг байгуулахдаа гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авна.
	<b>77 дугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын шийдвэрийг биелүүлэх</b>	77.1.Хурал, Засаг даргаас хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан шийдвэр тухайн нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөх бөгөөд түүнийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд заавал биелүүлнэ. 77.2.Хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд Хурал, Засаг даргаас гаргасан шийдвэрийг биелүүлээгүйгээс учирсан хохирлыг гэм буруутай этгээд бүрэн хэмжээгээр нөхөн төлнө.

---о0о---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр

Улаанбаатар хот

### АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Авлигын эсрэг хууль	<b>4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд</b>	4.1.Доор дурдсан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарна: 4.1.1.төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;
	<b>6 дугаар зүйл. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа</b>	6.1.Төрийн байгууллага энэ хуулийн 3.1.6-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр дараахь нийтлэг үүрэг хүлээнэ: 6.1.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 25-29 дүгээр зүйлд заасан нийтлэг үүрэг; 6.1.2.тодорхой чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө олон нийтийн анхаарал татаж байгаа мэдээллийг нээлттэй болгох, сонирхогч нийгмийн бүлгүүдэд өөрийн бодлого, байр суурийг танилцуулах, хяналтын тодорхой аргыг дэвшүүлэн хэрэгжүүлэх бололцоо олгох зорилгоор харилцан зөвлөлдөж ажиллах боломжийг бүрдүүлэх; 6.1.3.төрийн хяналтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах; 6.1.4.төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр нь мэдээлэх; 6.1.5.тухайн байгууллагын чиг үүргийн дагуу зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, сонгон шалгаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол олон нийтэд ил тод байлгаж, түүнтэй танилцах боломжоор хангах; 6.1.6.төрийн албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, эрхэлж байгаа ажлын онцлогтой нь холбогдуулж түүнд хориглох зүйлийг Төрийн албаны тухай хууль болон энэ хуульд заасны дагуу тогтоон мөрдүүлэх; 6.1.7.төрийн байгууллага нээлттэй, иргэдийн ашиг сонирхолд нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд тавих хяналтад төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж, хамтран ажиллах, мэдээллийг харилцан солилцох, олон нийтэд мэдээллийг тогтмол хүргэж байх; 6.1.8.авлигатай тэмцэх талаар сургалт, сурталчилгаа явуулах, хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулах, бүртгэх, хянах, зөвлөгөө өгөх асуудлыг бүтцийн нэгждээ хариуцуулах; 6.1.9.төрийн байгууллага тухайн салбарын албан хаагчийн ёс зүйн дүрмийг батлан гаргахын өмнө Авлигатай тэмцэх газраас санал авах; 6.1.10.төрийн байгууллагаас гаргасан шийдвэр иргэд болон бусад сонирхогч талуудад ойлгомжтой, нээлттэй байх;

		<p>6.1.11.иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх энэ чиглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх;</p> <p>6.1.12.бүрэн эрхийнхээ хүрээнд авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаварыг нь арилгах арга хэмжээ авах;</p> <p>6.1.13.авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих;</p> <p>6.1.14.энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг төрийн байгууллага, албан тушаалтан биелүүлэх, биелэлтийг холбогдох байгууллагад тайлагнах.</p> <p>6.2.Төрийн бүх шатны байгууллагын албан хаагч нь албан үүргээ гүйцэтгэж байх явцдаа олж мэдсэн авлигатай холбоотой асуудлыг шалгаж шийдвэрлэх нь өөрийнх нь бүрэн эрхэд хамаарахгүй байвал Авлигатай тэмцэх газарт мэдээлнэ.</p> <p>6.6.Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан хууль ёсны шаардлага, шийдвэрийг хүлээн авсан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан түүний дагуу холбогдох арга хэмжээг заавал авч, хариуг хугацаанд нь өгөх үүрэгтэй.</p> <p>6.7.Төрийн байгууллага, албан тушаалтан авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзсэн тушаал, шийдвэр, журам, дүрмийг Авлигатай тэмцэх газраас өгсөн саналын дагуу дахин хянаж хүчингүй болгох буюу өөрчилнө.</p> <p>6.8.Авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх үүргээ биелүүлээгүй албан тушаалтанд эрх бүхий албан тушаалтан сахилгын шийтгэл хүлээлгэнэ.</p>
	<p><b>7 дугаар зүйл.</b> <b>Хориглох зүйл</b></p>	<p>7.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд бусад хууль тогтоомжид тусгайлан хориглосноос гадна авлигын дараах зөрчлийг хориглоно:</p> <p>7.1.1.албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх;</p> <p>7.1.2.бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах;</p> <p>7.1.3.албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах;</p> <p>7.1.4.төсвийн болон хандив, тусламжийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах;</p> <p>7.1.5.албан үүргээ гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхтай холбогдуулан бусдаас шан харамж шаардах;</p> <p>7.1.6.албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх;</p> <p>7.1.7.албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх;</p> <p>7.1.8.үндэслэлгүйгээр хөрөнгөжих.</p> <p>Тайлбар:Албан тушаалтан зургаан сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыгоо үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй тохиолдолд үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэж үзнэ.</p>
	<p><b>8 дугаар зүйл.</b> <b>Авлигын тухай мэдэгдэх</b></p>	<p>8.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан үүрэг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх үүрэгтэй.</p> <p>8.2.Энэ хуулийн 8.1-д заасан мэдээлэх үүргийг хэрэгжүүлэхэд Төрийн болон албаны нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар тогтоосон хязгаарлалт хамаарахгүй.</p>

---оОо---





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

### АВТО ЗАМЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Авто замын тухай	<b>12 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх</b>	<p>12.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга авто замын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>12.1.1.үндэсний авто замын сүлжээг хөгжүүлэх төрийн бодлоготой уялдуулан нийслэл, орон нутгийн чанартай авто замын сүлжээг хөгжүүлэх бодлого, ерөнхий төлөвлөгөөг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах;</p> <p>12.1.2.авто замын тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийг харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх;</p> <p>12.1.3.нийслэл, орон нутгийн чанартай авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах ажлыг зохион байгуулах;</p> <p>12.1.4.нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдах авто замын барилга, засвар, арчлалтын ажлыг зохион байгуулах;</p> <p>12.1.5.олон улс, улсын болон орон нутгийн чанартай, тусгай зориулалтын авто замын бүрэн бүтэн байдлыг хангах, хамгаалах талаар харьяа нутаг дэвсгэрийн байгууллага, иргэнд үүрэг даалгавар өгөх, биелэлтийг хангуулах;</p> <p>12.1.6.нийслэлийн авто замын ажлыг санхүүжүүлэх, барих, ашиглах, засах, арчлах, талаар журам боловсруулан авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах, хэрэгжүүлэх;</p> <p>12.1.7.байгалийн гамшиг, гэнэтийн осол, аюулын улмаас үүссэн авто замын эвдрэл, гэмтлийг шуурхай засварлах шаардлага гарсан үед харьяа нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс тээвэр, холбооны хэрэгсэл, машин механизм, эд хөрөнгийг нөхөн олговортойгоор дайчлан гаргуулах, хүн хүчний туслалцаа авах ажлыг зохион байгуулах;</p> <p>12.1.8.харьяа нутаг дэвсгэртээ авто замын хөдөлгөөнийг зохих хууль, журмын дагуу зохион байгуулах, зохицуулах;</p> <p>12.1.9.аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулж,</p>

	батлуулахдаа авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авч тусгах.
<b>15 дугаар зүйл. Авто замын ангилал</b>	15.4.Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын чиглэл, чиглэлийн нэр, дугаарыг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэл, орон нутгийн чанартай авто замын чиглэл, чиглэлийн нэр, дугаарыг тухайн шатны Засаг дарга авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн тогтооно.
<b>16 дугаар зүйл. Авто замын бүрэлдэхүүн</b>	16.3.Нийслэл болон хот, суурингийн авто замын зурвас газрын өргөнийг холбогдох норм, дүрмийн хүрээнд аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно. 16.4.Онцгой тохиолдолд олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын зурвас газрын өргөнийг тухайн авто зам болон газар нутгийн онцлогтой уялдуулан авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэл, орон нутгийн чанартай авто замын зурвас газрын өргөнийг аймаг, нийслэлийн Засаг дарга холбогдох норм, дүрмийн хүрээнд өөрөөр тогтоож болно. 16.5.Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын хяналт тавих зурвас газрын хэмжээг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэл, орон нутгийн чанартай авто замын хяналт тавих зурвас газрын өргөнийг зураг төслийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.
<b>18 дугаар зүйл. Авто замын техник, эдийн засгийн үндэслэл</b>	18.2.Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын даалгаврыг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэл, орон нутгийн чанартай авто замын хувьд аймаг, нийслэлийн Засаг дарга, бусад авто замын хувьд тухайн авто замын захиалагч батална.
<b>24 дүгээр зүйл. Авто замын сан</b>	24.9.Тухайн жилд улсын авто замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажил, зарцуулах хөрөнгийг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэл, орон нутгийн чанартай авто замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажил, зарцуулах хөрөнгийг аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус баталж, хэрэгжүүлнэ.
<b>28 дугаар зүйл. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах</b>	28.1.Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замыг ашиглалтад авах асуудлыг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэл, орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах асуудлыг тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцан зохион байгуулна.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 6 дугаар сарын 4-ний өдөр

Улаанбаатар хот

### АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Авто Тээврийн тухай	<b>7 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх</b>	<p>7.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь автотээврийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>7.1.1.нутаг дэвсгэртээ автотээврийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах;</p> <p>7.1.2.автотээврийн талаар төрөөс баримтлах бодлоготой уялдуулан тухайн нутаг дэвсгэрт автотээврийн талаар баримтлах бодлого боловсруулж хэрэгжүүлэх;</p> <p>7.1.3.автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран нутаг дэвсгэртээ автотээврийн улсын хяналт хэрэгжүүлэх;</p> <p>7.1.4.нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийг тухайн нутаг дэвсгэрт зохицуулах, зохион байгуулах;</p> <p>7.1.5.хүн амын нутагшил, байршлын онцлог, зорчигч ба шуудан тээвэрлэлтийн хэрэгцээнээс шалтгаалан өрсөлдөх боломжгүй чиглэлд орон нутагт зорчигч, шуудан тээвэрлэлтийг зохих нөхөн төлбөр олгох нөхцөлтэйгээр тээвэрлэгчтэй гэрээ хийж гүйцэтгүүлэх;</p> <p>7.1.6.орон нутгийн цаг уурын байдлыг харгалзан мөсөн замын тээвэрлэлтийг эхлэх, дуусах хугацаа, чиглэл, мөсний даацыг тухайн орон нутгийн ус цаг уур, орчны хяналт шинжилгээний байгууллагатай хамтран тогтоох.</p> <p>7.2.Аймаг, нийслэлийн тээврийн албаны даргыг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлнө.</p> <p>7.3.Аймаг, нийслэлийн тээврийн албаны даргыг авто зам, тээврийн болон эдийн засгийн салбарын мэргэжилтэй иргэдээс Төрийн албаны тухай хуулийн 25, 26, 27 дугаар зүйлд заасны дагуу сонгон шалгаруулж томилно.</p> <p>7.4.Нийтийн тээврийн хэрэгслээр зорчиж байгаа хараагүй хүнд зориулж буудлыг зарлах, сонсголын бэрхшээлтэй иргэнд зориулж буудал бүрд нэр, хаяг, чиглэлийг бичмэл болон зургийн хэлбэрээр байрлуулах, өөрчлөх шийдвэрийг тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга гаргана.</p>
	<b>8 дугаар зүйл. Тээвэрлэлтийн ангилал, зохицуулалт</b>	8.4.Аймаг хооронд, орон нутаг, аймгийн төв, хотын доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чиглэлийг тогтоох, өөрчлөх шийдвэрийг тухайн аймаг, хотын Засаг дарга гаргах бөгөөд аймаг, нийслэлийн Засаг даргын эрх олгосон байгууллага хэрэгжүүлнэ.
	<b>14 дүгээр зүйл. Тээвэрлэлтийн ажлыг түр хугацаагаар зогсоох, хязгаарлах</b>	<p>14.1.Гамшиг, аюулт үзэгдэл болон аюул тохиолдсон нөхцөлд тээвэрлэлтийн ажлыг түр хугацаагаар зогсоох буюу хязгаарлах шийдвэрийг дараахь эрх бүхий албан тушаалтан гаргаж нийтэд мэдээлнэ:</p> <p>14.1.2.орон нутгийн тээвэрлэлтийн чиглэлд нийслэл, тухайн аймаг, сумын Засаг дарга</p>

---оОо---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 6 дугаар сарын 24-ний өдөр

Улаанбаатар хот

### АГААРЫН БОХИРДЛЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Агаарын бохирдлын төлбөрийн тухай	<b>5 дугаар зүйл. Агаарын бохирдлын төлбөр ногдох зүйл</b>	5.5. Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрээс агаарт бохирдуулах бодисыг бохирдуулах бодисын хаягдлын стандартад заасан хэмжээнээс хэтрүүлэн гаргасан тохиолдолд мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн байгаль орчны байцаагч, холбогдох сум, дүүргийн Засаг дарга учирсан хохирлыг арилгуулж, хохирлын хэмжээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр агаарын бохирдлын нөхөн төлбөр ногдуулан, төлөлтөд нь хяналт тавина.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

### АГААРЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Агаарын тухай	<b>15 дугаар зүйл. Агаарын чанарыг сайжруулах бүс</b>	15.7.Аймаг, нийслэлийн Засаг дарга агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах, хэрэгжилтийг тайлагнах үүрэг бүхий албыг байгуулж ажиллуулна.
	<b>18 дугаар зүйл.</b>	18.1.18.1.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.10-т заасан агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглах зөвшөөрлийг тухайн сум, дүүргийн Засаг дарга олгоно.
	<b>20 дугаар зүйл.</b>	20.5.Агаар хамгаалах зорилгоор нийтийн эзэмшлийн гудамж, талбайд тодорхой төрлийн тээврийн хэрэгсэл нэвтрэн орохыг сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр хориглох буюу хязгаарлаж болно.
	<b>23 дугаар зүйл. Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрийг тоноглох</b>	23.1 Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхдээ эх үүсвэр нэг бүрээ хянах дотоод хяналтын багаж хэрэгсэл болон агаар бохирдуулах бодисыг саармагжуулах, цэвэрлэх, физикийн сөрөг нөлөөллийг бууруулах тоног төхөөрөмжөөр тоноглоно. 23.2.Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрийг энэ хуулийн 23.1-д заасан багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр тоноглох, тэдгээрийн ашиглалтын байдалд тухайн салбарыг харьяалах төрийн захиргааны төв байгууллага, сум, дүүргийн Засаг дарга, байгаль орчны улсын байцаагч хяналт тавина.
	<b>27 дугаар зүйл.</b>	27.2.Улсын нэгдсэн тоо бүртгэл, агаар бохирдуулах бодисын хаягдал, агаарт үзүүлэх физикийн сөрөг нөлөөлөл, тэдгээрийн эх үүсвэрийн улсын тооллогыг төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу бүх шатны Засаг дарга мэргэжлийн албатай хамтран гүйцэтгэнэ.

---оОо---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 01 сарын 30 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай	<b>14 дүгээр зүйл. Сонгуулийн байгууллага</b>	14.18.Сонгуулийн хорооны аюулгүй байдлыг хангасан ажиллах байр, тээвэр, холбооны болон бусад шаардлагатай хэрэгслээр хангах асуудлыг тухайн шатны Засаг дарга хариуцна.
	<b>43 дугаар зүйл. Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх</b>	43.2.Сонгогчидтой хийх уулзалт, хурал, цуглаан зохион байгуулахад нь тухайн шатны Засаг дарга дэмжлэг үзүүлж, сонгуульд оролцогч талуудад тэгш хандах үүрэгтэй.
	<b>61 дүгээр зүйл. Санал авах байр, хугацаа</b>	61.2.Тухайн хэсгийн харьяалагдах сум, дүүргийн Засаг дарга Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан зааврын дагуу санал авахад шаардлагатай дараах зүйлийг санал авах өдрөөс долоогоос доошгүй хоногийн өмнө бэлэн болгох үүрэгтэй: Уг зүйлийг тус хуулийн 61.2.1-61.2.6 дэх заалтаас дэлгэрүүлж үзнэ үү.
	<b>62 дугаар зүйл. Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах ажиллагаа</b>	62.1.1.эрүүл мэндийн байдлын улмаас санал авах байранд өөрийн биеэр очиж чадахгүй сонгогч; 62.3.Энэ хуулийн 62.1.1-д заасан сонгогч асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй бол тухайн сонгогчийн харьяалагдах баг, хорооны Засаг дарга түүний хүсэлт, мэдээллийг холбогдох хэсгийн хороонд хүргүүлэх үүрэгтэй.
	<b>69 дүгээр зүйл. Санал авах өдөр хориглох үйл ажиллагаа</b>	69.1.Санал авах өдөр дараах үйл ажиллагааг хориглох бөгөөд аймаг, нийслэлийн Засаг дарга холбогдох шийдвэр гарган хяналт тавьж ажиллана: 69.1.1.согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах; 69.1.2.соёл урлаг, үзвэр, спортын зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулах; 69.1.3.гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төв ажиллах

---о0о---



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

**АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД,  
БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ  
ҮЕИЙН ХОРИО ЦЭЭРИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТУХАЙ**

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай	<b>5 дугаар зүйл. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын бүрэн эрх</b>	5.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ импортоор оруулж ирсэн амьтан, ургамлыг хууль тогтоомжид заасны дагуу хорио цээрийн дэглэмд байлгах арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавина.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

### АМЬТНЫ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Амьтны тухай	<b>5 дугаар зүйл. Амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах талаар төрийн болон өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх</b>	<p>5.5.Амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах талаар аймаг, нийслэлийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>5.5.1.амьтныг хамгаалахтай холбогдсон хууль тогтоомж, түүний хэрэгжилттэй холбогдуулан гаргасан Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;</p> <p>5.5.2.энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.1.7-6.1.9, 6.1.11-д заасан арга хэмжээг нутаг дэвсгэртээ авч хэрэгжүүлэх;</p> <p>5.5.3.амьтны мэдээллийн сангийн мэдээ баримтыг харьяалагдах сум, дүүргийн хэмжээгээр нэгтгэн бүрдүүлж, төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;</p> <p>5.5.4.нутаг дэвсгэртээ байршдаг амьтныг хамгаалах арга хэмжээг байгаль орчныг хамгаалах хөтөлбөртөө тусган хэрэгжүүлэх;</p> <p>5.5.5.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</p> <p>5.7.Амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах талаар сум, дүүргийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>5.7.1.харьяалах нутаг дэвсгэртээ байршдаг амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээг байгаль орчны хөтөлбөртөө тусган хэрэгжүүлэх;</p> <p>5.7.2.амьтныг эзэмших, ашиглах зөвшөөрлийг энэ хуульд заасан журмын дагуу иргэн, хуулийн этгээдэд олгох;</p> <p>5.7.3.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</p>



<p><b>17 дугаар зүйл. Амьтны амьдралын үйл ажиллагааны хэрэгтэй чанарыг ашиглах</b></p>	<p>16.1.Судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, гоо зүйн зориулалтаар /ажиглаж судлах, тэмдэг тавих, зурах, зураг авах зэрэг хэлбэрээр/ амьтныг ашиглахдаа түүнийг гэмтээлгүйгээр амьдрах орчныг нь алдагдуулахгүйгээр гүйцэтгэнэ., 18.1 Амьдралын үйл ажиллагааны бүтээгдэхүүн /зөгийн бал, лав, бугын цусан эвэр, хүдрийн заар зэрэг/-ийг авах зорилгоор амьтныг ашиглахдаа эрүүл мэндэд нь хор хохирол учруулахгүй, тамлан зовоохгүй, тэдгээрийн амьдрах орчныг алдагдуулахгүйгээр гүйцэтгэнэ./ 17.2.Энэ хуулийн 16.1, 18.1-д заасан хэлбэрээр амьтныг ашиглах зөвшөөрлийг сум, дүүргийн Засаг дарга олгоно.</p>
<p><b>23 дугаар зүйл. Агнуур зохион байгуулалт, түүний санхүүжилт, амьтны экологи- эдийн засгийн үнэлгээ тогтоох</b></p>	<p>23.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ агнуур зохион байгуулалтыг таван жил тутамд хийлгэж, үйлдвэрлэлийн зориулалтаар агналт явуулсан тохиолдолд жил бүр тооллого хийнэ.</p>
<p><b>25 дугаар зүйл. Агнуурын амьтан агнах, барих зөвшөөрөл</b></p>	<p>25.5.Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 26.2-т заасан агнуурын амьтны тоо хэмжээнд багтаан харьяалах нутаг дэвсгэрт агнуурын амьтан агнах, барих зөвшөөрлийг иргэн, хуулийн этгээдэд олгож болно.</p>
<p><b>27 дугаар зүйл. Үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих</b></p>	<p>27.1.Сумын Засаг дарга дараах болзол хангасан хуулийн этгээдтэй үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих гэрээ байгуулна: Уг болзолыг тус хуулийн 27.1.1.-27.1.3, 27.2 дахь хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.</p>
<p><b>38 дугаар зүйл. Зөрчил илрүүлсэн, мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах</b></p>	<p>38.1.Амьтны тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийг илрүүлсэн, илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн буюу түүний тухай мэдээлэл өгсөн иргэнд уг мэдээлэл нь батлагдсан тохиолдолд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн хэмжээний 15 хувиар тооцож мөнгөн шагналыг сум, дүүргийн Засаг дарга олгоно.</p>

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 04 сарын 24 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай	<b>5 дугаар зүйл. Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх төрийн байгууллагын бүрэн эрх</b>	5.5.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга архив, албан хэрэг хөтлөлтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 5.5.1.архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомжийг харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; 5.5.2.архивыг зориулалтын байр, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах, архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтныг мэргэшүүлэх, давтан сургах, тэдгээрийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх; 5.5.3.хуульд заасан бусад бүрэн эрх.
	<b>19 дүгээр зүйл. Төрийн архивыг харьяалах байгууллагын чиг үүрэг, төрийн архивын удирдлагыг томилох, чөлөөлөх</b>	19.3.Аймаг, нийслэлийн архивын даргыг тухайн шатны Засаг дарга архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр томилж, чөлөөлнө.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

### АХМАД НАСТНЫ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Ахмад настны тухай	<b>14 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг</b>	<p>14.5.Бүх шатны Засаг дарга ахмад настныг дэмжих талаар дараахь үүрэг хүлээнэ:</p> <p>14.5.1.баг, хорооны Засаг дарга ахмад настныг судалж бүртгэх, хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж тогтоох болон дэмжлэг, тусламж үзүүлэхэд шаардагдах баримт бичгийг бүрдүүлэхэд туслах, үнэн зөв тодорхойлолт гаргаж өгөх;</p> <p>14.5.2.сум, дүүргийн Засаг дарга ахмад настны талаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, ахмад настныг нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээнд хамруулах талаар эрх бүхий байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх, ахмад настныг нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах, эрүүл мэндийг нь хамгаалах, ажиллаж байсан аж ахуйн нэгж, байгууллага нь татан буугдсан, өөр орон нутгаас шилжин ирсэн ахмад настныг бүртгэж, нийгмийн хамгааллын арга хэмжээнд хамруулах;</p> <p>14.5.3.аймаг, нийслэлийн Засаг дарга ахмад настныг дэмжих талаар авах арга хэмжээ, зарцуулах төсвийн санал боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, энэ талаархи хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, хэрэгжилтэд хяналт тавих, ахмад настныг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах саналыг халамжийн байгууллагад уламжлах;</p> <p>14.5.4.аймаг, нийслэлийн Засаг дарга нь орон сууц барих аж ахуйн нэгжийн удирдлагатай тохиролцон шинээр баригдах орон сууцны дэд бүтцэд төсвөөс оруулсан хөрөнгө оруулалттай тэнцэх хэмжээний үнийн дүнтэй орон сууцыг эзэмшилдээ авах, эхний ээлжид орон байргүй ахмад настанд хөлслүүлэх, эзэмшүүлэх, хүүхэдтэйгээ хамтран төлбөрийн уян хатан, хөнгөлөлттэй нөхцөлөөр худалдан авах боломж бүрдүүлэх;</p> <p>14.5.5.аймаг, нийслэлд ахмадын ордон, сум, дүүрэгт ахмадын өргөө, танхим, төв байгуулж ажиллуулах, түүнд шаардагдах хөрөнгө, үйл ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсөвт жил бүр тусгах.</p>

---оОо---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 07 сарын 08 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Ашигт малтмалын тухай	<b>12 дугаар зүйл. Аймаг, сумын Засаг даргын бүрэн эрх</b>	<p>12.1.Ашигт малтмалын асуудлаар аймгийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>12.1.1.ашигт малтмалын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;</p> <p>12.1.2.харьяалах нутаг дэвсгэрт нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг зориулалтаар ашиглуулах, зөрчил гаргавал таслан зогсоох;</p> <p>12.1.3.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих;</p> <p>12.1.4.Газрын тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу тодорхой газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах шийдвэр гаргах.</p> <p>12.1.5.Газрын тухай хуулийн 16.1.11-д заасан зориулалтаар олгохоор сонгосон газрын талаар энэ хуулийн 11.1.23-д заасан дүгнэлт гаргуулах тухай хүсэлтийг төрийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.</p> <p>12.2.Ашигт малтмалын асуудлаар сумын Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>12.2.1.бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд хяналт тавих;</p> <p>12.2.2.харьяалах нутаг дэвсгэрт эрдэс баялгийн салбарын талаар хэрэгжиж байгаа шийдвэрийн талаар жил</p> <p>12.2.3.энэ хуулийн 43.3-т заасан гадаадын ажиллах хүчнээс төвлөрсөн хөрөнгийг соёл, боловсрол болон эрүүл мэндийн салбарт зарцуулах журмын хэрэгжилтийг зохион байгуулах;</p>

	<p>12.2.4.бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээний хэрэгжилтийг хангуулах, гэрээ байгуулсан тухай мэдээллийг төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;</p> <p>12.2.5.ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянах.</p> <p>Засаг дарга байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлахдаа холбогдолтой процесс, тавигдах шалгуур, хийгдэх ажиллагаа тус хуулийн 38 дугаар зүйлээс дэлгэрүүлж үзнэ үү.</p>
<p><b>17 дугаар зүйл.</b>  <b>Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох шалгаруулалтын талбайг ялгах</b></p>	<p>17.1.Энэ хуулийн 11.1.25-д заасны дагуу төрийн захиргааны байгууллага нь талбайн солбицлыг тодорхойлохдоо тухайн аймаг, нийслэлийн Засаг даргад бичгээр мэдэгдэх бөгөөд түүнд талбайн зургийг хавсаргана.</p> <p>17.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 17.1-д заасан мэдэгдлийг хүлээн авмагц тухайн талбай байрших сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг авч, 45 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хариу өгөх бөгөөд энэ хугацаанд хариу өгөөгүй бол тухайн саналыг зөвшөөрсөн гэж үзнэ. Аймаг, нийслэлийн Засаг дарга хуульд заасан үндэслэлээр татгалзсан хариу өгч болно.</p>
<p><b>20 дугаар зүйл.</b>  <b>Тусгай зөвшөөрөл олгох</b></p>	<p>20.8.Төрийн захиргааны байгууллага хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон даруйд энэ тухай байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн талбай байрших аймаг, сум, дүүргийн Засаг дарга, татварын албанд мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ.</p>
<p><b>39 дүгээр зүйл.</b>  <b>Байгаль орчныг хамгаалах талаар ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг</b></p>	<p>39.5.Энэ хуулийн 39.3-т заасан мөнгөн хөрөнгийг тухайн жилийн олборлолтын ажил эхлэхийн өмнө шилжүүлэх бөгөөд энэхүү шилжүүлэг хийгдсэн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэнэ</p> <p>39.6.Энэ хуулийн 39.5-д заасан хугацаанд мөн хуулийн 39.1.9-д заасан мөнгөн хөрөнгийг шилжүүлээгүй бол сум, дүүргийн Засаг дарга уурхайн тухайн жилийн олборлолтын ажлыг зогсоох эрхтэй.</p> <p>39.7.Тухайн жилийн нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийгээгүй тохиолдолд сум, дүүргийн Засаг дарга болон хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хамтран дараагийн жилийн олборлолтын ажлыг эхлүүлэхгүй байх эрхтэй.</p>

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 5 дугаар сарын 13-ны өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Аялал жуулчлалын тухай	<b>16 дугаар зүйл.</b> <b>Аялал жуулчлалын бүс</b>	<p>16.1.Монгол Улс тодорхой газар нутгийг тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтыг татах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх зорилгоор орон зайн зохистой төлөвлөлтийг бий болгосон аялал жуулчлалын бүстэй байна.</p> <p>16.2.Аялал жуулчлалын бүсийг дараах байдлаар ангилна:</p> <p>16.2.1.улсын аялал жуулчлалын бүс;</p> <p>16.2.2.орон нутгийн аялал жуулчлалын бүс.</p> <p>16.7.Аймаг, нийслэлийн аялал жуулчлалын асуудал хариуцсан нэгж орон нутгийн аялал жуулчлалын бүсийн хилийн заагийг аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийцүүлэн боловсруулах бөгөөд аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталж, газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд болон энэ хуулийн 27.1-д заасан аялал жуулчлалын мэдээллийн санд хүргүүлнэ.</p> <p>16.8.Орон нутгийн аялал жуулчлалын бүс нь менежментийн төлөвлөгөөтэй байна. Орон нутгийн аялал жуулчлалын бүсийн газар зохион байгуулалтын асуудлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.</p> <p>16.10.Энэ хуулийн 16.8-д заасан орон нутгийн аялал жуулчлалын бүсийн менежментийн төлөвлөгөөг аймаг, нийслэлийн аялал жуулчлалын асуудал хариуцсан нэгж боловсруулж, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.</p> <p>16.11.Улсын аялал жуулчлалын бүсийн менежментийг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн</p>

		<p>төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн аялал жуулчлалын бүсийн менежментийг аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцан зохион байгуулна.</p>
	<p><b>23 дугаар зүйл.</b> <b>Аймаг,</b> <b>нийслэлийн</b> <b>Засаг даргын</b> <b>бүрэн эрх</b></p>	<p>23.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга аялал жуулчлалын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>23.1.1.аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах;</p> <p>23.1.2.аялал жуулчлалын хууль тогтоомж, холбогдох бусад хууль, дүрэм, журам, техникийн зохицуулалт, стандартын хэрэгжилтийг хангуулах;</p> <p>23.1.3.харьяалах нутаг дэвсгэртээ аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх;</p> <p>23.1.4.харьяалах нутаг дэвсгэртээ аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлэх бодлоготой уялдуулан төлөвлөгөө боловсруулах, зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд санал оруулах, хэрэгжүүлэх;</p> <p>23.1.5.харьяалах нутаг дэвсгэртээ байгуулах аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагад газар эзэмших зөвшөөрлийг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тогтоосон нөөц, даац, тоо, байршлыг баримтлан зохих хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулж, олгох;</p> <p>23.1.6.аялал жуулчлалын мэдээллийн санг хөтлөх;</p> <p>23.1.7.аймаг, нийслэлийн хэмжээнд зохион байгуулагддаг аялал жуулчлалын арга хэмжээний товыг өмнөх оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө зарлах, уг арга хэмжээг зохион байгуулах, удирдлагаар хангах;</p> <p>23.1.8.улсын аялал жуулчлалын бүсэд гүйцэтгэж байгаа аялал жуулчлалын бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;</p> <p>23.1.9.орон нутгийн аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээг авах;</p> <p>23.1.10.шаардлагатай тохиолдолд харьяалах нутаг дэвсгэртээ жуулчны мэдээллийн төв байгуулах;</p> <p>23.1.11.байгаль, түүх, соёлын өв бүхий аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлан таниулах, хадгалж, хамгаалах;</p> <p>23.1.12.харьяалах нутаг дэвсгэртээ аялал жуулчлалын байгууллага, жуулчны үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг үр дагаврыг багасгах, арилгах арга хэмжээ авах;</p> <p>23.1.13.харьяалах нутаг дэвсгэртээ улсын болон олон улсын чанартай авто замын дагуу аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж,</p>

		<p>жуулчинд үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд хамтран ажиллах;</p> <p>23.1.14.аялал жуулчлалыг хөгжүүлэх хэрэгцээ, шаардлагыг харгалзан аймаг, нийслэлд аялал жуулчлалын асуудал хариуцсан нэгж, эсхүл ажилтан ажиллуулах.</p>
	<p><b>25 дугаар зүйл. Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх</b></p>	<p>25.1.Сум, дүүргийн Засаг дарга аялал жуулчлалын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>25.1.1.харьяалах нутаг дэвсгэртээ аялал жуулчлалын арга хэмжээг зохион байгуулах, орон нутгаа сурталчлах;</p> <p>25.1.2.сум, дүүргийн соёл, спорт, олон нийтийн арга хэмжээг аялал жуулчлалын үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;</p> <p>25.1.3.нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;</p> <p>25.1.4.жуулчны аюулгүй байдлыг хангах арга хэмжээг харьяалах нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага, нутгийн иргэдтэй хамтран зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>25.1.5.орон нутгийн иргэдийн өв соёлын үнэт зүйлс, гар урлал, уламжлалт соёлыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх зорилгоор орон нутагт хөрөнгө оруулалт татах нөхцөлийг хангах;</p> <p>25.1.6.харьяалах нутаг дэвсгэртээ аяллын маршрутын дагуу тэмдэг тэмдэглэгээ, нэгдсэн хаягжуулалт бий болгох.</p>

---о0о---





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 6 дугаар сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

### БАГШИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Багшийн хөгжлийг дэмжих тухай	<b>3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт</b>	3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно: 3.1.2."багшийн хөгжил" гэж багшийн мэдлэг, арга зүй, ур чадвар, боловсролоо дээшлүүлэх тасралтгүй үйл явцыг;
	<b>5 дугаар зүйл. Төрөөс багшийн хөгжлийг дэмжих тогтолцоо</b>	5.2.Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг үндэсний түвшинд багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн байгууллага, орон нутгийн түвшинд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, байгууллагын түвшинд захирал, сургалтын менежер, эрхлэгч, арга зүйч, сонирхлын бүлгийн түвшинд хамтын удирдлагын нэгдэл, багш өөрөө хэрэгжүүлнэ.
	<b>8 дугаар зүйл. Багшийг бэлтгэх</b>	8.1.Орон нутгийн төрийн захиргааны байгууллага нь тухайн нутаг дэвсгэрийн багшийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан захиалгаар багш бэлтгүүлэх гэрээг сургууль болон суралцагчтай байгуулж тэтгэлэг олгож болно.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 05 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

### БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай	<b>3 дугаар зүйл. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн үйлчлэх хүрээ</b>	3.1.Энэ хуулиар байгалийн ургамал, ус, ой, ан амьтны нөөцийг ашигласны төлбөртэй холбогдсон харилцааг зохицуулна. 3.2.Газар болон түүний хэвлийн нөөц ашигласны төлбөртэй холбогдсон харилцааг тусгай хуулиар зохицуулна.
	<b>4 дүгээр зүйл. Төлбөр төлөгч, түүнийг бүртгэх</b>	4.3.Сум, дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтан байгалийн нөөцийг ашиглах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын талаарх мэдээллийг зөвшөөрөл олгосон өдрөөс хойш 10 хоногийн дотор зохих шатны татварын албанд гаргаж өгөх бөгөөд татварын алба уг мэдээллийг үндэслэн төлбөр төлөгчийг бүртгэнэ.
	<b>23 дугаар зүйл. Байгалийн нөөц ашигласны төлбөр төлөх</b>	23.1.Сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөр хураах эрх бүхий албан тушаалтныг томилон ажиллуулна. 23.2.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг дараа сарын 10-ны өдрийн дотор орон нутгийн төсөвт төлж, төлбөрийн жилийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор харьяалагдах татварын албанд тушааж эцсийн тооцоо хийнэ. 23.3.Сум, дүүргийн Засаг даргын томилсон төлбөр хураах эрх бүхий албан тушаалтан төлбөрийг бэлнээр хураан авсан тухай бүр сум, дүүргийн төсөвт тушаана.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

### БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Байгалийн ургамлын тухай	<b>7 дугаар зүйл. Ургамлыг хамгаалах</b>	1.Ургамлыг гал түймэр, өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавьж болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах ажлыг бүх шатны Засаг дарга улсын төсвийн хөрөнгөөр, гэрээний дагуу газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ. 3.Ургамлыг өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавьж, хими, биологийн бодисын хортой нөлөөллөөс хамгаалах, хорио цээр тогтоох ажлыг сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийж гүйцэтгэнэ.
	<b>12 дугаар зүйл. Ургамлыг ахуйн зориулалтаар ашиглах</b>	1.Иргэн ховор ургамлыг өөрийн ам бүлийн хүнсний болон ахуйн бусад хэрэгцээг хангах зорилгоор Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.13-т заасны дагуу сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрлөөр ашиглаж болно.
	<b>13 дугаар зүйл. Ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах</b>	3.Элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.25-д заасны дагуу сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 7 <sup>1</sup> дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу олгоно.
	<b>14 дүгээр зүйл.</b>	3.Ургамлыг нөхөн сэргээх буюу нөхөн сэргэх нөхцөлийг бүрдүүлэх, хамгаалах зорилгоор бэлчээр, хадлангийн газрыг хуваарьтай, даацад нь тохируулж ашиглуулах асуудлыг сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга шийдвэрлэнэ.
	<b>18 дугаар зүйл. Ургамлыг ашиглах зорилгоор газар эзэмшүүлэх, ашиглуулах</b>	1.Сум, дүүргийн Засаг дарга ургамлыг нь үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зорилгоор түүний тархац газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн тодорхой хугацаатайгаар Газрын тухай хуульд заасан журмын дагуу гэрээ байгуулан эзэмшүүлж, ашиглуулж болно. Уг гэрээнд хуульд заасны дагуу тусгах зүйлийг тус хуулийн 18 дугаар зүйлийн 2 дахь хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

### БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай	<b>3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</b>	3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: 3.1.6."байгаль орчны нөлөөллийн үнэлгээ гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тодорхой төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоохыг;
	<b>8 дугаар зүйл. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ</b>	8.8.Төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллага нөлөөллийн үнэлгээ хийсэн эсэхэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны Засаг дарга, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавина.
	<b>9 дүгээр зүйл. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө</b>	9.12.Байгаль орчны менежментийн болон уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавина

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 3 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

### БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Байгаль орчныг хамгаалах тухай	<b>6 дугаар зүйл. Байгалийн баялгийг өмчлөх, байгаль орчныг хамгаалах</b>	5.Засаг дарга энэ хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 10 дахь заалт, 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс тухайн нутгийн байгаль орчинд онц их хэмжээний хохирол учирсныг шүүх шинжилгээний байгууллага, эсхүл эрх бүхий мэргэжлийн байгууллага хуульд заасан аргачлалаар албан ёсоор тогтоосон тохиолдолд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 64.2.5-т заасан арга хэмжээ авна.
	<b>10<sup>1</sup> дүгээр зүйл. Байгаль орчны аудит</b>	2.Байгаль орчны аудит хийх зардлыг төлөвлөгөөт хугацаанд хийж байгаа тохиолдолд тухайн аж ахуйн нэгж, байгууллага, төлөвлөгөөт бус хугацаанд Засаг дарга, эсхүл байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аудит хийлгэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд захиалагч тал хариуцна.
	<b>11 дүгээр зүйл. Байгаль орчны судалгаа, шинжилгээ, түүний санхүүжилт</b>	2.Төрийн захиргааны төв байгууллага, зохих шатны Засаг дарга нь эрдэм шинжилгээний болон холбогдох мэргэжлийн байгууллагад байгаль орчны судалгаа, шинжилгээний ажил хийх, төсөл боловсруулах захиалга өгч зохих төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээс гадна сонирхогч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад өөрийн хөрөнгөөр судалгаа, шинжилгээ хийхэд нь дэмжлэг үзүүлнэ.
	<b>16 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх</b>	2.Аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах; 2/нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн

		<p>мэдүүлэх, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;</p> <p>3/байгаль орчны мэдээллийн сангийн мэдээ, баримтыг төрийн захиргааны төв байгууллагад хугацаанд нь ирүүлэх;</p> <p>4/нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;</p> <p>5/нутаг дэвсгэртээ ажиллах байгаль орчны улсын ахлах болон улсын байцаагчийг энэ хуульд заасны дагуу ялгах тэмдэг, дүрэмт хувцас, бие хамгаалах зэвсэг, техник хэрэгсэл, уналгаар хангах;</p> <p>6/аймаг, нийслэлийн байгаль орчны албаны даргыг байгаль хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж томилох, чөлөөлөх</p> <p>7/нутаг дэвсгэртээ нөхөрлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг баталж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх;</p> <p>8/нөхөрлөлийн үйл ажиллагааг нутаг дэвсгэртээ батлагдсан төсвийн хүрээнд дэмжин хөгжүүлэх мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах;</p> <p>9/тухайн жилд нөхөрлөлийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хэлэлцүүлэх;</p> <p>10/байгалийн нөөцийг төрийн нэрийн өмнөөс хамгаалан, халдашгүй байдлыг нь хангах үүргийг тухайн нутаг дэвсгэртээ хариуцах.</p> <p>3.Аймаг, нийслэлийн байгаль орчны албаны даргыг байгаль орчны мэргэжилтэй иргэдээс Төрийн албаны тухай хуулийн 25, 26, 27 дугаар зүйлд заасны дагуу сонгон шалгаруулж томилно.</p>
	<p><b>17 дугаар зүйл.</b> <b>Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх</b></p>	<p>2.Сум, дүүргийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>1/нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, дээд шатны байгууллагын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;</p>

		<p>2/иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн баялгийн нөөц ашиглах эрхийн бичгийг хууль тогтоомжийн дагуу олгох;</p> <p>3/иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын байгалийн баялгийн ашиглалтад хяналт тавьж, тэдний ургуулсан ой, ургамал, өсгөн үржүүлсэн амьтан, сэргээн сайжруулсан, засаж тохижуулсан газар, уст цэгийг хүлээн авах;</p> <p>4/нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх; /Энэ заалтад 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/</p> <p>5/байгаль хамгаалагчийн ажлыг удирдан чиглүүлэх, албан үүргээ гүйцэтгэхэд нь шаардагдах ялгах тэмдэг, дүрэмт хувцас, бие хамгаалах зэвсэг, техник хэрэгсэл, уналгаар орон нутгийн төсөвтөө тусган хангах, шаардлагатай бусад туслалцаа үзүүлэх;</p> <p>6/аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын цэг тогтоох, бохирдлыг багасгах арга хэмжээ авах.</p> <p>7/энэ хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтад заасан шийдвэрийг үндэслэн иргэдийн нөхөрлөлд хариуцуулах байгалийн тодорхой төрлийн баялгаас нь зохих болзол, хугацаатайгаар хууль, журмын дагуу хамгаалуулах, ашиглуулах, эзэмшүүлэх гэрээ байгуулж, биелэлтэд нь хяналт тавих.</p> <p>8/байгалийн нөөцийг төрийн нэрийн өмнөөс хамгаалан, халдашгүй байдлыг нь хангах үүргийг тухайн нутаг дэвсгэртээ хариуцах;</p> <p>9/энэ хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан үүргээ нутгийн иргэдийн байгалийн нөөцийг зохистой ашиглах ухамсрыг төлөвшүүлэх, байгалийн нөөцийн хууль бус ашиглалттай тэмцэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, шүүхэд нэхэмжлэл гаргах зэрэг хэлбэрээр хэрэгжүүлэх;</p> <p>10/нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, мэргэжлийн сургалт явуулж үр дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах.</p>
--	--	---

<p><b>18 дугаар зүйл.</b> <b>Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх</b></p>	<p>2.Баг, хорооны Засаг дарга байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/байгаль орчныг хамгаалах талаархи хууль тогтоомж, иргэдийн Нийтийн Хурал болон дээд шатны байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах; 2/нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах ажлыг удирдан чиглүүлж орчны бохирдол, хог хаягдлыг цэвэрлэх жил бүрийн ажилд иргэдийг татан оролцуулах; 3/хууль тогтоомжид заасан тохиолдолд байгалийн баялгийн нөөц ашиглах эрхийн бичиг олгох; 4/нутаг дэвсгэртээ орчны эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангуулах, нийтийн хог хаягдлын цэг тогтоох. 5/нөхөрлөлийг байгуулах болон түүний үйл ажиллагаатай холбогдсон саналыг иргэдийн Нийтийн Хуралд танилцуулж хэлэлцүүлэх. 6/бусдын эзэмшил, ашиглалтад олгоогүй хадлангийн болон тариалангийн талбай, бэлчээр, уст цэгийг хамгаалах, ашиглах хуваарь гаргаж зохицуулах.</p>
<p><b>26 дугаар зүйл.</b> <b>Байгаль орчны хяналт</b></p>	<p>4.Улсын байцаагчийг дараахь байдлаар томилж, чөлөөлнө: 4/байгаль хамгаалагчийг энэ хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан нормативын дагуу сум, дүүргийн улсын байцаагчийн саналыг харгалзан сум, дүүргийн Засаг дарга.</p>
<p><b>35 дугаар зүйл.</b> <b>Мэдээллийн сангийн бүрдэл</b></p>	<p>1.Улсын мэдээллийн сан дараахь зүйлийн талаархи мэдээллээс бүрдэнэ: 2/газрын хэвлий, ашигт малтмал; 11/хог хаягдал; 12/тусгай хамгаалалттай газар нутаг;</p>
<p><b>37 дугаар зүйл.</b> <b>Мэдээллийн санд мэдээлэл төвлөрүүлэх үүрэг бүхий байгууллага, хэрэгжүүлэх хугацаа</b></p>	<p>2.Энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан мэдээллийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор улсын мэдээллийн санд төвлөрүүлнэ. 7.Энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 11, 12-т заасан мэдээллийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг дарга жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор улсын мэдээллийн санд төвлөрүүлнэ.</p>
<p><b>50 дугаар зүйл.</b> <b>Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл</b></p>	<p>4.Сум дүүргийн Засаг дарга дараах баримт бичгийг үндэслэн байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах иргэдийн нөхөрлөлтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж, тэдний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулна: Уг баримт бичгийн бүрдүүлбэрийг тус хуулийн 50 дугаар зүйлийн 4 дэх хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.</p>



		<p>8.Нөхөрлөлийн байгалийн нөөцийн хамтын менежментийн чиглэлээр явуулах үйл ажиллагааг дараах тохиолдолд тухайн сум, дүүргийн Засаг дарга зогсоож, гэрээг цуцална:</p> <p>Гэрээг цуцлах үндэслэлийг тус хуудийн 50 дугаар зүйлийн 8 дэх хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.</p>
	<p><b>54 дугаар зүйл.</b> <b>Байгаль орчныг хамгаалах эдийн засгийн хөшүүрэг</b></p>	<p>4.Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн, түүнчлэн зөрчлийг илрүүлсэн, илрүүлэхэд бодитой туслалцаа үзүүлсэн иргэнд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн орлогын дүнгийн 15 хувьтай тэнцэх мөнгөн урамшууллыг сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно.</p> <p>5. Хууль бусаар бэлтгэж хураалгасан байгалийн баялгийн борлуулалтын орлогын 15 хувийг тухайн зөрчлийг илрүүлсэн улсын байцаагч, байгаль хамгаалагчид тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно.</p> <p>6.Энэ зүйлийн 4, 5, 8, 9 дахь хэсэгт заасан урамшуулал олгох журмыг Сангийн болон Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд батална.</p> <p>7.Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан мэдээлэгчийг холбогдох хууль тогтоомжийн дагуу нууцлана.</p> <p>8.Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн иргэн, нөхөрлөл, төрийн бус байгууллагад 150000 төгрөгийн мөнгөн урамшууллыг сум, дүүргийн Засаг дарга ажлын 10 өдөрт багтаан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно.</p>
	<p><b>57 дүгээр зүйл.</b> <b>Байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлөх</b></p>	<p>2.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас байгаль орчны алдагдсан тэнцлийг болон байгалийн баялгийг нөхөн сэргээх, хүн амыг нүүлгэх, мал, амьтныг тухайн нутаг дэвсгэрээс шилжүүлэхэд гарсан зардлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр сум, дүүргийн Засаг дарга шүүхэд нэхэмжлэл гаргана.</p>

---oO---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

### БАРИЛГЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Барилгын тухай	<b>4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</b>	4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно: 4.1.1."барилга байгууламж" гэж орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээг; 4.1.11."барилгын ажил" гэж бүх төрлийн барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэх талбайг бэлтгэх, бүрдэл хэсгийг угсрах, шинэчлэн барих, буулгах, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулах үйл ажиллагааг;
	<b>9 дүгээр зүйл. Барилгын ажлын төрөл</b>	9.1.Барилгын ажил нь дараахь төрөлтэй байна: 9.1.1.барилга байгууламж шинээр барих; 9.1.2.барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэх; 9.1.3.барилга байгууламжийг засварлах, тоноглох; 9.1.4.буулгалтын ажил; 9.1.5.гадна талбайн тохижилт.
	<b>10 дугаар зүйл. Барилга байгууламжийн ангилал</b>	10.1.Барилга байгууламжийг төвөгшлөөр нь дараахь байдлаар ангилна: 10.1.1.барилгын ажлын зөвшөөрөл шаардахгүй барилга байгууламж; 10.1.2.бага төвөгшилтэй барилга байгууламж; 10.1.3.дунд зэргийн төвөгшилтэй барилга байгууламж; 10.1.4.өндөр төвөгшилтэй барилга байгууламж; 10.1.5.онцгой төвөгшилтэй барилга байгууламж.
	<b>20 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох</b>	20.2.Цамхаг, тулгуур, түшиц хана зэрэг 30 метрээс дээш өндөр, 60 метрээс дээш алгасалтай байгууламж, 16-аас дээш давхартай барилга, ус, дулаан, цахилгаан хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг зөвхөн тухайн барилга байгууламжийн хувьд олгох бөгөөд барилгын ажил гүйцэтгэж дуусах хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байна.
	<b>27 дугаар зүйл. Барилгын ажлын</b>	27.1.Барилгын ажлын зөвшөөрлийг дараах эрх бүхий этгээд олгоно:

<p><b>зөвшөөрөл олгох үйл ажиллагаа</b></p>	<p>27.1.1.энэ хуулийн 32.1.5-д заасан зөвшөөрлийг Засгийн газар; 27.1.2.энэ хуулийн 10.1.5, 20.2-т заасан зөвшөөрлийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага; 27.1.3.энэ хуулийн 27.1.1, 27.1.2-т зааснаас бусад зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга.</p>
<p><b>32 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх</b></p>	<p>32.1.5.цөмийн болон дулааны цахилгаан станц, усан цахилгаан станц, төмөр зам, нисэх онгоцны буудал, метро, улс дамнасан нефть болон хийн хоолой, газрын тос боловсруулах үйлдвэр, түүхий тос дамжуулах хоолой зэрэг улсын чанартай барилга байгууламжид барилгын ажлын зөвшөөрөл олгох, ашиглалтад оруулах асуудлыг шийдвэрлэх</p>
<p><b>35 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх</b></p>	<p>35.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга барилгын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 35.1.1.нутаг дэвсгэртээ барилгын салбарт баримтлах төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих; 35.1.2.барилгын үйл ажиллагаанд барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг мөрдүүлэх; 35.1.3.барилга байгууламжийн байршил тогтоох, газар олголт, загвар зураг батлах болон техникийн нөхцөл олгох үйл ажиллагааг зохион байгуулж, нэгдсэн бүртгэл хөтлөх, хадгалах, мэдээлэл түүний аюулгүй байдлыг хангах, мэдээллийн сангийн байнгын үйл ажиллагааг эрхлэх, хяналт тавих; 35.1.4.тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах; 35.1.5.барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам батлах, хэрэгжилтийг хангах; 35.1.6.барилгын ажлын зөвшөөрөл олгож, барилга байгууламжийг ашиглалтад оруулах; 35.1.7.барилга байгууламжийн баримт бичгийн шаардлагад нийцээгүй барилга байгууламжийг улсын хяналт хэрэгжүүлэгч байгууллагын ерөнхий байцаагчийн дүгнэлт болон шүүхийн шийдвэрийг үндэслэн албадан буулгах арга хэмжээг авч, холбогдох зардлыг буруутай этгээдээр төлүүлэх; 35.1.8.энэ хуулийн 35.1.3, 35.1.4, 35.1.6-д заасан үйл ажиллагаатай холбоотой хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэн, нэг цэгийн үйлчилгээгээр зохион байгуулах.</p>

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 07 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

### БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Биеийн тамир, спортын тухай	<b>8 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх</b>	8.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.1.1.харьяа нутаг дэвсгэртээ биеийн тамир, спортын талаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлэх; 8.1.2.харьяа нутаг дэвсгэртээ иргэнийг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх; 8.1.3.биеийн тамир, спортыг хөгжүүлэх, дэмжих чиглэлээр идэвх, санаачилгатай ажиллаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, дэмжлэг үзүүлэх; 8.1.4.суманд орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллуулах; 8.1.5.биеийн тамир, спортыг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах, хэрэгжилтийг хангах; 8.1.6.хүн амын нягтаршил, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн иргэний идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх боломжийг бий болгох, спортын барилга байгууламж, заал, талбайн хүрэлцээ, хангамжийг нэмэгдүүлэх, бэхжүүлэх; 8.1.7.биеийн тамир, спортыг хөгжүүлэх чиглэлээр спортын холбоод, бусад байгууллагатай хамтран ажиллах; 8.1.8.аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын газрын даргыг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн томилж, чөлөөлөх.
	<b>18 дугаар зүйл. Үндэсний шигшээ баг</b>	18.5.Аймаг, дүүргийн Засаг дарга нь аймаг, дүүргийн өсвөр үеийн шигшээ багт орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх бөгөөд аймаг, дүүргийн Биеийн тамир, спортын газар нь спортын 8-аас доошгүй төрлөөр спортын холбооны орон нутаг дахь салбартай хамтран сонгон шалгаруулж, үйл ажиллагааг нь зохион байгуулна.
	<b>26 дугаар зүйл. Биеийн тамир, спортын барилга байгууламж</b>	26.6.Хувийн өмчийн хөрөнгө оруулалтаар баригдсан, стандартын шаардлага хангасан спортын барилга байгууламж, спортын зааланд иргэнийг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллүүлэх зорилгоор тухайн шатны Засаг дарга дэмжлэг үзүүлж болно.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023оны 07 сарын 07 өдөр

Улаанбаатар хот

### БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Боловсролын тухай	<b>30 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх</b>	<p>30.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаас гадна боловсролын асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>30.1.1.орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллага байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг шийдвэрлэх;</p> <p>30.1.2.боловсролын сургалтын байгууллагын хичээлийн болон дотуур байр, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, ном, сурах бичгээр хангахад дэмжлэг үзүүлэх, зохион байгуулах, хууль тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх;</p> <p>30.1.3.насан туршийн суралцахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;</p> <p>30.1.4.нутаг дэвсгэрийн хэмжээнд үндэсний цөөнхийн монгол хэл болон эх хэлээрээ боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>30.1.5.орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний чанар, үр дүнг Засгийн газар болон иргэн, олон нийтийн өмнө хариуцах;</p> <p>30.1.6.боловсролын сургалтын байгууллагын нийт албан хаагчийг жилд нэг удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах арга хэмжээг авах;</p> <p>30.1.7.боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтанд урамшуулал олгох, нийгмийн баталгааг сайжруулахад нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагаас дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авах;</p> <p>30.1.8.орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллага, аймаг, нийслэлийн боловсролын газрыг зориулалтын барилга байгууламжаар хангах;</p> <p>30.1.9.ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид сургуулийн автобусаар үйлчлэх журам батлан, үйл ажиллагааг зохион байгуулах;</p>

		<p>30.1.10.орон нутаг дахь насан туршийн суралцахуйн төвийн үйл ажиллагааны болон тогтмол зардлыг санхүүжүүлэх, хамтран ажиллах;</p> <p>30.1.11.хуульд заасан бусад бүрэн эрх.</p>
	<p><b>31 дүгээр зүйл. Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх</b></p>	<p>31.1.Сум, дүүргийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ боловсролын асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>31.1.1.хүүхдэд сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмшүүлэх, иргэнд ерөнхий боловсрол нөхөн эзэмшүүлэх ажлыг дэмжих, хамтран ажиллах;</p> <p>31.1.2.иргэнд насан туршийн суралцахуйн талаарх мэдээллээр хангах, хамтран ажиллах, арга хэмжээ авах;</p> <p>31.1.3.өмчийн хэлбэр үл харгалзан боловсролын сургалтын байгууллагад хууль тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх;</p> <p>31.1.4.өмчийн бүх хэлбэрийн боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, орчны эрүүл, аюулгүй байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;</p> <p>31.1.5.насан туршийн суралцахуйн төвийн бүтэц, орон тоонд нийцүүлэн төсвийг баталж, санхүүжүүлэх, хамтран ажиллах, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх;</p> <p>31.1.6.тухайн нутаг дэвсгэрийн боловсролын сургалтын байгууллагын чанар, гүйцэтгэл, хүртээмжийг сайжруулах, шаардлагатай дэмжлэг үзүүлэх;</p> <p>31.1.7.хуульд заасан бусад бүрэн эрх.</p>
	<p><b>32 дугаар зүйл. Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх</b></p>	<p>32.1.Баг, хорооны Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ боловсролын асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>32.1.1.тухайн нутаг дэвсгэрийн цэцэрлэг болон ерөнхий боловсролын сургуульд хамрагдах насны хүүхдийн боловсрол эзэмших үйл ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;</p> <p>32.1.2.нутаг дэвсгэрийн хэмжээнд иргэдийн сургууль завсардалт гаргахгүй байх, сургууль завсардсан хүүхдийг сургалтад хамруулахад дэмжлэг үзүүлэх;</p> <p>32.1.3.тухайн нутаг дэвсгэрийн боловсролын сургалтын байгууллагын чанар, гүйцэтгэл, хүртээмжийг сайжруулах, шаардлагатай дэмжлэг үзүүлэх;</p> <p>32.1.4.хуульд заасан бусад бүрэн эрх.</p>

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

### БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай	<b>15 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх</b>	15.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 15.2.1.Зөвлөлийн даргаар томилогдон ажиллах хугацаанд Зөвлөлийн даргын бүрэн эрхийг хэрэгжүүлэх; 15.2.2.тухайн бүс нутгийн хөгжлийн асуудлаар Зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, түүний үйл ажиллагаанд бүх талын дэмжлэг үзүүлэх; 15.2.3.бүс нутгийн хөгжилд улсын төсвөөс оруулж буй хөрөнгө оруулалт болон санхүүгийн бусад дэмжлэгийг зориулалтын нь дагуу үр ашигтай ашиглах; 15.2.4.бүс нутгийн хөгжлийн талаар хийж байгаа ажлын үр дүнг Зөвлөлд тайлагнах; 15.2.5.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 7 дугаар сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

### ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай	<b>9 дүгээр зүйл. Төрийн байгууллага, албан тушаалтны бүрэн эрх</b>	<p>9.6.Аймаг, нийслэлийн Засаг дарга харьяалах сум, дүүрэгт нь оршин суугаа гадаадын иргэний хаягийн бүртгэлийн мэдээг нэгтгэн хагас жил тутам гаргаж гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад өгөх үүрэгтэй.</p> <p>9.7.Сум, хорооны Засаг дарга гадаадын иргэний асуудлаар дараахь эрх, үүрэгтэй.</p> <p>9.7.1.нутаг дэвсгэртээ оршин суугаа гадаадын иргэний хаягийн бүртгэл хөтлөх;</p> <p>9.7.2.гадаадын иргэний оршин суугаа газрын талаар тодорхойлолт гаргах;</p> <p>9.7.3.гадаадын иргэн гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах талаар холбогдох байгууллага, албан тушаалтантай хамтран ажиллах;</p> <p>9.7.4.хуульд заасан бусад эрх, үүрэг.</p>
	<b>26 дугаар зүйл. Гадаадын иргэний хаягийн бүртгэл</b>	<p>26.1.Монгол Улсад хувийн хэргээр болон энэ хуулийн 32.2-т заасан оршин суугч гадаадын иргэн 14 хоногийн дотор сумын Засаг даргын Тамгын газарт, эсхүл хорооны Засаг даргад хаягийн бүртгэл хийлгэнэ.</p> <p>26.2.Энэ хуулийн 26.1-д заасан гадаадын иргэн оршин суугаа хаягаа өөрчилбөл анх бүртгүүлсэн газартаа мэдэгдэн хасалт хийлгэж, шилжин очсон сумын Засаг даргын Тамгын газарт, эсхүл хорооны Засаг даргад 14 хоногийн дотор хаягийн бүртгэл хийлгэнэ.</p>

---o0o---





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 7 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

### ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Газрын тосны тухай	<b>10 дугаар зүйл. Нутгийн удирдлагын байгууллагын эрх, үүрэг</b>	<p>10.1.Аймгийн Засаг дарга газрын тосны асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>10.1.1.газрын тосны тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан Засгийн газрын болон харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх, тэдгээрийн биелэлтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах, үр дүнг хариуцах, дэмжлэг үзүүлэх;</p> <p>10.1.2.энэ хуулийн 11.2.17-д заасныг үндэслэн байгуулсан сум, дүүргийн Засаг дарга болон тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгасан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>10.1.3.энэ хуулийн 10.1.2-т заасан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг жил бүр газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан Засгийн газарт танилцуулах;</p> <p>10.1.4.хязгаарласан, эсхүл хориглосноос бусад тохиолдолд газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайд зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулахад бүх төрлийн дэмжлэг үзүүлэх;</p> <p>10.1.5.харьяалах нутаг дэвсгэрт газрын тосны салбарын талаар хэрэгжиж байгаа шийдвэрийг жил бүр олон нийтэд мэдээлэх;</p> <p>10.1.6.газрын тосны тухай хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах.</p> <p>10.2.Сумын Засаг дарга газрын тосны асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>10.2.1.харьяалах нутаг дэвсгэртээ тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг зориулалтаар нь ашиглуулах, эзэмшүүлэхэд хяналт тавих, зөрчил гаргавал зөрчлийг таслан зогсоох, арилгуулах;</p> <p>10.2.2.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, хуулиар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих;</p> <p>10.2.3.энэ хуулийн 11.2.17-д заасныг үндэслэн тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгасан гэрээ</p>

		<p>байгуулах, хэрэгжүүлэх, харьяалах дээд шатны Засаг даргад тайлагнах;</p> <p>10.2.4.харьяалах нутаг дэвсгэрт газрын тосны салбарын талаар хэрэгжиж байгаа шийдвэрийг жил бүр олон нийтэд мэдээлэх;</p> <p>10.2.5.газрын тосны тухай хууль тогтоомж, Засгийн газар болон харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийг хэрэгжүүлэх.</p> <p>10.3.Багийн Засаг дарга газрын тосны асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>10.3.1.газрын тосны тухай хууль тогтоомж, Засгийн газрын болон харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг хариуцах;</p> <p>10.3.2.энэ хуулийн 10.2.2-т заасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаа талаар дээд шатны Засаг даргад санал өгөх;</p> <p>10.3.3.энэ хуулийн 11.2.17-д заасан гэрээнд санал өгөх.</p>
	<p><b>11 дүгээр зүйл.</b> <b>Гэрээлэгчийн эрх, үүрэг</b></p>	<p>11.2.17.ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгасан гэрээг тухайн тусгай зөвшөөрлийн талбай орших сум, дүүргийн Засаг даргатай байгуулж ажиллах;</p>

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 06 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

### ГАЗРЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
ГАЗРЫН ТУХАЙ	<b>8 дугаар зүйл. Хилийн цэс, газар усны нэр, газар усны нэрийн болон газрын сангийн зураг</b>	<p>8.1.Аймаг, сум, нийслэл, дүүрэг бүр хилийн цэс, газар усны нэрийн болон газрын сангийн зурагтай байна.</p> <p>8.3.Аймаг, сум, нийслэл, дүүргийн хилийн цэсийн, газар усны нэрийн болон газрын сангийн зургийг тухайн шатны Засаг дарга, улсын хэмжээний иж бүрэн хувийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус тус хадгална.</p> <p>8.5.Газар усны албан ёсны нэрийг зөвхөн Улсын Их Хурал өөрчилнө.</p> <p>8.6.Албан ёсны баримт бичиг болон арга хэмжээнд газар усны давхар нэр хэрэглэх, газар усны албан ёсны нэрийг монгол хэлнээс бусад хэлээр орчуулах, бусад хэлний дуудлагаар галиглан бичихийг хориглоно.</p>
	<b>20 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын нийтлэг бүрэн эрх</b>	<p>20.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга газрын харилцааны талаар дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>20.2.1.нутаг дэвсгэртээ газрын талаар төрөөс явуулах нэгдсэн бодлого, газрын тухай хууль тогтоомж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж хангах;</p> <p>20.2.2.газар эзэмшигч, ашиглагчаас газар, түүний баялгийг хууль тогтоомж, гэрээний дагуу үр ашигтай, зохистой ашиглаж, хамгаалж байгаад хяналт тавих, зөрчлийг арилгах шийдвэр гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулах;</p> <p>20.2.3.аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, түүнд нийцүүлэн боловсруулсан сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;</p> <p>20.2.4.засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухайн нэгжийн газрын нэгдмэл сангийн тайланг жил бүр хянан нэгтгэж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх, дээд шатны Засаг дарга, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тайлагнах;</p>

	<p>20.2.5.газрыг тусгай хэрэгцээнд авах тухай асуудлыг газар эзэмшигч болон тухайн шатны Засаг даргатай тохиролцсоны дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;</p> <p>20.2.6.газрын төлөв байдлыг илэрхий доройтуулсан нь мэргэжлийн эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон бол тухайн газрыг албадан чөлөөлүүлэх шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>20.2.7.газар эзэмшүүлэх, ашиглуулахтай холбогдсон доод шатны Засаг даргын хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, зөрчлийг арилгах арга хэмжээ авах;</p> <p>20.2.8.аймаг, нийслэлийн газрын албаны даргыг Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргатай зөвшилцөж аймаг, нийслэлийн Засаг дарга, дүүргийн газрын албаны даргыг нийслэлийн газрын албаны даргатай зөвшилцөж дүүргийн Засаг дарга тус тус томилох, чөлөөлөх;</p> <p>20.2.9.газар эзэмшигч, ашиглагч нь хууль тогтоомж, гэрээнд заасан үүргээ хангалтгүй биелүүлснээс байгаль орчинд сөргөөр нөлөөлж байгаа тухай иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан санал, гомдлын талаар мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг гаргуулах хүсэлтээ газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргах.</p> <p>20.3.Аймаг, нийслэл, дүүргийн газрын албаны даргыг газрын харилцааны зохих мэргэжилтэй иргэдээс Төрийн албаны тухай хуулийн 25, 26, 27 дугаар зүйлд заасны дагуу сонгон шалгаруулж томилно.</p>
<p><b>21 дүгээр зүйл. аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх</b></p>	<p>21.3.Аймгийн Засаг дарга газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>21.3.1.сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд чиглэл өгөх;</p> <p>21.3.2.аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу аймгийн төвийн инженерийн шугам, сүлжээ бүхий газруудад газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэнэ. Уг асуудлыг шийдвэрлэхэд тухайн сумын Засаг даргын саналыг авсан байна.</p> <p>21.4.Сумын Засаг дарга газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>21.4.1.аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төсөлд санал өгөх;</p> <p>21.4.2.аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу нутаг дэвсгэрийнхээ тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;</p> <p>21.4.3.энэ хуулийн 21.3.2-т зааснаас бусад газрыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу сумын хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэж, зохион байгуулах.</p>

<p><b>22 дугаар зүйл. Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх</b></p>	<p>22.2.Баг, хорооны Засаг дарга газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 22.2.1.газрын тухай хууль тогтоомж, газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах талаархи нийтлэг шаардлагын биелэлтийг хангуулах; 22.2.2.дээд шатны байгууллага болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас газрын ашиглалт, хамгаалалтын талаар гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах; 22.2.3.нутаг дэвсгэртээ нийтийн эдэлбэрийн газрын ашиглалт, хамгаалалт, эрүүл ахуй, ариун цэврийн асуудлыг хариуцах.</p>
<p><b>26 дугаар зүйл. Газрын кадастр, газрын нэгдмэл сангийн тайлан</b></p>	<p>26.5.Газрын нэгдмэл сангийн сум, дүүргийн тайланг Засаг дарга тухайн оны 12 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар тасалбар болгон гаргаж, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргад; газрын нэгдмэл сангийн аймаг, нийслэлийн тайланг Засаг дарга дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тус тус гаргаж өгнө.</p>
<p><b>33 дугаар зүйл. Газар эзэмшүүлэх шийдвэр гаргах</b></p>	<p>33.1.Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газар эзэмшүүлэх асуудлыг дараахь журмыг баримтлан шийдвэрлэнэ: 33.1.1.энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан болон төсөвт байгууллагад зайлшгүй хэрэгцээтэй газрыг эзэмшүүлэх тухай шийдвэрийг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөний дагуу тухайн шатны Засаг дарга гаргана; 33.1.2.энэ хуулийн 33.1.1-д зааснаас бусад зориулалтаар болон энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан хэмжээнээс илүү газар эзэмших хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх асуудлыг тухайн шатны Засаг дарга дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ. Төсөл шалгаруулах, дуудлага худалдаа явуулах журмыг Засгийн газар тогтооно. 33.2.Энэ хуулийн 33.1.2-т заасан шийдвэрийн дагуу газар эзэмших эрх авсан этгээд нь заасан хугацаанд газар эзэмших эрхийн гэрчилгээний үнийг төлөөгүй бол уг эрхийн гэрчилгээг дахин дуудлага худалдаанд оруулна. 33.3.Эрхийн гэрчилгээгээр газар эзэмшүүлэх шийдвэрийн талаар үүссэн маргааныг энэ хуулийн 60.1.1-д заасны дагуу шийдвэрлэнэ. 33.4.Хорих ангийн гадна хориотой бүс болон аймаг, сум, нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд эзэмшүүлж болохоор зааснаас бусад газарт газар эзэмшүүлэхийг хориглоно. 33.5.Энэ хуулийн 33.1.2-т заасны дагуу төсөл шалгаруулах хэлбэрээр газар эзэмших эрхийг зөвхөн улсын төсвийн</p>

	<p>хөрөнгө оруулалтаар эсхүл гадаад улс, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт зориулж олгоно.</p> <p>33.6.Усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүс болон ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсэд иргэн, хуулийн этгээдэд газар ашиглуулах, эзэмшүүлэхийг хориглоно.</p> <p>33.7.Эрх бүхий этгээд газар эзэмшүүлэх, ашиглуулах тухай шийдвэр гаргаснаас хойш ажлын 15 өдрийн дотор энэ тухай мэдээллийг Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд оруулна.</p>
<p><b>36 дугаар зүйл.</b> <b>Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны үнэ, үйлчилгээний хураамж</b></p>	<p>36.1.Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан аргачлалын дагуу тухайн шатны Засаг дарга тогтооно.</p>
<p><b>37 дугаар зүйл.</b> <b>Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгах</b></p>	<p>37.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хугацаа сунгуулах тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор эрхийн гэрчилгээ эзэмших нөхцөлийг хангаж ажилласан эсэхийг хянаж, түүнийг хангасан тохиолдолд газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгах шийдвэр гаргана.</p>
<p><b>38 дугаар зүйл.</b> <b>Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх</b></p>	<p>38.1.Газар эзэмших эрхийн гэрчилгээг хуулиар зөвшөөрсөн хэлбэрээр бусдад шилжүүлж, барьцаалж болно. Эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх, барьцаалах үйл ажиллагаа нь зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд явагдана.</p> <p>38.2.Эрхийн гэрчилгээг шилжүүлэх хүсэлтийг талууд гаргах бөгөөд дараахь баримт бичгийг хавсаргана: Уг баримт бичгийн бүрдүүлбэрийг тус хуулийн 38.2 дахь хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.</p> <p>Эрхийн гэрчилгээг шилжүүлэх тухай хүсэлтийг тухайн шатны Засаг дарга хүлээн авч</p> <p>38.3.Эрхийн гэрчилгээ шилжүүлэх тухай хүсэлтийг тухайн шатны Засаг дарга хүлээн авч дараахь зүйлүүдийг тодруулна:</p> <p>Уг тодруулах зүйлийг тус хуулийн 38.3 дахь хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.</p>
<p><b>39 дүгээр зүйл.</b> <b>Газар эзэмших эрх дуусгавар болох</b></p>	<p>39.1.Газар эзэмших эрх дараахь тохиолдолд дуусгавар болно:</p> <p>39.1.1.газар эзэмших эрхийн гэрчилгээ болон газар эзэмших гэрээний хугацаа дуусахад сунгуулах хүсэлт гаргаагүй;</p> <p>39.1.2.газар эзэмшигч иргэн нас барсан, нас барсан гэж зарлагдсан, сураггүй алга болсонд тооцогдсон бөгөөд</p>

		<p>түүний хууль ёсны өв залгамжлагч байхгүй нь тогтоогдсон, газар эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага татан буугдсан;  39.1.3.эзэмшигч газар эзэмших гэрээгээ цуцлах тухай хүсэлт гаргасан;  39.1.4.газар эзэмших эрхийн гэрчилгээ хүчингүй болсон;  39.1.5.газрыг тусгай хэрэгцээнд авч нөхөх олговрыг газар эзэмшигчид бүрэн төлсөн.</p>
	<p><b>40 дүгээр зүйл.  Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох</b></p>	<p>40.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараахь тохиолдолд газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгоно:  40.1.1.эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын тухай хууль тогтоомж, газар эзэмших гэрээний нөхцөл, болзлыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;  40.1.2.газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашигласан нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон;  40.1.3.шилжүүлж авсан эрхийн гэрчилгээгээ улсын бүртгэлд бүртгүүлж, шинээр гэрээ байгуулаагүй;  40.1.4.байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй, энэ хуулийн 31.4-т заасны дагуу палеонтологи, археологи, угсаатны урьдчилсан хайгуул, судалгаа хийлгээгүй, зөвшөөрөл аваагүй нь тогтоогдсон;  40.1.5.эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй;  40.1.6.хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй.  40.1.7.газар эзэмших эрхтэй этгээд нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 30.6, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 17.2-д заасны дагуу холбогдох татварыг тодорхойлж тайлагнаагүй, үнэлгээ тооцоход шаардагдах мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулсан, худал мэд40.2.Энэ хуулийн 40.1-д заасан үндэслэл тогтоогдвол аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон захирамж гаргаж, энэ тухайгаа эрхийн гэрчилгээ эзэмшиж байсан буюу түүнийг барьцаалсан этгээдэд мэдэгдэнэ.  40.3.Эрхийн гэрчилгээ эзэмшигч болон барьцаанд авсан этгээд нь Засаг даргын шийдвэрийг хууль бус гэж үзвэл тухайн шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй.  40.4.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон шийдвэрээ газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж улсын бүртгэлд тусгуулна.  40.5.Эрхийн гэрчилгээ эзэмшигч болон барьцаалагч шүүхэд гомдол гаргасан тохиолдолд шүүхийн хүчин төгөлдөр</p>

		шийдвэр гартал тухайн газрыг эзэмших эрхийн гэрчилгээ шинээр олгохгүй.үүлж тайлагнасан.
	<b>41 дүгээр зүйл. Газар эзэмших эрх дуусгавар болоход газрыг чөлөөлөх</b>	<p>41.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрх дуусгавар болоход хууль болон газар эзэмших гэрээнд өөрөөр заагаагүй бол 90 хоногийн дотор уг газрыг чөлөөлж аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын мэдэлд шилжүүлнэ.</p> <p>41.2.Энэ хуулийн 39.1.1-39.1.4-т заасан үндэслэлийн дагуу газар чөлөөлөхтэй холбогдон гарах зардлыг газар эзэмшиж байсан этгээд өөрөө хариуцна.</p> <p>41.3.Эзэмшлийн газар нь гамшиг, аюулт үзэгдэл, осолд нэрвэгдэж, цаашид тухайн зориулалтаар ашиглах боломжгүй болсон тухай мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн газар эзэмшигч газар эзэмших гэрээгээ цуцлах тухай хүсэлт гаргасан бол уг газрыг засаж тохижуулах зардлыг шаардлагатай тохиолдолд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж болно. Харин уг газар дээрх барилга, байгууламж, бусад эд хөрөнгийг шилжүүлэх зардлыг газар эзэмшиж байсан этгээд өөрөө хариуцна.</p> <p>41.4.Энэ хуулийн 41.1-д заасан хугацаанд газраа чөлөөлөөгүй бол тухайн шатны Засаг дарга албадан нүүлгэх ажлыг зохих хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна.</p>
	<b>44 дүгээр зүйл. Газар ашиглуулах</b>	44.4.Монгол Улсад байнга /183 хоногоос дээш хугацаагаар/ оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд газрыг зөвхөн гэр бүлийн хамтын хэрэгцээний нь зориулалтаар ашиглуулах асуудлыг дуудлага худалдааны зарчмаар тухайн шатны Засаг дарга шийдвэрлэнэ.
	<b>51 дүгээр зүйл. Газрыг ашиглах эрүүл ахуйн шаардлага</b>	<p>51.2.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчны тэнцвэрт байдал, хүн амын эрүүл мэнд, мал, амьтан, агаар, ой, ус, ургамалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламж барих, тоног төхөөрөмж байршуулах, үйлдвэрийн хаягдал, бохир ус, хортой болон бусад бодисыг газрын дор хадгалах, булах ажлыг мэргэжлийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр гүйцэтгэнэ.</p> <p>51.3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 51.2-т заасан ажлыг гүйцэтгэхийн өмнө энэ тухайгаа тухайн шатны Засаг даргад урьдчилан мэдэгдэж, хүн амд мэдээлэн, уг газрын заагийг тэмдэгжүүлж, сэрэмжлүүлэх байнгын дохио тэмдэгтүүд өөрийн хөрөнгөөр байрлуулна.</p>
	<b>52 дугаар зүйл. Бэлчээр, түүнийг зохистой ашиглах, хамгаалах</b>	<p>52.1.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн нутгийн онцлог, бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг харгалзан өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, отрын нөөц нутаг гэсэн ерөнхий хуваарийн дагуу газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган батална.</p> <p>52.2.Зуслан, намаржаа болон отрын бэлчээрийг баг, хот айлаар хуваарилж нийтээр ашиглана. Тухайн жилийн</p>



		<p>бэлчээрийн гарц, иргэдийн саналыг харгалзан өвөлжөө, хаваржааны бэлчээрийг малаас чөлөөлөх, мал оруулах хугацааг сум, дүүргийн Засаг дарга тогтоож, баг, хорооны Засаг дарга, иргэд мөрдөж хэрэгжүүлнэ. Өвөлжөө, хаваржааны тодорхой нутаг бэлчээрийг талхлагдахаас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор тухайн бүс нутгийн онцлог, бэлчээр ашиглаж ирсэн уламжлал, газрын даац, чадавхийг харгалзан, багийн иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн сумын Засаг дарга малчдад болзол, гэрээний дагуу хэсэг бүлгээр ашиглуулж болно.</p> <p>52.3.Ойн сан бүхий газрыг зохих хууль тогтоомжийн дагуу бэлчээрт ашиглаж болно.</p> <p>52.5.Эрчимжсэн суурин мал аж ахуй эрхлэх болон тэжээвэр амьтныг өсгөн үржүүлэх зорилгоор хашсан бэлчээрийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад улирал харгалзахгүй тодорхой болзол, гэрээний дагуу ашиглуулж болно.</p> <p>52.6.Энэ хуулийн 52.1-д заасан ерөнхий хуваарь, 52.4, 52.5-д заасан газрын хэмжээ болон уг газрыг ашиглуулахтай холбогдсон журмыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.</p> <p>52.7.Өвөлжөө, хаваржааны доорхи газрыг Монгол Улсын иргэн хот айлаар дундаа хамтран эзэмшиж болно.</p> <p>52.8.Гамшиг, аюулт үзэгдэл, ослын улмаас өөр аймаг, сумын нутаг дэвсгэрт нүүдэллэх шаардлага гарвал тухайн шатны Засаг дарга нар уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Хэрэв тохиролцохгүйд хүрвэл уг асуудлыг дээд шатны Засаг дарга буюу Засгийн газар шийдвэрлэнэ.</p> <p>52.9.Гамшиг, аюулт үзэгдэл тохиолдсон үед ашиглах сум дундын отрын нөөц нутаг, түүний заагийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймаг дундын отрын нөөц нутаг, түүний заагийг орон нутгийн удирдлагын хүсэлтийг харгалзан Засгийн газар тогтооно.</p> <p>52.10.Бэлчээр ашиглах асуудлаар гарсан аливаа маргааныг багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж зохицуулна. Эс тохиролцсон тохиолдолд сумын Засаг дарга шийдвэрлэнэ.</p>
	<p><b>53 дугаар зүйл. Хадлангийн талбайг зохистой ашиглах, хамгаалах</b></p>	<p>53.1.Сум, дүүргийн Засаг дарга мэргэжлийн эрх бүхий байгууллагатай хамтран хадлангийн талбайд газар зохион байгуулалтын арга хэмжээ авч, түүний хэрэгжилтийг хангана.</p> <p>53.2.Сум, дүүргийн Засаг дарга хадлан авах бололцоотой талбайг жил бүр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулахаар баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн хуваарилж, түүний хэрэгжилтийг зохион байгуулна.</p> <p>53.3.Газрын нэгдмэл сангийн ангилалд бүртгэгдсэн хадлангийн талбайд 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хадлан авч дуустал мал бэлчээхийг хориглоно.</p>

		<p>53.4.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага сум, дүүргийн Засаг даргатай тохиролцон бэлчээрийн зохих ургацтай хэсгийг хадлангийн талбай болгон ашиглаж болно. Энэ нь газрын нэгдмэл сангийн ангилалд бүртгэгдсэн хадлангийн газарт хамаарахгүй.</p> <p>53.5.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн, хадлангийн талбайг усалгаатай болгох, хамгаалах, бордох, ойн зурвас тарих зэргээр өөрийн хүч, хөрөнгөөр сайжруулалт хийж, ургацыг нь тогтвортой дээшлүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад сумын Засаг дарга уг талбайг нь эзэмшүүлж болно.</p>
	<p><b>54 дүгээр зүйл.</b> <b>Тариалангийн талбайг зохистой ашиглах, хамгаалах</b></p>	<p>54.1.Энэ хуулийн 29.2, 29.3, 29.5-д зааснаас бусад тохиолдолд шинээр тариалангийн талбай бий болгох асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.</p> <p>54.2.Тариалангийн зориулалтаар газар эзэмшиж, ашиглаж байгаа этгээд хөрсийг хамгаалах, түүний үржил шимийг бууруулахгүй байх арга хэмжээ байнга авч, хууль тогтоомжид заасан хугацаа, журмын дагуу тухайн газарт агрохимийн шинжилгээ хийлгүүлнэ.</p> <p>54.3.Тариалангийн газрыг өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн албан ёсны зөвшөөрөлгүйгээр тухайн газарт мал, амьтан оруулах, бэлчээхийг хориглоно.</p> <p>54.4.Тариалангийн газрыг эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг багийн иргэдийн Нийтийн Хурлын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн сумын Засаг дарга зохион байгуулна.</p>
	<p><b>56 дугаар зүйл.</b> <b>Хот, тосгон, бусад суурины газрыг зохистой ашиглах, хамгаалах</b></p>	<p>56.4.Хот, тосгон бусад суурины доторх бусдын эзэмшил, ашиглалтад олгогдоогүй газрыг тухайн шатны Засаг дарга шийдвэр гаргаж, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу ашиглалтын зориулалт, ашиглаж эхлэх хугацаа бусад нөхцөл шаардлагуудыг бичсэн дохио, санамж тавих, хашаа, хайс татах, сахиул ажиллуулах зэргээр хамгаалалтад авна.</p> <p>56.6.Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана.</p>
	<p><b>57 дугаар зүйл.</b> <b>Газрын нэгдмэл санд төрийн хяналт тавих</b></p>	<p>57.3.Зохих зөвшөөрөлгүйгээр газар дээр барилга, байгууламж барьсан, эсхүл бусад хэлбэрээр түүнийг дур мэдэн эзэмшсэн бол аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга уг газрыг чөлөөлөх тухай хугацаатай мэдэгдэл өгнө.</p> <p>57.4.Мэдэгдэлд заасан хугацаанд газрыг чөлөөлөөгүй бол аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга уг газрыг албадан чөлөөлөх арга хэмжээ авч, холбогдох зардлыг гэм буруутай этгээдээс гаргуулна.</p> <p>57.5.Энэ хуулийн 57.4-т зааснаар газрыг чөлөөлөөгүй бол уг барилга, байгууламжийг шаардлагатай гэж үзвэл төрийн өмчлөлд үнэ төлбөргүй шилжүүлнэ.</p>

<p><b>58 дугаар зүйл. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, түүнийг гаргах</b></p>	<p>58.6.Эрхийн гэрчилгээгээр эзэмшиж, ашиглаж буй газрын төлөв байдал, чанарыг газар эзэмшигч, ашиглагч, улсын болон аймаг, сум, нийслэлийн тусгай хэрэгцээний газрын төлөв байдал, чанарыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэл, сумын Засаг дарга, бусад газрын төлөв байдал, чанарыг тухайн шатны Засаг дарга тус тус хариуцна.</p>
<p><b>59 дүгээр зүйл. Газрын харилцааны талаархи цагдаагийн байгууллагын үүрэг</b></p>	<p>59.1.Газар чөлөөлүүлэх, албадан нүүлгэхэд цагдаагийн байгууллага дараахь үүрэгтэй: 59.1.1.хууль, гэрээнд заасан үндэслэлээр газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болсон, эсхүл зохих зөвшөөрөлгүйгээр газар эзэмшсэн, ашигласан бол албадан нүүлгэх тухай Засаг даргын шийдвэрийн биелэлтийг хангах; 59.1.2.газар чөлөөлүүлэх, албадан нүүлгэхэд хүч хэрэглэсэн буюу зохион байгуулалттайгаар саатуулсан, эсэргүүцсэн бол зохих журмын дагуу арга хэмжээ авах.</p>
<p><b>60 дугаар зүйл. Газартай холбогдон үүссэн маргааныг хянан шийдвэрлэх</b></p>	<p>60.1.Газартай холбогдон үүссэн дараахь маргааныг дор дурдсан байгууллага, албан тушаалтан шийдвэрлэнэ: 60.1.1.газар эзэмших, ашиглах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон Засаг даргын хооронд үүссэн маргааныг тухайн Засаг даргын дээд шатны Засаг дарга; 60.1.2.газар эзэмших, ашиглах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүссэн маргаан, газар ашиглах гэрээний нөхцөл, болзлын талаар газар эзэмшигч ба ашиглагчийн хооронд үүссэн маргааныг зохих шатны Засаг дарга; 60.1.3.газрын төлөв байдал, чанар, түүнийг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах талаар үүссэн маргааныг хууль тогтоомжийн дагуу зохих мэргэжлийн байгууллагын хяналт хариуцсан албан тушаалтан буюу тухайн шатны Засаг дарга;</p>
<p><b>61 дүгээр зүйл. Хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, үйлдлийг таслан зогсоох</b></p>	<p>61.1.Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан өөрийн шийдвэр, үйлдэл /эс үйлдэхүй/-ээрээ газрын тухай хууль тогтоомж, газар эзэмшигч, ашиглагчийн хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол уг байгууллага, албан тушаалтан өөрөө буюу түүний дээд шатны байгууллага, албан тушаалтан, эсхүл шүүх уг хууль бус шийдвэрийг хүчингүй болгож, үйлдлийг таслан зогсооно.</p>

---оОо---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1998 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

### ГАЗРЫН ХЭВЛИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Газрын хэвлийн тухай	<b>7 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх</b>	<p>2.Аймаг, нийслэлийн Засаг дарга газрын хэвлийг судлах, ашиглах, хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>1/нутаг дэвсгэртээ газрын хэвлийг судлах, ашиглах, хамгаалах талаархи төрийн бодлогыг хэрэгжүүлж, газрын хэвлийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, мөн хуульд заасан эрх хэмжээний дотор аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулж хангах;</p> <p>2/нутаг дэвсгэртээ хийгдсэн геологийн судалгааны болон нутаг дэвсгэртээ оршиж байгаа ашигт малтмалын талаархи мэдээллийг зохих журмын дагуу холбогдох аж ахуйн нэгж, байгууллагаас гаргуулан авч танилцах;</p> <p>3/нутаг дэвсгэртээ улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа бүх төрлийн геологийн судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх;</p> <p>4/энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасан тохиолдолд газрын хэвлийг ашиглах эрхийг хуульд заасан эрх хэмжээнийхээ дотор дуусгавар болгох;</p> <p>5/газрын хэвлийг дур мэдэн ашиглах болон ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж дур мэдэн барихыг зогсоох;</p> <p>6/хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</p>
	<b>8 дугаар зүйл. Сумын Засаг даргын бүрэн эрх</b>	<p>2.Сум, дүүргийн Засаг дарга газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>1/нутаг дэвсгэртээ газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаархи төрийн бодлогыг хэрэгжүүлж, газрын хэвлийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, мөн хуульд заасан эрх хэмжээнийхээ дотор сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулж хангах;</p> <p>2/нутаг дэвсгэртээ газрын хэвлийн баялгийг ашиглуулахтай холбогдуулан эдэлбэр газар олгох;</p> <p>3/ашигт малтмалын нөөцийг илрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;</p> <p>4/ердийн ашигт малтмал, газар доорхи цэнгэг усыг ашиглах тухай саналыг холбогдох байгууллагад тавих;</p> <p>5/ердийн ашигт малтмалын ордыг зохистой ашиглах болон газрын хэвлийг ашиглах явцад эвдэрсэн газрыг аюул осолгүй болгож, аж ахуйн хэрэгцээнд цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулахад хяналт тавих, засаж тохижуулсан газрыг хүлээн авах;</p>

	6/хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.
<b>8<sup>1</sup> дүгээр зүйл. Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх</b>	2.Баг, хорооны Засаг дарга газрын хэвлийг судлах, ашиглах, хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/нутаг дэвсгэртээ газрын хэвлийг судлах, ашиглах, хамгаалах талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлж, газрын хэвлийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын болон дээд шатны Засаг даргын шийдвэр, мөн хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулж хангах; 2/нутаг дэвсгэртээ улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх бүх төрлийн геологийн судалгааны ажил болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайд хувийн хөрөнгөөр гүйцэтгэх хайгуулын ажлаар ашигт малтмалын нөөцийг илрүүлэхэд дэмжлэг үзүүлэх; 3/хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.
<b>12 дугаар зүйл. Геологийн судалгаа хийхэд зориулан ашиглуулахаар газрын хэвлийг олгох</b>	2.Геологийн судалгаа хийгч нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйл ажиллагаагаа явуулах тухайгаа сум, дүүргийн Засаг даргад бүртгүүлсний дараа ажлаа эхэлнэ.
<b>15 дугаар зүйл. Ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар ашиглуулахаар газрын хэвлийг олгох</b>	1.Ашигт малтмал олборлох, газар доор нефть, хий, бусад бодис, материал хадгалах, хортой бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг хамгаалан булах, бохир ус зайлуулахаас өөр зориулалтаар ашиглуулахаар газар доор барилга байгууламж барих, ашиглахад зориулан газрын хэвлийг дор дурдсан байгууллага, албан тушаалтан олгоно: 1/улсын болон аймаг, нийслэлийн чанартай барилга байгууламж барих, ашиглахад зориулан тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга; 2/орон нутгийн чанартай барилга байгууламж барих, ашиглахад зориулан тухайн сум, дүүргийн Засаг дарга. 3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшил газрынхаа хилийн дотор ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар аж ахуйн болон ахуйн хэрэгцээндээ зориулан тухайн сум, дүүргийн Засаг даргаас тогтоосон журмын дагуу газрын хэвлийг ашиглах эрхтэй 4.Газар доор нефть, хий, бусад бодис, материал хадгалах, хортой бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг хамгаалан булах, бохир ус зайлуулах зориулалттай барилга байгууламж барих, ашиглахад зориулан газрын хэвлийг тухайн аймаг, нийслэлийн Засаг даргын зөвшөөрлийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга олгоно.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 7 дугаар сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

### ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Галын аюулгүй байдлын тухай	<b>15 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын үүрэг</b>	<p>15.1.Галын аюулгүй байдлыг хангах талаар аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараах үүрэг хүлээнэ:</p> <p>15.1.1.холбогдох хууль тогтоомж, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичиг болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, дээд шатны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх;</p> <p>15.1.2.хот, суурин газрын төлөвлөлт, газар олголтод гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх байгууллагын дүгнэлтийг үндэслэх;</p> <p>15.1.3.гал түймэртэй тэмцэх, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар нутаг дэвсгэртээ сургалт, сурталчилгаа зохион байгуулах;</p> <p>15.1.4.нутаг дэвсгэртээ гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг ажиллуулах зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган шийдвэрлүүлэх;</p> <p>15.1.5.гал түймэр унтраах аврах анги, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангах;</p> <p>15.1.6.ой, хээрийн гал түймэр гарсан үед бүрэн эрхийн хүрээнд хүн хүч, техник хэрэгслийг дайчлан тухайн гал түймрийг унтраах ажлыг шуурхай зохион байгуулах, ажлын явцыг холбогдох байгууллагад шуурхай мэдээлэх;</p> <p>15.1.7.ой, хээрийн гал түймрийн эрсдэл өндөртэй газарт түймэр тархахаас урьдчилан сэргийлэх зурвас шинээр байгуулах, зурвасыг сэргээх төсөв, төлөвлөгөөг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, батлуулж, хэрэгжүүлэх;</p> <p>15.1.8.гал түймэрт дайчлагдах хүн хүч, техник хэрэгслийн тоо хэмжээг тодорхой тогтоосны үндсэн дээр ой, хээрийн гал түймрийг унтраах багаж, техник хэрэгслээр хангах.</p>

---о0о---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар 02-ны өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Гамшгаас хамгаалах тухай	<b>10 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах</b>	10.1.Гамшгаас хамгаалах бэлэн байдал нь дараах зэрэгтэй байна: 10.1.1.өдөр тутмын бэлэн байдал; 10.1.2.өндөржүүлсэн бэлэн байдал; 10.1.3.бүх нийтийн бэлэн байдал. Дээрх төрлөөс хамаараад бэлэн байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ тус бүрийг тус хуулийн 10.3, 10.4 дүгээр хэсгээс дэлгэрүүлж авч үзнэ үү.
	<b>11 дүгээр зүйл. Бэлэн байдлын зэрэгт болон олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлд шилжүүлэх</b>	11.2.Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт бүрэн, эсхүл хэсэгчилсэн байдлаар, шат дараалан, эсхүл шууд шилжүүлнэ. 11.2.1.энэ хуулийн 11.2-т заасан "бүрэн" гэдгийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг бүхэлд нь, "хэсэгчилсэн" гэдгийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн зарим хэсэг, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийн тодорхой хэсгийг бэлэн байдлын зэрэгт шилжүүлэхийг ойлгоно. 11.3.Өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх шийдвэрийг дараахь албан тушаалтан гаргана: 11.3.1.сум, дүүргийн нутаг дэвсгэрт холбогдох мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн тухайн сум, дүүргийн Онцгой комиссын дарга; 11.3.2.хоёр буюу түүнээс дээш сум, дүүрэг, аймгийн нутаг дэвсгэрт холбогдох мэргэжлийн байгууллага болон тухайн сум, дүүргийн Онцгой комиссын даргын саналыг үндэслэн тухайн аймаг, нийслэлийн Онцгой комиссын дарга; 11.3.3.улсын хэмжээнд, эсхүл нийслэл болон хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэрт Улсын Онцгой комиссын даргын саналыг үндэслэн Засгийн газар; 11.3.4.шаардлагатай тохиолдолд хариуцсан салбар, байгууллагыг гамшгаас хамгаалах улсын албаны дарга. 11.3.5.олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлийг Засгийн газар тогтооно. 11.4.Энэ хуулийн 11.3-т заасан албан тушаалтны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх саналд нутаг дэвсгэрээр дамжин тархсан, бүс нутгийг хамарсан, хамарч болзошгүй гамшгийн

	цагийн байдлын үнэлгээ, өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх үндэслэлийг тусгаж шийдвэрийн төслийг хавсаргана. 11.6.Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх шийдвэр гаргасан албан тушаалтан бэлэн байдлын зэргийг сунгах, бууруулах, цуцлах шийдвэрийг гаргана.
<b>13 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах</b>	13.3.Гамшгаас хамгаалах сургалтыг дараахь байгууллага, албан тушаалтан зохион байгуулна: 13.3.3.сум, дүүргийн мэргэжлийн анги, гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн сургалтыг тухайн шатны Засаг дарга 13.3.4.иргэний сургалтыг тухайн баг, хорооны Засаг дарга;
<b>17 дугаар зүйл. Голомтын бүс тогтоох</b>	17.1.Голомтын бүсийг доор дурдсан албан тушаалтан тогтооно: 17.1.1.аймаг, нийслэл, сум, дүүргийн нутаг дэвсгэр, объектод хор уршгийг арилгах арга хэмжээг шууд удирдан зохион байгуулж байгаа мэргэжлийн байгууллагын удирдлага, эсхүл мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн тухайн шатны Засаг дарга
<b>21 дүгээр зүйл. Хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаа</b>	21.2.Хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд шаардагдах зардлыг улсын хэмжээнд Засгийн газар, орон нутгийн хэмжээнд тухайн шатны Засаг дарга шийдвэрлэнэ.
<b>22 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт</b>	22.3.Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, шийдвэр гаргах, шуурхай зохион байгуулах, хяналт тавих эрх бүхий Улсын онцгой комиссыг Засгийн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн онцгой комиссыг тухайн шатны Засаг дарга байгуулна. 22.6.Салбар дундын гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, уялдуулан зохицуулах, мэдээ, мэдээлэл солилцох, хүч хэрэгсэл, нөөцийг оновчтой хуваарилах зорилгоор төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, холбогдох бусад байгууллагыг түшиглэн гамшгаас хамгаалах орон тооны бус Улсын албыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, аймаг, сум, нийслэл, дүүрэгт орон нутгийн албыг тухайн шатны Засаг даргын шийдвэрээр байгуулна.
<b>23 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага</b>	23.1.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын хэмжээнд онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн чиглүүлж, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга удирдан зохион байгуулж, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид тухайн шатны Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдэд тэдгээрийн удирдлага зохион байгуулж, хэрэгжүүлнэ. 23.3.Улсын онцгой комиссыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, орон нутгийн онцгой комиссыг тухайн шатны Засаг дарга тэргүүлнэ. 23.4.Улсын онцгой комиссын орлогч дарга нь онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, орон нутгийн онцгой комиссын орлогч дарга нь орон нутгийн онцгой байдлын байгууллагын дарга, сумын онцгой комиссын орлогч дарга нь тухайн сумын Засаг даргын Тамгын газрын дарга байна.



	<b>27<sup>1</sup> дүгээр зүйл.Онцгой комиссын бүрэн эрх</b>	Онцгой комиссын бүрэн эрхтэй холбоотой зохицуулалтыг тус хуулийн 27 <sup>1</sup> дүгээр зүйлээс дэлгэрүүлж авч үзнэ үү.
	<b>32 дугаар зүйл. Засаг даргын бүрэн эрх</b>	<p>32.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга гамшгаас хамгаалах асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>32.1.1.нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, удирдах, хэрэгжүүлэх;</p> <p>32.1.2.нутаг дэвсгэрийн онцлогт нийцүүлэн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийг байгуулах, тэдгээрийг гамшгийн үед үүрэг гүйцэтгэх дадлага, чадвартай болгох;</p> <p>32.1.3.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн эх үүсвэр, гамшгаас хамгаалах болон орон нутгийн нөөцийг бүрдүүлэх, түүнийг захиран зарцуулах;</p> <p>32.1.4.гамшгийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар дээд шатны болон онцгой байдлын байгууллагад мэдээлэх, мэргэжлийн зөвлөгөө, зааварчилгаа, дэмжлэг авах;</p> <p>32.1.5.хууль тогтоомж, дээд шатны байгууллага, албан тушаалтны шийдвэрийн дагуу хүмүүнлэгийн тусламжийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хуваарилах ажлыг зохион байгуулах, тайлагнах;</p> <p>32.1.6.нэрвэгдэгсдэд санхүүгийн болон эд материал, сэтгэл зүйн тусламж, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>32.1.7.гамшгийн эрсдэлийг бууруулах ажиллагаанд иргэдийн оролцоог хангах;</p> <p>32.1.8.гамшгаас хамгаалах хууль тогтоомж, дээд шатны байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг хангах;</p> <p>32.1.9.гамшиг болон аюулын үед нутаг дэвсгэрийн хэмжээнд хүч хэрэгслийг татан оролцуулах;</p> <p>32.1.10.орон нутгийн онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг ажиллах нөхцөл, боломжоор хангах, дэмжлэг үзүүлэх;</p> <p>32.1.11.харилцаа холбоо, зарлан мэдээлэх системийн байнгын бэлэн байдлыг хангах;</p> <p>32.1.12.гамшгийн эрсдэлийн болон гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийлгэж, шаардлагатай арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх;</p> <p>32.1.13.тухайн шатны Засаг дарга нь төв, орон нутагт томилогдон ажиллаж байгаа онцгой байдлын байгууллагын удирдах албан тушаалтныг албан тушаалын орон сууцаар хангах, дэмжлэг үзүүлэх.</p> <p>32.1.14.онцгой байдлын байгууллагын салбар, нэгжгүй сум, суурин газарт гамшгаас хамгаалах асуудлыг Засаг даргын тамгын газрын аль нэг албан тушаалтанд хавсран гүйцэтгүүлнэ.</p> <p>32.2.Баг, хорооны Засаг дарга энэ хуулийн 32.1-д заасан бүрэн эрхээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.</p>

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 10 дугаар сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

### ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Геодези, зураг зүйн тухай	<b>5 дугаар зүйл. Геодези, зураг зүйн үйл ажиллагааны талаархи төрийн байгууллагын бүрэн эрх, чиг үүрэг</b>	<p>5.8. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга геодези, зураг зүйн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>5.8.1. геодези, зураг зүйн үйл ажиллагааны талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах;</p> <p>5.8.2. нутаг дэвсгэртээ хамаарах байр зүйн зураг, зураг зүйн бүтээлд тусгагдах газар зүйн нэр, хил, шинээр байгуулагдсан болон өөрчлөгдсөн объектын талаархи мэдээлэл, геодезийн байнгын цэг, тэмдэгтийн хадгалалт, хамгаалалтанд хяналт тавьж, жил бүр тооллого явуулж дүнг дараа жилийн 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдээлэх;</p> <p>5.8.3. геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгж, иргэн харьяа нутаг дэвсгэрт нь хийж байгаа геодези, зураг зүйн ажилд хяналт тавих;</p> <p>5.8.4. нутаг дэвсгэртээ хамаарах газар зүйн нэрийн хэрэглээнд хяналт тавих, шинэ нэрийн талаар санал дэвшүүлэх.</p>
	<b>10 дугаар зүйл. Геодезийн байнгын цэг, тэмдэгт</b>	<p>10.3. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь геодезийн байнгын цэг, тэмдэгт байрлаж байгаа газарт барилга байгууламж барих, газар шорооны ажил хийхдээ сум, дүүргийн Засаг дарга буюу хил хамгаалах ерөнхий газраар уламжлан геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авна. Уг цэг, тэмдэгтийг хөдөлгөх, нүүлгэн шилжүүлэх зайлшгүй шаардлага гарвал түүнийг сэргээн босгох зардлыг хүсэлт гаргасан байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хариуцна.</p>
	<b>11 дүгээр зүйл. Газар зүйн нэр</b>	<p>11.1. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг газар зүйн албан ёсны нэрийн тухай мэдээллээр хангах, газар зүйн нэрийг зөв бичих, хэрэглэх, хамгаалах асуудлыг сум, дүүргийн Засаг дарга, геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхлэн хамтран зохицуулна.</p>

---oOo---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 06 сарын 06 өдөр

Улаанбаатар хот

### ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай	<b>27 дугаар зүйл. Төрийн байгууллагын үүрэг</b>	Төрийн байгууллагын хүлээх үүрэгтэй холбоотой зохицуулалтыг тус хуулийн 27.1, 30.1 дэх хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.
	<b>28 дугаар зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар нутгийн захиргааны байгууллагын үүрэг</b>	28.1.Нутгийн захиргааны бүх шатны байгууллага гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар дараах үүрэг хүлээнэ: 28.1.1.нутгийн захиргааны бүх шатны байгууллага өөрийн эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлж байгаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг дээд шатны байгууллагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулах; 28.1.2.харьяа нутаг дэвсгэртээ гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулах; 28.1.3.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зардлыг өөрийн төсвөөс тусгайлан төлөвлөж санхүүжүүлэх; 28.1.4.шүүх, прокурор, хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлж байгаа төрийн бус байгууллага, иргэдийн үйл ажиллагаа, санал, санаачилгыг дэмжин туслах; 28.1.5.харьяа нутаг дэвсгэрийн иргэдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулж байгаа ажлын талаар мэдээлэл өгөх; 28.1.6.Салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, боловсронгуй болгох; 28.1.7.нутаг дэвсгэртээ бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн байдалд дүгнэлт хийж, түүний шалтгаан, нөхцөлийг арилгах талаар мэргэжлийн байгууллага, эрдэмтэн, судлаач, шинжээчтэй хамтран ажиллах;

		<p>28.1.8.ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх чиглэлээр идэвх санаачилгатай ажилласан хуулийн этгээд, иргэний үйл ажиллагааг дэмжих;</p> <p>28.1.9.нутаг дэвсгэр хариуцсан хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааны үр нөлөөнд үнэлэлт, дүгнэлт өгөх;</p> <p>28.1.10.хууль тогтоомжид заасан бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэх, шийдвэр гаргахдаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлого баримтлах;</p> <p>28.1.11.харьяа нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа цахим тоглоомын газар, интернэт кафе болон барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхлэгчид тавих шаардлага, ажиллах цагийн хуваарийг аймаг, нийслэлийн Засаг дарга баталж, мөрдүүлэх;</p> <p>28.1.12.харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдах, түүгээр үйлчлэх болон мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, тэдгээрийн угтвар бодисыг үйлдвэрлэх, импортлох, худалдах тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн үйл ажиллагаанд эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавих;</p> <p>28.1.13.гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлж байсан хүнийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байр бий болгох, хөдөлмөрлөх дадал, туршлага олоход нь дэмжлэг үзүүлэх;</p> <p>28.1.14.нийтийн хэв журмыг сахиулах зорилгоор олон нийтийн байцаагч томилон ажиллуулах;</p> <p>28.1.15.иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор нийтийн эзэмшлийн гудамж, талбайд байршуулан ашиглаж байгаа дүрс бичлэгийн техник, хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хадгалалтын аюулгүй байдал, хэвийн ажиллах нөхцөл, боломжийг байнгын бүрдүүлж, арчлан хамгаалах, шаардагдах зардлыг хариуцах;</p>
	<p><b>40 дүгээр зүйл. Нийтийн хэв журмыг сахиулах зорилгоор олон нийтийн байцаагчийг томилох</b></p>	<p>40.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн бус байгууллага болон баг, хорооны Засаг даргын саналыг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ эргүүлийн үүрэг гүйцэтгэх олон нийтийн байцаагчийг томилон ажиллуулна.</p>

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 6 дугаар сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

### ГЭР БҮЛИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Гэр бүлийн тухай	<b>25 дугаар зүйл. Хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах</b>	<p>25.4.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн болон хүүхдийн ашиг сонирхол хоорондоо зөрчилдөж байгаа нь тогтоогдсон бол сум, дүүргийн Засаг дарга хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах төлөөлөгчийг томилж болно.</p> <p>25.5.Бүтэн өнчин, эцэг, эх нь хоёулаа эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан, удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа, хорих газарт ял эдэлж байгаа зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй, эсхүл тэжээн тэтгэхээс зайлсхийсэн хүний хүүхдийн эрх, ашиг сонирхлыг сум, дүүргийн Засаг дарга хамгаална.</p> <p>25.6.Энэ хуулийн 25.4, 25.5-д заасан хүүхдийн тухай мэдээллийг ясли, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлгийн байгууллагын холбогдох албан тушаалтан болон иргэн хүүхдийн оршин суугаа /оршин байгаа/ газрын сум, дүүргийн Засаг даргад өгөх үүрэгтэй.</p> <p>25.7.Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хуулийн 2 дугаар зүйлд заасны дагуу цагдаагийн байгууллагаас шилжүүлсэн хүүхдийг хүлээн авсан хүүхдийн буюу харгалзан дэмжих байгууллага нь гурав хоногийн дотор энэ тухай сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэх үүрэгтэй.</p> <p>25.8.Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 25.6, 25.7-д заасан хүүхдийн тухай мэдээллийг хүлээн авснаас хойш гурав хоногийн дотор хүүхдийн амьдралын нөхцөлийг судалж, эцэг, эх болон төрөл садангийн хүн байхгүй нь тогтоогдсон бол түүний эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүрэг хүлээнэ.</p> <p>25.9.Сум, дүүргийн Засаг дарга нь хүнд нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж, бүртгэл хөтлөн, түүнийг гэр бүлдээ авч</p>

		асран хүмүүжүүлэхээр хүсэлт гаргасан иргэнд шилжүүлж болно. 25.10.Хүүхдийг энэ хуулийн 25.9-д заасны дагуу шилжүүлэх боломжгүй бол сум, дүүргийн Засаг дарга нь асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгох, үрчлүүлэх, хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.
	<b>26 дугаар зүйл. Хүүхдээ хүмүүжүүлэх эрх, үүрэг</b>	26.8.Эцэг, эх нь гэрлэлтээ цуцлуулсан, эсхүл хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар хүүхдээсээ тусдаа амьдарч байгаа нөхцөлд энэ хуулийн 26.2-т заасан үүргээ хэрэгжүүлж байгаад нь харьяалах сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллага хяналт тавина.
	<b>28 дугаар зүйл. Эцэг, эх байх эрх хязгаарласнаас үүсэх үр дагавар</b>	28.3.Эцэг, эх нь хоёулаа эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан бол хүүхдийг хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлнэ. 28.4.Энэ хуулийн 28.3-т заасан тохиолдолд түүнтэй холбогдсон зардлыг тухайн эцэг, эхээс гаргуулах ба эцэг, эх нь төлбөрийн чадваргүй бол түүний оршин суугаа газрын сум, дүүргийн Засаг дарга хариуцаж болно. 28.5.Сум, дүүргийн Засаг дарга хохирлоо буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргаж болно. 28.6.Энэ хуулийн 27.1-д заасан нөхцөл арилаагүй, эсхүл эцэг, эх нь хүүхдийнхээ эрх, ашиг сонирхлыг хохироож байгаа нь тогтоогдсон бол эцэг, эх байх эрхийг хязгаарласан тухай шүүхийн шийдвэр гарснаас хойш зургаан сарын дараа сум, дүүргийн Засаг дарга болон энэ хуулийн 27.2-т заасан этгээд тухайн хүний эцэг, эх байх эрхийг хасуулах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргаж болно.
	<b>55 дугаар зүйл. Хүүхэд үрчлэх, үрчлүүлэх ерөнхий нөхцөл</b>	55.6.Үрчлэн авахыг хүсэгч нь хүүхдийн оршин суугаа сум, дүүргийн Засаг даргад хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтээ гаргана. 55.7.Сум, дүүргийн Засаг дарга хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтийг хянан үзэж, үрчлүүлэх эсэх тухай шийдвэрийг 20 хоногт багтаан гаргана.
	<b>56 дугаар зүйл. Хүнд нөхцөлд байгаа үрчлүүлэх хүүхдийн бүртгэл, хяналт</b>	56.1.Сум, дүүргийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэрийн хэмжээн дэх хүнд нөхцөлд байгаа үрчлүүлэх хүүхдийн судалгаа гаргаж, бүртгэл хөтөлнө.

---oOo---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

### ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай	<b>19 дүгээр зүйл. Бүх шатны Засаг даргын чиг үүрэг</b>	<p>19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>19.1.1.харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;</p> <p>19.1.2.хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;</p> <p>19.1.3.орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>19.1.4.орон нутгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө болон төсөвт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлын төсөв, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон төлөвлөгөөний төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>19.1.5.хохилогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусгуулах саналыг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах;</p> <p>19.1.6.хохилогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах, нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;</p> <p>19.1.7.гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх;</p> <p>19.1.8.гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах;</p> <p>19.1.9.хуульд заасан бусад.</p>

<p><b>24 дүгээр зүйл.</b> <b>Сум, багийн</b> <b>Засаг даргын</b> <b>Үүрэг</b></p>	<p>24.1.Сум,багийн Засагдарга хүчирхийллийг таслан зогсоох, хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор дараахь арга хэмжээг шуурхай авах үүргийг хүлээнэ:</p> <p>24.1.1.хүчирхийлэл үйлдэгчийг дуудан ирүүлж, шаардлага тавих, сануулга өгөх;</p> <p>24.1.2.хохирогчийг эмнэлгийн яаралтай тусламжид холбох, шаардлагатай бол хохирогчийн байгаа орон байрны аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах, боломжтой бол хохирогчийг төрөл, садан, ойр дотны хүний түр хамгаалалтад өгөх;</p> <p>24.1.3.хохирогчид энэ хууль болон бусад хуульд заасан эрх, үүргийг нь тайлбарлаж, түүнд үзүүлэх үйлчилгээний талаархи мэдээллээр хангах;</p> <p>24.1.4.хохирогчийн зөвшөөрснөөр харьяа сум, баг, хорооны нийгмийн ажилтанд мэдэгдэх;</p> <p>24.1.5.хүчирхийлэл үйлдэгдсэн тухай хохирогч, хүчирхийлэл үйлдэгч, гэрчээс асууж, тэмдэглэл хөтлөх, шаардлагатай бусад ажиллагаа явуулах;</p> <p>24.1.6.энэ хуулийн 24.1.1, 24.1.2, 24.1.3, 24.1.4, 24.1.5-д заасны дагуу авсан арга хэмжээний талаар цагдаагийн алба хаагчид мэдэгдэж, холбогдох тэмдэглэлийг шилжүүлэх;</p> <p>24.1.7.хуульд заасан бусад.</p> <p>24.2.Сум, багийн Засаг дарга хохирогч бие махбод, сэтгэл санааны хувьд ноцтой хохирол хүлээсэн, хохирч болзошгүй, эсхүл хүүхэд хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй гэж үзвэл хохирогч зөвшөөрөл өгсөн эсэхийг үл харгалзан харьяа сум, баг, хорооны нийгмийн ажилтанд, эсхүл сургуулийн нийгмийн ажилтанд мэдэгдэнэ.</p>
<p><b>30 дугаар зүйл.</b> <b>Хүүхдийг</b> <b>тусгай</b> <b>хамгаалалтаар</b> <b>хангах</b></p>	<p>30.1.Хүүхдийн эсрэг хүчирхийллийн тухай мэдээлэл хүлээн авсан цагдаагийн байгууллага, сум, багийн Засаг дарга хүчирхийллийг таслан зогсоох, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах зорилгоор энэ хуулийн 24, 25 дугаар зүйлд зааснаас гадна дараахь арга хэмжээг авна:</p> <p>30.1.1.хүүхдийг нэг цэгийн үйлчилгээний төв, эсхүл түр хамгаалах байранд хүргэх;</p> <p>30.1.2.энэ хуулийн 30.1.1-д заасан арга хэмжээг авах боломжгүй бол эцэг, эх, төрөл, садангийн болон бусад этгээд, өөр гэр бүлд хүлээлгэн өгөх;</p> <p>30.1.3.хүүхдэд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлдэг төрийн, төрийн бус байгууллагад хүргэх.</p> <p>30.1.4.хүүхдийн байгууллага, ажилтанд мэдээлэх.</p> <p>30.3.Энэ хуулийн 30.1-д заасан арга хэмжээг цагдаагийн алба хаагч, сум, багийн Засаг дарга, харьяа сум, баг, хороо, сургуулийн нийгмийн ажилтан, эсхүл хүүхдэд үйлчилгээ үзүүлж байгаа ажилтантай хамтран хэрэгжүүлнэ.</p> <p>30.5.Цагдаагийн алба хаагч, эсхүл сум, баг, хорооны Засаг дарга энэ хуулийн 30.1-д заасан иргэн, байгууллагад хүүхдийг хүлээлгэн өгөх бол түүнд эрх, үүргийг сануулж, бичгээр баталгаажуулна.</p>

---o0o---





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1998 оны 5 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

### ДАЙНЫ БАЙДЛЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Дайны байдлын тухай	<b>18 дугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг даргын үүрэг</b>	<p>18.1.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга нь дайны байдлын үед тухайн нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг хэрэгжүүлэх үндсэн байгууллага болох аймаг, нийслэлийн батлан хамгаалах газар, сум, дүүргийн батлан хамгаалах товчоог тэргүүлнэ.</p> <p>18.3.Дайны байдалтай холбогдуулан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн Засаг дарга дараахь үүргийг хүлээнэ:</p> <p>Тайван цагт:</p> <p>18.3.1.нутаг дэвсгэрийн засаг захиргаа, эдийн засгийг дайны байдалд шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулан дээд шатны байгууллагад оруулж, түүнийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулах;</p> <p>18.3.2.нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн болон жилийн төлөвлөгөө, төсөв, санхүүгийн үйл ажиллагааг батлан хамгаалах ашиг сонирхолд нийцүүлж байх;</p> <p>18.3.3.зэвсэгт хүчин, бусад цэргийг зайлшгүй шаардлагатай бүтээгдэхүүнээр хангах Засгийн газрын захиалга-даалгаврын биелэлтийг зохион байгуулах;</p> <p>18.3.4.стратегийн ач холбогдол бүхий зам, гүүр, төмөр замын зангилгаа, нисэх онгоцны буудал, холбооны сүлжээ, улсын онц чухал объектыг хамгаалах арга хэмжээ авах;</p> <p>18.3.5.улсын дайчилгааны материаллаг нөөц болон орон нутгийн хүнс, эд хөрөнгийн нөөцийг бүрдүүлэх, шинэчлэх, нөхөн сэлбэх;</p> <p>18.3.6.цэргийн насны залуучуудыг эрүүлжүүлэх, тэдэнд эх оронч хүмүүжил олгох, бие бялдар, оюуны өв тэгш хөгжлийг хангах тогтолцоог бүрдүүлэх ажил зохион байгуулах;</p> <p>18.3.7.цэргийн бэлтгэл үүрэгтний дайчилгаатай сургууль, цугларалтыг төрийн захиргааны холбогдох байгууллагатай хамтран хууль тогтоомжид заасны дагуу зохион явуулах.</p> <p>Дайны байдлын үед хэрэгжүүлэх үүргийг тус хуулийн 18.3.8-18.3.20 дахь заалтаас дэлгэрүүлж үзнэ үү.</p> <p>18.4.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга, батлан хамгаалах газар, товчооны шийдвэрийг Засаг дарга, нутаг дэвсгэрийн бүх байгууллага, иргэд заавал биелүүлнэ.</p>

---оОо---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1998 оны 5 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

### ДАЙЧИЛГААНЫ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Дайчилгааны тухай	<b>18 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын үүрэг</b>	<p>18.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга дараахь үүрэг хүлээнэ:</p> <p>18.1.1.дайчилгааны даалгаврыг үндэслэн аймаг, нийслэлийн дайчилгааны төлөвлөгөөг Засгийн газраар; зэвсэгт хүчний нэгтгэл, ангийг бие бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах дайчилгааны төлөвлөгөөг Зэвсэгт хүчний Жанжин штабын даргаар тус тус батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>18.1.2.сум, дүүргийн дайчилгааны даалгаврыг тогтоож, тэдний дайчилгааны төлөвлөгөөг батлах;</p> <p>18.1.3.дайчилгааны бэлтгэлийг хангах төсвийн төслийг боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулах, батлагдсан төсвийг захиран зарцуулах;</p> <p>18.1.4.дайчилгааны даалгавраар тогтоогдсон материал, хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, түүнийг шинэчлэх, нөхөн сэлбэх ажлыг зохион байгуулах;</p> <p>18.1.5.нутаг дэвсгэртээ дайчилгааны зарлан мэдээлэл явуулах журмыг тогтоож бэлэн байдлыг хангах;</p> <p>18.1.6.дайчилгаа зарласан үед дайчилгааны даалгаврыг тогтоосон хугацаанд нь биелүүлэх;</p> <p>18.1.7.дайчилгааны арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлэх нөхцөлийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах;</p> <p>18.1.8.цугларах, шилжүүлэх байрыг тогтоох;</p> <p>18.1.9.нутаг дэвсгэрийнхээ байгууллага, аж ахуйн нэгжийн дайчилгааны даалгаврын биелэлтэд хяналт тавих.</p> <p>18.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга хууль тогтоомжид заасан бусад үүргийг хүлээнэ.</p>
	<b>19 дүгээр зүйл. Сум, дүүрэг /баг, хороо/-ийн Засаг даргын үүрэг</b>	<p>19.1.Сум, дүүрэг /баг, хороо/-ийн Засаг дарга дараахь үүрэг хүлээнэ:</p> <p>19.1.1.нутаг дэвсгэртээ дайчилгааны зарлан мэдээлэлт явуулах бэлтгэл, бэлэн байдлыг хангах;</p> <p>19.1.2.сум, дүүрэг /баг, хороо/-ийн дайчилгааны төлөвлөгөөний төслийг боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргаар батлуулан мөрдөн ажиллах;</p> <p>19.1.3.нутаг дэвсгэрийнхээ байгууллага, аж ахуйн нэгж, иргэний дайчилгааны даалгаврын биелэлтэд хяналт тавих;</p> <p>19.1.4.дайчилгаа зарласан үед дайчилгааны даалгаврыг тогтоосон хугацаанд нь биелүүлэх.</p> <p>19.2.Сум, дүүрэг /баг, хороо/-ийн Засаг дарга хууль тогтоомжид заасан бусад үүрэг хүлээнэ.</p>

---оОо---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

### ДОНОРЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Донорын тухай	<b>8 дугаар зүйл. Нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргын эрх, үүрэг</b>	8.1.Донорын үйл ажиллагааны талаар нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг дарга дараахь эрх, үүрэгтэй: 8.1.1.цусны донорын үйлсийг сурталчлах, эгнээг өргөжүүлэх, донор хадгалалтыг сайжруулах үйл ажиллагааг дэмжиж ажиллах; 8.1.2.гамшгийн үед харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллагад цус, цусан бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх, нөхөн сэлбэхэд шаардагдах нэмэлт санхүүжилтийг шийдвэрлэж, удирдлага зохион байгуулалтаар хангах.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 05 сарын 30 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай	<b>10 дугаар зүйл. Төрийн байгууллагын бүрэн эрх</b>	10.5.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 10.5.1.нутаг дэвсгэрийнхээ сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг жигд, тогтвортой зохион байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэх; 10.5.2.сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг мэргэжлийн бүтэц, орон тоогоор хангахад дэмжлэг үзүүлэх; 10.5.3.сургуулийн дэргэдэх туслах аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; 10.5.4.орон нутгаас нийлүүлэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг тогтвортой явуулах арга хэмжээг хэрэгжүүлэх.
	<b>12 дугаар зүйл. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хяналт</b>	12.1.Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд дараах этгээд хяналт тавьж, хэрэгжүүлнэ: 12.1.1.төрийн хяналтыг энэ хуулийн 10.2.5-д заасан журмын дагуу тухайн шатны Засаг дарга, аймаг, нийслэлийн боловсрол, эрүүл мэндийн газар, хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага;

---о0о---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 7 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

### ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЖУРМЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Жагсаал, цуглаан хийх журмын тухай	<b>9 дүгээр зүйл. Жагсаал, цуглаан хийх журам</b>	<p>1. Гудамж, талбайд жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг сум, дүүргийн Засаг даргад өгч бүртгүүлнэ. Жагсаал, цуглаан хийхээр төлөвлөсөн гудамж, талбай нь хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн хилийн цэст хамаарах газар нутгийг хамарч байгаа бол мэдэгдлийг аймаг, нийслэлийн Засаг даргад өгч бүртгүүлнэ.</p> <p>3. Засаг дарга жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор түүнийг бүртгэсэн эсэхээ бичгээр мэдэгдэнэ.</p> <p>4. Жагсаал, цуглаан хийх мэдэгдлийг бүртгэх эсэх тухай асуудлыг шийдвэрлэхийн тулд нэмж тодруулах буюу зохицуулбал зохих асуудал гарвал Засаг дарга энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацааны дотор зохион байгуулагчтай харилцаж зохицуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд жагсан явах чиглэлийг өөрчлөх эрхтэй.</p> <p>5. Засаг дарга энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацааны дотор хариу мэдэгдээгүй бол зохион байгуулагч нь мэдэгдэлд дурдсан газарт, түүнд заасан хугацааны дотор жагсаал, цуглааныг зохион байгуулах эрхтэй.</p>
	<b>10 дугаар зүйл. мэдэгдлийг хянах</b>	<p>1. Жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдэл хүлээн авсан Засаг дарга дор дурдсан үндэслэл байвал түүнийг хийхийг бүртгэхээс татгалзсан шийдвэр гаргаж, энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацаанд жагсаал, цуглаан зохион байгуулагчид бичгээр мэдэгдэнэ:</p> <p>Уг мэдэгдэлд татгалзах үндэслэл байгаа эсэхийг тус хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.</p>
	<b>14 дүгээр зүйл. Жагсаал, цуглааныг албадан тараах</b>	<p>1. Дараахь тохиолдолд Засаг дарга жагсаал, цуглааныг албадан тараах шийдвэр гаргана:</p> <p>1/ энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу бүртгүүлэлгүйгээр жагсаал, цуглаан зохион байгуулсан бол;</p> <p>2/ бүртгүүлсэн боловч жагсаал, цуглаан хийх газрыг дур мэдэн өөрчилж, энэ хуулийн 7 дугаар зүйлд хориглосон газарт жагсаал, цуглаан хийж байгаа буюу хийхээр завдсан бол;</p> <p>3/ энэ хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан байгууллага жагсаал, цуглааныг зохион байгуулсан бол;</p> <p>4/ жагсаал, цуглааны явцад түүний анхны зорилго өөрчлөгдөж, энэ хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан агуулга, шинжтэй болсон, эсхүл онц болон дайны байдал зарласан буюу гамшиг болон аюул тохиолдсон үед мөн зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас бусад зорилгоор жагсаал, цуглаан хийж байгаа бол;</p> <p>5/ жагсаал, цуглааныг зохион байгуулагч буюу түүнд оролцогчид энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 3,12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүргээ үл биелүүлснээс нийгмийн хэв журам алдагдаж, эмх замбараагүй байдал бий болсон буюу хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан бол.</p>



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 2 дугаар сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

### ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай	<b>10 дугаар зүйл. Төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгаа</b>	10.1.Төрөөс эрэгтэй, эмэгтэй хүний төрийн албанд орох, албан тушаал эрхлэх тэгш эрх бодитой хэрэгжих боломж, нөхцөлөөр хангахын тулд дараахь бодлого хэрэгжүүлнэ: 10.1.1.томилогдох төрийн улс төрийн албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл ... аймагт ... 15 хувиас, ... суманд 25 хувиас ... доошгүй байх; 10.2.Төрийн байгууллагын дэргэдэх болон үндэсний хэмжээний хороо, зөвлөл, комисс зэрэг зөвлөлдөх буюу хамтын удирдлагын байгууллагад аль нэгэн хүйсийн төлөөлөл нийт гишүүний 40 хувиас доошгүй байна.
	<b>19 дүгээр зүйл. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаархи төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын чиг үүрэг</b>	19.1.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ: 19.1.1.тухайн салбар, орон нутгийн хөгжлийн бодлого, ерөнхий төлөвлөгөө, хөтөлбөр, төсөлд жендэрийн мэдрэмжтэй болгох арга зүйг нэвтрүүлэх, тэдгээрийн төсөлд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийлгэж, тайланг хэлэлцэж, дүгнэлт гаргах; 19.1.2.тухайн салбар, орон нутгийн хэмжээнд хүйсээр ангилсан статистикийн мэдээллийг бүрдүүлэх, жендэрийн эрх тэгш байдлын төлөв байдал, бодлогын үр нөлөөг үнэлэх; 19.1.4.зөвлөх чиг үүрэг бүхий жендэрийн салбар зөвлөл, хороо байгуулж, түүний бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах; 19.1.5.төрийн байгууллагын жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой зарим чиг үүргийг олон нийтийн болон төрийн бус байгууллагаар гэрээний дагуу гүйцэтгүүлэх, үүнд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж батлуулах; 19.1.6.тухайн салбар, орон нутгийн хэмжээнд жендэрийн сургалт, гэгээрлийн ажил явуулах; 19.1.7.энэ хуулийн 11.4-т заасан арга хэмжээг тухайн салбар, орон нутгийн онцлог, шаардлагад нийцүүлэн зохион байгуулах; 19.1.8.төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад ажиллагсдын хүйсийн тэнцвэртэй байдлын тайланг сум, дүүргийн Засаг дарга дараа оны 01 дүгээр сарын 10-ны дотор аймаг, нийслэлийн Засаг даргад, аймаг, нийслэлийн Засаг дарга дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор Жендэрийн үндэсний хороонд тус тус хүргүүлэх;

---о0о---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 06 сарын 06 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай	<b>18 дугаар зүйл. Нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын бүрэн эрх</b>	18.2.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх арга хэмжээг орон нутагт зохион байгуулах ажлыг хариуцан гүйцэтгэнэ. 18.3.Тухайн шатны Засаг дарга жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг кластераар хөгжүүлэх тухай саналаа боловсруулж, дээд шатны эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.
	<b>18<sup>1</sup> дүгээр зүйл. Аймаг, сум, нийслэл, дүүргийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны асуудал хариуцсан байгууллага, албан тушаалтны эрх, үүрэг</b>	18 <sup>1</sup> .1.Аймаг, нийслэлийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны асуудал хариуцсан байгууллага нь дараах эрх, үүрэгтэй: 18 <sup>1</sup> .1.3.аймаг, нийслэлийн Засаг даргыг мэдээллээр хангах, арга зүйн зөвлөмж өгөх, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх;

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

### ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Залуучуудын хөгжлийг дэмжих тухай	<b>12 дугаар зүйл. Аюулгүй амьдрах, хөгжих орчныг бүрдүүлэх</b>	12.3.Залуучуудын өөрийгөө хөгжүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааг дараахь чиглэлээр дэмжинэ: 12.3.1.залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн, соёл, урлаг, биеийн тамир, спортын цогцолбор, хөгжлийн төв, цэцэрлэгт хүрээлэн, дэд бүтцийг шинээр барьж байгуулах, өргөтгөх төсөл, арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх; 12.3.2.залуучуудын авьяас чадвар, бие бялдар, сэтгэхүйг хөгжүүлэхэд шашин болон улс төрөөс ангид урлаг, соёл, спортын арга хэмжээнд залуучууд оролцох, эдгээр арга хэмжээг зохион байгуулсан хуулийн этгээдийг дэмжих; 12.3.3.түүх, соёлын өвийг хамгаалах, эх оронч үзлийг төлөвшүүлэх, ардын урлаг, ёс заншил, уламжлалт зан үйлийг хөгжүүлэхэд залуучуудын оролцоог хангах; 12.3.4.залуучуудын дунд гэр бүлийн соёл, хүмүүжлийн уламжлалыг дээдлэх, удам угсаагаа мэдэх, угийн бичиг хөтлөх, сурталчлах үйл ажиллагааг дэмжих; 12.3.5.байгаль орчныг хамгаалах ардын зан үйлийг сурталчлах, төлөвшүүлэх санаачилгыг дэмжих. 12.4.Энэ хуулийн 12.3.1, 12.3.2, 12.3.3, 12.3.4, 12.3.5-д заасан үйл ажиллагааг бүх шатны Засаг дарга нар хэрэгжүүлнэ.
	<b>16 дугаар зүйл. Хүмүүнлэгийн ажилд оролцох оролцоог дэмжих</b>	16.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 6.1.3, 6.1.4-т заасан сайн дурын болон хүмүүнлэгийн ажилд оролцсон залуучууд болон залуучуудын иргэний нийгмийн байгууллагын сайн туршлагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан алдаршуулж, олон нийтэд түгээн дэлгэрүүлнэ.
	<b>21 дүгээр зүйл. Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг</b>	21.1.Бүх шатны Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ залуучуудын хөгжлийг дэмжих талаар дараахь чиг үүрэгтэй:



	<p><b>даргын чиг үүрэг</b></p>	<p>21.1.1.харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа залуучуудын салбар зөвлөлийг тэргүүлэх;  21.1.2.залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;  21.1.3.залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах;  21.1.4.энэ хуулийн 11.1.7 дахь заалт, 13, 14, 15 дугаар зүйлд заасан арга хэмжээг залуучуудын оролцоог дэмжих тусгай хөтөлбөрийн дагуу харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;  21.1.5.энэ хуулийн 9.5 дахь хэсэг, 11.1.7 дахь заалт, 20.8 дахь хэсэгт заасан арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгах;  21.1.6.хууль тогтоомжид заасан бусад.</p>
	<p><b>22 дугаар зүйл. Залуучуудын хөгжлийн үндэсний болон салбар зөвлөл</b></p>	<p>22.1.Залуучуудын хөгжлийг дэмжих салбар дундын үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд, орон нутагт залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга тус тус тэргүүлнэ.  Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, чиг үүрэгтэй холбоотой зохицуулалтыг тус хуулийн 22.2-22.4 дэх хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.</p>
	<p><b>24 дүгээр зүйл. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих</b></p>	<p>24.1.Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хууль тогтоомжоор эрх олгосон бусад байгууллага, албан тушаалтан эрх хэмжээнийхээ хүрээнд залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавина.</p>

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 7 дугаар сарын 8-ны өдөр

Улаанбаатар хот

### ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай	<b>9 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын эрх, үүрэг</b>	<p>9.3.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараах эрхтэй байна:</p> <p>9.3.1.харьяа нутаг дэвсгэрийнхээ нийтийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн явах чиглэл, зогсоолын байршлыг тогтоох, өөрчлөх;</p> <p>9.3.2.зам, түүний ойролцоо худалдаа, үйлчилгээ явуулах, уралдаан, тэмцээн, жагсаал, цуглаан, бусад арга хэмжээ зохион байгуулахад зөвшөөрөл олгох;</p> <p>9.3.3.тухайн нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний акт зөрчсөн зөрчилд шийтгэл хүлээлгэх ажлыг зохион байгуулах.</p> <p>9.4.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараах үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>9.4.1.зам тээврийн осол, хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;</p> <p>9.4.2.замын хөдөлгөөний түгжрэл, саатлын шалтгаан, нөхцөлийг судалж, түүнийг арилгахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;</p> <p>9.4.3.иргэдэд замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах;</p> <p>9.4.4.тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд, иргэнд замыг цэвэрлэх, бохирдол, цас мөсийг арилгахыг үүрэг болгох;</p> <p>9.4.5.харьяа нутаг дэвсгэрийнхээ зам, замын байгууламж гэрэлтүүлэг, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгслийн бүрэн бүтэн байдал, замын хөдөлгөөний зохион байгуулалт, аюулгүй байдалд хяналт тавьж, илэрсэн зөрчил, иргэдийн санал, гомдлыг холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээг авахуулах;</p> <p>9.4.6.зам, замын байгууламжийг шинээр барих, өргөтгөх, засварлах, тоноглох, замын гэрэлтүүлэг, тэмдэг, тэмдэглэл хийх ажил нь холбогдох хууль, захиргааны хэм хэмжээний акт, байгаль орчны болон замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах;</p> <p>9.4.7.харьяа нутаг дэвсгэрийнхээ замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажлын хэрэгжилтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жилд хоёроос доошгүй удаа тайлагнах.</p> <p>9.5.Замын хөдөлгөөний түгжрэл, саатлыг зохицуулах зорилгоор аймаг, нийслэлийн Засаг дарга нь харьяа нутаг дэвсгэртээ Монгол Улсын хууль тогтоомж, Замын хөдөлгөөний дүрэмд нийцүүлэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоосон захиргааны хэм хэмжээний акт гаргаж болно.</p>



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

### ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Захиргааны ерөнхий хууль	<b>4 дүгээр зүйл. Захиргааны үйл ажиллагааны зарчим</b>	4.1.Захиргааны үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим үйлчилнэ. 4.2.Захиргааны үйл ажиллагаанд дараах тусгай зарчмыг баримтална: 4.2.1.хуульд үндэслэх; 4.2.2.шуурхай, тасралтгүй байх; 4.2.3.хуульд заасан төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад үйл ажиллагаанд ил тод, нээлттэй байх; 4.2.4.үр нөлөөтэй байх; 4.2.5.зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, шийдвэр нь үндэслэл бүхий байх; 4.2.6.бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах тохиолдолд тэдгээрт урьдчилан мэдэгдэх, оролцоог нь хангах; 4.2.7.ашиг сонирхлын зөрчилтэй захиргааны үйл ажиллагаанаас татгалзан гарах, татгалзан гаргах боломжийг хангах; 4.2.8.хууль ёсны итгэлийг хамгаалах.
	<b>6 дугаар зүйл. Захиргааны байгууллагыг төлөөлөх</b>	6.1.Захиргааны байгууллагыг хуулиар бүрэн эрх олгогдсон удирдах албан тушаалтан хуульд заасны дагуу итгэмжлэлгүйгээр, эсхүл хуулиар эрх олгогдсон удирдах албан тушаалтны шийдвэрээр итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлнө.
	<b>8 дугаар зүйл.</b>	8.1.Хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно.
	<b>19 дүгээр зүйл. Төлөөлөгчийг томилох</b>	19.1.Захиргааны байгууллагын оршин байгаа газрын сум, дүүргийн Засаг дарга дараах оролцогчийн хувьд эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нь хамгаалан оролцох төлөөлөгчийг томилно: 19.1.1.оролцогч хэн болох нь тодорхойгүй бол; 19.1.2.оролцогчийн оршин байгаа хаяг нь тодорхойгүй, байнгын оршин суугаа хаягтаа байхгүй, эсхүл удаа дараа /хоёр буюу түүнээс дээш/ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол; 19.1.3.Монгол Улсад байнга оршин суудаггүй, төлөөлөн хүлээн авах этгээдийг нэрлээгүй бол; 19.1.4.захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд хамаарах эзэнгүй эд юмстай холбоотой үүсэх эрх, үүргийг хэрэгжүүлэх шаардлагатай бол.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

### ЗАХИРГААНЫ БОЛОН ИРГЭНИЙ ПРОЦЕССИЙН ХУУЛИУДАД

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай (2016.02.04)	<b>39 дүгээр зүйл. Эд мөрийн баримт</b>	39.6.Шаардлагатай бол эд мөрийн баримтыг эзэмшигч, эсхүл эд мөрийн баримт байгаа газрын баг, хорооны Засаг дарга, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цагдаагийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтанд хадгалуулж болно. Хадгалахаар авсан этгээд эд мөрийн баримтыг хэвийн байдлаар хадгалах үүрэгтэй.
	<b>59 дүгээр зүйл. Шүүхэд дуудан ирүүлэх</b>	59.7.Мэдэгдэх хуудсыг гардуулан өгвөл зохих хүн оршин суугаа газартаа болон ажлынхаа газарт байхгүй бол уг хуудсыг түүний хамт амьдардаг насанд хүрсэн хүн, эсхүл сум, баг, хорооны Засаг дарга, түүний ажлын албанд, эсхүл ажлын газрынх нь захиргаанд хүлээлгэн өгч, гарын үсэг зуруулна.
Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай (2002.01.30)	<b>45 дугаар зүйл. Эд мөрийн баримт</b>	45.3.Шаардлагатай бол эд мөрийн баримтыг эзэмшигч, эсхүл зохих баг, хорооны Засаг дарга, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, цагдаагийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтанд хадгалуулж болно. Хадгалахаар авсан этгээд эд мөрийн баримтыг хэвийн байдлаар хадгалах үүрэгтэй.
	<b>77 дугаар зүйл. Шүүхийн мэдэгдэх хуудас</b>	77.6.Мэдэгдэх хуудсыг гардуулан өгвөл зохих иргэн оршин суугаа газартаа буюу ажлынхаа газарт байхгүй бол уг хуудсыг түүний хамт амьдардаг насанд хүрсэн иргэн, эсхүл сум, баг, хорооны Засаг дарга, түүний ажлын албанд буюу ажлын газрынх нь захиргаанд хүлээлгэн өгч, гарын үсэг зуруулна.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

### ЗӨРЧЛИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Зөрчлийн тухай	<b>6.1 дүгээр зүйл. Хог хаягдлын тухай хууль зөрчих</b>	12.Хуульд заасны дагуу гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх чиглэл, хуваарийг тогтоож, сум, дүүргийн Засаг даргаар батлуулж мөрдөх үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.  18.Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагааг тухайн аймаг, нийслэлийн Засаг даргаас олгосон зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
	<b>7.8 дугаар зүйл. Ургамал хамгааллын тухай хууль зөрчих</b>	5.Ургамал, түүнээс гаралтай түүхий эдийг тээвэрлэх, борлуулахдаа тухайн сум, дүүргийн Засаг даргын Тамгын газраас бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ аваагүй бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
	<b>7.13 дугаар зүйл. Газрын тосны тухай хууль зөрчих</b>	16.Гэрээлэгч:  16.9.орон нутгийн хөгжилд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгасан гэрээг тухайн тусгай зөвшөөрлийн талбай орших сум, дүүргийн Засаг даргатай байгуулж ажиллах үүргээ биелүүлээгүй бол хүнийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гучин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

<p><b>12.2 дугаар зүйл. Геодези, зураг зүйн тухай хууль зөрчих</b></p>	<p>5.Геодезийн байнгын цэг, тэмдэгт байрлуулж уг цэг, тэмдэгтийн байрлаж байгаа сум, дүүргийн Засаг даргад, эсхүл хилийн зурваст бол хил хамгаалах ерөнхий газрын харьяа тусгай ангийн удирдлагад хүлээлгэж өгөөгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>
<p><b>13.1 дүгээр зүйл. Тариалангийн тухай хууль зөрчих</b></p>	<p>3.Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч: 3.1.тариалангийн газраа бүхэлд нь, эсхүл тодорхой хэсгийг нь хоёр жил ашиглахгүй өнжөөхдөө сум, дүүргийн Засаг даргад албан ёсоор мэдэгдээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>
<p><b>14.7 дугаар зүйл. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих</b></p>	<p>57.Замын хөдөлгөөний түгжрэл, саатлыг зохицуулах зорилгоор аймаг, нийслэлийн Засаг даргаас харьяа нутаг дэвсгэртээ Монгол Улсын хууль тогтоомж, Замын хөдөлгөөний дүрэмд нийцүүлэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоосон захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн бол хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>
<p><b>15.28 дугаар зүйл. Орон нутгийн хамгаалалтын тухай хууль зөрчих</b></p>	<p>2.Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүн болон ажилтныг үүрэг гүйцэтгэх боломжоор хангах, орон нутгийн хамгаалалтын сургалт, зохион байгуулалттай бусад арга хэмжээнд хамруулах үүргээ биелүүлээгүй, эсхүл аймаг, нийслэлийн Засаг даргаас тогтоосон даалгавар, орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөгөөр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй бол хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>
<p><b>15.30 дугаар зүйл. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль зөрчих</b></p>	<p>2. .... аймаг, нийслэлийн Засаг дарга ... нь нийтийн албанаас чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд нээлттэй тендер шалгаруулалтаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд төрийн болон орон нутгийн хэрэгцээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авагч, төрийн санхүүгийн нөөц бүрдүүлэгч, төрөөс баталгаа гаргасан зээл хүртэгч аж ахуйн нэгжийн хувь, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч болсон бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>

---о0о---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 5 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

### ИННОВАЦИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Инновацийн тухай	<b>11 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх</b>	<p>11.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга инновацийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>11.1.1. орон нутагтаа инновацийг хөгжүүлэхэд хувийн хэвшлийн оролцоог хангах, хамтарсан санхүүжилттэй инновацийн төсөл хэрэгжүүлэх;</p> <p>11.1.2. аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт байгуулагдсан паркийн хэвийн үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах нийгмийн дэд бүтэц байгуулах, суурь үйлчилгээ үзүүлэх ажлыг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, бусад эх үүсвэрээр шийдвэрлэх, паркийн захиргаанд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах;</p> <p>11.1.3. орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн инновацийн төслийн нээлттэй шалгаруулалт зохион байгуулах, инновацийн грант олгох;</p> <p>11.1.4. энэ хуулийн 11.1.3-т заасныг орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх, шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор үнэт цаас гаргах, гадаадын хөнгөлөлттэй зээлд хөрөнгийн баталгаа гаргах;</p> <p>11.1.5. инновацийн үйл ажиллагааг дагнан эрхлэх үүрэгтэй орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байгуулж ажиллуулах;</p> <p>11.1.6. хуульд заасан бусад бүрэн эрх.</p>

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

### ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай	<b>7 дугаар зүйл. Өргөдөл, гомдлын талаар төрийн байгууллага, албан тушаалтны хүлээх нийтлэг үүрэг</b>	<p>.Өргөдөл, гомдлын талаар төрийн байгууллага, албан тушаалтан дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:</p> <p>1/иргэдээс өргөдөл, гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрэн хангах;</p> <p>2/харьяаллын дагуу ирсэн өргөдөл, гомдлыг заавал хүлээн авах;</p> <p>3/өргөдөл, гомдолд дурдсан асуудал бүрийг эрх хэмжээнийхээ хүрээнд хянан үзэж, үндэслэлтэй шийдвэрлэх;</p> <p>4/өргөдөл, гомдлыг хугацаанд нь барагдуулах;</p> <p>5/өргөдөл, гомдолд дурдсан төр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах;</p> <p>6/өргөдөл, гомдолд үндэслэл бүхий хариу өгөх;</p> <p>7/өргөдөл, гомдлын талаар гаргасан шийдвэрийн дагуу харьяа байгууллага, доод шатны албан тушаалтны авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг шалгах;</p> <p>8/иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаархи мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлэх;</p> <p>9/хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчлах.</p> <p>10/өргөдөл, гомдол хүлээн авах үүрэг бүхий ажилтан өргөдөл, гомдлыг тогтоосон хугацаанд нь шийдвэрлэх албан тушаалтанд хүргэх.</p> <p>2.Тухайн байгууллага, албан тушаалтан өөрийн эрх хэмжээнд хамаарах өргөдөл, гомдлыг үндэслэлгүйгээр өөр байгууллага, албан тушаалтанд шилжүүлж болохгүй.</p> <p>3.Байгууллагын удирдлага нь тухайн жилд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаархи дүн мэдээг жил бүр нийтэд тайлагнана.</p>
	<b>9 дүгээр зүйл. Өргөдөл, гомдол гаргах хэлбэр</b>	<p>1.Өргөдөл, гомдлыг төрийн албан ёсны хэлээр бичгээр буюу амаар гаргана. Өргөдөл, гомдлыг цахим сүлжээгээр дамжуулан гаргаж болно. Байгууллага бүр цахим хаягтай байна.</p> <p>3.Амаар биечлэн гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч байгаа этгээд тэмдэглэн авч, өргөдөл, гомдол гаргагчийн гарын үсгийг зуруулна. Гарын үсгээ зурж чадахгүй бол энэ тухай тэмдэглэнэ.</p> <p>4.Иргэд радио, телевизээр явуулж байгаа шууд нэвтрүүлгээр болон тусгайлан ажиллуулсан утсаар дамжуулан өргөдөл, гомдол гаргаж болно.</p>



		5.Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан өргөдөл, гомдолд амаар хариу өгч болох бөгөөд шаардлагатай бол шалгаж тодруулан бичгээр хариу өгч болно.
	<b>12 дугаар зүйл. Өргөдөл, гомдлыг хүлээн авах, бүртгэх</b>	<p>1.Төрийн бүх байгууллага өргөдөл, гомдол гаргагчийг хүлээн авч уулзах байр, өргөдөл, гомдол хүлээн авах цагийн хуваарийг тогтоож, нийтэд мэдэгдэнэ. Хол газраас ирсэн иргэнийг хүлээлгэлгүйгээр хүлээн авч уулзана.</p> <p>2.Иргэдийг хүлээн авах байранд ирж амаар гаргасан өргөдөл, гомдлыг түүнийг хүлээн авах үүрэг бүхий ажилтан тэмдэглэн авч, тусгай бүртгэлд бүртгэнэ.</p> <p>3.Бичгээр болон цахим сүлжээгээр дамжуулан ирүүлсэн өргөдөл, гомдлыг тухайн байгууллагын бичиг хэрэг хариуцсан ажилтан хүлээн авч, дарааллын дагуу бүртгэнэ.</p> <p>4.Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт зааснаар бүртгэсэн өргөдөл, гомдлыг түүнийг шийдвэрлэх албан тушаалтанд өдөрт нь багтаан шилжүүлнэ.</p> <p>5.Гомдлыг түүнд холбогдож байгаа албан тушаалтанд өөрт нь шилжүүлэхийг хориглоно.</p> <p>6.Өргөдөл, гомдлыг албан тушаалтан шууд хүлээн авч болно.</p> <p>7."Нууц", "гарт нь" гэж хаягласан өргөдөл, гомдлыг тухайн албан тушаалтанд шууд өгнө.</p> <p>8.Өргөдөл, гомдлыг энэ зүйлийн 6,7 дахь хэсэгт зааснаар хүлээн авсан албан тушаалтан дараахь журмыг биелүүлнэ: 1/өөрийн эрх хэмжээнд хамаарах өргөдөл, гомдлыг хүлээн авснаас хойш, түүнчлэн албан тушаалтан томилолтоор өөр газар ажиллаж байгаа бол ирснээс хойш ажлын нэг өдөрт багтаан энэ зүйлд заасан бүртгэлд бүртгүүлнэ;</p>
	<b>15 дугаар зүйл. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хариу өгөх</b>	<p>1.Өргөдөлд дурдсан асуудлыг шууд шийдвэрлэх боломжтой бол зохих шийдвэрийг гаргана.</p> <p>2.Шууд шийдвэрлэх боломжгүй бөгөөд удаан хугацаанд шийдвэрлэгдэх асуудал /орон сууц олгуулах гэх мэт/-аар гаргасан өргөдлийг тусгай бүртгэлд бүртгэж, шийдвэрлэлтэд хяналт тавина.</p> <p>3.Гомдлыг албан тушаалтан өөрийн бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэнэ.</p> <p>4.Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн, эсхүл энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан арга хэмжээ авсан тохиолдолд энэ тухай хариуг биечлэн амаар буюу харилцах утсаар, эсхүл бичгийн зэрэг тохиромжтой хэлбэрээр мэдэгдэнэ.</p> <p>5.Хариуг амаар, харилцах утсаар мэдэгдсэн бол энэ тухай бүртгэлд тэмдэглэнэ.</p>
	<b>16 дугаар зүйл. шийдвэрлэх, хариу өгөх хугацаа</b>	<p>1.Өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг тухайн байгууллагын удирдах албан тушаалтан 30 хүртэл хоногоор нэмж сунгаж болно. Хугацаа сунгасан тухай өргөдөл, гомдол гаргагчид мэдэгдэнэ.</p> <p>2.Саналын шинжтэй өргөдлийн хариуг 90 хоногт багтаан өгнө.</p>
	<b>19 дүгээр зүйл.</b>	3.Сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нь өөр байгууллага, албан тушаалтан шийдвэрлэхээр хуульд шууд зааснаас бусад өөрийн эрхлэх асуудлын хүрээ, хуулиар хүлээсэн чиг үүрэгт нь хамаарах асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг доод шатны байгууллага, албан тушаалтанд шилжүүлэхгүйгээр эцэслэн хариу өгнө.



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 6 дугаар сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

### ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Иргэний улсын бүртгэлийн тухай	<b>11 дүгээр зүйл. Үрчилсний бүртгэл</b>	<p>11.1.Хүүхэд үрчлэн авахыг хүсэгч дараах баримт бичгийг бүрдүүлж, хүүхдийн оршин суугаа газрын сум, дүүргийн Засаг даргад өөрийн биеэр хандана:</p> <p>Уг баримт бичгийн бүрдүүлбэрийг тус хуулийн 11.1.1-11.1.5, 11.2, 11.3-аас дэлгэрүүлж үзнэ үү.</p> <p>11.4.Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 11.1, 11.3-т заасан баримт бичгийн бүрдэл хангагдсан гэж үзвэл хүүхэд, гэр бүл, нийгмийн асуудал хариуцсан ажилтнаар дүгнэлт гаргуулна.</p> <p>11.5.Сум, дүүргийн Засаг дарга хүүхэд үрчлүүлэх эсэх тухай шийдвэрийг энэ хуулийн 11.4-т заасан дүгнэлтэд үндэслэн 20 хоногийн дотор гаргана.</p>
	<b>27 дугаар зүйл. Хүн ам, өрхийн бүртгэл</b>	<p>27.1.Статистикийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу баг, хорооны Засаг дарга хүн ам, өрхийн болон иргэний түр оршин суух бүртгэлийг хөтөлнө.</p> <p>27.2.Баг, хорооны Засаг дарга энэ хуулийн 27.1-д заасан бүртгэлийн мэдээллийг улсын бүртгэлийн байгууллагатай харилцан солилцоно.</p>

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

### ИРГЭНИЙ ХУУЛЬ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Иргэний хууль	<b>523 дугаар зүйл. Гэрээслэлийн хэлбэр, гэрээслэлийг гэрчлүүлэх</b>	523.1.Гэрээслэлийг бичгээр хийж, үйлдсэн газар, он, сар, өдрийг зааж, нотариатаар, гэрээслэл хийсэн газар нотариат байхгүй бол баг, сумын Засаг даргаар гэрчлүүлнэ.
	<b>528 дугаар зүйл. Өв хүлээн авах, хүлээн авахаас татгалзах журам</b>	528.1.Өвлүүлэгчийг нас барах хүртэл түүнтэй хамт амьдарч байсан өвлөгч нь өв нээгдсэнээс хойш гурван сарын дотор өв хүлээн авахаас татгалзсан тухайгаа нотариат буюу нотариат байхгүй газар баг, сумын Засаг даргад мэдэгдээгүй бол уг өвийг хүлээн авсан гэж үзнэ. 528.2.Энэ хуулийн 528.1-д зааснаас бусад өвлөгчид нь өв нээгдсэнээс хойш нэг жилийн дотор хуульд заасны дагуу өвлөгдсөн эд хөрөнгийг эзэмдэн авсан буюу эрхлэн удирдсан, эсхүл нотариат буюу баг, сумын Засаг даргад өв хүлээн авах буюу өвлөх эрхийн гэрчилгээ олгохыг хүсч, өргөдөл гаргасан байвал уг өвийг хүлээн авсан гэж үзнэ.
	<b>531 дүгээр зүйл. Өвлөх эрхийн гэрчилгээ олгох</b>	531.1.Хууль ёсны буюу гэрээслэлээр өвлөгч нь өвлөх эрхийн гэрчилгээ олгох хүсэлтийг өв нээгдсэн газрын нотариат, нотариатгүй газар баг, сумын Засаг даргад гаргана.
	<b>537 дугаар зүйл. Өвлөгдөх эд хөрөнгийг хамгаалах журам, хугацаа</b>	537.1.Өв нээгдсэн газрын нотариат, нотариатгүй газар баг, сумын Засаг дарга шаардлагатай гэж үзвэл өвлөгч, өвлүүлэгчийн үүрэг гүйцэтгүүлэгч, түүнчлэн төрийн ашиг сонирхлын үүднээс өвлөгдөх эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авна.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 12 дугаар сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

### МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Мал, амьтны эрүүл мэндийн тухай	<b>7 дугаар зүйл. Урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээг хэрэгжүүлэх</b>	<p>7.3.Орчны цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд доор дурдсан этгээд дараахь үүргийг хүлээнэ:</p> <p>7.3.3.сум, дүүргийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ гамшгийн улмаас хорогдсон мал, амьтны хүүр, сэг зэмийг цуглуулж устгах, бэлчээр, уст цэг, үерийн жалга, усны эх булгийг цэвэрлэх арга хэмжээг зохион байгуулах;</p> <p>7.3.4.гудамж, талбай, цэцэрлэг болон нийтийн эзэмшлийн газар үхсэн мал, амьтны талаархи иргэн, байгууллагаас мэдээлэл хүлээн авсан харьяалах хорооны Засаг дарга тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгжтэй хамтран цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийх, шаардлагатай үед сорьц авч лабораторид хүргүүлэх;</p> <p>7.4.Мал, амьтны шилжилт хөдөлгөөний хяналтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:</p> <p>7.4.1.мал, амьтан өмчлөгч мал, амьтнаа ялган тэмдэглэж, бүртгэл хөтлөх;</p> <p>7.12.Мал, амьтны шилжилт хөдөлгөөнд дараахь үйл ажиллагааг хориглоно:</p> <p>7.12.2.аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын хамтарсан шийдвэрээр отор, эсхүл нүүлгэн шилжүүлэлт хийхээс бусад тохиолдолд энэ хуулийн 7.4.1-д заасан ялган тэмдэглэгээ, бүртгэл хийгдээгүй мал, амьтныг сум, дүүргийн нутаг дэвсгэрээс гадагш тээвэрлэх, тууварлах, уналга, эдэлгээнд ашиглах;</p> <p>7.12.3.мал, амьтныг хяналтын цэгт шалгуулахгүй өнгөрөх, эсхүл тогтоосон замаас өөр замаар тээвэрлэх, тууварлах, уналга, эдэлгээнд ашиглах;</p>
	<b>9 дүгээр зүйл.</b>	9.4.Дархлаажуулалтын товыг мал эмнэлгийн тасаг тогтоож, баг, хорооны Засаг дарга малчин, амьтан маллагчид зарлан мэдээлнэ.
	<b>10 дугаар зүйл.</b>	10.1.Гоц халдварт өвчин гарсан үед мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын, бусад халдварт өвчин гарсан үед аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагын саналыг үндэслэн сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр энэ хуулийн 16.1.4-т заасан өвчингүй бүсэд байгаа мал, амьтныг нүүлгэн шилжүүлж болно.

<p><b>13 дугаар зүйл.</b> <b>Бэлэн байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх</b></p>	<p>13.4.Улсын бэлэн байдлын төлөвлөгөөнд тусгайлан заасан бол аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага, мал эмнэлгийн тасгийн саналыг үндэслэн тухайн шатны Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжүүлэх бэлэн байдлын дэд төлөвлөгөөг батална.</p>
<p><b>15 дугаар зүйл.</b> <b>Халдварт өвчнийг оношлох, шуурхай хариу арга хэмжээ хэрэгжүүлэх</b></p>	<p>15.5.Хорио цээр, хязгаарлалт тогтоох халдварт өвчний талаар мэдээлэл хүлээн авсан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараахь үйл ажиллагааг нэн даруй хэрэгжүүлнэ: 15.5.1.энэ хуулийн 17.2, 18.1, 18.3-т заасны дагуу дэглэм тогтоож, халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээг зохион байгуулах, хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, эсхүл хориглох; 15.5.2.энэ хуулийн 16.1.1-16.1.3-т заасан бүс дэх мал, гэрийн тэжээвэр болон зэрлэг амьтны байршил, нягтаршил, хөдөлгөөнийг тандах ажиллагааг зохион байгуулах.</p>
<p><b>17 дугаар зүйл.</b> <b>Хорио цээрийн дэглэм тогтоох, цуцлах</b></p>	<p>17.2.Хорио цээрийн дэглэм тогтоох өвчний жагсаалтад багтсан халдварт өвчин гарсан үед доор дурдсан албан тушаалтан голомтын бүсийн хилийн зааг болон хорио цээрийн дэглэмийг тогтоож, цуцална: 17.2.1.халдварт өвчний тархалт нэг сумын нутаг дэвсгэрийг хамарсан, эсхүл халдварт өвчний голомтыг нэгтгэх нөхцөл үүсээгүй бол мал эмнэлгийн тасгийн саналыг үндэслэн сумын Засаг дарга; 17.2.2.хоёр буюу түүнээс дээш сумын нутгийг хамарсан халдварт өвчний голомтыг нэгтгэх нөхцөл үүссэн бол аймгийн мал эмнэлгийн байгууллагын саналыг үндэслэн аймгийн Засаг дарга;</p>
<p><b>19 дүгээр зүйл.</b></p>	<p>19.1.Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед ажиллах мэргэжлийн багийг малын эмчээр ахлуулан тухайн сум, нийслэлийн Засаг дарга томилно.</p>
<p><b>23 дугаар зүйл.</b> <b>Мал, амьтнаас хүнд халдварладаг өвчинтэй тэмцэх, хяналтад авах арга хэмжээ</b></p>	<p>23.4.Аймаг, нийслэлийн Засаг дарга зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүлжүүлэх үйл ажиллагааг Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.2-т заасны дагуу, энэ хуулийн 23.2-т заасан хамтарсан зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлнэ. 23.6.Хот, суурин газрын нутаг дэвсгэрт мал, амьтан, тэдгээрийн гаралтай хүнсний бус түүхий эдийн худалдаа эрхлэх байршлыг тухайн шатны мал эмнэлгийн улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн Засаг дарга тогтооно. 28.7.Мал эмнэлгийн бүх шатны төрийн байгууллагын удирдах албан тушаалтныг доор дурдсанаар томилж, чөлөөлнө: 28.7.2.энэ хуулийн 28.3-т заасан байгууллагын захирлыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагын даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга; 28.7.3.мал эмнэлгийн тасгийн даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагын дарга.</p>
<p><b>30 дугаар зүйл.</b></p>	<p>30.12.Сум, дүүргийн Засаг дарга, мал эмнэлгийн тасаг, тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгж энэ хуулийн 28.2-т заасан байгууллагын даргын баталсан загварын дагуу гурвалсан гэрээ байгуулж, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх мал эмнэлгийн үйлчилгээг гүйцэтгүүлнэ.</p>

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 05 дугаар сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

### МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай	<b>5 дугаар зүйл. Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын үүрэг</b>	<p>5.1.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны бүх шатны байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>5.1.1.харьяа нутаг дэвсгэртээ мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>5.1.2.мал хулгайлах гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг судлан, арилгах арга хэмжээг зохион байгуулах;</p> <p>5.1.3.мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд олон нийтийг татан оролцуулж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагад дэмжлэг туслалцаа үзүүлэх;</p> <p>5.1.4.иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа мал сүргээ хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн сургалт, сурталчилгаа зохион байгуулах;</p> <p>5.1.5.төв суурин газар, хүнсний зах, махны үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж зэрэг шаардлагатай газарт мал, мах бэлтгэх төвлөрсөн цэг тогтоож, мал, махны гарал үүсэлд хяналт тавих;</p> <p>5.1.6.малыг им тамга, зүсийн бүртгэл, өдрийн хариулга, шөнийн манаатай болгох, эргүүл, харуул ажиллуулах ажлыг орон нутгийн онцлогт тохируулан зохион байгуулах, энэ хүрээнд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын үүсгэл санаачлагыг дэмжих;</p> <p>5.1.7.шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагатай хамтран энэ хуулийн 7.1.1-д заасан им тамга, бүртгэлтэй тулгаж, хэсэгчилсэн буюу ганцаарчилсан хяналтын тооллого явуулах;</p> <p>5.1.8.бод малыг улсын хэмжээнд индексжүүлсэн тамгын сүлжээнд хамруулах ажлыг зохион байгуулах.</p>
	<b>10 дугаар зүйл. гарал үүслийн гэрчилгээ</b>	<p>10.1.Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас төв суурин газарт борлуулах, худалдах зорилгоор оруулж байгаа мал, маханд мал, мах бэлтгэх гарал үүслийн гэрчилгээ олгоно.</p>
	<b>12 дугаар зүйл. Отрын болон тууврын малд бүртгэл хөтөлөх</b>	<p>12.1.Мал бүхий иргэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэг нэгжээс өөр нэгжид түр хугацаагаар оторлох болон тууварлах, шилжин суурьших тохиолдолд тухайн малчин малдаа бүртгэл хөтөлнө.</p> <p>12.2.Энэ хуулийн 12.1-д заасан бүртгэлд малын төрөл, тоо толгой, нас, хүйс, зүс, им тамга, оторлох нутаг, хугацаа, оторлох, тууварлах буюу шилжин суурьших засаг захиргааны нэгжийг заах бөгөөд уг бүртгэлийг тухайн сум, дүүргийн Засаг дарга батламжилна.</p>



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 12 дугаар сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

### МАЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Малын генетик нөөцийн тухай	<b>11 дүгээр зүйл. Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээ</b>	<p>11.2.Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх итгэмжлэл, зэрэг дэв бүхий мал зүйчтэй, стандартын шаардлага хангасан байр, тоног төхөөрөмж бүхий хуулийн этгээд, мал зүйч мэргэжилтэн өмчийн хэлбэр харгалзахгүйгээр Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгж байгуулж, үйл ажиллагааны чиглэлд тохирсон хөтөлбөрөө энэ хуулийн 16.8-д заасан байгууллагаар баталгаажуулснаар мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээг эрхлэх эрхтэй болно.</p> <p>11.6.Энэ хуулийн 11.2-т заасан үйлчилгээний нэгж нь тухайн сум, дүүргийн Засаг дарга, үйлчлүүлэгчтэй гэрээ байгуулж дараахь үйл ажиллагаа эрхэлнэ: Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгжийн үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг тус хуулийн 11.6 дахь хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.</p> <p>11.7.Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгж өөрийн байршиж байгаагаас өөр нутаг дэвсгэрт үйлчилгээ үзүүлэх эрхтэй бөгөөд энэ тохиолдолд тухайн сум, дүүргийн хөдөө аж ахуйн тасагт хүсэлтээ илэрхийлэн бүртгүүлж, энэ хуулийн 11.6-д заасан гэрээ байгуулан ажиллана.</p>

---о0о---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 6 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

### МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Малын индексжүүлсэн даатгалын тухай	<b>6 дугаар зүйл. Сумын малын хорогдлыг тогтоох, мэдээлэх</b>	<p>6.1.Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тухайн оны хагас жилийн мал тооллогын дүнг үндэслэн сумын малын хорогдлын тоог гаргана.</p> <p>6.2.Энэ хуулийн 6.1-д заасан тооллогыг тухайн жилийн 6 дугаар сарын эхний хагаст багтаан түүвэр судалгааны аргаар зохион байгуулна.</p> <p>6.3.Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 6.1-д заасны дагуу тогтоосон малын хорогдлын тоог өнгөрсөн жилийн эцэст тоологдсон малын тоонд харьцуулан сумын малын хорогдлын хувийг малын төрөл тус бүрээр гаргаж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.</p> <p>6.4.Бүх шатны Засаг дарга Статистикийн тухай хуульд заасан статистикийн мэдээллийн талаарх бүрэн эрхээс гадна энэ хуулийн 6.3-т заасан мэдээллийг даатгуулагчид шуурхай хүргэх арга хэмжээг авна.</p>
	<b>28 дугаар зүйл. Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих</b>	<p>28.1.Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг Санхүүгийн зохицуулах хороо болон бүх шатны Засаг дарга, давхар даатгалын компанийн удирдлага холбогдох хууль тогтоомжид заасан эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ.</p>

---o0o---





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Монгол Улсын ерөнхийлөгчийн сонгуулийн тухай	<b>39 дүгээр зүйл. Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх</b>	39.2.Сонгогчидтой хийх уулзалт, хурал, цуглаан зохион байгуулахад нь тухайн шатны Засаг дарга дэмжлэг үзүүлж, нэр дэвшигчдэд тэгш хандах үүрэгтэй.
	<b>56 дугаар зүйл. Санал авах байр, хугацаа</b>	56.2.Тухайн сонгуулийн хэсгийн харьяалагдах сум, дүүргийн Засаг дарга Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан зааврын дагуу санал авахад шаардлагатай дараах зүйлийг санал авах өдрөөс долоогоос доошгүй хоногийн өмнө бэлэн болгох үүрэгтэй: Санал авахад шаардлагатай уг зүйлийг тус хуулийн 56.2 дэх хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.
	<b>58 дугаар зүйл. Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах ажиллагаа</b>	58.1.1.эрүүл мэндийн байдлын улмаас санал авах байранд өөрийн биеэр очиж чадахгүй сонгогч; 58.3.Энэ хуулийн 58.1.1-д заасан сонгогч нь асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй бол тухайн сонгогчийн харьяалагдах баг, хорооны Засаг дарга түүний хүсэлт, мэдээллийг холбогдох хэсгийн хороонд хүргүүлэх үүрэгтэй.
	<b>67 дугаар зүйл. Санал авах өдөр хориглох үйл ажиллагаа</b>	67.1.Санал авах өдөр дараах үйл ажиллагааг хориглох бөгөөд аймаг, нийслэлийн Засаг дарга холбогдох шийдвэр гарган хяналт тавьж ажиллана: 67.1.1.согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах; 67.1.2.соёл урлаг, үзвэр, спортын зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээг зохион байгуулах; 67.1.3.гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төв ажиллах

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН ИРГЭНД ГАЗАР ӨМЧЛҮҮЛЭХ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай	<b>4 дүгээр зүйл.</b>	4.1.Иргэнд газрыг дараахь зориулалтаар өмчлүүлнэ: 4.1.1.гэр бүлийн хэрэгцээний; 4.1.2.аж ахуйн зориулалтаар.
	<b>12 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх</b>	12.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга дараахь бүрэн эрхтэй: 12.1.1.иргэдэд газар өмчлүүлэх талаархи төрийн нэгдсэн бодлого, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах; 12.1.2.сум, дүүргийн Засаг даргын саналыг хянаж нэгтгэн тухайн жилд аймаг, нийслэлийн хэмжээнд иргэдэд өмчлүүлэх газрын нийт хэмжээний тухай саналыг сум, дүүрэг бүрээр, энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан зориулалт тус бүрээр боловсруулж аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх; 12.1.3.аймгийн төвийн сумын Засаг дарга болон нийслэлийн дүүргийн Засаг даргын өргөн мэдүүлснээр иргэний газар өмчлүүлэх тухай өргөдлийг хүлээн авч, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг үндэслэн газар өмчлүүлэх тухай шийдвэр гаргах; 12.1.4.аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр газар өмчилж авсан иргэн өмчийнхөө газрыг гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөл, эзэмшилд шилжүүлсэн, газар тариалангийн газрыг зориулалт бусаар ашигласан, хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашигласан тохиолдолд тухайн газрыг хураан авах шийдвэр гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах; 12.1.5.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.
	<b>14 дүгээр зүйл. Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх</b>	14.1.Сум, дүүргийн Засаг дарга дараахь бүрэн эрхтэй: 14.1.1.Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах; 14.1.2.сум, дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд тухайн жилд иргэдэд өмчлүүлэх газрын байршил, нийт хэмжээний тухай саналыг дүүргийн хувьд хороо бүрээр, энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан зориулалт тус бүрээр, сумын хувьд баг, тосгон бүрээр, энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан зориулалт бүрээр тус тус боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх; 14.1.3.аймгийн төвийн сумын болон нийслэлийн дүүргийн Засаг дарга иргэдийн газар өмчлөх хүсэлтийг хүлээн авч аймаг, нийслэлийн Засаг даргад уламжлах, бусад сумын Засаг дарга уг

	<p>өргөдлийг хүлээн авч тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг үндэслэн газар өмчлүүлэх тухай шийдвэр гаргах;</p> <p>14.1.4.өмчийнхөө газрыг бусдад эзэмшүүлэх, ашиглуулахаар гаргасан иргэний хүсэлтийг хүлээн авч бусдад эзэмшүүлэх, ашиглуулах зөвшөөрөл олгох;</p> <p>14.1.5.иргэн өмчийнхөө газрыг гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөл, эзэмшилд шилжүүлсэн, газар тариалангийн газрыг зориулалт бусаар ашигласан, хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашигласан тохиолдолд тухайн иргэнд газар өмчлүүлэх шийдвэр гаргасан сумын Засаг дарга газрыг нь хураан авах шийдвэр гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах, эсхүл тухайн иргэнд газар өмчлүүлэх шийдвэр гаргасан аймаг, нийслэлийн Засаг даргад шүүхэд нэхэмжлэл гаргах саналыг уламжлах;</p> <p>14.1.6.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх</p>
<b>16 дугаар зүйл. Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх</b>	<p>16.1.Баг, хорооны Засаг дарга дараахь бүрэн эрхтэй:</p> <p>16.1.1.дээд шатны байгууллага болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас иргэдийн газар өмчлөлийн асуудлаар гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах;</p> <p>16.1.2.нутаг дэвсгэртээ Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих;</p> <p>16.1.3.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</p>
<b>18 дугаар зүйл.</b>	<p>18.1.Энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан зориулалтаар иргэнд өмчлүүлэх газрын үнийг газрын суурь үнэ, газрын үнэлгээний аргачлалыг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга тогтооно.</p>
<b>21 дүгээр зүйл. Газар өмчлүүлэх тухай шийдвэр гаргах</b>	<p>21.1.Иргэнд газар өмчлүүлэх эрх бүхий Засаг дарга иргэний гаргасан өргөдөл, тухайн иргэн энэ хуульд заасны дагуу газрыг өмчилж авах эрх бүхий этгээд болохыг нотолсны үндсэн дээр түүнд газар өмчлүүлэх тухай захирамж гаргана.</p>
<b>29 дүгээр зүйл. Иргэн өмчийн газраа бусдад эзэмшүүлэх, ашиглуулах</b>	<p>29.2.Иргэн өмчийн газраа бусдад эзэмшүүлэх, ашиглуулах зөвшөөрөл авах тухай хүсэлтээ сум, дүүргийн Засаг даргад бичгээр гаргана.</p> <p>29.5.Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 29.2-т заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор зөвшөөрөл өгөх эсэхийг шийдвэрлэнэ.</p> <p>Иргэн өмчийн газраа бусдад эзэмшүүлэх, ашиглуулахтай холбоотой зохицуулалтыг тус хуулийн 29.1-29.7 дахь хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.</p>
<b>30 дугаар зүйл.</b>	<p>30.1.Иргэн өмчийн газраа Засгийн газар, аймаг, нийслэл, сумын Засаг даргатай урьдчилан тохиролцсоны үндсэн дээр гэрээ байгуулан тодорхой хугацаагаар нийтийн эдэлбэр болон улсын, аймаг, нийслэл, сумын тусгай хэрэгцээнд түр ашиглуулж болно.</p>
<b>33 дугаар зүйл. Газар өмчлөгч иргэний эрхийг хязгаарлах эрх /сервитут/</b>	<p>33.1.Сум, дүүргийн Засаг дарга улсын болон тухайн нутаг дэвсгэрийн хүн амын нийтлэг ашиг сонирхлыг хангах зайлшгүй шаардлагатай тохиолдолд иргэнд өмчлүүлсэн газарт дор дурдсан нийтийн сервитут тогтоож болно:</p> <p>33.1.1.уг газраар дамжин өнгөрөх;</p> <p>33.1.2.уг газарт газрын заагийн болон геодезийн байнгын цэг, тэмдэгт тавих;</p> <p>33.1.3.намагжилтыг багасгах ажил гүйцэтгэх;</p> <p>33.1.4.газар зохион байгуулалтын бусад арга хэмжээ хэрэгжүүлэх.</p>

---о0о---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 12 сарын 20 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай	<b>14 дүгээр зүйл. Сонгуулийн байгууллага</b>	14.17.Сонгуулийн хороог аюулгүй байдлыг хангасан ажиллах байр, тээвэр, холбооны болон бусад шаардлагатай хэрэгслээр хангах асуудлыг тухайн шатны Засаг дарга хариуцна.
	<b>20 дугаар зүйл. Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх</b>	20.10.Хэсгийн хороо сонгогчдын нэрийн жагсаалтыг хүлээн авсан өдрөөс эхлэн өөрийн ажиллах байранд, өөрийн ажиллах байргүй бол сум, хорооны Засаг даргын Тамгын газрын байранд сонгогч өөрт нь холбогдох мэдээлэлтэй чөлөөтэй танилцах боломж олгоно.
	<b>44 дүгээр зүйл. Сонгогчтой хийх уулзалт, хурал, цуглаан</b>	44.2.Сонгогчтой хийх уулзалт, хурал, цуглаан зохион байгуулахад нь тухайн шатны Засаг дарга дэмжлэг үзүүлж, сонгуульд оролцогч талуудад тэгш хандах үүрэгтэй.
	<b>62 дугаар зүйл. Санал авах байр, хугацаа</b>	62.2.Тухайн хэсгийн харьяалагдах сум, дүүргийн Засаг дарга Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан зааврын дагуу санал авахад шаардлагатай дараах зүйлийг санал авах өдрөөс долоогоос доошгүй хоногийн өмнө бэлэн болгох үүрэгтэй: 62.2.1.санал авах байр; 62.2.2.сонгогч саналаа нууцаар өгөхөд шаардагдах бүхээг; 62.2.3.зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогч саналаа нууцаар өгөхөд шаардагдах бүхээг; 62.2.4.суурин болон зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг; 62.2.5.сонгогчийн бүртгэлийн мэдээллийг ажиглагчид үзүүлэх дэлгэц; 62.2.6.хууль тогтоомжид заасан бусад.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 сарын 07 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Монгол Улсын их хурлын тухай	<b>40 дүгээр зүйл. Гишүүний бүрэн эрхийн баталгаа</b>	40.17.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, түүний Тамгын газар өөрийн төсөвтөө тусгасны үндсэн дээр гишүүн, түүний бие төлөөлөгч-туслахыг албан өрөө, тавилга, техник хэрэгслээр хангаж шаардлагатай бусад дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Монгол Улсын хилийн тухай	<b>30 дугаар зүйл. Улсын хилийн бүс, түүнд мөрдөх журам</b>	30.1.Хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тусгай журам тогтоосон нутаг дэвсгэрийг улсын хилийн бүс гэх бөгөөд түүний өргөнийг улсын хил хамгаалах байгууллага тухайн нэгжийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр улсын хилийн шугамаас 100 км-ээс илүүгүйгээр тогтооно.
	<b>50 дугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг даргын бүрэн эрх</b>	50.1.Хилийн аймаг, сумын Засаг дарга дараахь бүрэн эрхтэй: 50.1.1.харьяалах нутаг дэвсгэрт нь байгаа улсын хил хамгаалах байгууллагын хангалт үйлчилгээнд туслалцаа үзүүлж, Монгол Улсын хилийн хууль тогтоомжийг иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага сахин биелүүлж байгаад хяналт тавих; 50.1.2.улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулахад шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх; 50.1.3.иргэнийг сайн дурын үндсэн дээр улсын хил хамгаалалтад татан оролцуулах; 50.1.5.хилийн аймаг, сумын төсөвт улсын хил хамгаалалтад зориулсан нэмэгдэл зардал тусгах. 50.2.Хилийн аймаг, сумын Засаг дарга нь энэ хуулийн 50.1-д заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор дэргэдээ улсын хил хамгаалалтад туслах хүчний орон тооны бус зөвлөл /цаашид "зөвлөл" гэх/ ажиллуулна.
	<b>52 дугаар зүйл. Улсын хил хамгаалалтад туслах хүчний удирдлага</b>	52.1.Улсын хил хамгаалалтад туслах хүчнийг хилийн аймаг, сумын Засаг дарга, түүний дэргэдэх зөвлөл, улсын хил хамгаалах байгууллага тус тусын бүрэн эрхийн хүрээнд удирдлагаар хангана. 52.2.Зөвлөлийн дарга нь хилийн аймаг, сумын Засаг дарга, түүний орлогч дарга нь хилийн цэргийн ангийн дарга, нарийн бичгийн дарга нь хилийн аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын дарга байна.

---о0о---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 2 дугаар сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

### МОНГОЛ ХЭЛНИЙ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Монгол хэлний тухай	<b>17 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга</b>	17.1. Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга дараах үүрэг хүлээнэ: 17.1.1. харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд энэ хуулийн хэрэгжилтийг хангах, түүнтэй холбоотой үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих; 17.1.2. харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд албан байгууллага, гудамж, талбайн нэр хаягийг кирил болон үндэсний бичгээр хослуулан, эсхүл дангаар нь бичиж хэвших ажлыг зохион байгуулах; 17.1.3. үндэсний бичгийн хэрэглээг түгээн дэлгэрүүлэхэд идэвх санаачилга гарган ажиллаж байгаа иргэн, хуулийн этгээдийг урамшуулах ажлыг зохион байгуулах; 17.1.4. хуульд заасан бусад үүрэг.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 01 сарын 29 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### МУЗЕЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Музейн тухай	<b>7 дугаар зүйл Музейн үйл ажиллагааны чиглэл</b>	7.3. Аймаг, нийслэлийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрт нь үйл ажиллагаа явуулдаг музейн үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор дөрвөн жил тутам хараат бус хуулийн этгээдээр үнэлгээ хийлгэнэ. 7.5. Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 7.3-т заасан үнэлгээний тайланг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.
	<b>8 дугаар зүйл Музейн үзүүлэг, дэглэлт</b>	8.3. Төрийн өмчийн музейн үзүүлэг, дэглэлтийг шинэчлэх төлөвлөгөөг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, орон нутгийн өмчийн музейн үзүүлэг, дэглэлтийг шинэчлэх төлөвлөгөөг аймаг, нийслэлийн Засаг дарга соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн батална. Хувийн музейн үзүүлэг, дэглэлтийг шинэчлэх төлөвлөгөөг үүсгэн байгуулагч нь батална.
	<b>18 дугаар зүйл Музейн үйл ажиллагаанд хяналт тавих</b>	18.1. Музейн үйл ажиллагаанд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга, Мэргэжлийн хяналтын байгууллага болон улсын байцаагч хяналт тавина.

---o0o---





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 5 дугаар сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Нийгмийн даатгалын тухай	<b>22 дугаар зүйл. Нийгмийн даатгалын байгууллагын удирдлага</b>	1.Нийгмийн даатгалын төв байгууллага нь нийгмийн даатгалын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний, орон нутгийн байгууллага нь тухайн шатны Засаг дарга болон нийгмийн даатгалын дээд шатны байгууллагын удирдлагын дор ажиллана.  3.Нийгмийн даатгалын төв байгууллагын даргыг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18 <sup>д</sup> дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу нийгмийн даатгалын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагын даргыг нийгмийн даатгалын төв байгууллагын дарга, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагын даргыг нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагын дарга тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө.
	<b>33 дугаар зүйл. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих</b>	Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ.

---о0о---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

### НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай	<b>3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</b>	<p>3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:</p> <p>3.1.5."хамаарал бүхий этгээд" гэж тухайн нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг;</p> <p>3.1.6."нэгдмэл сонирхолтой этгээд" гэж тухайн нийтийн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг;</p> <p>3.1.11."ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал" гэж тухайн нийтийн албан тушаалтан өөрийн нэг ангид сурч байсан болон сурч байгаа этгээд, мөн гишүүнчлэлд нь хамаардаг холбоо, сан, хамтын шийдвэр гаргадаг байгууллага, тэдгээрийн гишүүд, нэг нутгийн хүн гэх зэрэг олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгохуйц этгээдтэй холбоотой асуудлаар үйл ажиллагаа явуулахыг.</p>
	<b>7 дугаар зүйл. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар төрийн байгууллагын хүлээх нийтлэг үүрэг</b>	<p>7.1.Төрийн байгууллагын байрлаж байгаа байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлахыг хориглоно.</p> <p>7.2.Төрийн байгууллагын удирдлага ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авах үүрэгтэй:</p> <p>7.2.1.ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоож, мөрдүүлэх;</p> <p>7.2.2.хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу авах, бүртгэх, хянан шалгах;</p> <p>7.2.3.ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах ажлыг зохион байгуулах, мэдээлэл, мэдэгдлийн дагуу шалгах, хариуцлага хүлээлгэх;</p> <p>7.2.4.ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд хуульд заасан эрх мэдлээ хэрэгжүүлэхийг зөвшөөрөхгүй байх;</p> <p>7.2.5.ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг арилгах талаар бичгээр зөвлөмж өгөх;</p> <p>7.2.6.энэ хууль болон Засгийн газраас баталсан журмаар зөвшөөрсөн тохиолдолд өөрийн удирдлагад байгаа албан тушаалтан давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх.</p>

		7.3.Энэ хуулийн 7.2.2, 7.2.3-т заасан шалгалтын явцад авлигын шинжтэй зөрчил илэрсэн бол Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулна.
	<b>10 дугаар зүйл.</b>	10.1.Албан тушаалтан бүрэн эрхийнхээ дагуу олж авсан мэдээллийг хууль бусаар задруулах, албан үүрэгт нь хамааралгүй байдлаар ашиглахыг хориглоно.
	<b>20 дугаар зүйл.</b> <b>Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон хориглолт</b>	20.2. ... аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, ... албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд нээлттэй тендер шалгаруулалтаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд төрийн болон орон нутгийн хэрэгцээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авагч, төрийн санхүүгийн нөөц бүрдүүлэгч, төрөөс баталгаа гаргасан зээл хүртэгч аж ахуйн нэгжийн хувь, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч байж болохгүй. 20.3.Энэ хуулийн 20.2-т заасан албан тушаалтан, түүнтэй хамаарал бүхий этгээд энэ зүйлд заасан үүргийг нийтийн албанаас чөлөөлөгдсөний дараа хоёр жилийн хугацаанд мөн биелүүлнэ. 20.5.Албан тушаалтан нийтийн албанаас чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд албан үүргээ гүйцэтгэж байх хугацаандаа төрийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, улсын болон орон нутгийн нөөцийн хуваарилалт, удирдах, хянах, хариуцлага хүлээлгэх зэрэг асуудлаар шийдвэр гаргаж байсан аж ахуйн нэгжийн хувь, хөрөнгө эзэмшигч, хамтрагч болох, тус аж ахуйн нэгжээс хөрөнгө шилжүүлж авахыг хориглоно.
	<b>20<sup>1</sup> дүгээр зүйл.Улс төрд нөлөө бүхий зарим этгээдэд тавих хориглолт, хязгаарлалт</b>	20 <sup>1</sup> .1. ... аймаг, нийслэлийн Засаг дарга, эсхүл түүний эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, хүүхэд төрөөс санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт, арилжааны шинжтэй төсөл, хөтөлбөр, төрөөс олгох хөнгөлөлт, баталгаа, хандив, зээл хүртэгч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч байж болохгүй. 20 <sup>1</sup> .2. ... аймаг, нийслэлийн Засаг даргын эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, хүүхэд төрийн албаны удирдах албан тушаал эрхлэх, төрийн болон орон нутгийн өмчит компани, улсын үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлагад ажиллахыг хориглоно.
	<b>21 дүгээр зүйл.Албан тушаалаас чөлөөлөгдсөн ий дараах хязгаарлалт</b>	21.1.Албан тушаалтан нь албан үүргээс чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд ашиг сонирхлын зөрчил үүсч болох дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно: Уг хориглосон үйл ажиллагааг тус хуулийн 21.1 дэх хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү. 21.2.Энэ хуулийн 21.1.2-т заасан хязгаарлалт нь тухайн этгээд албан тушаалд сонгогдож, томилогдохоос өмнө байгуулагдсан буюу сунгагдсан гэрээ, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ, түүнчлэн нээлттэй тендер шалгаруулалтын дагуу байгуулагдсан, эсхүл жилийн орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс бага үнийн дүн бүхий гэрээ, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд хамаарахгүй. 21.3.Албан тушаалтан энэ хуулийн 21.1-д заасан хязгаарлалтад хамаарах этгээдтэй албаны чиг үүргийн дагуу харилцаа тогтоохыг хориглоно.

---ооо---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 12 дүгээр сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

### НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯРЫН БОЛОН ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай	<b>3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо</b>	.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: 3.1.1."нийтээр тэмдэглэх баярын өдөр" гэж улс орны хэмжээнд нийтээр амарч, баяр болгон тэмдэглэдэг өдрийг;
	<b>4 дүгээр зүйл. Нийтээр тэмдэглэх баярын өдөр</b>	4.1.Нийтээр тэмдэглэх баярын өдөр: 4.1.1.Хуульд өөрөөр заагаагүй бол Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяр: 7 дугаар сарын 10, 11, 12, 13, 14, 15; 4.1.3.Цагаан сар: билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 1, 2, 3; 4.1.4.Шинэ жил: 1 дүгээр сарын 1; 4.1.5.Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр: 3 дугаар сарын 8; 4.1.6.Хүүхдийн баяр: 6 дугаар сарын 1. 4.1.7.Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр: 12 дугаар сарын 29. 4.1.8.Их Эзэн Чингис хааны өдөр: Их Эзэн Чингис хаан мэндэлсэн билгийн тооллын өвлийн тэргүүн сарын шинийн 1. 4.1.9.Бүгд Найрамдах Улс тунхагласан өдөр: 11 дүгээр сарын 26. 4.1.10.Бурхан багшийн Их дүйчин өдөр: билгийн тооллын зуны тэргүүн сарын шинийн 15. 7.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга төсөвт зардлыг хэтрүүлэхгүйгээр баярын болон тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулна.

---оОо---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 12 сарын 19 өдөр

Улаанбаатар хот

### НОМЫН САНГИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Номын сангийн тухай	<b>24 дүгээр зүйл. Номын сангийн үйл ажиллагаанд үзүүлэх дэмжлэг</b>	<p>24.4.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ иргэдэд номын сангийн үйлчилгээг хүргэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>24.4.1.номын сангийн сан хөмрөгийг баяжуулах, сэргээн засварлах, хамгаалах, номын сангийн үйлчилгээ хүргэх төлөвлөгөө, хөтөлбөрийн төсөл боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулан хэлэлцүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;</p> <p>24.4.2.зөөврийн номын сангийн үйлчилгээг малчид, тариаланчид, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүргэх арга хэмжээг зохион байгуулах;</p> <p>24.4.3.уншлагыг дэмжих олон талт арга хэмжээ, үйлчилгээг зохион байгуулахад төсөв, санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлэх;</p> <p>24.4.4.номын сангийн үйлчилгээний стандарт, норм, нормативыг сахин мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих;</p> <p>24.4.5.номын сангийн сан хөмрөгийг хадгалах, хамгаалах, цахим үйлчилгээ нэвтрүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, холбогдох зардлыг төсөвт тусгах.</p> <p>24.5.Энэ хуулийн 24.1-д заасан зардлыг төр хариуцна.</p>

---оОо---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 5 дугаар сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

### НЯЛХ, БАЛЧИР ХҮҮХДИЙН ХҮНСНИЙ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай	<b>17 дугаар зүйл. Төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүлээх үүрэг</b>	17.1.Төрийн байгууллага, аж ахуйн нэгж нь хүүхэд хөхүүлэх, хооллох орчин, нөхцөлийг бүрдүүлж болно. 17.2.Иргэн хүүхдэд зориулсан хүнстэй холбоотой зүй бус зар сурталчилгаа болон хууль зөрчсөн үйлдлийг холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.
	<b>18 дугаар зүйл. Хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих</b>	18.1.Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хууль тогтоомжийн биелэлтэд дараахь этгээд хяналт тавина: 18.1.1.төрийн хяналтыг бүх шатны Засаг дарга, хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан өөрсдийн эрх хэмжээний хүрээнд;

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

### ОЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Ойн тухай	<b>6 дугаар зүйл. Ойн мэдээллийн сангийн тогтолцоо, журам</b>	6.4.Бүх шатны Засаг дарга ой, хээрийн түймрийн цагийн байдлын тухай мэдээг дээд шатны Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тогтмол хугацаанд шуурхай мэдээлнэ.
	<b>17 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх</b>	17.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 17.2.1.ойн тухай хууль тогтоомж, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах; 17.2.2.ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах, биелэлтийг хангах; 17.2.3.ойн сангийн мэдээ, тайланг төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж байх; 17.2.4.тухайн жилд ойгоос бэлтгэх модны хэмжээний талаарх саналаа төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх; 17.2.5.ой, хээрийн түймрээс учирсан хохирлын хэмжээг тогтоолгож, байгаль орчныг нөхөн сэргээх талаар улсын захиалга өгч, судалгаа-шинжилгээний ажил гүйцэтгүүлэх, үр дүнг тооцож, хэрэгжүүлэх арга хэмжээ авах; 17.2.6.ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаар ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагаас явуулж байгаа үйл ажиллагааны явцад хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах, шаардлагатай бол ойн санд сөргөөр нөлөөлж байгаа үйл ажиллагааг нь түдгэлзүүлэх, зогсоох; 17.2.7.ойн хөнөөлт шавж, өвчин, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, учирсан хохирлыг арилгах, ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс шаардагдах хөрөнгийг батлуулах, хэрэгжүүлэх; 17.2.8.аймгийн байгаль орчны газрын харьяанд сум дундын ойн анги, нийслэлийн байгаль орчны газарт ойн асуудал эрхэлсэн нэгж байгуулж, бүтэц, орон тоог батлан, тэдгээрийн даргыг ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөн томилж, чөлөөлөх;
	<b>18 дугаар зүйл. Сум, дүүргийн</b>	18.2.Сум, дүүргийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 18.2.1.ойн тухай хууль тогтоомж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, дээд шатны байгууллагын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

	<p><b>болон Засаг даргын бүрэн эрх</b></p>	<p>18.2.2.ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх;</p> <p>18.2.3.энэ хуулийн 34.1, 38.1-д заасны дагуу эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээг олгоход хяналт тавих, уг эрхийн бичиг, гэрчилгээг үндэслэлгүй олгосон нь тогтоогдвол түүнийг хүчингүй болгох;</p> <p>18.2.4.ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийн түймрээс хамгаалах талаарх ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах, тэдний тарьж ургуулсан таримал ойг хүлээн авах;</p> <p>18.2.5.ой, хээрийн түймэр, хөнөөлт шавж, өвчин, хууль бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, учирсан хор хөнөөлийг арилгах;</p> <p>18.2.6.энэ хуулийн 18.1.4-т заасан шийдвэрийг үндэслэн ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойн сангийн тодорхой хэсгийг болзол, хугацаатайгаар эзэмшүүлэх гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих;</p> <p>18.2.7.ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөг үндэслэн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон хязгаарт багтаан мод бэлтгэх шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хяналт тавих;</p> <p>18.2.8.ойн нөөцийн бүртгэл, ой зохион байгуулалтын ажлыг өөрийн хариуцсан нутаг дэвсгэртээ ойн мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, сумын ойн менежментийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх;</p> <p>18.2.9.ойн ангийн дарга болон ойн асуудал эрхэлсэн албан тушаалтныг томилох, чөлөөлөх;</p> <p>18.2.10.ой, хээрийн түймрээс хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах арга хэмжээний орон нутгийн төлөвлөгөөг жил тутамд батлан хэрэгжилтийг зохион байгуулах;</p> <p>18.2.11.төмөр зам, хот хоорондын зам, иргэдийн өвөлжөө, хаваржаа, үтрэм, тариалангийн талбай, ой дахь барилга, байгууламжид ой, хээрийн түймрийн хамгаалалтын зурвас хийлгэж, хүлээн авах;</p> <p>18.2.12.нутаг дэвсгэртээ ой, хээрийн түймрийн аюултай үед эргүүл, харуул ажиллуулах, иргэд, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг энэ ажилд татан оролцуулах;</p> <p>18.2.13.ой, хээрийн түймэр унтраах ажлыг удирдан зохион байгуулж, дайчилгааны дэс дараалал, хуваарийг түймрийн аюултай үе эхлэхээс өмнө жил бүр гаргаж мөрдүүлэх;</p> <p>18.2.14.ой, хээрийн түймрийн аюултай үед ой, хээрт аялал, зугаалгаар явах, ан агнах, мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах болон бусад төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд зөвшөөрөл олгож, шаардлагатай тохиолдолд дээрх үйл ажиллагааг хязгаарлах, зогсоох талаар дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;</p> <p>18.2.15.ой, хээрийн түймрээс учирсан хохирол, түймрийг унтраахад гарсан зардлын хэмжээг тогтоох ажлын хэсгийг томилж ажиллуулах;</p> <p>18.2.16.ой, хээрийн түймэр хоёр ба түүнээс дээш сумын нутаг дэвсгэрийг хамарсан тохиолдолд түймрийг унтраахад гарсан зардлыг аймаг, нийслэлийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх;</p> <p>18.2.17.ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар нутаг дэвсгэртээ сургалт, сурталчилгаа явуулах болон нутгийн өрх, мод бэлтгэх үйл ажиллагаа эрхэлдэг ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойн сан бүхий газрыг хариуцуулж, хяналт тавих;</p> <p>18.2.18.ой, хээрийн түймэр унтраах ажлыг шуурхай зохион байгуулж хүн хүч, техник хэрэгслийг дайчлах, ой, хээрийн түймэр гарсан тухай болон түймрийг унтраах ажлын явцын талаарх мэдээллийг дээд шатны Засаг</p>
--	--	---



	<p>дарга, холбогдох бусад байгууллагад цаг хугацаанд нь шуурхай мэдээлэх;</p> <p>18.2.19.ой, хээрийн түймрийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох, түймэр тавьсан гэм буруутай этгээдийг тогтооход цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах.</p>
<p><b>19 дүгээр зүйл.</b> <b>Баг, хорооны</b> <b>Засаг даргын</b> <b>бүрэн эрх</b></p>	<p>19.2.Баг, хорооны Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>19.2.1.ойн тухай хууль тогтоомж, иргэдийн Нийтийн Хурал болон дээд шатны байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;</p> <p>19.2.2.нутаг, дэвсгэртээ мод, сөөг тарих ажлыг зохион байгуулж, иргэдийг өргөнөөр оролцуулах;</p> <p>19.2.3.ой, хээрийн түймрээс хамгаалах сурталчилгааг хүн бүрт хүргэж түймэртэй тэмцэх бэлтгэлийг хангуулах;</p> <p>19.2.4.ой, хээрийн түймэртэй тэмцэх ажлыг шуурхай зохион байгуулах, хүн хүч, техник хэрэгслийг дайчлах, ой, хээрийн түймэр гарсан тухай болон түймрийг унтраах ажлын явцыг дээд шатны Засаг дарга болон холбогдох бусад байгууллагад шуурхай мэдээлэх;</p> <p>19.2.5.нутаг дэвсгэр дэх ойн сан бүхий газруудыг тодорхой хугацаагаар иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгжид хариуцуулж хяналт тавих;</p> <p>19.2.6.ой, хээрийн түймрийн шалтгаан, гаргасан этгээд, хохирлыг тогтооход эрх бүхий байгууллагад дэмжлэг үзүүлэх.</p>
<p><b>21 дүгээр зүйл.</b> <b>Ойн нөхөрлөл,</b> <b>түүний эрх, үүрэг</b></p>	<p>Ойн нөхөрлөлд ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээ олгохтой холбоотой асуудлыг тус хуулийн 21, 22 дугаар зүйлээс дэлгэрүүлж үзнэ үү.</p>
<p><b>31 дүгээр зүйл.</b> <b>Мод тарьж</b> <b>ургуулах ажлыг</b> <b>зохион байгуулах</b></p>	<p>31.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга бүх нийтээр мод тарих сарын ажлыг жил бүр зохион байгуулж, 16 насанд хүрсэн иргэн бүр нэг, аж ахуйн нэгж, байгууллага таваас доошгүй мод тарьж ургуулах, услах, арчлах бөгөөд өөрийн хүчээр гүйцэтгэх боломжгүй тохиолдолд зардлыг хандивлана.</p> <p>31.2.Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга мод суулгах талбайг сонгох, хөрс боловсруулах, тарьц суулгацаар хангах, тэдгээрийг услах, арчлах ажлыг ойн мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж, уг ажилд иргэдийг татан оролцуулна.</p>
<p><b>36 дугаар зүйл.</b> <b>Өөр аймаг,</b> <b>сумын нутаг</b> <b>мод бэлтгэх</b></p>	<p>36.1.Өөр аймаг, сумын нутагт мод бэлтгэх бол зохих шатны Засаг дарга нар урьдчилан тохиролцож, тухайн жилд бэлтгэх модны дээд хязгаарт оруулах саналаа аймаг, нийслэлийн Засаг дарга төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.</p> <p>36.2.Энэ хуулийн 36.1-д заасны дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга нар мод бэлтгэх талаар тохиролцоонд хүрч чадаагүй бол төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.</p>
<p><b>43 дугаар зүйл.</b> <b>Ой, хээрийн</b> <b>түймрээс</b> <b>учирсан</b> <b>хохирлыг</b> <b>тогтоох</b></p>	<p>43.1.Ой, хээрийн түймрээс учирсан хохирлыг зохих шатны Засаг даргын шийдвэрээр байгуулсан ажлын хэсэг тухайн түймэр унтарснаас хойш 30 хоногт багтаан тогтооно.</p> <p>43.3.Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан таримал ой болон тэдгээрийн эзэмшлийн ойд гаднаас түймэр орж хохирол учруулсан тохиолдолд хохирлын хэмжээг төр хариуцаж, ойжуулалтын ажлыг улсын хөрөнгөөр гүйцэтгэж өгнө.</p>
<p><b>44 дүгээр зүйл.</b> <b>Ой, хээрийн</b> <b>түймэр унтраах</b> <b>дайчилгааг</b> <b>зохион байгуулах</b></p>	<p>44.1.Бүх шатны Засаг дарга нар хүн хүч, техник хэрэгслийг дайчлан нутаг дэвсгэртээ гарсан ой, хээрийн түймрийг унтраах ажлыг шуурхай зохион байгуулах, түүнтэй холбогдсон Засаг даргын шаардлагыг иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага заавал биелүүлэх үүрэгтэй.</p>



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

### ОНЦ БАЙДЛЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Онц байдлын тухай	<b>3 дугаар зүйл. Онц байдал</b>	Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт буюу түүний зарим хэсэгт Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болсон үед онцгой нөхцөл, түүний үр дагаврыг арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгох зорилгоор энэ хуульд заасны дагуу иргэдийн эрх, эрх чөлөө, хуулийн этгээдийн эрхийг хязгаарлаж, тэдэнд нэмэгдэл үүрэг хариуцуулан төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд тодорхой хугацаагаар тогтоосон эрх зүйн онцгой дэглэмийг онц байдал гэнэ.
	<b>4 дүгээр зүйл. Онц байдал зарлах үндэслэл</b>	Монгол Улсын Үндсэн хуульд заасан ёсоор дор дурдсан онцгой нөхцөл бий болсон үед онц байдал зарлаж болно: 1/ улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал тохиолдсон; 2/Үндсэн хуулийн дэг журам, нийгмийн хууль ёсны тогтолцоо оршин тогтноход заналхийлсэн аливаа байгууллага, бүлэг хүний зохион байгуулалт бүхий хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн нийтийн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр тохинуулах боломжгүй болсон.
	<b>10 дугаар зүйл. Засаг даргын онцгой бүрэн эрх</b>	1.Энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан үндэслэлээр онц байдал тогтоосон бол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараахь онцгой бүрэн эрх эдэлнэ: 1/энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 6-д заасан бүрэн эрхийг тухайн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх; 2/энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан онцгой арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг тухайн нутаг дэвсгэрт удирдан зохион байгуулах; 3/тухайн болон доод шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр онц байдал тогтоосон шийдвэр, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Монгол Улсын Үндэсний

		<p>аюулгүй байдлын зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаварт харшилж байна гэж үзвэл онц байдлын хугацаанд үйлчлэлийг зогсоох;</p> <p>4/онц байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэх асуудлаар тухайн нутаг дэвсгэрийн холбогдох байгууллага, албан тушаалтанд харьяалал харгалзахгүйгээр заавал биелүүлэх үүрэг даалгавар өгч, хэрэгжилтэд нь хяналт тавих;</p> <p>5/онц байдал тогтоосон шийдвэр, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засаг даргаас өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлээгүй төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдах албан тушаалтныг огцруулж, орны хүнийг онц байдлын хугацаагаар томилох;</p> <p>6/онц байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор тухайн нутаг дэвсгэрт тусгай үүрэг гүйцэтгэж байгаа цагдаа, тагнуул, цэргийн болон бусад байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, харилцан ажиллагааг хангах;</p> <p>7/онц байдал тогтоосон шийдвэр, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх зорилгоор тэдгээрт нийцүүлэн захирамж гаргах.</p> <p>2.Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан Засаг даргын захирамжийг тухайн нутаг дэвсгэр дэх аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэд заавал биелүүлэх үүрэгтэй.</p> <p>3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан онцгой бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ Засаг дарга энэ хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан асуудлаар төрийн өмчийн болон төрийн өмч давамгайлсан аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын аливаа шийдвэрийг, түүнчлэн дээд шатны Засаг дарга нь доод шатны Засаг даргын аливаа шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох эрхтэй.</p>
--	--	---

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

### ОРОН СУУЦНЫ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Орон сууцны тухай	<b>8 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх</b>	8.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга орон сууцны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.2.1.нутаг дэвсгэртээ орон сууц хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө болон орон сууцны хорооллын хэсэгчилсэн төлөвлөгөөний төсөл боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх; 8.2.2.орон сууцны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; 8.2.3.орон сууцны тооллого, паспортжуулах ажлыг зохион байгуулан мэдээллийн санг эрхлэн хөтөлж, холбогдох мэдээллийг орон сууцны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад өгөх; 8.2.4.орон сууц хөгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэх.
	<b>15 дугаар зүйл. Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн зориулалт, төлөвлөлтийг өөрчлөх</b>	15 <sup>1</sup> .3.Ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцны оронд шинээр орон сууцны барилга барих хөрөнгө оруулагч нь аймаг, нийслэлийн Засаг дарга, сууц өмчлөгчидтэй харилцан тохиролцож гэрээ байгуулах бөгөөд уг гэрээнд сууц өмчлөгчдийг нүүлгэн шилжүүлэх, орон сууцаар түр хангах, шинэ орон сууцны ашиглалтад орох хугацаа, талбайн хэмжээ, үнэ, төлбөр, хариуцлагын асуудлыг тусгана.
	<b>16 дугаар зүйл. Нийтийн зориулалттай орон сууцны байшинд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх</b>	16.3.Барилгын хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь орон сууцны тухай болон холбогдох бусад хууль тогтоомж, тухайн орон сууцны Сууц өмчлөгчдийн холбооны дүрэмд заасны дагуу сууцандаа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг хянан шалгана.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 10 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

### ОРОН СУУЦ ХУВЬЧЛАХ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
<b>ОРОН СУУЦ ХУВЬЧЛАХ ТУХАЙ</b>	<b>10 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх</b>	<p>1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга төрийн өмчийн орон сууцыг хувьчлах талаар дараахь бүрэн эрхтэй:</p> <p>1/ орон сууц хувьчлах үүрэг бүхий орон сууц хувьчлах товчоог аймаг, нийслэл, сум, дүүрэгт байгуулах талаар төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөх;</p> <p>2/ нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд төрийн өмчийн орон сууц хувьчлах ажлын талаар мэдээлэл авах, хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>3/ орон сууц хувьчлах товчоог ажлын байраар хангах;</p> <p>4/ нутаг дэвсгэрийнхээ орон сууц ашиглалтын байгууллагыг орон сууц хувьчлах бэлтгэл ажил хангахад татан оролцуулах;</p> <p>5/ орон сууц хувьчлахтай холбоотой асуудлаар орон сууцны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох бусад байгууллагад санал оруулах;</p> <p>6/ хуульд заасан бусад бүрэн эрх.</p>
	<b>13 дугаар зүйл. Магадлан шинжлэх хэсэг</b>	<p>1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын хамтын шийдвэрээр хувьчлах орон сууцны чанар, аваарь, осолгүйн байдал, ариун цэвэр, эрүүл ахуйн болон техникийн шаардлага хангасан эсэхийг тогтоож, тухайн орон сууц хүн амьдрах шаардлага хангаж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах бүрэн эрхтэй орон тооны бус магадлан шинжлэх хэсгийг байгуулна.</p> <p>Магадлан шинжлэх хэсэгтэй холбоотой нарийвчилсан зохицуулалтыг тус хуулийн 13 дугаар зүйлээс дэлгэрүүлж үзнэ үү.</p>
	<b>14 дүгээр зүйл. Магадлан шинжлэх хэсгийн дүгнэлт</b>	<p>1. Магадлан шинжлэх хэсэг тухайн орон сууц хүн амьдрах шаардлага хангасан эсэх талаар дүгнэлт гаргана.</p> <p>2. Аймаг, нийслэлийн Засаг дарга магадлан шинжлэх хэсгийн дүгнэлтийг үндэслэн хүн амьдрах шаардлага хангасан болон үл хангасан орон сууцны жагсаалтыг баталж, нийтэд мэдээлнэ.</p>

---о0о---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 01 сарын 23 өдөр

Улаанбаатар хот

### ОЮУНЫ ӨМЧИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Оюуны өмчийн тухай	<b>11 дүгээр зүйл. Оюуны өмчийн байгууллага</b>	11.5.Оюуны өмчийн байгууллагын орон нутаг дахь хэлтэс, тасаг, оюуны өмчийн улсын байцаагч үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд тухайн шатны нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг дарга дэмжлэг үзүүлнэ.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 2 дугаар сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

### ӨРИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Өрийн удирдлагын тухай	<b>10 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх</b>	10.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга өрийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.2.1.орон нутгийн хэмжээнд зээллэгийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг боловсруулж, энэ хуулийн 19.1-д заасны дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх; 10.2.2.тухайн орон нутагт зээллэгийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, үйл ажиллагаанд хяналт тавих; 10.2.3.энэ хуульд заасны дагуу зээлийн гэрээ, хэлэлцээр байгуулах ажлыг зохион байгуулах, аймаг, нийслэлийн үнэт цаас гаргах; 10.2.4.тухайн орон нутагт гадаад зээллэгийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг холбогдох тооцоо, судалгааны хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх; 10.2.5.гадаад зээллэгийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн дотоодын эх үүсвэрийн хэмжээг жил бүрийн төсвийн төсөлд тусгуулах; 10.2.6.хуульд заасан бусад бүрэн эрх.
	<b>12 дугаар зүйл. Өр үүсгэх зориулалт</b>	12.3.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь энэ хуулийн 19 281 дүгээр зүйлд заасныг баримтлан төсөвт туссаны үндсэн дээр Засгийн газраас зөвшөөрснөөр өр үүсгэж болно.
	<b>28<sup>1</sup> дүгээр зүйл. Аймаг, нийслэл үнэт цаас гаргах</b>	28 <sup>1</sup> .2.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь тухайн аймаг, нийслэлийн нэрийн өмнөөс үнэт цаас гаргагчийн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 5 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

### СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Соёлын өвийг хамгаалах тухай	<b>16 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх</b>	<p>16.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>16.1.1.соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон дээд шатны байгууллагын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;</p> <p>16.1.2.соёлын өвийг хамгаалах, зохистой ашиглах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж батлуулах, биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;</p> <p>16.1.3.соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, хамгаалах, хяналт тавих ажлыг зохион байгуулах;</p> <p>16.1.4.соёлын өвийн судалгаа, тайлан мэдээллийг зохих журмын дагуу гаргаж, аймаг, нийслэл, улсын бүртгэл, мэдээллийн санд хүргүүлэх;</p> <p>16.1.5.зохих журмын дагуу соёлын өвийн үзлэг, тооллого хийх;</p> <p>16.1.6.соёлын өвд эрсдэл учруулахуйц аливаа үйл ажиллагааг таслан зогсоож, хуульд заасны дагуу арга хэмжээ авах;</p> <p>16.1.7.палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрөл авсан мэргэжлийн байгууллага, багт дэмжлэг үзүүлэх;</p> <p>16.1.8.соёлын өвийг сурталчлах;</p> <p>16.1.9.дэлхийн болон үндэсний соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын бүс тогтоох ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх;</p> <p>16.1.10.соёлын өвийг хамгаалахад идэвх, санаачилгатай оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, хуульд заасан дэмжлэг үзүүлэх;</p> <p>16.1.11.түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хууль бус малтлагыг таслан зогсоох, соёлын өвийн зөрчлийн талаарх мэдээллийн мөрөөр арга хэмжээ авах ажлыг удирдан зохион байгуулах;</p> <p>16.1.12.соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг олж тогтоох, олон нийтэд таниулах, дэмжлэг үзүүлэх, өвлөн уламжлуулах ажлыг зохион байгуулах;</p> <p>16.1.13.хуульд заасан бусад бүрэн эрх.</p>
	<b>17 дугаар зүйл. Сум, дүүргийн Засаг</b>	<p>17.1.Сум, дүүргийн Засаг дарга соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>17.1.1.соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг хангах;</p>



	<p><b>даргын бүрэн эрх</b></p>	<p>17.1.2.соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, хамгаалах, хяналт тавих ажлыг зохион байгуулах;</p> <p>17.1.3.палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллага, багт зориулалт бүхий газрыг ашиглуулах;</p> <p>17.1.4.палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгааны ажил дууссаны дараа судалгаа явуулсан байгууллагаас уг газрыг аюул осолгүй болгохыг шаардах, хүлээн авах.</p> <p>17.1.5.харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа дэлхийн болон үндэсний соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын захиргааны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;</p> <p>17.1.6.сум, дүүргийн хамгаалалтад байгаа түүх, соёлын дурсгалт газрыг аялал жуулчлалын байгууллагад гэрээгээр ашиглуулах;</p> <p>17.1.7.устах, эвдрэх, гэмтэх аюул учирч байгаа соёлын өвийг авран хамгаалах, сэргээн засварлах, сэргээн уламжлуулах арга хэмжээ авах.</p>
	<p><b>19 дүгээр зүйл. Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх</b></p>	<p>19.1.Баг, хорооны Засаг дарга соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>19.1.1.соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж, иргэдийн Нийтийн Хурал болон дээд шатны хурал, Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;</p> <p>19.1.2.соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд иргэдийг татан оролцуулах;</p> <p>19.1.3.түүх, соёлын үл хөдлөх дурсгал, түүний орчныг цэвэр үзэмжтэй байлгах, хог хаягдлыг цэвэрлэхэд иргэдийг татан оролцуулах ажлыг зохион байгуулах;</p> <p>19.1.4.соёлын өвийг хамгаалахад идэвх, санаачилгатай оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хуульд заасны дагуу урамшуулах, дэмжлэг үзүүлэх, дээд шатны байгууллагад уламжлах;</p> <p>19.1.5.хуульд заасан бусад бүрэн эрх.</p>
	<p><b>37 дугаар зүйл. Соёлын өвийг хамгаалах тогтолцоо</b></p>	<p>37.1.Соёлын өвийг хамгаалах асуудлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага болон бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, энэ хуулиар үүрэг хүлээсэн байгууллага, эрх бүхий этгээд хариуцна.</p> <p>37.2.Соёлын өвийн хамгаалалтад соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, бүх шатны Засаг дарга, соёлын өвийн хяналтын улсын байцаагч, гэрээт харуул, хуулиар эрх олгосон байгууллага, албан тушаалтан хяналт тавина.</p> <p>37.5.Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын дэргэд тухайн дурсгалын талаарх мэдээллийг агуулсан танилцуулга, тайлбар, тэмдэг, тэмдэглэгээ байрлуулна. Танилцуулга, тайлбар, тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу хийж, байрлуулах ажлыг аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцан зохион байгуулна.</p> <p>37.6.Аймаг, нийслэлийн Засаг дарга хот, суурин газарт орших түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын харагдах сүр барааг хадгалах зорилгоор түүний эргэн тойронд шинээр барих барилга байгууламжид өндрийн хязгаар тогтооно. Өндрийн хязгаар тогтоох шалгуур үзүүлэлтийг хот байгуулалтын болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.</p>
	<p><b>39 дүгээр зүйл. Соёлын биет бус өвийг</b></p>	<p>39.1.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон бүх шатны Засаг дарга соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийг тухайн угсаатан ястны түүх, уламжлал, ёс заншил, ахуй нөхцөлтэй нь</p>

	<p><b>өвлөн уламжлуулах</b></p>	<p>уялдаатайгаар судалж, сурталчлах, өвлөн уламжлуулах, хадгалж хамгаалах асуудлыг хариуцна.</p> <p>39.3.Соёлын биет бус өвийг хамгаалах, биет бус өвийг өвлөн уламжлагчийг урамшуулах, шавь сургалт зохион байгуулах асуудлыг бүх шатны Засаг дарга зохион байгуулна.</p>
	<p><b>40 дүгээр зүйл. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах</b></p>	<p>40.3.Энэ хуульд заасан шаардлагыг зөрчсөн этгээдийг илрүүлсэн, соёлын өвийг хуулбарласан, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулсан тухай мэдээлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, улсын байцаагч, гэрээт харуулд борлуулалтын орлогын 15 хувийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга олгоно.</p>
	<p><b>45 дугаар зүйл. Түүх, соёлын дурсгалт газар</b></p>	<p>45.2.Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 45.1-д заасны дагуу хамгаалалтын бүс тогтоосон түүх, соёлын дурсгалт газарт гэрээт харуул томилж ажиллуулна.</p>
	<p><b>58 дугаар зүйл. Соёлын өвийн хяналт</b></p>	<p>58.1.Соёлын өвийн хяналтыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, бүх шатны Засаг дарга, улсын байцаагч, гэрээт харуул хэрэгжүүлнэ.</p> <p>58.5.Соёлын өвийн гэрээт харуулыг сум, дүүргийн Засаг дарга томилно.</p>

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 07 сарын 02 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### СОЁЛЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Соёлын тухай	<b>18 дугаар зүйл. Соёлын байгууллагын эрх, үүрэг, удирдлага</b>	18.2.Аймаг, нийслэлийн соёлын газрын удирдлагыг аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө. 18.3.Төрийн өмчийн соёлын байгууллагын удирдлагыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн соёлын байгууллагын удирдлагыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн аймаг, нийслэлийн Засаг дарга, сум, дүүргийн соёлын байгууллагын удирдлагыг аймаг, нийслэлийн соёлын газрын удирдлагатай зөвшилцөн сум, дүүргийн Засаг дарга тус тус томилж, чөлөөлнө.
	<b>24 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх</b>	24.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга соёлын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 24.1.1.орон нутгийн онцлог бүхий соёлын бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, брэнд бий болгох, баяжуулан хөгжүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах; 24.1.2.орон нутгийн өмчийн соёлын байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх, барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулах.
	<b>30 дугаар зүйл. Соёлын орчин, орон зайг хөгжүүлэх</b>	30.1.Аймаг, нийслэл, сум, дүүрэгт түүх, соёл, урлаг, эсхүл соёлын үнэт зүйлийг төлөөлж, илэрхийлэх соёлын орчин, орон зайг бүрдүүлж, хөгжүүлнэ. 30.2.Энэ хуулийн 30.1-д заасан соёлын орчин, орон зайг бүрдүүлэх, хөгжүүлэх чиг үүргийг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бүх шатны Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллага хэрэгжүүлнэ.
	<b>35 дугаар зүйл. Мерчандайзийн гэрээ</b>	35.3.Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах загвараар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах эрхийг олгоно: 35.4.Энэ хуулийн 35.3-т зааснаас бусад орон нутгийн өмчийн соёлын үнэт зүйл, урлагийн бүтээлийн загвараар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах эрхийг тухайн шатны Засаг дарга олгоно.
	<b>37 дугаар зүйл. тавих нөхцөл, шаардлага</b>	37.5.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга соёлын үйл ажиллагаа эрхлэх зориулалт бүхий хувийн өмчийн барилга байгууламжийг ашиглан иргэнд соёлын үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж болно.

---о0о---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

### СОНГУУЛИЙН АВТОМАТЖУУЛСАН СИСТЕМИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Сонгуулийн автоматжуулсан системийн тухай	<b>8 дугаар зүйл. Сонгуулийн автоматжуулсан системийг ашиглахтай холбогдон төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага болон нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны Засаг даргын хүлээх үүрэг</b>	8.1.Сонгуулийн автоматжуулсан системийг ашиглан явуулж байгаа сонгуулийн үйл ажиллагаанд төрийн захиргааны төв байгууллага, холбогдох төрийн захиргааны байгууллага, аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бүх шатны Засаг дарга энэ хууль болон сонгуулийн тухай хууль тогтоомжид заасан чиг үүрэг, тус тусын бүрэн эрхийн хүрээнд оролцож, сонгуулийн хорооноос тавьсан асуудлыг шуурхай шийдвэрлэж, бүх талын дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.
	<b>16 дугаар зүйл. Автоматжуулах хэрэгслийн иж бүрдлийг байршуулах нөхцөлийг хангах</b>	16.1.Бүх шатны Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрт ажиллах сонгуулийн хороодын байршилд автоматжуулах хэрэгслийн иж бүрдлийг суурилуулахад шаардлагатай зохих хэмжээний талбай, цахилгаан эрчим хүч, мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ бүхий өрөө тасалгаагаар хангах асуудлыг хариуцан шийдвэрлэх үүрэг хүлээнэ.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 12 дугаар сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

### СТАНДАРТЧИЛАЛ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай	<b>24 дүгээр зүйл. Стандартчилал, техникийн зохицуулалтын байгууллагын тогтолцоо</b>	24.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангаж, тохирлын үнэлгээний байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.
	<b>26 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн стандартчилал, техникийн зохицуулалтын байгууллага</b>	26.2.Аймаг, нийслэлийн стандартчилал, техникийн зохицуулалтын байгууллагын даргыг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулж аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 6 дугаар сарын 5-ны өдөр

Улаанбаатар хот

### СТАТИСТИКИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
<b>СТАТИСТИКИЙН ТУХАЙ</b>	<b>5 дугаар зүйл.</b>	3.Албан ёсны статистикийн мэдээллийг Үндэсний статистикийн хороо, яам, төрийн бусад албан газар, бүх шатны Засаг дарга эрхлэн гаргана.
	<b>11 дүгээр зүйл. Статистикийн байгууллагын тогтолцоо</b>	2.Монгол Улсын статистикийн байгууллагын тогтолцоо нь албан ёсны статистикийн үйл ажиллагааг хараат бус, бие даасан байдлаар улс, орон нутгийн хэмжээнд төвлөрүүлэн эрхэлдэг Үндэсний статистикийн хороо, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх статистикийн газар, хэлтсээс бүрдэнэ. Суманд статистикийн үйл ажиллагааг сумын Засаг даргын Тамгын газрын уг ажлыг хариуцсан ажилтан, баг, хороонд тэдгээрийн Засаг дарга эрхлэн гүйцэтгэнэ.
	<b>18 дугаар зүйл. Яам, Монголбанк, төрийн бусад албан газар, бүх шатны Засаг даргын статистикийн мэдээллийн талаархи нийтлэг бүрэн эрх</b>	Яам, төрийн бусад албан газар, бүх шатны Засаг дарга статистикийн мэдээллийн талаар дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/албан ёсны статистик мэдээллийн үнэн зөв байдалд тогтмол шалгалт хийж, түүний бодит байдлыг хангах; 2/статистикийн мэдээллийг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд газар дээр нь очиж гаргуулан авах, гарсан зардлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх; 3/мэдээлэл, судалгааны дүнг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэх; 4/статистикийн мэдээллийг Үндэсний статистикийн хорооноос баталж, зөвшөөрсөн маягтаар мэдээлэгчээс гаргуулан авах.
	<b>20 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын статистикийн мэдээллийн</b>	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/нутаг дэвсгэртээ байгаа статистикийн мэдээлэгчдээс статистикийн мэдээллийг хугацаанд нь гаргуулан авч нэгтгэх, судалгаа, дүгнэлт хийж ашиглах, албан ёсны статистикийн мэдээллийг хугацаанд нь зохих дээд шатны байгууллагад өгөх

	<p><b>талаархи бүрэн эрх</b></p>	<p>2/Үндэсний статистикийн хорооноос өгсөн удирдамж, чиглэлийн дагуу статистикийн тооллого, түүвэр судалгааг зохион байгуулж явуулах; 3/засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийнхээ удирдлагын үйл ажиллагаанд хэрэглэх зорилгоор, захиргааны статистикийн мэдээллийг бусад мэдээлэлтэй давхардуулахгүйгээр статистикийн байгууллагын зөвшөөрснөөр авах, мэдээллийн санг бий болгох.</p>
	<p><b>21 дүгээр зүйл. Баг, хорооны Засаг даргын статистикийн мэдээллийн талаархи бүрэн эрх</b></p>	<p>Баг, хорооны Засаг дарга энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/хүн ам, өрхийн бүртгэл хөтлөх; 2/хүн амын амьжиргааны түвшингийн судалгаа хийх; 3/мал, тэжээвэр амьтад, эд хөрөнгийн тооллого, бүртгэл явуулах; 4/газар нутаг, эдэлбэр газрын тооллого, бүртгэл явуулах; 5/үйлдвэрлэл, үйлчилгээний талаар мэдээлэл, судалгаа авах, гаргах; 6/зохих чиглэлийн дагуу явуулах тооллого, түүвэр судалгааг зохион байгуулж явуулах; 7/албан ёсны статистикийн мэдээллийг тогтоосон хугацаанд зохих дээд шатны Засаг даргад гаргаж өгөх.</p>

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 6 дугаар сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

### СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦНЫ БАЙШИНГИЙН ДУНДЫН ӨМЧЛӨЛИЙН ЭД ХӨРӨНГИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай	<b>5 дугаар зүйл. Сууц өмчлөгчдийн холбоо</b>	5.3. Сууц өмчлөгчдийн холбоог зохион байгуулах хурлыг сууц өмчлөгчдийн санаачилгаар хуралдуулна. Шаардлагатай тохиолдолд тухайн нутаг дэвсгэрт байгаа орон сууц хувьчлах товчоо болон тухайн шатны Засаг даргын санаачилгаар хуралдуулна.
	<b>18 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх</b>	18.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараахь бүрэн эрхтэй: 18.1.1. холбоог зохион байгуулах хурлын шийдвэрийг үндэслэн сум, дүүргийн Засаг даргын тамгын газар холбоог бүртгэх; 18.1.2. холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах, биелэлтэд хяналт тавих; 18.1.3. холбооны үйл ажиллагааг дэмжих; 18.1.4. холбоонд тухайн орон сууцны байшингийн ерөнхий төлөвлөгөөг үндэслэн дэвсгэр болон орчны газрыг газрын тухай хууль тогтоомжид заасны дагуу тодорхой болзолтойгоор гэрээний дагуу ашиглуулах; 18.1.5. хэд хэдэн холбоонд хамаарч буй орчны газрын тохижилт, үйлчилгээг хамтран хариуцах талаархи холбооны эрх, үүрэг, хариуцлагыг гэрээнд нарийвчлан тусгаж, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, хяналт тавих; 18.1.6. дундын өмчлөлийн эд хөрөнгийн засварт орон нутгийн төсвөөс зээл олгох, хөрөнгө оруулалт хийх хэмжээг тогтоох; 18.1.7. холбооны гишүүдийн хүсэлтээр болон шаардлагатай бол санаачлагаараа холбооны үйл ажиллагаанд эрх бүхий байгууллага, албан тушаалтнаар хяналт, шалгалт хийлгэж, дүгнэлт гаргуулах.

---oOo---





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

### СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Сэргээгдэх эрчим хүчний тухай	<b>5 дугаар зүйл. Сэргээгдэх эрчим хүчний талаархи төрийн байгууллагын чиг үүрэг</b>	5.5.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 5.5.1.сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг байршуулах газрыг аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах; 5.5.2.сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр байршуулах зориулалтаар газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг хууль тогтоомжид заасан журмын дагуу шийдвэрлэх; 5.5.3.аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд сэргээгдэх эрчим хүч ашиглахын ач холбогдлыг сурталчлах; 5.5.4.орон нутгийн өмчийн бие даасан үүсгүүрийг иргэн, хуулийн этгээдэд түрээслүүлэх.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 7 дугаар сарын 8-ны өдөр

Улаанбаатар хот

### ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Тагнуулын байгууллагын тухай	<b>8<sup>1</sup>дүгээр зүйл.</b> <b>Төрийн байгууллага, албан тушаалтантай харилцан ажиллах</b>	<p>8<sup>1</sup>.1.Төрийн байгууллага, албан тушаалтан нь үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлаар мэдээ, мэдээлэл солилцож, дэмжлэг үзүүлэх талаар тагнуулын байгууллагатай харилцан ажиллана.</p> <p>8<sup>1</sup>.2.Төрийн байгууллага нь тагнуулын байгууллагад шаардлагатай мэдээллийг саадгүй гаргаж өгөх, өөрийн мэдээлэл, өгөгдлийн санг үнэ төлбөргүй ашиглуулах үүрэгтэй.</p> <p>8<sup>1</sup>.3.Төрийн байгууллага, албан тушаалтан нь албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн тагнуулын байгууллага, ажилтны болон халхавчлах үйл ажиллагаатай холбоотой аливаа мэдээллийг задруулахыг хориглоно.</p> <p>8<sup>1</sup>.4.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ тагнуулын байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүрэгтэй.</p>

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 7 дугаар сарын 1-ний өдөр

Улаанбаатар хот

### ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Тамхины хяналтын тухай хууль	<b>5 дугаар зүйл. Тамхины хяналтын талаар төр, иргэн, хуулийн этгээдийн хүлээх нийтлэг үүрэг</b>	<p>5.1.Тамхины хяналтын талаар төрийн байгууллага дараахь үүрэг хүлээнэ:</p> <p>5.1.1.эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тамхины хяналтын талаар төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх, төрийн бус байгууллагын санаачлага, оролцоог дэмжих, нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах;</p> <p>5.1.2.төрийн бүх шатны болон нутгийн өөрөө удирдах байгууллага нь бүрэн эрхийнхээ дагуу хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах бодлогын хүрээнд дангаар буюу холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллах.</p> <p>5.1.3.нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, олон нийтийн боловсрол олгох чиглэлээр тамхи үйлдвэрлэгч, эсхүл түүний ашиг сонирхлын төлөө ажиллаж байгаа хуулийн этгээд, иргэдтэй хамтран ажиллахаас татгалзах;</p> <p>5.1.4.тамхины хяналтын тухай хууль тогтоомж боловсруулах явцад ашиг сонирхлын зөрчил байгаа гэж үзсэн тохиолдолд тамхи үйлдвэрлэгчээс тавьсан саналыг хүлээн авахаас татгалзах;</p> <p>5.1.5.тамхины хяналтын талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцож байгаа төрийн албан хаагч, бусад ажилтны ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлыг шийдвэрлэж, хамтран ажиллахаас татгалзах;</p> <p>5.1.6.утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгт утаат тамхи татахыг зөвшөөрсөн анхааруулах тэмдэг байрлуулах;</p> <p>5.1.7.энэ хуулийн 9.1.1-9.1.4, 9.1.7, 9.1.8-д заасан хориглосон газраас бусад гадаад орчин дахь нийтийн эдэлбэр газарт байгуулах утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгийн байршил, төсвийг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэх.</p>

<p><b>7 дугаар зүйл.</b> <b>Тусгай болон энгийн зөвшөөрөл</b></p>	<p>7.9.Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сум, дүүргийн Засаг дарга, чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч олгоно.</p> <p>Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сунгахтай холбоотой бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг тус хуулийн 7.10, 7.11 дүгээр хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.</p>
<p><b>9 дүгээр зүйл.</b> <b>Утаат тамхи татахыг хориглох</b></p>	<p>9.1.Дараах газар утаат тамхи татахыг хориглоно:</p> <p>9.1.1.бүх төрлийн нийтийн тээврийн хэрэгсэл;</p> <p>9.1.2.олон нийтийн үзвэр, үйлчилгээний газар;</p> <p>9.1.3.шатахуун түгээгүүрийн газар, шатах, тослох, тэсэрч, дэлбэрэх бодис, материалын үйлдвэр, түүний нөөцийн агуулах;</p> <p>9.1.4.зорчигч тээврийн буудал, зочид буудлын нийтийн танхим, тамхи татахыг хориглосон өрөө;</p> <p>9.1.5.нийтийн хоол, худалдаа, баар, цэнгээний газрын утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгээс бусад орчин;</p> <p>9.1.6.аж ахуйн нэгж, байгууллагын утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгээс бусад ажлын байрын дотоод орчин;</p> <p>9.1.7.агаарын хөлөг, зорчигч тээврийн галт тэрэг;</p> <p>9.1.8.цэцэрлэг, бүх шатны сургууль, сургуулийн дотуур байр, эмнэлэг, сувилал, тэдгээрийн гаднах орчин, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн орц, шат, цахилгаан шат, хүүхдийн тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн.</p>
<p><b>11 дугаар зүйл.</b> <b>Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих</b></p>	<p>11.1.Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий холбогдох байгууллага, цагдаа болон хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ.</p>

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

### ТАРИАЛАНГИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Тариалангийн тухай	<b>5 дугаар зүйл. Атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх</b>	Атар газрыг тариалангийн газарт шилжүүлэхтэй холбоотой процессийг тус хуулийн 5 дугаар зүйлээс дэлгэрүүлж үзнэ үү.
	<b>14 дүгээр зүйл. Тариалангийн газрын зориулалт өөрчлөх</b>	Тариалангийн газрын зориулалтад өөрчлөлт оруулах боломжтой эсэх асуудлыг тус хуулийн 17 дугаар зүйлээс дэлгэрэнгүй үзнэ үү.
	<b>20 дугаар зүйл. Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчийн эрх, үүрэг</b>	20.4.Тариалангийн зориулалтаар газар эзэмшигч, ашиглагч нь хоёроос дээш жил эзэмшил, ашиглалтад байгаа газартаа бүрэн болон хэсэгчлэн тариалалт хийгээгүй бол тариалалт хийгээгүй газрын хэмжээгээр газар эзэмших эрхийн гэрчилгээг сум, дүүргийн Засаг дарга хүчингүй болгоно.
	<b>21 дүгээр зүйл. Тариалангийн үйлдвэрлэлийн төлөвлөлт</b>	21.3.Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн жилийн тариалангийн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг тариалан эрхлэгчдийн саналд тулгуурлан боловсруулж, сум, дүүрэг тус бүрээр баталж, хэрэгжилтийг зохион байгуулна.
	<b>24 дүгээр зүйл. Тариалангийн үйлдвэрлэлийг хамгаалах</b>	24.1.Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа газарт дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 24.1.1.мал, тэжээвэр амьтан оруулах, бэлчээх; 24.1.2.ан ав хийх; 24.1.3.дайран өнгөрөх, зам гаргах; 24.1.4.өвс, сүрэл, байгалийн бусад ургамал шатаах; 24.1.5.тариалан эрхлэхтэй холбоогүй бусад үйл ажиллагаа. 24.2.Тариалангийн талбайн захаас гадагш 500 метрийн зайд мал бэлчээх, оторлох болон бэлчээрийн мал аж ахуйн өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа байхыг хориглоно. 24.3.Энэ хуулийн 24.2-т заасан мал аж ахуй эрхлэгчийн өвөлжөө, хаваржааг тухайн орон нутагт нүүлгэн

		<p>шилжүүлэхтэй холбогдсон тээврийн зардлыг тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч нэг удаа хариуцна.</p> <p>24.4.Энэ хуулийн 24.3-т заасны дагуу нүүн шилжих мал аж ахуй эрхлэгчийн өвөлжөө, хаваржааны газрын асуудлыг сум, дүүргийн Засаг дарга 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.</p>
	<p><b>27 дугаар зүйл. Тариалангийн газрын хөрсний төлөв байдал, чанарт тавих хяналт</b></p>	<p>27.3.Мэдэгдэлд заасан хугацаанд хөрсний төлөв байдлыг сайжруулах арга хэмжээ аваагүй бол тариалангийн асуудал хариуцсан нутгийн захиргааны байгууллага нь газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг хүчингүй болгох саналыг зохих шатны Засаг даргад хүргүүлнэ.</p> <p>27.4.Энэ хуулийн 27.3-т заасан саналыг үндэслэн тухайн шатны Засаг дарга хөрсний төлөв байдлыг дордуулсан иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг хүчингүй болгож, Газрын тухай хуульд заасны дагуу тухайн этгээдэд мэдэгдэнэ.</p>

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 03 сарын 22 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Татварын ерөнхий хууль	<b>77 дугаар зүйл. Татварын албаны удирдлага, түүний бүрэн эрх</b>	77.5. Аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хот, дүүргийн татварын газар, хэлтсийн даргыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга тухайн шатны Засаг дарга, хотын Захирагчтай зөвшилцөн томилж, чөлөөлнө.
		77.8. Сум, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны татварын ажилтныг тухайн аймаг, хотын татварын албаны дарга тухайн шатны Засаг дарга, хот, тосгоны Захирагчтай зөвшилцөн томилж, чөлөөлөх бөгөөд тухайн ажилтанд сахилгын шийтгэл оногдуулах эрхтэй байна.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 7 дугаар сарын 5-ны өдөр

Улаанбаатар хот

### ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Төмөр замын тээврийн тухай	<b>11 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх</b>	<p>11.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>11.1.1. төмөр замын зурвас газар, объект, өртөө, буудалд нийгмийн хэв журам сахиулах ажлыг төмөр замын байгууллагатай хамтран зохион байгуулах;</p> <p>11.1.2. хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төмөр замын хөдөлгөөнтэй шууд холбоотой албан тушаалд ээлжээр ажилладаг ажилтныг цэргийн албанд татахаас бусад дайчилгаанд хамааруулахгүй байх;</p> <p>11.1.3. гамшгийн хор уршгийг арилгах, төмөр замын байгууллагын тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах мод, хайрга, чулуу, элс, ус зэргийг хууль тогтоомжийн дагуу олгох;</p> <p>11.1.4. шаардлагатай бол гамшиг, ослын болон гологдлын хор уршгийг арилгах болон аюулгүй байдлыг хангахад нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс тоног төхөөрөмжийг нөхөн олговортойгоор гаргуулах, хүн хүчний туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах.</p>
	<b>27 дугаар зүйл. Төмөр замын зурвас газар, аюултай болон аюулгүйн бүс тэдгээрийн дэглэм</b>	<p>27.10. Төмөр замын зурвас газраас гаднах аюулгүйн бүсэд газар эзэмшүүлэх, ашиглуулах, аливаа үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг тухайн нутаг дэвсгэрийн Засаг дарга аюулгүй байдлын талаар гаргасан зөвлөмж, дүгнэлтийг харгалзан төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн олгоно.</p>

---o0o---





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 5 дугаар сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

### ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай	<b>78 дугаар зүйл. Орон нутгийн өмчийн талаархи Засаг даргын бүрэн эрх</b>	<p>1. Засаг дарга нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас орон нутгийн өмчийн эд хөрөнгийн талаар гарсан шийдвэрийг Засгийн газрын бодлогод нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэгтэй.</p> <p>2. Хуульд өөрөөр заагаагүй бол Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>1/ иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний дотор орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах;</p> <p>2/ орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх баригчийг томилох;</p> <p>3/ орон нутгийн өмчийн төлөөлөгчийг томилох, өөрчлөх саналаа Хурлын даргад оруулах;</p> <p>4/ орон нутгийн өмчийн эд хөрөнгийн нэгдсэн бүртгэл хөтлөх, эд хөрөнгийн тооллого явуулах ажлыг зохион байгуулах;</p> <p>5/ орон нутгийн өмчит албан байгууллагыг шаардлагатай эд хөрөнгөөр хангах;</p> <p>6/ орон нутгийн өмчийн эд хөрөнгийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын мэргэжил, арга зүйн удирдлагын дор хувьчлах ажлыг зохион байгуулах;</p> <p>7/ нутгийн өмч эрхэлсэн ажилтан буюу албыг шуурхай удирдах.</p>

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 12 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

### ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль	<b>45 дугаар зүйл. Захиалагч худалдан авах ажиллагааг зохион байгуулах</b>	45.2.Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад дор дурдсан этгээд захиалагч байна: 45.2.1. ... аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга нь өөрийн хэрэгцээнд худалдан авах бүх бараа, ажил, үйлчилгээний хувьд; 45.2.2. аймаг, нийслэлийн Засаг дарга нь тухайн орон нутагт худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд. 45.3.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг дарга захиалагч байна. 45.6.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь шаардлагатай гэж үзвэл сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт энэ хуулийн 45.2.2-т заасан эрхээ шилжүүлж болно.
	<b>46 дугаар зүйл. Захиалагчийн эрх, үүрэг</b>	46.1.Захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авах талаар дараахь эрх, үүрэгтэй байна: 46.1.1.энэ хуульд заасны дагуу үнэлгээний хороо байгуулах; 46.1.2.үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах; 46.1.3.үнэлгээний хорооноос гаргасан дүгнэлтэд үндэслэн гэрээ байгуулах эрх олгох шийдвэр гаргах; 46.1.4.худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах; 46.1.5.энэ хуулийн 7.6-д зааснаас бусад бараа, ажил, үйлчилгээг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр батлагдсаны дараа худалдан авах ажиллагааг эхлүүлэх; 46.1.6.гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах;

		<p>46.1.7.хууль, гэрээнд зааснаас бусад тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулахгүй байх;</p> <p>46.1.8.барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх;</p> <p>46.1.9.гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж байгаа ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, санхүүжилтийн хуваарь, ажил эхлэх, дуусах хугацаа болон авто зам, инженерийн шугам сүлжээний хувьд дайран өнгөрөх маршрут зэргийг багтаасан мэдээллийн самбарыг төв, суурин бүрийн олон нийтэд үзэгдэхүйц газар уг ажил, үйлчилгээний баталгаат хугацааны туршид заавал байрлуулахыг шаардах.</p> <p>46.2.Энэ хуулийн 4.1.1-д заасан захиалагчийг төлөөлж төсвийн ерөнхий менежер, 4.1.2-т заасан захиалагчийг төлөөлж гүйцэтгэх захирал энэ хуулийн 46.1-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.</p> <p>46.3.Энэ хуулийн 46.2-т заасан захиалагчийг төлөөлөх эрх бүхий этгээд энэ хуулиар өөрт олгогдсон эрхийг холбогдох албан тушаалтанд шилжүүлж болох боловч ийнхүү эрхээ шилжүүлэх нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.</p> <p>46.4.Захиалагч тухайн худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлаар зөвхөн албан бичгээр харилцана.</p>
	<p><b>53 дугаар зүйл.</b>  <b>Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний чиг үүрэг</b></p>	<p>53.2.Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий нэгжтэй байна.</p> <p>53.3.Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх худалдан авах ажиллагааны нэгжийн даргыг тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргатай, дүүргийн Засаг даргын дэргэдэх худалдан авах ажиллагааны нэгжийн даргыг дүүргийн Засаг дарга нийслэлийн Засаг даргатай тус тус зөвшилцөн томилж, чөлөөлнө.</p>

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 05 дугаар сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

### ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДГИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Төрийн бэлгэ тэмдгийн тухай хууль	<b>2 дугаар зүйл. Төрийн бэлгэ тэмдэг</b>	1.Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг нь Төрийн сүлд, туг,далбаа, тамга, дуулал /цаашид "Төрийн бэлгэ тэмдэг" гэх/ мөн.
	<b>6 дугаар зүйл. Төрийн сүлдийг байрлуулах</b>	1. Төрийн сүлдийг: 7/ бүх шатны Засаг даргын албан тасалгаанд;
	<b>13 дугаар зүйл. Төрийн далбааг мандуулах</b>	1. Төрийн далбааг дараахь газар байнга мандуулна: 3/аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын албан ажлын байр; 2. Төрийн далбааг дараахь газар, тээврийн хэрэгсэл дээр түр хугацаагаар мандуулна: 1/ Улсын Их Хурлын болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн өдөр-санал хураах байр; 3/ Монгол Улсын Үндсэн хуулийн болон Монгол Улсыг Бүгд Найрамдах Улсаар тунхагласан өдөр-төрийн захиргааны төв байгууллагын байр; 4/ Монгол ардын хувьсгалын ойн баярын өдөр-баяр наадмын талбай, төрийн захиргааны төв байгууллага,зэвсэгт хүчин, бусад цэргийн нэгтгэл, анги болон хилийн салбарын байр;
	<b>14 дүгээр зүйл. Төрийн далбааг байрлуулах, дүрслэх</b>	1.Төрийн далбааг дараахь газар байнга байрлуулна: 3/ Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, бүх шатны Засаг даргын албан тасалгаа;
	<b>28 дугаар зүйл. Хуулийн биелэлтэд тавих хяналт</b>	Энэ хуулийн биелэлтэд тавих хяналтыг бүх шатны Засаг дарга, цагдаагийн байгууллага, гадаад харилцаа болон батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, улсын хил хамгаалах байгууллага хэрэгжүүлнэ.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 1 дүгээр сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот

### ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Төрийн хяналт шалгалтын тухай	<b>8 дугаар зүйл. Аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хорооны Засаг даргын бүрэн эрх</b>	<p>8.1.Бүх шатны Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>8.1.1.хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, түүний байгууллагын болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн биелэлтийг нутаг дэвсгэртээ оршдог нийт байгууллага, аж ахуйн нэгжид тэдгээрийн харьяалал, өмчийн төрөл хэлбэрийг харгалзахгүйгээр хянан шалгах;</p> <p>8.1.2.хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, түүний байгууллагын болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн биелэлтийг нутаг дэвсгэртээ мэдээлэх, сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүн, биелэлтийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу дээд шатны Засаг дарга, Засгийн газарт мэдээлэх.</p> <p>8.1.3.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу хяналт шалгалтын чиг үүргийг гүйцэтгэх.</p> <p>8.2.Аймаг, нийслэлийн Засаг даргын тусгай бүрэн эрх:</p> <p>8.2.1.Засгийн газраас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн өөрийн болон доод шатны Засаг даргын ажлын алба, харьяа байгууллага, аж ахуйн нэгжид дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг баталж мөрдүүлэх;</p> <p>8.2.2.хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлж байгаа байдлыг судлах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж нэгтгэн, тэдгээрийг боловсронгуй болгох саналаа Ерөнхийлөгч, Засгийн газарт өргөн мэдүүлэх;</p> <p>8.2.3.сум, дүүрэг, харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүртгэл санхүүгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийх арга хэмжээ авна.</p> <p>8.3.Сум, дүүргийн Засаг даргын тусгай бүрэн эрх</p> <p>8.3.1.хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, түүний байгууллагын болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах талаар зохиож байгаа ажил, түүний явц, үр дүнгийн тухай нутаг дэвсгэртээ оршдог байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригчдын мэдээллийг сонсож, илтгэл сонсголыг хэлэлцэн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах.</p>

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1993 оны 11 дүгээр сарын 11-ни өдөр

Улаанбаатар хот

### ТӨР, СҮМ ХИЙДИЙН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Төр, сүм хийдийн харилцааны тухай	<b>4 дүгээр зүйл.</b> <b>Төр, сүм хийдийн харилцааны үндэс</b>	<p>3.Төрийн байгууллага, албан тушаалтан хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд сүм хийдийн дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохыг хориглоно.</p> <p>4.Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд хохирол учирч болох нөхцөлд төрөөс сүм хийдийн тухайн үйл ажиллагааг зөвлөн зохицуулах, шаардлагатай бол зогсоох эрхтэй.</p> <p>6.Сүм хийдээс төрийн байгууллагын үүргийг эрхлэн гүйцэтгэхгүй бөгөөд төрийн эрх мэдлийн төлөө улс төрийн үйл ажиллагаа явуулах, түүнд оролцох, санхүүжүүлэхийг хориглоно.</p> <p>7.Шашны нэр хүнд, хүн амын сүсэг бишрэлийг улс төрийн нам, байгууллага, албан тушаалтны эрх ашигт нийцүүлэн ашиглах, шашныг гаднаас зохион байгуулалттайгаар нэвтрүүлэх үйл ажиллагаа явуулахыг хориглоно.</p>
	<b>5 дугаар зүйл.</b> <b>Төр, сүм хийдийн харилцааг тодорхойлон хэрэгжүүлэх</b>	<p>3.Төрөөс сүм хийдтэй харилцах харилцааг зохион байгуулж хэрэгжүүлэх ажлыг Монгол Улсын Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус эрхлэн гүйцэтгэнэ.</p>

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 12 сарын 09 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай	<b>11 дүгээр зүйл. Засаг даргын бүрэн эрх</b>	<p>11.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга түншлэлийн хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>11.2.1. тухайн орон нутагт түншлэлээр хэрэгжүүлэх төслийн саналыг боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх;</p> <p>11.2.2. түншлэлийн төслийн саналыг салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;</p> <p>11.2.3. тухайн орон нутагт түншлэлээр хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилтийг хангах, түншлэгч талуудад дэмжлэг үзүүлэх, хамтарч ажиллах, түншлэлийн гэрээний биелэлтэд энэ хууль болон түншлэлийн гэрээнд заасны дагуу хяналт тавих;</p> <p>11.2.4. төслийн бүрэн шинжилгээ хийх төслийн багийн бүрэлдэхүүнд болон түншлэлийн гэрээний хэлэлцээрт оролцох, түншлэлийн гэрээг төрийн түншлэгч талыг төлөөлж түншлэлийн болон салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран байгуулах;</p> <p>11.2.5. түншлэлээр бий болсон болон түншлэлд хамаарах аливаа хөрөнгийг түншлэлийн гэрээ, энэ хууль, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу орон нутгийн өмчид шилжүүлэх, бүртгэх.</p>
	<b>33 дугаар зүйл. Түншлэлийн гэрээ</b>	<p>33.3. Түншлэлийн гэрээнд төрийн түншлэгч талыг төлөөлж Засгийн газрын эрх олгосноор төсөл хэрэгжүүлэх салбарын болон түншлэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, төсөл хэрэгжих орон нутгийг төлөөлж аймаг, нийслэлийн Засаг дарга гарын үсэг зурж баталгаажуулна.</p>

---оОо---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 12 сарын 23 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### ТӨСВИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Төсвийн тухай хууль	<b>14 дүгээр зүйл. Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний бүрэн эрх</b>	<p>14.1. Дараах албан тушаалтан төсвийн ерөнхийлөн захирагч байна:</p> <p>14.1.20. аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн энэ хуулийн 14.1.18, 14.1.19-д зааснаас бусад төсвийн.</p> <p>14.2. Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>14.2.1. жилийн төсвийн хязгаарт багтаан төсвийн төслийг боловсруулах;</p> <p>14.2.2. өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох;</p> <p>14.2.3. өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;</p> <p>14.2.4. өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах;</p> <p>14.2.5. өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах;</p> <p>14.2.6. хөтөлбөрийн үр дүн, төсвийн гүйцэтгэлийн тайланг гарган, Засгийн газрын хуралдаанд танилцуулах;</p> <p>14.2.7. өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллага, Засгийн газрын тусгай сан, гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн төслийн тайлан бүхий хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайланг нэгтгэн, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;</p> <p>14.2.8. хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр тайлагнах;</p> <p>14.2.9. хөрөнгө оруулалтын арга хэмжээ хэрэгжиж дууссаны дараа хөрөнгө оруулалтын үр дүнгийн талаарх тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;</p> <p>14.2.10. өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.</p> <p>14.2.11. төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах;</p>



		<p>14.2.12.эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох.</p> <p>14.3.Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна.</p> <p>14.4.Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.</p> <p>14.5.Төсвийн ерөнхийлөн захирагч нь түүнд хамаарах төсвийн асуудлыг хариуцан гүйцэтгэх санхүүгийн нэгж, нягтлан бодогч, ажилтантай байна.</p>
	<b>31 дүгээр зүйл.</b>	31.5.Засгийн газар болон Засаг даргын зөвлөл нь төсвийн төслийг төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр хэлэлцэнэ.
	<b>40 дүгээр зүйл. Үр дүнгийн гэрээ</b>	<p>40.1.Төсвийн шууд захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагч нь харьяалагдах дээд шатныхаа төсвийн захирагчтай төсвийн жил эхлэхээс өмнө үр дүнгийн гэрээ байгуулна.</p> <p>40.2.Энэ хуулийн 40.1-д заасан үр дүнгийн гэрээнд байгууллагын төсвийн жилд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, тэдгээрийн төсөв, хүрэх үр дүн, түүнийг дүгнэх талаар тусгасан байна.</p> <p>40.3.Үр дүнгийн гэрээний биелэлтийг харьяалагдах дээд шатны төсвийн захирагч нь хагас, бүтэн жилээр дүгнэнэ.</p> <p>40.4.Үр дүнгийн гэрээний биелэлт, хэрэгжилтийн явц байдалд үндэслэн үр дүнгийн гэрээг дүгнэх эрх бүхий этгээд нь дараах арга хэмжээг авна: 40.4.1.төсвийн үр дүнг сайжруулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар үүрэг өгч, хяналт тавьж ажиллах; 40.4.2.хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд урамшуулах, хариуцлага тооцох.</p> <p>40.5.Төсвийн ерөнхийлөн захирагч энэ хуулийн 40.1-д заасан үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэхдээ шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг харгалзана.</p>
	<b>41 дүгээр зүйл. Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах</b>	<p>41.2.Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ: 41.2.1.хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх; 41.2.2.батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах; 41.2.3.төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах; 41.2.4.төсвийн сар, улирлын хуваарийг баримталж ажиллах; 41.2.5.энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх; 41.2.6.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх; 41.2.7.хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах.</p>

	<b>63 дугаар зүйл.</b>	63.1.Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна.
	<b>65 дугаар зүйл.</b>  <b>Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх</b>	65.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 65.1.1.тухайн шатны төсвийн төсөл, тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах; 65.1.2.орон нутаг дахь төсвийн байгууллага, төлөөлөн гүйцэтгэх төрийн чиг үүргийн төсвийн төсөл, гүйцэтгэл, сар, улирлын мэдээ, санхүүгийн тайланг нэгтгэн боловсруулж холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх; 65.1.3.холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчтай төрийн чиг үүргийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид төлөөлөн гүйцэтгэх гэрээг байгуулж ажиллах; 65.1.4.орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээг холбогдох хуульд нийцүүлэн байгуулах; 65.1.5.иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан орон нутгийн төсвийг энэ хуулийн 8.5.5-д заасан хугацаанд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх; 65.1.6.энэ хуулийн 39.1-д заасан гэрээний дагуу улсын төсвийн байгууллагын төлөвлөсөн зардлыг зориулалтаар нь цаг хугацаанд нь, тасралтгүй бүрэн санхүүжүүлэх; 65.1.7.аймаг, нийслэлийн жилийн төсвийн сар, улирлын хуваарийг баталж, мөрдүүлэх; 65.1.8.тухайн шатны төсвийн байгууллагын орон тоог төсвийн захирагч бүрээр батлах.
	<b>66 дугаар зүйл.</b>  <b>Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх</b>	66.1.Сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 66.1.1.тухайн шатны төсвийн төсөл, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах; 66.1.2.орон нутаг дахь төсвийн байгууллага, төлөөлөн гүйцэтгэх төрийн чиг үүргийн төсвийн төсөл, гүйцэтгэл, сар, улирлын мэдээ, санхүүгийн тайланг нэгтгэн боловсруулж аймаг, нийслэлийн Засаг дарга болон холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх; 66.1.3.аймаг, нийслэлийн Засаг даргатай төрийн чиг үүргийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид төлөөлөн гүйцэтгэх гэрээг байгуулж ажиллах; 66.1.4.иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан орон нутгийн төсвийг түүнийг баталснаас хойш ажлын долоон өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх; 66.1.5.энэ хуулийн 39.2-т заасан гэрээний дагуу улсын төсвийн байгууллагын төлөвлөсөн зардлыг зориулалтаар нь цаг хугацаанд нь тасралтгүй бүрэн санхүүжүүлэх; 66.1.6.сум, дүүргийн жилийн төсвийн сар, улирлын хуваарийг баталж мөрдүүлэх; 66.1.7.тухайн шатны төсвийн байгууллагын орон тоог төсвийн захирагч бүрээр батлах.

---оОо---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 1 дүгээр сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

### ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай	<b>11 дүгээр зүйл. аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх</b>	<p>11.2.Түгээмэл тархацтай ашигт малтмалын асуудлаар аймаг, нийслэлийн Засаг дарга доор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>11.2.1.түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;</p> <p>11.2.2.харьяалах нутаг дэвсгэрт нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг зориулалтаар ашиглуулах, зөрчил гаргасан тохиолдолд уг зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авах;</p> <p>11.2.3.хүний эрүүл мэнд, байгаль орчин, нөхөн сэргээлт, уурхайн хаалт болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих;</p> <p>11.2.4.түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн өргөдлийг хянах;</p> <p>11.2.5.харьяалах нутаг дэвсгэрт нь хамаарах түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох;</p> <p>11.2.6.түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн гүйцэтгэлийг хянах</p>
	<b>37 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг цуцлах</b>	<p>37.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 37.1.1-37.1.4-т заасан цуцлах үндэслэл тогтоогдсоноос хойш ажлын 10 өдөрт багтаан тусгай зөвшөөрөл эзэмшигчид энэ тухай мэдэгдэл өгөх бөгөөд түүнд тусгай зөвшөөрлийг цуцлах болсон үндэслэлийг тодорхой заана.</p> <p>37.6.Аймаг, нийслэлийн Засаг дарга хайгуулын тусгай зөвшөөрлийг цуцалсан бол мэргэжлийн хяналтын байгууллагад, ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцалсан бол татварын асуудал эрхэлсэн байгууллага, төрийн захиргааны байгууллагад тус тус мэдэгдэнэ.</p> <p>41.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд үүссэн талбайн хилийн маргааныг аймаг, нийслэлийн Засаг дарга шийдвэрлэнэ.</p>

---oOo---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 10 дугаар сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

### ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ОРЧНЫ БҮСИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай	<b>5 дугаар зүйл. Орчны бүсийн хилийн заагийг тогтоох</b>	<p>5.1.Орчны бүсийг тогтоохоос өмнө тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа /цаашид "хамгаалалтын захиргаа" гэх/ сум, дүүргийн Засаг даргатай хамтран тухайн асуудлаар нутгийн иргэдэд мэдээлэл өгөх, орчны бүс тогтоох зорилго, энэ талаар гарсан санал, орчны бүсийн тухай хууль тогтоомж, иргэдийн оролцооны тухай тайлбарлан танилцуулсан байвал зохино.</p> <p>5.2.Хамгаалалтын захиргаа тухайн сум, дүүргийн Засаг даргатай хамтран орчны бүсэд хамруулах газар нутгийг энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан шалгуурын дагуу судална.</p> <p>5.3.Судалгааны бүх мэдээллийг 1:500000-аас багагүй масштабтай газрын зурагт буулгаж түүндээ газар, ус, ан амьтан, ой, ургамлын нөөцийг тусгана.</p> <p>5.4.Хамгаалалтын захиргаа энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан Зөвлөлтэй хамтран орчны бүсийн зааг тогтоох саналыг боловсруулж, сум, дүүргийн Засаг даргад уламжилна.</p> <p>5.5.Сум, дүүргийн Засаг дарга саналыг хянан үзэж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулна.</p>
	<b>8 дугаар зүйл. Орчны бүсийн менежментийн төлөвлөгөө</b>	<p>8.1.Засаг дарга нь хамгаалалтын захиргаа, зөвлөлтэй хамтран энэ хуульд заасны дагуу орчны бүсийн менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.</p> <p>Уг орчны бүсийн менежментийн төлөвлөгөөнд тусгах зүйлийг тус хуулийн 8.2 дахь хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.</p>
	<b>10 дугаар зүйл. Орчны бүсийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт</b>	<p>10.2.Зөвлөл нь орчны бүсэд хяналт хэрэгжүүлэхэд тухайн орон нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллагад туслалцаа үзүүлнэ.</p> <p>10.3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага орчны бүсийн хамгаалалт, байгаль орчны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх гомдлоо холбогдох хуульд заасан журмын дагуу шүүх, улсын байцаагч буюу зохих шатны Засаг даргад гаргана.</p> <p>10.4.Улсын байцаагч, Засаг даргын гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргана.</p>

---оОо---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

### ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай	<b>27 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх</b>	Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10/ зохих шатны Засаг даргатай зөвшилцөн тухайн дархан цаазат газар, байгалийн цогцолборт газарт хамгаалалтын захиргаа байгуулах асуудлыг шийдвэрлэж, даргыг нь байгаль орчны мэргэжилтэй, тухайн салбарт 3-аас доошгүй жил ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасны дагуу сонгон шалгаруулж томилох;
	<b>29 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх</b>	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тусгай хамгаалалттай газар нутгийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/ тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; 2/өөрийн нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийг улсын тусгай болон орон нутгийн хамгаалалтад авах, ангиллыг өөрчлөх, хилийн заагийг тогтоох саналыг судалгаанд үндэслэн боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж, хэлэлцүүлэх; 3/ байгалийн нөөц газар, дурсгалт газрын хамгаалалтыг эрхлэх. 4/байгалийн нөөц газар, дурсгалт газар, орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтыг эрхлэх; 5/орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын менежментийг гэрээгээр хариуцах байгалийн нөөцийн хамтын

		менежментийн нөхөрлөл, хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах.
	<b>29<sup>1</sup> дүгээр зүйл. Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх</b>	Сум, дүүргийн Засаг дарга тусгай хамгаалалттай газар нутгийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/харьяалах нутаг дэвсгэрийн тусгай хамгаалалттай газар нутагт гамшгийг таслан зогсоох, гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээг Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах; 2/байгаль, цаг уурын хүндрэл тохиолдсон үед дархан цаазат, байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц болон дурсгалт газар, тэдгээрийн орчны бүсэд хамгаалалтын дэглэм, горим, бэлчээрийн нөөц, даацад нийцүүлэн мал бэлчээрлүүлэх, хадлан бэлтгэх ажлыг гэрээний үндсэн дээр харьяалах хамгаалалтын захиргаатай хамтран зохион байгуулах;
	<b>34 дүгээр зүйл. Газар ашиглах хугацаа, газрын хэмжээ</b>	2. Тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах газрын хэмжээг төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хэмжээний дотор хамгаалалтын захиргаа буюу сум, дүүргийн Засаг дарга тогтооно.
	<b>42 дугаар зүйл. Төрийн хяналт</b>	1. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хамгаалалтын захиргаа, бүх шатны Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

### ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай	<b>8 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх</b>	8.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн асуудлаар аймаг, нийслэлийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.1.1.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах; 8.1.2.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрийн болон хадгалах байр, агуулахын газрын байнгын байршлыг Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн дагуу тогтоож мэдээллийн нэгдсэн санд ажлын таван өдрийн дотор бүртгүүлэх; 8.1.3.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрийн болон хадгалах байр, агуулахад тогтоосон аюулгүйн бүсийн хил хязгаарт иргэд болон аж ахуйн нэгж, байгууллагад газар олгохгүй байх. 8.1.4.харьяа нутаг дэвсгэр дэх энэ хуулийн 9.2-т заасан бүсийн дэглэмийг зөрчихөөс сэргийлэх арга хэмжээг иргэдийн дунд зохион байгуулах
	<b>9 дүгээр зүйл. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх, хадгалалтын аюулгүйн бүс</b>	9.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрийн болон хадгалах байр, агуулах нь аюулгүйн бүстэй байна. 9.2.Энэ хуулийн 9.1-д заасан аюулгүйн бүс, түүний дэглэмийг Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэмд заасны дагуу тогтооно.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 6 дугаар сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

### УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ХУУЛЬ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
<b>УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ХУУЛЬ</b>	<b>15 дугаар зүйл. Улсын бүртгэлийн байгууллагын тогтолцоо</b>	15.4. Улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтэс, тасаг, ажилтны бүртгэлийн үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг дарга дэмжлэг үзүүлнэ.

---o0o---





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 7 дугаар сарын 5-ны өдөр

Улаанбаатар хот

### УЛСЫН НӨӨЦИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
<b>УЛСЫН НӨӨЦИЙН ТУХАЙ</b>	<b>4 дүгээр зүйл. Улсын нөөц</b>	4.1.Улсын нөөцийг стратегийн, батлан хамгаалах материаллаг, гамшгийн болон орон нутгийн гэж ангилна. 4.2.Орон нутгийн нөөцөд тухайн шатны Засаг дарга, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын даргын шийдвэрээр бүрдүүлэх, хадгалах, захиран зарцуулах аймаг, сум, нийслэл, дүүрэг, аж ахуйн нэгж, байгууллагад байх нөөцийг хамааруулна.
	<b>16 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх</b>	16.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 16.1.1.орон нутаг дахь улсын нөөцийн салбарын үйл ажиллагааг өөрийн эрх хэмжээний хүрээнд удирдлагаар хангаж, хяналт тавих; 16.1.2.улсын нөөцийг бүрдүүлэх, сэлгэх, тээвэрлэхэд дэмжлэг үзүүлэх; 16.1.3.орон нутгийн нөөцийг бүрдүүлэх талаар онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад санал өгөх.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

### УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Ургамал хамгааллын тухай	<b>10 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх</b>	<p>10.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга ургамал хамгааллын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>10.1.1. ургамал хамгааллын тухай хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх, технологийг мөрдүүлэх арга хэмжээг зохион байгуулах;</p> <p>10.1.2. нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх ургамал хамгаалал, хорио цээрийн арга хэмжээ, зардлын төслийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг тайлагнах;</p> <p>10.1.3. ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлын тархалт, олшролт, хөнөөлийн тухай төрийн захиргааны төв байгууллагад жил бүр мэдээлэх;</p> <p>10.1.4. ургамлын хорио цээртэй өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал илэрвэл орон нутгийн болон мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн нутаг дэвсгэртээ ургамлын хорио цээр тогтоох, цуцлах;</p> <p>10.1.5. ургамлын хорио цээртэй өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал тархсан болон тархаж болзошгүй нутаг дэвсгэрийн тухай нийтэд зарлан мэдээлэх;</p> <p>10.1.6. ургамлын хорио цээр тогтоосон үед тэмцэх арга хэмжээг орон нутгийн болон мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд иргэн, хуулийн этгээдийг дайчлан оролцуулах;</p> <p>10.1.7. ургамал хамгааллын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын ажиллагаанд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах;</p> <p>10.1.8. бэлчээр, тариалангийн газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээд ургамал хамгааллын талаар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, зөрчлийг арилгуулах.</p>
	<b>13 дугаар зүйл. Иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг</b>	<p>13.2. Иргэн, хуулийн этгээд ургамал хамгааллын талаар дараахь үүрэгтэй:</p> <p>13.2.1. ашиглаж, эзэмшиж байгаа болон өмчийн газарт нь ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал илэрвэл өөр газарт тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай авах, тухайн сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэх;</p> <p>13.2.2. ургамал, түүнээс гаралтай түүхий эдийг тээвэрлэх, борлуулахдаа тухайн сум, дүүргийн Засаг даргын Тамгын газраас бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ авах.</p>



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 5 дугаар сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

### УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Усан замын тээврийн тухай	<b>7 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх</b>	<p>7.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга усан замын тээврийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>7.1.1. усан замын тээврийн талаар төрөөс баримтлах бодлоготой уялдуулан тухайн нутаг дэвсгэрт усан замын тээвэр зохицуулалтын асуудлыг төрийн захиргааны төв байгууллагатай хамтран шийдвэрлэх, хэрэгжилтийг зохион байгуулах;</p> <p>7.1.2. нутаг дэвсгэртээ усан замын тээврийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах;</p> <p>7.1.3. усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон улсын мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран нутаг дэвсгэртээ усан замын тээврийн хяналтыг хэрэгжүүлэх, түүнд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрт тусгаж шийдвэрлэх;</p> <p>7.1.4. орон нутгийн усан замын сүлжээнд усан замын тээврийн хэрэгслээр зорчигч, ачаа тээвэрлэх, аялах чиглэл, хөвөлтийн улирлын эхлэх, дуусах хугацаа, бүсийг усан замын тээврийн хэрэгслийн зориулалт, хүчин чадалд нийцүүлэн тухайн орон нутгийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагатай хамтран батлах;</p> <p>7.1.5. тухайн орон нутгийн өмчийн усан замын дохио, тэмдэг болон зогсоолын засвар, арчлалт, хамгаалалт, ашиглалтад хяналт тавих, санхүүжилтийг жил бүрийн улс, орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрт тусгаж шийдвэрлэх;</p> <p>7.1.6. тухайн орон нутгийн өмчийн усан замын зогсоол, төв буудал, бусад хөвөгч байгууламжийн үйл ажиллагаа болон тэдгээрийг зохих төлбөртэйгээр хэрэглэгчид ашиглуулах асуудлыг зохицуулах;</p> <p>7.1.7. усан замын тээврийн хөвөлтийн улиралд ажиллах авран хамгаалах байнгын бус ажиллагаатай нэгжийг орон нутаг дахь хэрэгцээ шаардлагыг харгалзан нутаг дэвсгэртээ байгуулах эсэхийг шийдвэрлэх, орон нутгийн онцгой байдлын газар болон усан замын тээврийн хэрэгслийн ахмад, өмчлөгч, эзэмшигч, жолооч нартай хамтран ажиллах, хяналт тавих, санхүүжилтийг жил бүрийн улс, орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрт тусгаж шийдвэрлүүлэх;</p> <p>7.1.8. усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв, холбогдох төрийн байгууллага болон онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран усан замын тээврийн тухай хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулах, хэрэгжилтийг зохион байгуулах.</p>



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

### УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Ус бохирдуулсны төлбөрийн тухай	<b>4 дүгээр зүйл.</b> <b>Ус бохирдуулсны төлбөр төлөгч, түүнийг бүртгэх</b>	<p>4.2.Сав газрын захиргаа, эсхүл сум, дүүргийн Засаг даргатай ус бохирдуулсны төлбөрийн гэрээ байгуулсан хот, суурин газрын ахуйн болон үйлдвэрийн хаягдал усыг цэвэрлэдэг хуулийн этгээд нь ус бохирдуулагчийн талаарх мэдээллийг харьяалах татварын албанд хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл олгосон өдрөөс хойш нэг сарын дотор гарган өгч, татварын алба уг мэдээллийг үндэслэн төлбөр төлөгчийг бүртгэнэ.</p> <p>4.3.Сав газрын захиргаа, эсхүл сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 4.2 дахь хэсэгт зааснаас бусад ус бохирдуулагчийн талаарх мэдээллийг харьяалах татварын албанд хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл олгосон өдрөөс хойш нэг сарын дотор гарган өгч, татварын алба уг мэдээллийг үндэслэн төлбөр төлөгчийг бүртгэнэ.</p>

---оОо---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 05 сарын 17 өдөр

Улаанбаатар хот

### УСНЫ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Усны тухай	<b>7 дугаар зүйл. Усны мэдээллийн сан, тоо бүртгэл</b>	7.3.Усны тоо бүртгэлийг аймаг, сум, нийслэл, дүүргийн хэмжээнд тухайн шатны Засаг дарга жил бүр зохион байгуулж, улсын усны мэдээллийн санд оруулна.
	<b>12 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх</b>	12.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга усны харилцааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 12.1.1.усыг хамгаалах, зохистой ашиглах, хуримтлуулах, нөхөн сэргээх, үерийн аюул, болзошгүй хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, уршгийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, хөрөнгийн хэмжээг тодорхойлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, хэрэгжүүлэх; 12.1.2.улсын зэрэглэлтэй хотын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул, судалгааны захиалга гаргаж, байгаль орчны болон барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад оруулах; 12.1.3.ус, усан орчинг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, усны барилга байгууламжийг барихтай холбогдсон үйл ажиллагааг зохион байгуулах; 12.1.4.усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн зааг, тэжээгдлийн мужийг тэмдэгжүүлж, хамгаалах, тохижуулах, бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангах 12.1.5.хуульд заасан бусад бүрэн эрх.
	<b>13 дугаар зүйл. Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх</b>	13.1.Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 12.1.1, 12.1.3-т зааснаас гадна усны харилцааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 13.1.1.усыг үйлдвэрлэлийн зориулалтаар зөвшөөрөлгүй ашиглах, дур мэдэн цооног гаргасан үйл ажиллагааг таслан зогсоох; 13.1.2.Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад рашааныг ашиглуулах гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавих;

	<p>13.1.3.усны нөөц хомсдох, гол, горхи, нуур, булаг, шанд, рашаан, худгийн ус ширгэх, бохирдох тохиолдолд тухайн эх үүсвэрээс ус ашиглахыг зогсоох, тэдгээрийг нөхөн сэргээх, ойжуулах, ургамалжуулах талаар шийдвэр гаргах, байгальд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх;</p> <p>13.1.4.мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн нутаг дэвсгэртээ хаягдал ус зайлуулах цэг тогтоох;</p> <p>13.1.5.энэ хуулийн 28.4-т заасан дүгнэлтийг үндэслэн ус ашиглах зөвшөөрөл олгох;</p> <p>13.1.6.усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн зааг, тэжээгдлийн мужийг тэмдэгжүүлж, бүсийн дэглэмийг мөрдүүлэх;</p> <p>13.1.7. хуульд заасан бусад бүрэн эрх.</p>
<p><b>15 дугаар зүйл. Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх</b></p>	<p>15.1.Баг, хорооны Засаг дарга усны харилцааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>15.1.1.усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, зохистой ашиглах, усны орчинг нөхөн сэргээх тухай хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрийн биелэлтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулж хангах;</p> <p>15.1.2.гол, горхи, булаг, шанд, рашааны эхийг хамгаалах, тохижуулах, мод тарих, ургамалжуулах, ундаргыг нэмэгдүүлэх, бохирдлоос сэргийлэх арга хэмжээнд иргэдийг татан оролцуулах;</p> <p>15.1.3.нутаг дэвсгэртээ байгаа уст цэгийн ашиглалт, хамгаалалт, эзэмшилтэд хяналт тавих;</p> <p>15.1.4.усны онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг сахиулах;</p> <p>15.1.5.хуульд заасан бусад эрх.</p>
<p><b>17 дугаар зүйл. Сав газрын захиргааны бүрэн эрх</b></p>	<p>17.1.Сав газрын захиргаа нь усны харилцааны талаар дараах бүрэн эрхийг тухайн сав газартаа хэрэгжүүлнэ:</p> <p>17.1.3.бүх шатны Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг мэргэжлийн зөвлөмжөөр хангах;</p>
<p><b>18 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн байгаль орчны албаны бүрэн эрх</b></p>	<p>18.1.Аймаг, нийслэлийн байгаль орчны алба нь усны харилцааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>18.1.1.усны тухай хууль тогтоомжийн биелэлтийн явцад хяналт тавьж, үр дүнг аймаг, нийслэлийн Засаг дарга, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах;</p>
<p><b>22 дугаар зүйл. Усны нөөцийг хамгаалах</b></p>	<p>22.17.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ашиглаж дууссан цооногоо битүүмжлэн аймаг, нийслэлийн байгаль орчны алба, сум, дүүргийн Засаг даргад хүлээлгэж өгнө.</p>
<p><b>23 дугаар зүйл. Ган, цөлжилт, хуурайшилтын үед усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах</b></p>	<p>23.1.Ган, цөлжилт, хуурайшилтын үеийн тэнцвэрийг хангах зориулалтаар бороо, цас, үерийн усыг хуримтлуулах, далан, хаалт, хиймэл нуур, цөөрөм барьж байгуулах ажлын талаарх тухайн нутгийн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын үүсгэл санаачилгыг дэмжиж, бүх</p>

	<p>шатны Засаг дарга сав газрын захиргаатай хамтран зохион байгуулна.</p> <p>23.2.Тухайн жилийн ган, цөлжилт, хуурайшилтын зэрэглэлийг аймаг, нийслэлийн Засаг дарга, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран тогтооно.</p>
<p><b>24 дүгээр зүйл.</b> <b>Усны нөөцийг</b> <b>бохирдохоос</b> <b>хамгаалах</b></p>	<p>24.2.Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг хоногт 50 шоометрээс их, эсхүл энэ хуулийн 10.1.12-д заасан аюултай бохирдуулах бодис агуулсан хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн сав газрын захиргаа, хоногт 50 шоометрээс бага хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга олгоно.</p>
<p><b>28 дугаар зүйл.</b> <b>Ус ашиглагчид</b> <b>олгох зөвшөөрөл</b></p>	<p>28.4.Хоногт 100 шоометрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, 50-100 шоометр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоометр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана.</p> <p>28.6.Энэ хуулийн 28.4-т заасан дүгнэлтийг үндэслэн ус ашиглах зөвшөөрлийг хоногт 100 шоометрээс их ус ашиглах тохиолдолд сав газрын захиргаа, хоногт 50-100 шоометр ус ашиглахад аймаг, нийслэлийн байгаль орчны алба, хоногт 50 шоометрээс бага ус ашиглахад сум, дүүргийн Засаг дарга олгож, усны мэдээллийн санд бүртгэнэ.</p> <p>28.7.Хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн ус хангагч байгууллага нь усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаар дүгнэлт гаргуулж, сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авна.</p>
<p><b>29 дүгээр зүйл.</b> <b>Ус ашиглах гэрээ</b> <b>байгуулах, цуцлах</b></p>	<p>29.1.Энэ хуулийн 28.6, 28.7-д заасан зөвшөөрлийг үндэслэн хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрээс хангагдаж байгаа ус ашиглагчтай тухайн ус хангагч байгууллага, төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрээс хангагдаж байгаа ус ашиглагчтай сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, сум, дүүргийн Засаг дарга гэрээ байгуулна.</p>
<p><b>32 дугаар зүйл.</b> <b>Усны барилга</b> <b>байгууламж</b></p>	<p>32.5.Усны барилга байгууламж эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бусдын усны хэрэгцээг гэрээний үндсэн дээр хангах үүрэгтэй бөгөөд гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, сум, дүүргийн Засаг дарга тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан гэрээг цуцалж болно.</p>

---oOo---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

### УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай	<b>6 дугаар зүйл. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх</b>	6.2. Аймаг, нийслэлийн ус цаг уур, орчны шинжилгээний төв болон лаборатори, хүрээлэнгийн даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, улсын сүлжээний нэгжийн албан хаагчийг Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж, тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн харьяалах төв, лаборатори, хүрээлэнгийн дарга томилж, чөлөөлнө.
	<b>7 дугаар зүйл. Аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хорооны Засаг даргын эрх, үүрэг</b>	7.1. Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаар дараахь эрх, үүрэгтэй: 7.1.1. ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаархи хууль тогтоомж, Засгийн газар, бусад эрх бүхий байгууллагын шийдвэрийн биелэлтийг хангах; 7.1.2. нутаг дэвсгэрийнхээ ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний нэгжийн тасралтгүй ажиллах нөхцлийг бүрдүүлж, үйл ажиллагааны нэгдмэл дэг журмыг мөрдүүлэх; 7.1.3. ус цаг уур, орчны мэдээллээр нутаг дэвсгэрийнхээ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг шуурхай хангах, аюул болон орчны ноцтой бохирдлоос сэргийлэх ажлыг зохион байгуулах; 7.1.4. нутаг дэвсгэртээ аюулт үзэгдэл, гамшгийн хохирлыг тооцож, хохирлоос урьдчилан сэргийлэх журамд тодотгол хийж байх, учирсан хохирлын талаар төрийн захиргааны байгууллагад шуурхай мэдээлэх; 7.2. Баг, хорооны Засаг дарга ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаар дараахь эрх, үүрэгтэй: 7.2.1. энэ хуулийн 7.1.3-т заасан бүрэн эрхийг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх; 7.2.2. аюулт үзэгдэл, гамшгийн хохирлыг тооцож сум, дүүргийн Засаг даргад шуурхай мэдээлэх; 7.2.3. нутаг дэвсгэрийнхээ ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талбай, тоног төхөөрөмжийг хамгаалах арга хэмжээ авах.

---o0o---





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 07 сарын 05 өдөр

Улаанбаатар хот

### ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай	<b>5 дугаар зүйл. Паркийн зорилго, хэлбэр, зарчим</b>	5.2. Паркийн удирдлага өмчлөлийн хувьд дараах хэлбэртэй байна: 5.2.1. төрийн өмчит; 5.2.2. орон нутгийн өмчит; 5.2.3. хувийн өмчит; 5.2.4. бусад.
	<b>10 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх</b>	10.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга паркийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.1.1. паркийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөлд хяналт тавих; 10.1.2. холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн паркийн удирдлагад газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэн, гэрээ байгуулах; 10.1.3. энэ хуулийн 5.2.3, 5.2.4-т заасан паркийн газрыг эзэмшүүлж, ашиглуулах асуудлыг Газрын тухай хуульд заасны дагуу шийдвэрлэх; 10.1.4. харьяалах нутаг дэвсгэртээ үйлдвэрлэл, технологийн парк байгуулахад дэмжлэг үзүүлэх; 10.1.5. харьяалах нутаг дэвсгэртээ үйлдвэрлэл, технологийн паркийн асуудлаар гарсан шийдвэр, хэрэгжүүлж байгаа төслийн талаар тухай бүр олон нийтэд мэдээлэх; 10.1.6. хуульд заасан бусад бүрэн эрх.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 10 сарын 10 өдөр

Улаанбаатар хот

### ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХ БОЛОН ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай	<b>6 дугаар зүйл. Зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх арга хэмжээний үндсэн чиглэл</b>	6.1.Төрөөс зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: 6.1.3.терроризмын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж, терроризмоос ангид байх үзлийг төлөвшүүлэх;
	<b>11 дүгээр зүйл. Терроризмтой тэмцэх зөвлөл</b>	11.7.Аймаг, нийслэл дэх Зөвлөлийн орон тооны бус салбар зөвлөл /цаашид "салбар зөвлөл" гэх/-ийг аймаг, нийслэлийн Засаг дарга даргална.
	<b>12 дугаар зүйл. Зөвлөлийн эрх хэмжээ</b>	2.1.Зөвлөл дараах эрх хэмжээг хэрэгжүүлнэ: 12.1.3.зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх чиглэлээр төрийн байгууллага, иргэн, хэвлэл мэдээллийн болон бусад байгууллагын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах; 12.1.5.энэ хуулийн 6.1.3-т заасан чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулах; 12.2.Салбар зөвлөл энэ хуулийн 12.1.3, 12.1.5-д заасан эрх хэмжээг хэрэгжүүлж, харьяа нутаг дэвсгэртээ зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмоос урьдчилан сэргийлэх, үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг зохион байгуулна.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

### ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
<b>ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ</b>	<b>11 дүгээр зүйл. Бүх шатны Засаг дарга нарын оролцоо</b>	11.1.Бүх шатны Засаг дарга үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаанаас сэргийлэх, таслан зогсоох, түүний шалтгаан, нөхцлийг судлан тогтоох, арилгах арга хэмжээ авч, энэ асуудлаар нутаг дэвсгэртээ байгаа үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй албадад чиглэл өгч, холбогдох байгууллагад санал, хүсэлт тавина.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 сарын 28 өдөр

Улаанбаатар хот

### ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Үндэсний их баяр наадмын тухай	<b>5 дугаар зүйл. Үндэсний их баяр наадам</b>	<p>5.2.Хуульд өөрөөр заагаагүй бол Үндэсний их баяр наадмыг жил бүр Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1.1-д заасны дагуу аймаг, сумын баяр наадмыг 07 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд, улсын баяр наадмыг 07 дугаар сарын 11, 12, 13-ны өдрүүдэд улс орон даяар нэгэн зэрэг тэмдэглэнэ.</p> <p>5.3.Онцгой нөхцөл байдлаас шалтгаалан энэ зүйлийн 5.2-т зааснаас өөр өдрүүдэд улс, аймаг, сумын баяр наадмыг тэмдэглэх бөгөөд улс, аймгийн баяр наадмын хугацааг Засгийн газар, сумын баяр наадмын хугацааг аймгийн Засаг дарга тогтооно.</p> <p>5.4.Энэ хуулийн 5.3-т заасан нөхцөлд аймаг, сумын баяр наадмыг тэмдэглэх хугацааг 08 дугаар сарын 10-ны өдрөөс хэтрүүлэхгүй байхаар тогтооно.</p> <p>5.5.Улсын баяр наадмыг нийслэл хотод, эсхүл Засгийн газраас тогтоосон газарт, аймаг, сумын баяр наадмыг тухайн шатны Засаг даргын тогтоосон газарт тэмдэглэнэ.</p>
	<b>8 дугаар зүйл. Үндэсний бөх, үндэсний хурдан морь, сурын болон шагайн харвааны цол, чимэг</b>	<p>8.4.Аймаг, сумын баяр наадмыг зохион байгуулах хорооны саналыг үндэслэн бөх, сурын болон шагайн харваачид аймаг, сумын цолыг аймаг, дүүрэг, сумын Засаг дарга, аймгийн баяр наадмыг зохион байгуулах хорооны саналыг үндэслэн шагайн харваачид үндэсний спортын төрлөөр аймгийн цолыг аймгийн Засаг дарга олгоно.</p> <p>8.5.Энэ хуулийн 10.5, 10.6-д заасан амжилт, тухайн үндэсний спортын холбоо болон аймаг, сумын баяр наадмыг зохион байгуулах хорооны саналыг үндэслэн уяачид аймаг, сумын цолыг аймаг, дүүрэг, сумын Засаг дарга олгоно.</p>

	<p><b>10 дугаар зүйл. Үндэсний хурдан морины уралдаан</b></p>	<p>10.5.Аймгийн баяр наадмын үндэсний хурдан морины уралдаанд морь нь зургаан удаа түрүүлсэн, эсхүл 12 удаа айрагдсан уяачид аймгийн алдарт уяач цол олгоно.</p> <p>10.6.Сумын баяр наадмын үндэсний хурдан морины уралдаанд морь нь зургаан удаа түрүүлсэн, эсхүл 12 удаа айрагдсан уяачид сумын алдарт уяач цол олгоно.</p>
	<p><b>17 дугаар зүйл. Аймаг, сумын баяр наадмыг зохион байгуулах талаарх Засаг даргын бүрэн эрх</b></p>	<p>17.1.Аймаг, сумын баяр наадмыг зохион байгуулах талаар аймаг, сумын Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>17.1.1.хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах;</p> <p>17.1.2.энэ хуулийн 16.5.9-д заасан нийтлэг журмын хүрээнд баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх үүрэг бүхий аймаг, сумын хорооны бүрэлдэхүүн, дүрмийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан мөрдөх;</p> <p>17.1.3.энэ хуулийн 8.4-т заасан саналыг үндэслэн бөх, сурын болон шагайн харваачид, уяачид үндэсний спортын төрлөөр аймаг, сумын цол олгох, хүчингүй болгох;</p> <p>17.1.4.аймаг, сумын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардагдах төсвийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан зарцуулах;</p> <p>17.1.5.Үндэсний их баяр наадмын үндэсний хурдан морины уралдаан болон бусад сунгаа, бэлтгэлийн үед хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор уг нөхцөлийг үүсгэж байгаа үйл ажиллагааг хязгаарлах, хориглох арга хэмжээг авах, хяналт тавих.</p>

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 10 дугаар сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

### ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
<b>ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ</b>	<b>7 дугаар зүйл. Бүх шатны Засаг даргын бүрэн эрх</b>	7.1.Бүх шатны Засаг дарга харилцаа холбооны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 7.1.1.нутаг дэвсгэртээ харилцаа холбооны үйлчилгээг сайжруулах арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх; 7.1.2.аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны гудамж, талбай, барилга, орон сууц, хашааг хаягжуулах арга хэмжээ авах; 7.1.3.гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэний улмаас харилцаа холбооны сүлжээнд гарсан осол, гэмтлийг арилгах ажлыг зохион байгуулах; 7.1.4.радио, телевизийн болон харилцаа холбооны бусад сүлжээ байгуулж, ашиглах санаачлагыг дэмжих, туслалцаа үзүүлэх; 7.1.5.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 6 дугаар сарын 5-ны өдөр

Улаанбаатар хот

### ХАРЬЯАТЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Харьяатын тухай	<b>20 дугаар зүйл. Төрийн захиргааны байгууллагын эрх хэмжээ</b>	6.Засаг захиргаа, нутаг, дэвсгэрийн нэгжийн Засаг дарга, орон нутгийн цагдаагийн байгууллага болон улсын бүртгэлийн байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа иргэний харьяаллын асуудлаар хүсэлт гаргасан хүний, Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн буюу консулын газар нь гадаад улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа мөн асуудлаар хүсэлт гаргасан хүний хувийн байдлыг тодорхойлж дүгнэлт гаргана.
	<b>22 дугаар зүйл. Монгол Улсын иргэний харьяаллын асуудлаар хүсэлт гаргах журам</b>	1.Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах тухай хүсэлтийг аймаг, нийслэлийн Засаг дарга, хэрэв Монгол Улсын иргэн гадаад улсад оршин суугаа бол Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчдийн буюу консулын газар,Монгол Улсын гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар дамжуулан Ерөнхийлөгчид уламжилна. 3.Хүсэлтийг хүлээн авсан аймаг, нийслэлийн Засаг дарга, Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн буюу консулын газар холбогдох бусад баримт бичгийн бүрдлийг шалган хэрвээ уг баримт бичиг нь гадаад хэл дээр үйлдэгдсэн бол түүний албан ёсоор баталгаажуулсан орчуулга тодорхой саналын хамт Монгол Улсын гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.
	<b>26 дугаар зүйл. Монгол Улсын иргэний харьяаллын асуудлаар гарсан шийдвэрийг биелүүлэх байгууллага</b>	1.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа хүний иргэний харьяаллын асуудлаар гарсан шийдвэрийг аймаг, нийслэлийн Засаг дарга, гадаад улсын нутаг дэвсгэр дээр оршин суугаа хүний хувьд гарсан шийдвэрийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох дипломат төлөөлөгчийн буюу консулын газар хариуцан биелүүлнэ.

---оОо---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 сарын 07 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай	<b>4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт</b>	<p>4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:</p> <p>4.1.7."Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хөгжлийн зорилтот хөтөлбөрт суурилсан орон нутгийн онцлогийг тусгасан дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийг;</p> <p>4.1.10."Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр" гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэхэд чиглэсэн төлөвлөлтийн баримт бичгийг;</p> <p>4.1.11."Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө" гэж орон нутгийн онцлогт нийцсэн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн баримт бичгийг;</p> <p>4.1.12."Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр" гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн хавсралт баримт бичгийг;</p>
	<b>9 дүгээр зүйл. Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчийн эрх, үүрэг</b>	<p>9.10.Аймаг, нийслэлийн Засаг даргын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаарх чиг үүрэг:</p> <p>9.10.1.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулж, үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;</p>



		<p>9.10.2.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг боловсруулахад холбогдох саналаа үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;</p> <p>9.10.3.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хууль тогтоомжид заасан хугацаанд Засгийн газар болон үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тус тус хүргүүлэх;</p> <p>9.10.4.Засаг дарга сум, дүүргийн түвшинд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн уялдааг хангах, үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>9.10.5.Засаг дарга энэ хуулийн 9.10.1, 9.10.2, 9.10.3, 9.10.4-д заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ энэ хуулийг дагаж мөрдөх.</p>
	<p><b>17 дугаар зүйл. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн цаглавар</b></p>	<p>17.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга үйл ажиллагааныхаа хөтөлбөрийн хэрэгжилтийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хууль тогтоомжид заасан хугацаанд танилцуулна.</p> <p>17.2.Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авч, Засаг даргыг томилогдсоны дараах хоёр сарын дотор багтаан боловсруулна.</p> <p>17.4.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг Засаг даргыг томилогдсоны дараах 90 хоногт багтаан батална.</p> <p>17.5.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тухайн шатны Засаг дарга батлан хэрэгжүүлнэ.</p>
	<p><b>24 дүгээр зүйл. Хориглох зүйл, хүлээлгэх хариуцлага</b></p>	<p>24.4.Энэ хуулийн 4.1.6, 4.1.10-т заасан төлөвлөлтийн баримт бичигт туссан салбарын үзүүлэлтээ жигд ханган биелүүлээгүй нь Засгийн газрын гишүүнийг болон энэ хуулийн 4.1.7, 4.1.12-т заасан төлөвлөлтийн баримт бичигт туссан орон нутгийн үзүүлэлтээ жигд ханган биелүүлээгүй нь аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргыг огцруулах үндэслэл болно.</p>

---oOo---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

### ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай	<b>15 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох нөхцөл</b>	15.10. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь харьяалах засаг захиргааны нэгжид үйл ажиллагаа явуулж байгаа бүх шатны боловсролын байгууллагыг энэ хуулийн 15.1-д заасан сургалтын орчныг бүрдүүлэхэд зориулж тусгай хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлж, холбогдох зардлыг орон нутгийн төсөвт тусган шийдвэрлэнэ.
	<b>37 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох</b>	37.2. Хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг дараахь комисс /цаашид "Комисс" гэх/ тогтооно: 37.2.1. 0-16 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс; 37.2.2. 16 ба түүнээс дээш насны хүний хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс; 37.2.3. хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгаан, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс.
	<b>38 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүртгэх</b>	38.1. Энэ хуулийн 37.2-т заасан комиссын дүгнэлтийг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүртгэн үнэмлэх олгох үүргийг аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газар хэрэгжүүлнэ. 38.2. Энэ хуулийн 38.1-д заасан үнэмлэх нь хөгжлийн бэрхшээлтэй хүн хууль тогтоомжид заасан эрхээ эдлэх, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах үндсэн баримт болно. 38.3. Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх статистикийн мэдээллийг тогтоосон хугацаанд бүртгэл, статистикийн төрийн захиргааны байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад өгнө.

	<p><b>41 дүгээр зүйл. Орон тооны бус зөвлөл</b></p>	<p>41.4.Зөвлөл нь аймаг, нийслэл, дүүрэгт салбар зөвлөлтэй байх бөгөөд салбар зөвлөлийг Засаг дарга тэргүүлнэ.</p>
	<p><b>42 дугаар зүйл. Засаг даргын бүрэн эрх</b></p>	<p>42.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар харьяалах нутаг дэвсгэртээ дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>42.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангуулах арга хэмжээ авах;</p> <p>42.1.2.дэд бүтэц, нийтийн зориулалттай барилга байгууламж, хэвлэл, мэдээллийн хэрэгслийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байлгах, хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол, эрүүл мэнд, биеийн тамир, спорт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шат дараалсан арга хэмжээний төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих;</p> <p>42.1.3.хөгжлийн бэрхшээлтэй хүнд хамт олонд түшиглэн хөгжүүлэх үйлчилгээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;</p> <p>42.1.4.аж ахуйн нэгж, байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэйгээр үйлчлэх санал, санаачилгыг дэмжих;</p> <p>42.1.5.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаанд зарцуулагдах хөрөнгийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн тухайн жилийн орон нутгийн төсөвт тусгуулан батлуулах;</p> <p>42.1.6.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомжийг сурталчлах, түүний хэрэгжилтийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтран зохион байгуулах, урлаг соёл, биеийн тамир, олон нийтийн арга хэмжээнд оролцуулах, хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш эрх, эрх чөлөөг хүндэтгэх нөлөөллийн арга хэмжээ авах.</p>

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 5 дугаар сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

### ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Хог хаягдлын тухай	<b>9 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх</b>	<p>9.3.Хог хаягдлын талаар аймаг, нийслэлийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>9.3.1.хог хаягдлын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах;</p> <p>9.3.2.энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох;</p> <p>9.3.3.энэ хуулийн 9.3.2-т заасан зөвшөөрөл олгох журмыг батлах;</p> <p>9.3.4.хог хаягдлын менежментийг сайжруулах орон нутгийн хөтөлбөрийн биелэлтийг хангах;</p> <p>9.3.5.энэ хуулийн 8.1.3-т заасан журмын дагуу хог хаягдлын тайланг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд ирүүлэх;</p> <p>9.3.6.хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт, шалгалтыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах;</p> <p>9.3.7.нутаг дэвсгэрийн хэмжээнд аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаанд хяналт тавих;</p> <p>9.3.8.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, олон улсын зээл, тусламжаар байгуулсан хог хаягдал сэргээн ашиглах, дахин боловсруулах, булшлах, устгах байгууламжийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулах;</p> <p>9.3.9.хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор ангилан ялгах, дахивар нөөц цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагааг зохион байгуулж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх;</p>

		<p>9.3.10. хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учирсан эсхүл болзошгүй аюул үүсэх нөхцөл бүрдсэн тохиолдолд тархалтыг зогсоох, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг авах;</p> <p>9.3.11. нутаг дэвсгэрийн хэмжээнд хөрс бохирдуулагч жорлонгийн тоог үе шаттайгаар бууруулах арга хэмжээг авах, шаардагдах зардлыг шийдвэрлэх;</p> <p>9.3.12. хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журмыг батлах;</p> <p>9.3.13. хууль тогтоомжид заасан бусад.</p> <p>9.4. Хог хаягдлын талаар сум, дүүргийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>9.4.1. нутаг дэвсгэрийн хэмжээнд хог хаягдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;</p> <p>9.4.2. энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулах;</p> <p>9.4.3. нутаг дэвсгэрт хамаарах олон улсын, улсын, орон нутгийн чанартай авто замын байгууламж болон авто зам дагуух хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг энэ хуулийн 9.4.2-т заасны дагуу зохион байгуулах;</p> <p>9.4.4. хог хаягдлын үйлчилгээний хураамжаас төвлөрсөн орлогыг энэ хуулийн 41.9-д заасны дагуу зарцуулах;</p> <p>9.4.5. нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлүүлэх;</p> <p>9.4.6. энэ хуулийн 42.3, 42.4-т заасан хог хаягдлын талаархи боловсрол олгох сургалт, сурталчилгааг зохион байгуулах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх;</p> <p>9.4.7. хог хаягдлын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах;</p> <p>9.4.8. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөлтөд хяналт тавих;</p> <p>9.4.9. хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;</p> <p>9.4.10. энэ хуулийн 9.5.7-д заасан иргэдийн бүлгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;</p> <p>9.4.11. нийтийн эдэлбэр газарт хогийн савыг хүртээмжтэй тоогоор байрлуулах;</p> <p>9.4.12. нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдал, цас, мөсийг хариуцан цэвэрлэх 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газрын хилийн заагийг тогтоох;</p> <p>9.4.13. энэ хуулийн 9.3.11-д заасан эрхийг хэрэгжүүлэх;</p> <p>9.4.14. энэ хуулийн 9.3.12-т заасан журмын дагуу ажиллах хог хаягдлын олон нийтийн байцаагчийн урамшууллыг</p>
--	--	--

		<p>жил бүрийн төсөвт тусгаж, батлуулах, зарцуулалтад хяналт тавих.</p> <p>9.5.Хог хаягдлын талаар баг, хорооны Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>9.5.1.нутаг дэвсгэрийн хэмжээнд хог хаягдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;</p> <p>9.5.2.хог хаягдлыг цэвэрлэх үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах;</p> <p>9.5.3.иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөлтөд хяналт тавих;</p> <p>9.5.4.хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;</p> <p>9.5.5.хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих;</p> <p>9.5.6.хог хаягдлын талаархи олон нийтийн боловсролыг дээшлүүлэх ажилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах;</p> <p>9.5.7.хог хаягдлыг бууруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах санал санаачилга гаргах, зохион байгуулах үүрэг бүхий орон тооны бус иргэдийн бүлэг байгуулж ажиллуулах.</p>
	<p><b>13 дугаар зүйл. Хог хаягдалтай холбогдох үйл ажиллагаанд тавих хяналт</b></p>	<p>13.1.Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд улсын мэргэжлийн хяналтын байгууллага, бүх шатны Засаг дарга, цагдаа, хог хаягдлын олон нийтийн байцаагч болон хууль тогтоомжоор эрх олгогдсон албан тушаалтан хяналт тавина.</p>
	<p><b>41 дүгээр зүйл. Хог хаягдлын үйлчилгээний хураамж, төлбөр, үйл ажиллагааны санхүүжилт</b></p>	<p>41.13.Хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн тухай мэдээлэл өгсөн иргэнд уг мэдээлэл нь батлагдсан тохиолдолд зөрчил гаргагчид ногдуулсан торгуулийн 15 хувиар тооцож сум, дүүргийн Засаг дарга мөнгөн урамшуулал олгоно.</p>
	<p><b>42 дугаар зүйл. Хог хаягдлын талаархи боловсрол олгох</b></p>	<p>42.3.Хог хаягдлын талаархи боловсрол олгох сургалтыг орон нутагт зохион байгуулж, иргэдийг сургалтад бүрэн хамруулахад бүх шатны Засаг дарга санхүүгийн болон зохион байгуулалтын дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.</p> <p>42.4.Хувийн өмчит аж ахуйн нэгж, байгууллага өөрийн санаачлагаар хог хаягдлын талаархи боловсрол олгох сургалт зохион байгуулахад сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга болон нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллага нь сургалтын талбай, байраар дэмжлэг үзүүлэх, иргэдийн оролцоог хангахад туслалцаа үзүүлнэ.</p>

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 5 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

### ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай	<b>25 дугаар зүйл. Бүх шатны Засаг даргын бүрэн эрх</b>	<p>25.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>25.1.1. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг төлөвлөж, хэрэгжүүлэх;</p> <p>25.1.2. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>25.1.3. үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгааныг судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;</p> <p>25.1.4. хүний эрүүл мэнд, амь насанд ноцтой хохирол учруулсан үйлдвэрийн томоохон осол, хурц хордлогын үед түүний хор уршгийг арилгах, хүн амыг авран хамгаалахад чиглэгдсэн арга хэмжээ шуурхай авах;</p> <p>25.1.5. хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн нутаг дэвсгэртээ хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал эрхэлсэн ажилтныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг нь уялдуулах;</p> <p>25.1.6. хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг энэ хууль болон холбогдох стандартын дагуу зохион байгуулах;</p> <p>25.1.7. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон нутгийн зөвлөл байгуулж, ажиллуулах;</p> <p>25.1.8. хуульд заасан бусад бүрэн эрх.</p> <p>25.2. Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, Засаг даргын шийдвэрийг хэрэгжүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>25.2.1. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, иргэдийн Төлөөлөгчдийн болон иргэдийн Нийтийн хурал, дээд шатны Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;</p> <p>25.2.2. үйлдвэрлэлийн осол, аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллөөс иргэдийг хамгаалах, сэрэмжлүүлэхэд чиглэсэн арга хэмжээнд байгууллага, аж ахуйн нэгж, иргэнийг татан оролцуулах ажлыг зохион байгуулах;</p> <p>25.2.3. энэ хуулийн 25.1.6-д заасан бүрэн эрх;</p> <p>25.2.4. хуульд заасан бусад бүрэн эрх.</p>

---оОо---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 07 сарын 02 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Хөдөлмөрийн тухай	<b>15 дугаар зүйл. Нийгмийн гурван талт түншлэлийн удирдлага</b>	15.6.Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг Ерөнхий сайд, салбар хорооны бүрэлдэхүүнийг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн хорооны бүрэлдэхүүнийг тухайн шатны Засаг дарга талуудын саналыг үндэслэн тус тус батална.
	<b>33 дугаар зүйл. Хамтын гэрээ, хамтын хэлэлцээрийн биелэлтэд хяналт тавих, хэрэгжүүлэх</b>	33.1.Хамтын гэрээ, хамтын хэлэлцээрийн биелэлтэд талууд хяналт тавих бөгөөд хяналт тавих арга, хэлбэрийг талууд харилцан тохирч хамтын гэрээ, хамтын хэлэлцээрт тусгана. Хамтын хэлэлцээрт тусгайлан заагаагүй бол аймаг, нийслэл, сум, дүүргийн хамтын хэлэлцээрийн биелэлтэд тухайн шатны Засаг дарга, улсын хамтын хэлэлцээрийн биелэлтэд Үндэсний хороо тус тус хяналт тавина.
	<b>159 дүгээр зүйл. Хөдөлмөрийн удирдлагын тогтолцоо</b>	159.2.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, бүх шатны Засаг дарга, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллага болон сум, хороонд хөдөлмөрийн асуудал хариуцсан ажилтан /хөдөлмөрийн байгууллага/ хөдөлмөрийн төрийн удирдлагыг хэрэгжүүлнэ.

---o0o---





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 6 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

### ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай	<b>29 дүгээр зүйл. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага</b>	29.3.Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын даргыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө.
	<b>30 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллага, Хурлын болон Засаг даргын бүрэн эрх</b>	30.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 30.3.1.энэ хуулийн 22.1.2-т заасан хөрөнгийг аймаг, нийслэл, дүүргийн төсөвт тусгуулах талаар жил бүр санал боловсруулах; 30.3.2.хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг уялдуулан зохион байгуулах, хянах; 30.3.3.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдах ажил олоход хүндрэлтэй иргэдийн талаарх мэдээлэл, судалгааг гаргаж, хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээг тодорхойлох, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамруулах; 30.3.4.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.
	<b>32 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт</b>	32.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд дараах эрх бүхий байгууллага, албан тушаалтан хяналт тавина: 32.1.1.Улсын Их Хурал, Засгийн газар, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд;

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 05 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

### ХӨРС ХАМГААЛАХ, ЦӨЛЖИЛТӨӨС СЭРГИЙЛЭХ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай	<b>6 дугаар зүйл. Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх нийтлэг арга хэмжээ</b>	6.1.Хөрс хамгаалахад дараах нийтлэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: 6.1.1.сул зэрэглэлийн доройтол илэрсэн хөрсөнд сэргийлэх; 6.1.2.дунд зэрэглэлийн доройтол илэрсэн хөрсөнд сааруулах; 6.1.3.хүчтэй зэрэглэлийн доройтол илэрсэн хөрсөнд тэмцэх; 6.1.4.хөрсийг нөхөн сэргээх; 6.1.5.хөрс хамгаалах чиглэлээр чадавхийг бэхжүүлэх; 6.1.6.олон салаа зам гаргахгүй байх. 6.2.Цөлжилттэй тэмцэхэд дараах нийтлэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: 6.2.1.бүс нутгийн онцлогт тохируулан газрын тогтвортой менежментийг бий болгох; 6.2.2.ойн зурвас бүхий тариалан эрхлэлтийг дэмжих; 6.2.3.усны нөөцийг зөв зохистой ашиглах, хамгаалах, нэмэгдүүлэх; 6.2.4.ой болон ургамлыг хамгаалах, ойжуулах; 6.2.5.тариалангийн талбайн хөрс хамгаалах.
	<b>8 дугаар зүйл. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх талаар төрийн байгууллагын бүрэн эрх</b>	8.4. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх талаар аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.4.1.хөрсний доройтлыг бууруулах, бохирдлыг аюулгүй болгох, саармагжуулах, дарж булах, хуулж авах зэрэг бусад арга хэмжээг мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэх; 8.4.2.нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх чиглэлээр энэ хуулийн 6.1, 6.2-т заасан арга хэмжээг

		<p>хэрэгжүүлэх зардлын төсвийн төслийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж, хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг тайлагнах;</p> <p>8.4.3.нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх талаар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, зөрчлийг арилгуулах;</p> <p>8.4.4.хөрсний доройтолд орох магадлалтай газар нутгийн жагсаалтыг аймаг, нийслэлийн газрын алба, мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран тодорхойлж тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган жил бүр газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;</p> <p>8.4.5.иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын буруутай үйл ажиллагаанаас хөрс хүчтэй доройтсон, цөлжсөн нь мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон бол тухайн газар нутагт тодорхой төрлийн үйл ажиллагааг тав хүртэл жилийн хугацаагаар хязгаарлах, хориглох</p>
	<p><b>12 дугаар зүйл. Хөрсөнд учруулсан хохирлын нөхөн төлбөр</b></p>	<p>12.1.Хөрсөнд доройтол учруулсан тохиолдолд мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн байгаль орчны хяналтын улсын байцаагч, холбогдох сум, дүүргийн Засаг дарга учирсан хохирлыг арилгуулж, нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг наймаас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгууль ногдуулан, төлөлтөд нь хяналт тавина.</p> <p>12.2.Гэм буруутай этгээд нөхөн төлбөр төлсөн нь түүнийг Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.</p>

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 05 сарын 06 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### ХОРШООНЫ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Хоршооны тухай	<b>43 дугаар зүйл. Нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын бүрэн эрх</b>	43.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хоршооны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 43.2.1.хоршоог дэмжих, хоршооны үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; 43.2.2.хоршооны бараа, бүтээгдэхүүний борлуулалт болон хоршоод үйл ажиллагааны чиглэлээр хорших, харилцан уялдаатай хамтын ажиллагааг дэмжих ажлыг зохион байгуулах; 43.2.3.хуульд заасан бусад бүрэн эрх

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 5 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

### ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Хот байгуулалтын тухай	<b>9 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх</b>	9.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь хот байгуулалтын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 9.1.1.хот, тосгоны батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон барилгажилтын төслийг үндэслэн газар олгох, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; 9.1.2.аймаг, нийслэлийн ерөнхий архитекторыг 4 жилийн хугацаагаар нээлттэй сонгон шалгаруулалт, нээлттэй сонсголын үндсэн дээр томилох; 9.1.3.ерөнхий архитектороор удирдуулсан Хот байгуулалт, барилга захиалагчийн албыг байгуулах; 9.1.4.аймаг, нийслэлийн хөгжлийн төсөл, хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, тодотгол, шинэчлэл хийх асуудлыг санаачлан зохион байгуулах; 9.1.5.хот байгуулалтын үйл ажиллагаа болон газар ашиглалт, хамгаалалтад хяналт тавих; 9.1.6.хот байгуулалтын чиглэлээр хийгдсэн ажлын талаархи тайланг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жилд нэг удаа ирүүлэх.
	<b>16 дугаар зүйл. Шинэ хороолол, бичил хорооллын төлөвлөлт, байгуулалт</b>	16.1.Шинэ хороолол, бичил хорооллыг төлөвлөх болон байгуулах асуудлыг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр аймаг, нийслэлийн Засаг дарга санаачилна.
	<b>18 дугаар зүйл. Олон нийтэд мэдээлэх</b>	18.1.Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, хотын захирагчийн ажлын алба нь энэ хуулийн хүрээнд гаргасан аливаа шийдвэрийн талаар тухай бүр олон нийтэд мэдээлнэ.

---оОо---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 6 дугаар сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

### ХОТ, СУУРИН ГАЗРЫГ ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай	<b>11 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх</b>	<p>11.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хот, суурин газрыг дахин хөгжүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>11.1.1.хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг үндэслэн төсөл санаачлах, боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>11.1.2.улс, орон нутгийн төсвөөр хэрэгжих төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх;</p> <p>11.1.3.төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах;</p> <p>11.1.4.төсөл хэрэгжүүлэх гурван талт гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг хангуулах;</p> <p>11.1.5.төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөг нийтэд сурталчлах, мэдээллэх, санал, гомдол хүлээн авах замаар олон нийтийн оролцоог хангах ажлыг зохион байгуулах;</p> <p>11.1.6.сэргээн босголтын үйл ажиллагааг Засгийн газрын шийдвэрээр хэрэгжүүлэх.</p> <p>11.2.Газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч иргэн, хуулийн этгээдтэй аймаг, нийслэлийн Засаг дарга гурван талт гэрээ байгуулна.</p>
	<b>14 дүгээр зүйл. Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаа</b>	<p>14.1.Хот, суурин газрыг дахин хөгжүүлэхээр иргэн, хуулийн этгээдээс гаргасан саналыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хүлээн авах, хянан шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд хэрэгжүүлэх эсэх талаар шийдвэр гаргана.</p> <p>14.2.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга энэ зүйлийн 14.1-д заасан саналыг дэмжсэн тохиолдолд төсөл хэрэгжүүлэхээр сонгох талбайд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, батлуулах ажлыг Хот байгуулалтын тухай хуулийн дагуу зохион байгуулж, уг төлөвлөгөөнд хууль ёсны эрх, ашиг</p>

		<p>сонирхол нь хөндөгдсөн, хөндөгдөж болзошгүй иргэн, хуулийн этгээдийн саналыг авч тусгана.</p> <p>14.4.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нийтийн эрх ашигт хамаарах дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслийг санаачилна:</p> <p>14.4.1.хот, суурин газар, дүүрэг, хорооллын чанартай инженерийн бэлтгэл арга хэмжээ, батлан хамгаалах болон гамшгаас хамгаалах зориулалт бүхий барилга байгууламж барих;</p> <p>14.4.2.хот, суурин газар, дүүрэг, хорооллын чанартай инженерийн болон нийгмийн дэд бүтэц, нийтээр ашиглах барилга байгууламж барих;</p> <p>14.4.3.улс, орон нутаг, хот, суурин газрын эдийн засаг, нийгмийн хөгжилд тэргүүлэх ач холбогдол бүхий бусад ажил.</p> <p>14.5.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга төсөл хэрэгжүүлэхийг сонирхогч хуулийн этгээдийн саналыг хүлээн авах талаар аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас төсөл хэрэгжүүлэх талбайн байршил, хэмжээ, хил зааг, зориулалтыг тогтоох шийдвэр гаргаснаас хойш 14 хоногийн дотор нийтэд мэдээлнэ.</p>
	<p><b>15 дугаар зүйл.</b></p>	<p>15.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хот төлөвлөлтийн шаардлага хангахгүй барилгажсан хэсгийг дахин төлөвлөж барилгажуулах, нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах тухай саналыг хянаж, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр төсөл санаачилна.</p>
	<p><b>16 дугаар зүйл.</b> <b>Ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих</b></p>	<p>16.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга барилга, хот байгуулалтын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын дүгнэлтийг үндэслэн тухайн барилга байгууламжийг ашиглахыг хориглосон шийдвэр гаргана.</p> <p>16.3.Барилга байгууламж өмчлөгч нь тухайн барилга байгууламжийг ашиглахыг хориглосон шийдвэрийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргаас хүлээн авмагц түүнийг дахин төлөвлөлтөд оруулах тухай хүсэлтээ 14 хоногийн дотор тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад хүргүүлнэ.</p>

---оОо---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 10 дугаар сарын 6-ны өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай	<b>8 дугаар зүйл.</b> <b>Аймаг,</b> <b>нийслэлийн</b> <b>Засаг даргын</b> <b>бүрэн эрх</b>	<p>8.1.Аймаг, сум, нийслэлийн Засаг дарга хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>8.1.1.хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан бодлого, шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>8.1.2.нутаг дэвсгэрийнхээ ус хангамж, ариутгах татуурга, гадаргын ус зайлуулах барилга байгууламжийг төлөвлөх талаар төсөл, хөтөлбөр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах;</p> <p>8.1.3.ус хангамж, ариутгах татуургын орон нутгийн өмчийн барилга байгууламжийн захиалагчийн үүргийг Барилгын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх;</p> <p>8.1.4.ус хангамж, ариутгах татуургын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад тухайн чиглэлээр мэргэшсэн хүнийг хот, суурины ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн томилж, чөлөөлөх;</p> <p>8.1.5.унд, ахуйн хэрэглээний усны аюулгүй байдлыг хангах, ариун цэврийн байгууламжийн стандартыг мөрдүүлэх;</p> <p>8.1.6.тухайн нутаг дэвсгэрт цэвэр, бохир усны шугам сүлжээний хамгаалалтын зурваст баригдсан барилга байгууламж, айл өрхийг нүүлгэн шилжүүлэх, эдгээр зөрчлийг гаргуулахгүй байх арга хэмжээг авах;</p> <p>8.1.7.нүхэн жорлонгийн тоог бууруулах ажлыг зохион байгуулах;</p> <p>8.1.8.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</p> <p>8.2.Сумын Засаг дарга нь тухайн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын баримт бичигтэй уялдуулан ус хангамж, ариутгах татуурга, инженерийн дэд бүтцийн шугам сүлжээг бүрдүүлж, ашиглалт, үйлчилгээг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.</p>

---оОо---





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1993 оны 12 дугаар сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

### ХОТ, ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай	<b>10 дугаар зүйл. Хот, тосгоны удирдлагын тогтолцоо</b>	<p>4.Аймаг, сум, багийн төв болох хот, тосгоны удирдлагын бүрэн эрхийг тухайн хот, тосгон оршин байгаа засаг захиргааны нэгжийн засаг дарга хэрэгжүүлнэ.</p> <p>5.500 хүртэл хүн амтай сууринд оршин суугчдын нийгэм, ахуйн асуудлыг тухайн сууринд голлох аж ахуйн нэгжийн удирдлага, түүнчлэн харьяалах баг, сумын иргэдийн Нийтийн болон төлөөлөгчдийн хурал, Засаг дарга тус тус шийдвэрлэнэ.</p>
	<b>14 дүгээр зүйл. Захирагчийг сонгогдсонд тооцож бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх</b>	<p>1.Хот, тосгоны захирагчийн сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг тухайн хот, тосгоны захирагчаар сонгогдсонд тооцно.</p> <p>2.Хэрэв нэр дэвшигчдийн хэн нь ч олонхийн санал аваагүй бол сонгуульд оролцсон нийт сонгогчийн хамгийн олон санал авсан хоёр хүнийг дахин санал хураалтад оруулна. Дахин санал хураалтад оролцсон нийт сонгогчийн олонхийн санал авсан хоёр хүнийг дахин санал хураалтад оруулна. Дахин санал хураалтад оролцсон нийт сонгогчийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг тухайн хот, тосгоны захирагчаар сонгогдсонд тооцно.</p> <p>3.Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу сонгогдсон улсын зэрэглэлтэй хотын захирагчийн бүрэн эрхийг Ерөнхий сайд, аймгийн зэрэглэлтэй хотын захирагчийн бүрэн эрхийг аймгийн Засаг дарга, тосгоны захирагчийн бүрэн эрхийг сумын Засаг дарга тус тус хүлээн зөвшөөрнө.</p>
	<b>15 дугаар зүйл. Хот, тосгоны захирагчийг</b>	<p>2.Захирагчийг огцруулах саналыг сонгуулийн эрх бүхий оршин суугчдын 30-аас доошгүй хувь нь бичгээр гаргасан, түүнчлэн Ерөнхий сайд, аймаг, сумын Засаг дарга үндэслэл бүхий санал гаргасан</p>

	<p><b>чөлөөлөх, огцруулах</b></p>	<p>бол захирагчийг огцруулах эсэх асуудлаар оршин суугчдын санал хураалтыг явуулна.</p> <p>3.Гэмт хэрэг үйлдсэн болохыг тогтоосон шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон, мөн түүнчлэн тухайн хот, тосгоны захирагчийг огцруулах тухай санал хураалтад оролцсон оршин суугчдын олонхи нь огцруулахыг дэмжвэл захирагчийг огцруулна.</p> <p>4.Энэ зүйлийн 1, 3 дахь хэсэгт заасныг үндэслэн хот, тосгоны захирагчийг чөлөөлөх, огцруулах тухай шийдвэрийг Ерөнхий сайд болон харьяалах аймаг, сумын Засаг дарга тус тус гаргана.</p>
	<p><b>16 дугаар зүйл. Хот, тосгоны захирагч ажлаа тайлагнах</b></p>	<p>Хот, тосгоны захирагч нь ажлаа тухайн хот, тосгоны оршин суугчдад жилд 2 удаа тайлагнаж, үйл ажиллагааныхаа талаар Ерөнхий сайд болон харьяалах аймаг, сумын Засаг даргад тус тус мэдээлж байна.</p>
	<p><b>25 дугаар зүйл. Хот, тосгоны захирагчийн эрхийн баталгаа</b></p>	<p>2.Хот, тосгоны захирагчийн захирамж хууль тогтоомжид нийцээгүй бол өөрөө өөрчилж, хүчингүй болгож эсхүл Ерөнхий сайд болон харьяалах аймаг, сумын Засаг дарга тус тус хүчингүй болгоно.</p>
	<p><b>32 дугаар зүйл. Нутгийн захиргааны байгууллагатай харилцах</b></p>	<p>3.Захирагчийн шийдвэрт харьяалах засаг захиргааны нэгжийн Засаг дарга үүрэг хүлээхээр тусгагдсан тохиолдолд уг шийдвэрийг хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл Засаг дарга түдгэлзүүлж болно.</p> <p>4.Хот, тосгоны захирагч нь эдийн засаг, аж ахуйн асуудлаар Засаг даргатай харилцан ажиллах бөгөөд хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол улсын зэрэглэлтэй хотын захирагч, аймгийн Засаг даргын хооронд үүссэн маргааныг Ерөнхий сайд, аймгийн зэрэглэлтэй хот, тосгоны захирагч, сум, багийн Засаг даргын хооронд үүссэн маргааныг харьяалах дээд шатны Засаг дарга тус тус шийдвэрлэнэ.</p>

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр

Улаанбаатар хот

### ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ УЛСЫН ТООЛЛОГЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай	<b>6 дугаар зүйл. Тооллого зохион байгуулж явуулахад гарах зардал, түүний санхүүжилт</b>	6.5.Тооллого зохион байгуулж явуулах комиссын ажиллах байр, тээвэр, холбооны болон бусад шаардлагатай хэрэгслээр хангах асуудлыг тухайн шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга, холбогдох төрийн захиргааны төв байгууллага хариуцна.
	<b>16 дугаар зүйл. Тооллого зохион байгуулж явуулахад нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх, үүрэг</b>	16.2.Тооллого зохион байгуулж явуулахад бүх шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга дор дурдсан үүрэгтэй оролцоно: 16.2.1.нутаг дэвсгэртээ тооллого явуулах бэлтгэл ажлыг хангах; 16.2.2.тооллого явуулахын өмнө хүн ам, өрхийн бүртгэлийн хөдөлгөөнийг бүрэн хийж, мэдээллийн санг бэлтгэх; 16.2.3.тооллогын асуудлаар Улсын комисс болон Үндэсний статистикийн хорооноос өгсөн удирдамж, чиглэлийн дагуу тооллогын ажлыг нутаг дэвсгэртээ зохион байгуулах; 16.2.4.тооллого явуулахтай холбогдуулан харъяа нутаг дэвсгэрийн гудамж, талбайн нэр, байр, орон сууцны хаягжилт, дугаарлалтыг цэгцлэх, тооллого явуулах нутаг дэвсгэрийн хил заагийг тогтоон, зураглал гаргах; 16.2.5.тооллогын комиссыг ажиллах болон тооллогын материалыг хадгалах байр, тавилга, шаардлагатай бусад тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах; 16.2.6.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

---оОо---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1998 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр

Улаанбаатар хот

### ХҮН АМЫН АМЬЖИРГААНЫ ДООД ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай	<b>3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо</b>	3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:  3.1.1.хүн амын амьжиргааны доод түвшин гэж хэрэглээний доод хэмжээг мөнгөн хэлбэрээр илэрхийлснийг;  3.1.2.хэрэглээний доод хэмжээ гэж хүний нэн тэргүүний зайлшгүй хэрэгцээг хангах хүнсний болон хүнсний бус хэрэглээний сагсаар тодорхойлсон бараа, үйлчилгээний шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоосон тоо, хэмжээг.
	<b>6 дугаар зүйл. Хүн амын амьжиргааны доод түвшинг хэрэглэх</b>	6.1.Нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөдөлмөрийн хөлс, нөхөн олговрын хэмжээг тогтоох, төрөөс иргэдэд эд, мөнгөний туслалцаа үзүүлэхэд хүн амын амьжиргааны доод түвшинг жишиг болгон зохих хууль тогтоомжоор зохицуулна.
	<b>7 дугаар зүйл. Хүн амын амьжиргааны доод түвшингийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт</b>	7.1.Хүн амын амьжиргааны доод түвшингийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага хяналт тавина.

---о0о---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 12 сарын 13 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### ХҮНИЙ ДАРХЛАЛ ХОМСДОЛЫН ВИРУСЫН ХАЛДВАР, ДАРХЛАЛЫН ОЛДМОЛ ХОМСДОЛООС СЭРГИЙЛЭХ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай	<b>6 дугаар зүйл. Нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргын эрх, үүрэг</b>	6.2.Бүх шатны Засаг дарга хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавина.
	<b>11 дүгээр зүйл. Хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой хүний эрхийг хамгаалах</b>	11.1.Хуульд өөрөөр заагаагүй бол хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой хүний эрх, эрх чөлөөг хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой гэсэн үндэслэлээр хязгаарлахыг хориглоно. 11.2.Хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой хүнийг гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг хориглоно. 11.3.Байгууллага, албан тушаалтан, иргэн нь хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой хүний талаарх мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд задруулахыг хориглоно. 11.4.Энэ хуулийн 11.3-т заасан мэдээлэлд хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой нь тогтоогдсон хүний эцэг, эхийн нэр, өөрийн нэр, ажлын, сургуулийн болон байнга оршин суугаа газрын хаяг, онцлог тэмдэг, гэрэл зураг, утасны дугаар, шинжилгээний хариу хамаарна.

---о0о---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 12 дугаар сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

### ХҮНСНИЙ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Хүнсний тухай	<b>5 дугаар зүйл. Хүнсний хангамжийг тодорхойлох</b>	<p>5.1.Монгол хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөхөд шаардагдах хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>5.2.Энэ хуулийн 5.1-д заасны дагуу баталсан зохистой хэмжээг үндэслэн хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хүнсний хангамжийг тодорхойлно.</p> <p>5.3.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 5.1-д заасны дагуу баталсан зохистой хэмжээг үндэслэн нутаг дэвсгэрийнхээ хүн амын хүнсний хангамжийг тодорхойлно.</p> <p>5.4.Энэ хуулийн 5.2, 5.3-т заасны дагуу тодорхойлсон хүнсний хангамжийн тогтвортой, тэнцвэртэй, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааг улсын хэмжээнд хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, дүүрэгт аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх хүнсний асуудал хариуцсан төрийн байгууллагын нэгж, сум, тосгонд хүнсний асуудал хариуцсан албан хаагч хэрэгжүүлнэ.</p>
	<b>6 дугаар зүйл. Хүнсний нөөц</b>	<p>6.1.Хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтвортой байлгах зорилгоор стратегийн хүнсний улирлын нөөцийг бүрдүүлнэ.</p> <p>6.2.Энэ хуулийн 6.1-д заасан стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмыг Засгийн газар батална.</p> <p>6.3.Аймаг, нийслэлийн Засаг дарга нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд энэ хуулийн 6.2-т заасан журмын дагуу стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.</p> <p>6.5.Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг стратегийн хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангах арга хэмжээг тухайн шатны Засаг дарга авч хэрэгжүүлнэ.</p>

---оОо---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 01 сарын 19 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Хүн худалдаалахтай тэмцэх тухай	<b>9 дүгээр зүйл. Хамгаалах байр</b>	<p>9.1. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, алдар хүндийг хамгаалах, аюулгүй байдлыг нь хангах зорилгоор хамгаалах байр ажиллана.</p> <p>9.2. Хохирогч болсон гэж өөрийгөө үзсэн этгээд хамгаалах байрны үйлчилгээнд хамрагдах тухай хүсэлтээ цагдаагийн байгууллага, эсхүл хамгаалах байрны захиргаанд гаргана.</p> <p>9.3. Хүн худалдаалах гэмт хэргийг цагдаагийн болон тагнуулын байгууллага шалгаж эхэлсэн эсэхийг үл харгалзан хохирогчийг хамгаалах байранд түр байрлуулна.</p>
	<b>13 дугаар зүйл. Хохирогч хүүхдийг хамгаалах</b>	<p>13.1. Хүүхэд хохирогч болсон бол цагдаагийн байгууллага болон энэ хуулийн 9.1-д заасан хамгаалах байрны ажилтан нь түүний эцэг, эхийг нэн даруй олж тогтоох арга хэмжээ авна.</p> <p>13.2. Хохирогч хүүхдийн эцэг, эхийг олж тогтоогоогүй тохиолдолд түүнийг асран хамгаалах, харгалзан дэмжих этгээдийг тухайн сум, дүүргийн Засаг дарга томилно.</p> <p>13.3. Хохирогч хүүхдийг энэ хуулийн 9.1-д заасан хамгаалах байранд насанд хүрсэн хохирогчоос тусад нь байрлуулна.</p> <p>13.4. Хохирогч хүүхдийг зохих шатны сургуульд хамруулах үүргийг тухайн сум, дүүргийн Засаг дарга хариуцна.</p>

---о0о---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 07 сарын 01 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Хууль зүйн туслалцааны тухай	<b>23 дугаар зүйл. Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагатай харилцах</b>	<p>23.1. Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд дараах байдлаар дэмжлэг үзүүлнэ:</p> <p>23.1.1. салбарыг стандартын шаардлага хангасан ажлын байр, техник, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслээр хангах;</p> <p>23.1.2. хууль зүйн туслалцаа үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тухайн нутаг дэвсгэрт ажиллахаар томилогдсон улсын өмгөөлөгчийг орон байраар хангахад дэмжлэг үзүүлэх.</p> <p>23.2. Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга иргэний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын салбарын өмгөөлөгч, ажилтныг орон сууц, тээврийн хэрэгслээр хангах, улсын өмгөөлөгч, түүний гэр бүлийн гишүүнд дэмжлэг үзүүлэхэд шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж болно.</p>

---o0o---





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

### ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
<b>ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ</b>	<b>46 дугаар зүйл. Хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах</b>	46.3.Засгийн газар, холбогдох төрийн захиргааны төв байгууллага, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга хууль тогтоомжийг өөрийн бүрэн эрх, чиг үүргийн дагуу харьяалах салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

### ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
<b>ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ</b>	<b>16 дугаар зүйл. Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл</b>	Хүүхдийн төлөө орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах дүрэм, хүүхдийн төлөө сангийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг тус хуулийн 16 дугаар зүйлээс дэлгэрүүлж үзнэ үү.
	<b>17 дугаар зүйл. Бүх шатны Засаг даргын үүрэг, оролцоо</b>	17.1.Бүх шатны Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ хүүхдийн эрхийг хангах талаар дараахь арга хэмжээ авна: 17.1.1.тухайн шатны хүүхдийн төлөө зөвлөлийг тэргүүлэх; 17.1.2.хүүхдийн эрхийг хангах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэмжээг авах, энэ талаар гарсан санал, санаачилгыг дэмжих, нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах; 17.1.3.тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тухайн жилд хүүхдийн эрхийг хангах үйл ажиллагаанд шаардагдах төсвийг батлуулж, хэрэгжүүлэх, үр дүнг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж, олон нийтэд мэдээлэх; 17.1.4.хүүхдэд зориулсан үйлдвэрлэл, үйлчилгээ, сургалт, хүмүүжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийг дэмжих, үйл ажиллагаанд нь хяналт тавих; 17.1.5.хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр ашигтай өнгөрүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авах, хүүхдэд зориулсан барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, зориулалтын дагуу ашиглуулах; 17.1.6.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг түр байршуулах, асрамжлах, шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

---оОо---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

### ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Хүүхэд хамгааллын тухай	<b>15 дугаар зүйл. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд хамгааллын хамтарсан багийн ажил үйлчилгээ</b>	15.1.Аймаг, дүүргийн Засаг дарга орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай зөвшилцөн хүүхдийн эрхийн хууль зүйн хороог байгуулах бөгөөд хороо нь дараахь үйл ажиллагаа явуулна: Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны эрхлэх үйл ажиллагааг тус хуулийн 15.1.1-15.1.7 дахь заалтаас дэлгэрүүлж үзнэ үү.
	<b>18 дугаар зүйл. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны, орон нутгийн байгууллагын үйл ажиллагаа</b>	18.4.Аймаг, нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан газар, хэлтсийн даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, дүүргийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан газар, хэлтсийн даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан дарга Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж томилж, чөлөөлнө.
	<b>20 дугаар зүйл. Нийгмийн ажилтны эрх зүйн байдал</b>	20.5.Нийгмийн ажилтныг ажиллах нөхцөл, боломжоор хангах үүргийг сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хариуцна.
	<b>23 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын санхүүжилт</b>	23.2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор хүүхэд хамгааллын хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажил, үйлчилгээний зардал, нийгмийн ажилтны урамшууллыг улс болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

### ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Хүүхэд харах үйлчилгээний тухай	<b>13 дугаар зүйл.</b> <b>Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох</b>	<p>13.2.Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байдал, баг, хорооны Засаг даргын санал, дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга олгоно.</p> <p>13.3.Баг, хорооны Засаг дарга энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан нөхцөл, шаардлага болон баримт бичгийн бүрдлийг хангасан эсэхийг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу хянан, магадлан шалгах ажиллагааг хийнэ. Магадлан шалгах ажиллагааг дууссанаас хойш ажлын гурван өдөрт багтаан дүгнэлтийг баримт бичгийн хамт сум, дүүргийн Засаг даргад хүргүүлнэ. Сум, дүүргийн Засаг дарга зөвшөөрөл олгох эсэх шийдвэрийг ажлын таван өдөрт багтаан гаргана.</p> <p>13.4.Энэ хуулийн 13.3-т заасны дагуу баг, хорооны Засаг дарга дүгнэлт гаргахад орон нутгийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага арга зүйн дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.</p>

---о0о---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

### ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль	<b>18 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын бүрэн эрх</b>	18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараахь бүрэн эрхтэй: 18.1.1.тухайн нутаг дэвсгэрт хэрэглэгчийн эрхийг хамгаалах бодлого болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих; 18.1.2.хэрэглэгчид хэрэглээний соёл эзэмшүүлэх сургалт зохион байгуулах; 18.1.3.тухайн нутаг дэвсгэрт хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай гэрээний үндсэн дээр хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх.

---oOo---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 2 дугаар сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

### ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Цагдаагийн албаны тухай	<b>7 дугаар зүйл. Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага</b>	7.2.Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын даргыг цагдаагийн төв байгууллагын дарга тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө.
	<b>16 дугаар зүйл. Засгийн газар болон нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргаас цагдаагийн байгууллагатай харилцах</b>	16.4.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд хариуцсан нутаг дэвсгэртээ нийтээр дагаж мөрдөх журам тогтоож, түүний хэрэгжилтийг хангуулахыг тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад хуулиар хүлээсэн үүргийнх нь хүрээнд даалгана. 16.5.Засгийн газар болон нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргаас цагдаагийн байгууллагатай харилцах талаар энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. 16.6.Засаг дарга тухайн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын даргыг албаны орон сууцаар хангах арга хэмжээ авна.
	<b>28 дугаар зүйл. Орон байр, бусад газарт нэвтрэн орох</b>	28.11.Оршин суугч, эзэмшигчийн эзгүйд орон байр, бусад газарт нэвтрэн орсон бол тэдгээрт даруй мэдэгдэх, боломжгүй бол 24 цагийн дотор мэдэгдэх арга хэмжээ авна. 28.12.Энэ хуулийн 28.11-д заасны дагуу оршин суугч, эзэмшигчид мэдэгдэх боломжгүй бол түүний оршин суугаа газрын баг, хорооны Засаг даргад мэдэгдэнэ.
	<b>44 дүгээр зүйл. Жагсаал, цуглааныг албадан тараах</b>	44.1.Цагдаагийн байгууллага жагсаал, цуглааныг албадан тараахын өмнө оролцогчдод бүх төрлийн холбоо, мэдээллийн хэрэгсэл ашиглан жагсаал, цуглааныг албадан тараах тухай сум,

		дүүргийн Засаг даргын шийдвэрийг мэдэгдэж, биелүүлээгүй, эсхүл эсэргүүцсэн тохиолдолд авах арга хэмжээг урьдчилан анхааруулна.
	<b>63 дугаар зүйл. Олон нийтийн цагдаа</b>	63.2.Аймаг, нийслэлийн Засаг даргаас Иргэний зөвлөл, цагдаагийн байгууллагатай зөвшилцөн гаргасан саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал олон нийтийн цагдаагийн тоог жил бүр тогтооно.
	<b>65 дугаар зүйл. Иргэн, хуулийн этгээд, албан тушаалтны үүрэг, туслалцаа</b>	65.5.Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга бүх талын туслалцаа үзүүлэх үүрэгтэй.
	<b>94 дүгээр зүйл. Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх</b>	94.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нь нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, алба хаагчийг орон байр, хүнс, тээвэр, холбооны хэрэгслээр хангах, томилогдсон алба хаагч, түүний гэр бүлийн гишүүдэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж болно.
	<b>95 дугаар зүйл. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих</b>	95.1.Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга зөвхөн хуульд тусгайлан эрх олгосон асуудлаар цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавина.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

### ЦЭРГИЙН АЛБАНЫ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Цэргийн албаны тухай	<b>12 дугаар зүйл. Хугацаат цэргийн албанд татах</b>	12.2.Монгол Улсын иргэн 18-25 насны эрэгтэйчүүдийг хугацаат цэргийн албанд татна. 12.3.Хугацаат цэргийн албанд татагдах иргэнд цэргийн жинхэнэ албанд татах тухай цэргийн зарлан дуудах мэдэгдэл хүргүүлнэ. 12.4.Хугацаат цэргийн албанд татагдах иргэний цэрэг татлагын байранд ирсэн байх өдөр, цагийг аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар батална.
	<b>13 дугаар зүйл. Цэрэг татлагын товчоо</b>	13.1.Цэргийн албаны ээлжит татлагыг эрхлэн явуулах цэрэг татлагын товчоог дарга, орлогч, нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулах бөгөөд цэрэг татлагын товчооны бүрэлдэхүүнд төрийн захиргааны байгууллагын зохих албан тушаалтан болон шаардлагатай мэргэжлийн байгууллагын ажилтныг томилон ажиллуулна. 13.5.Товчооны шийдвэрийн талаархи гомдол, маргааныг аймаг, нийслэлийн Засаг дарга шийдвэрлэнэ. 13.6.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга цэрэг татлага явуулахад шаардлагатай байр, тээврийн хэрэгслээр хангаж, дэмжлэг үзүүлэх албан тушаалтныг томилж ажиллуулах үүрэгтэй.
	<b>31 дүгээр зүйл. Дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах</b>	31.2.Иргэн цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр оруулан хаах, төлбөрөөс чөлөөлөх шийдвэрийг цэргийн штабын саналыг үндэслэн аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Засаг дарга гаргана.
	<b>33 дугаар зүйл. Цэргийн бэлтгэл албаны сургалт</b>	33.8.Цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэнд цэргийн анхан шатны бэлтгэл олгох сургалтыг аймаг, нийслэлийн Засаг дарга зохион байгуулна.
	<b>34 дүгээр зүйл. Цэргийн бүртгэл</b>	34.1.Цэргийн бүртгэлийг аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Засаг даргын Тамгын газар зохион байгуулна.

---o0o---





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

### ШУУДАНГИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Шуудангийн тухай	<b>8 дугаар зүйл. Бүх шатны Засаг даргын эрх хэмжээ</b>	8.1. Шуудангийн талаар бүх шатны Засаг дарга дараахь эрх хэмжээтэй байна: 8.1.1. хүн амд шуудан, хэвлэл хүргэх ажлыг зохион байгуулах, цаг үеийн болон байнгын саад бэрхшээл бүхий газарт байрладаг үйлчлүүлэгчид шуудангийн илгээмж хүргэхэд үйлчлэгчид дэмжлэг үзүүлэх; 8.1.2. хууль тогтоомжид заасан бусад эрх хэмжээ.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

### ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай	<b>128 дугаар зүйл.</b>	128.1.Бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газар нь доод шатны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд захиргааны хэргийн талаархи шүүхийн шийдвэрийн биелэлтэд хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийн хүрээнд хяналт тавьж, харилцан хамтран ажиллана.
	<b>164 дүгээр зүйл. Нийтэд тустай ажил хийлгэх ял эдлэх хугацаа, түүнийг тооцох, ял эдэлж дуусах</b>	164.4.Ялтны гэр бүлийн гишүүн хүндээр өвчилсөн, нас барсан, гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон бол 7 хүртэл хоногийн чөлөө олгож болно. 164.5.Чөлөөг энэ хуулийн 164.4-т заасан нөхцөл байдал бий болсныг нотолсон сум, дүүргийн Засаг даргын, эмнэлгийн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн ял эдлүүлж байгаа шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн дарга шийдвэрлэнэ.
	<b>187 дугаар зүйл. Тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийн засрал хүмүүжлийн байдалд хяналт тавих</b>	187.1.Шийдвэр гүйцэтгэгч тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийн засрал хүмүүжлийн байдалд дараахь журмаар хяналт тавина: 187.1.3.тогтоолын биелэлтийг хойшлуулсан өсвөр насны хүнийг хараа хяналтдаа байлгаж, хүмүүжүүлэх үүрэг хүлээсэн этгээд болон сум, дүүргийн Засаг даргаас хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх харилцан мэдээлэл солилцоход дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах, тогтоолын биелэлтийг хойшлуулсан насанд хүрсэн этгээдийг зохих ажлын байраар хангахад туслалцаа үзүүлэх;
	<b>189 дүгээр зүйл.</b>	189.5.Сум, дүүргийн Засаг дарга үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд шүүхээс даалгасан үүрэг, хязгаарлалтыг биелүүлэх талаар зохих туслалцаа үзүүлнэ.
	<b>288 дугаар зүйл. баталгаа</b>	288.5.Аймаг, сумын Засаг дарга тухайн нутаг дэвсгэр дэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дарга, дэд даргыг албаны орон сууцаар хангах арга хэмжээ авна.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 12 сарын 23 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Шүүх шинжилгээний тухай	<b>78 дугаар зүйл. Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх</b>	78.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нь шинжилгээний байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нутаг дэвсгэр хариуцсан шинжилгээний байгууллага, алба хаагч, түүний гэр бүлийн гишүүдэд нийгэм, эдийн засгийн дэмжлэг үзүүлж болно.

---оОо---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

### ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай	<b>5 дугаар зүйл. Өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зохион байгуулалт</b>	5.3.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн байршил, үйлчлэх хүрээг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бодлого, төлөвлөлтийн хүрээнд тухайн аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын саналыг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.
	<b>15 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, түүнд тавих шаардлага</b>	15.23.Төрийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн олон нийтийг төлөөлөх гурван гишүүнийг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн өмчит нэгдсэн эмнэлгийн олон нийтийг төлөөлөх гурван гишүүнийг аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газар нээлттэй сонгон шалгаруулна.  15.30.Төрийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, орон нутгийн өмчит нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг аймаг, дүүргийн Засаг дарга шууд батламжилна.

---о0о---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 2 дугаар сарын 04-ний өдөр

Улаанбаатар хот

### ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Эрүүл ахуйн тухай	<b>4 дүгээр зүйл. Хүрээлэн байгаа орчинд тавих эрүүл ахуйн шаардлага</b>	<p>4.1.Хүн амыг ундны болон ахуйн дараахь нөхцөл, шаардлагыг хангасан усаар хангана:</p> <p>4.1.3.харьяалах нутаг дэвсгэрийнхээ хүн амыг энэ хуулийн 4.9-т заасан стандартыг хангасан ундны усаар тогтвортой, хүртээмжтэй хангах арга хэмжээг тухайн шатны Засаг дарга хэрэгжүүлэх;</p> <p>4.1.5.ус хангамж, ариун цэврийн байгууламжийн сүлжээнд эрсдэлийн үнэлгээг тогтмол хийлгэх, гарсан үнэлгээний дагуу арга хэмжээг авах үүргийг тухайн шатны Засаг дарга хүлээх.</p> <p>4.4.Хүн амын суурьшлын хөрс нь эрүүл ахуйн дараахь нөхцөл, шаардлагыг хангасан байна:</p> <p>4.4.3.иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн өмч, эзэмшил, ашиглалтад байгаа газар болон орчны 50 метр хүртэлх газрын хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах, ногоон байгууламжийн арчилгааг хийх;</p> <p>4.6.Энэ хуулийн 4.4.3-т заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг ногдох газартаа цэвэрлэгээ, арчилгаа хийж байгаа эсэхэд тухайн баг, хорооны Засаг дарга хяналт тавина.</p> <p>4.9.Хүн амын ундны ус, хүний амьдрах орчны агаар, хөрсний эрүүл ахуйн стандартыг эрүүл мэндийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран боловсруулж, стандартчиллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.</p>
	<b>11 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын эрх, үүрэг</b>	<p>11.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:</p> <p>11.1.1.эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх;</p> <p>11.1.2.хүн амын эрүүл, аюулгүй орчныг хангах талаар асуудал боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх;</p> <p>11.1.3.харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд усны эх үүсвэрийн онцгой, энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтэд хяналт тавих;</p>

		<p>11.1.4.төвлөрсөн бус ариун цэврийн байгууламжид тавих эрүүл ахуйн шаардлагыг хэрэгжүүлэх;</p> <p>11.1.5.хог хаягдлын цэг, ариун цэврийн байгууламж, оршуулгын газарт эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг хангах;</p> <p>11.1.6.нийтийн эзэмшлийн зам, талбайн цэвэрлэгээ, тохижилт, цэцэрлэгжүүлэлт, эзэмшлийн байдлыг хариуцах;</p> <p>11.1.7.нутаг дэвсгэрийн хэмжээнд эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих олон нийтийн хяналтыг сайжруулах, санал санаачилга өрнүүлэхэд дэмжлэг үзүүлэх;</p> <p>11.1.8.эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг татан оролцуулах;</p> <p>11.1.9.нутаг дэвсгэрийнхээ хүн амын эрүүл, аюулгүй орчныг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж батлуулах, зарцуулалтад хяналт тавих;</p> <p>11.1.10.хуульд заасан бусад бүрэн эрх.</p>
	<p><b>12 дугаар зүйл. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал, Засаг даргын эрх, үүрэг</b></p>	<p>12.1.Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал, Засаг дарга дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:</p> <p>12.1.1.эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг хангах ажилд нутаг дэвсгэрийн хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг татан оролцуулах;</p> <p>12.1.2.эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг сайжруулах сургалт, сурталчилгаанд аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг хамруулах ажлыг зохион байгуулах;</p> <p>12.1.3.нутаг дэвсгэрийн хэмжээнд эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд олон нийтийн тавих хяналт, санал санаачилгыг өрнүүлэхэд дэмжлэг үзүүлэх;</p> <p>12.1.4.нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтийн эзэмшлийн зам, талбайг хог, хаягдалгүй байлгах;</p> <p>12.1.5.хуульд заасан бусад бүрэн эрх.</p>
	<p><b>17 дугаар зүйл. Эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих</b></p>	<p>17.1.Эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг холбогдох хууль, хяналтын байгууллага, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон хууль тогтоомжоор эрх олгосон бусад байгууллага, албан тушаалтан эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ.</p>

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 5 дугаар сарын 5-ны өдөр

Улаанбаатар хот

### ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
<b>ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ</b>	<b>11 дүгээр зүйл. Бүх шатны Засаг даргын бүрэн эрх</b>	<p>11.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>11.1.1. эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;</p> <p>11.1.2. харьяалах нутаг дэвсгэртээ хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон хөтөлбөр, төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;</p> <p>11.1.3. эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн харьяалах нутаг дэвсгэрийнхээ эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, оновчтой байршуулах, материаллаг бааз, хүний болон санхүүгийн нөөцийг зохистой хуваарилах;</p> <p>11.1.4. байгалийн онц аюултай үзэгдэл болон олон улсын хөл хориот өвчин гарсан тохиолдолд шаардлагатай арга хэмжээг шуурхай авах;</p> <p>11.1.5. эрүүл мэндийг хамгаалах, дэмжих чиглэлээр идэвх, санаачилгатай ажиллаж байгаа хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, сурталчлах ажлыг зохион байгуулах;</p> <p>11.1.6. аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын даргыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн Төрийн албаны тухай хуулийн дагуу томилох, чөлөөлөх;</p> <p>11.1.7. харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтний</p>

		<p>нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>11.1.8.харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагад нэмэлт санхүүжилт олгох;</p> <p>11.1.9.тухайн шатны нэгдсэн эмнэлгээс бусад эрүүл мэндийн байгууллагын удирдлагыг томилох, чөлөөлөх асуудлаар эрүүл мэндийн газрын даргатай зөвшилцөх;</p> <p>11.2.Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>11.2.1.эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага, дээд шатны Засаг даргаас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;</p> <p>11.2.2.харьяалах нутаг дэвсгэрийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тэгш, хүртээмжтэй байдлыг хангах;</p> <p>11.2.3.эрүүл мэндийг хамгаалах, дэмжих чиглэлээр нийтийг хамарсан арга хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг татан оролцуулах ажлыг зохион байгуулах;</p> <p>11.2.4.харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагыг шаардлагатай боловсон хүчин, материаллаг бааз, санхүүгийн хувьд бэхжүүлэх;</p> <p>11.2.5.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</p> <p>11.3.Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн даргыг тухайн шатны Засаг дарга, аймгийн эрүүл мэндийн газрын даргатай зөвшилцөж томилж, чөлөөлнө.</p>
	<p><b>12 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын бүрэн эрх</b></p>	<p>12.2.Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нь тухайн шатны Засаг даргатай зөвшилцөж, харьяа нэгдсэн эмнэлгээс бусад эрүүл мэндийн байгууллагын даргыг хууль тогтоомжид заасны дагуу томилж, чөлөөлнө.</p>
	<p><b>19 дүгээр зүйл. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох</b></p>	<p>19.2.Улсын хэмжээнд тусламж, үйлчилгээ үзүүлэх болон гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эрүүл мэндийн бусад байгууллагад аймаг, нийслэлийн Засаг дарга тусгай зөвшөөрөл олгоно.</p>

---o0o---





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 2 дугаар сарын 1-ний өдөр

Улаанбаатар хот

### ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Эрчим хүчний тухай	<b>7 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх</b>	7.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга эрчим хүчний тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, нутаг дэвсгэрийнхээ эрчим хүчний хангамжийн талаархи бодлого боловсруулан холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.  7.3. Тухайн нутаг дэвсгэр дэх эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын зурваст баригдсан барилга, байгууламж, айл өрхийг нүүлгэн шилжүүлэх, мод, бут, сөөгийг зайлуулах, дээрх зөрчлийг гаргуулахгүй байх арга хэмжээ авна.
	<b>9 дүгээр зүйл. Зохицуулах хорооны бүрэн эрх</b>	9.1. Зохицуулах хороо нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:  9.1.12. аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, гишүүдийг аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлөх;
	<b>33 дугаар зүйл. Шугам сүлжээний хамгаалалтын зурвас</b>	33.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга шугам сүлжээг хамгаалах дүрмийн дагуу хамгаалалтын зурвасын хэмжээг баталгаажуулна.

---o0o---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

### ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ

Хуулийн нэр	Засаг даргын тус хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэг	
	Хуулийн зүйл	Хуулийн заалт
Эрчим хүч хэмнэлтийн тухай	<b>7 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх</b>	<p>7.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга эрчим хүч хэмнэлтийн тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх бүхий байгууллагын шийдвэр, төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангана.</p> <p>7.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга эрчим хүч хэмнэлтийн талаар орон нутгийн бодлогыг тодорхойлж холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.</p> <p>7.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга эрчим хүч хэмнэлтийн талаар хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд хүргүүлэх.</p>

---o0o---

## 1.2. ЗАСАГ ДАРГЫН ТЭРГҮҮЛДЭГ ЗӨВЛӨЛ, КОМИСС

Хуульд аймаг Засаг даргын тэргүүлэхээр, ахлахаар 10 зөвлөл, сумын Засаг дарга тэргүүлэхээр, ахлахаар 7 зөвлөл тус тус ажиллахаар заасан байна. Харин тэдгээр зөвлөл, комиссын дотоод зохион байгуулалт, эрхлэх үйл ажиллагаа, чиг үүргийг тухайн хуульд нь болон холбогдох эрх бүхий этгээдээс тогтоосон хэм хэмжээ (журам, дүрэм, дэг)-г мөрдлөг болгон ажиллахаар зохицуулжээ. Үүнд:

№	Нэгжийн нэр	Үндэслэл	Хуулийн зүйл, заалт
1.	Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл	Залуучуудын хөгжлийг дэмжих салбар дундын үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий орон нутагт залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг аймаг, сумын Засаг дарга тус тус тэргүүлнэ.	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21.1.1, 22.1, 22.2 дахь хэсэг
2.	Улсын хил хамгаалалтад туслах хүчний орон тооны бус зөвлөл	Зөвлөлийн дарга нь хилийн аймаг, сумын Засаг дарга түүний орлогч дарга нь хилийн цэргийн ангийн дарга, нарийн бичгийн дарга нь хилийн аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын дарга байна.	Монгол Улсын Хилийн тухай хуулийн 50.2 52.1, 52.2 дахь хэсэг
3.	Засаг даргын зөвлөл	Нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна.	Төсвийн тухай хуулийн 31.5, Сангийн сайдын 2021.04.20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 4.1, 5.2, 6.4 дэх заалт
4.	Терроризмтой тэмцэх орон тооны бус салбар зөвлөл	Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллага, холбогдох төрийн байгууллагын зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, мэдээлэл солилцох чиг үүрэг бүхий “Терроризмтой тэмцэх орон тооны бус салбар зөвлөл”-ийг аймгийн Засаг даргална.	Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 11.7, 12.2 дахь хэсэг
5.	Салбар зөвлөл	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар дундын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий орон тооны бус салбар зөвлөлийг аймгийн Засаг дарга тэргүүлнэ.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 41.1-41.4 дахь хэсэг

6.	Хүүхдийн төлөө зөвлөл	Хүүхдийн эрхийг хангах талаархи салбар дундын үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Хүүхдийн төлөө зөвлөлийг аймаг, сум Засаг дарга тус тус тэргүүлнэ.	Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16.1, 17.1.1 дахь заалт
7.	Хамтарсан баг	Хамтарсан баг нь өрхийн эмч, сум, хороо, сургуулийн, халамжийн, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэх бөгөөд хамтарсан багийг тухайн сумын Засаг дарга ахална.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20.1 дэх хэсэг
8.	Аймаг, сумын батлан хамгаалах товчоо	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга нь дайны байдлын үед тухайн нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг хэрэгжүүлэх үндсэн байгууллага болох аймгийн батлан хамгаалах газар, сумын батлан хамгаалах товчоог тэргүүлнэ.	Дайны байдлын тухай хуулийн 18.1 дахь хэсэг
9.	Орон нутгийн онцгой комисс	Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, шийдвэр гаргах, шуурхай зохион байгуулах, хяналт тавих эрх бүхий аймаг, сумын онцгой комиссыг тухайн шатны Засаг дарга байгуулна. Орон нутгийн онцгой комиссыг тухайн шатны Засаг дарга тэргүүлнэ.	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22.3, 23.3 дахь хэсэг
10.	Хөдөлмөрийн эрхлэлтийн аймгийн зөвлөл	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд нийгмийн түншлэгч талуудын оролцоог хангах, орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн бодлого, үйл ажиллагааг удирдан зохицуулах зөвшилцлийн байгууллага байна. Зөвлөлийн дарга нь аймгийн Засаг дарга байна.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23.1.10, Засгийн газрын 2020 оны 147-р тогтоол, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017.01.27-ны өдрийн 2 тогтоолоор батлагдсан "Аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм"-ийн 3.1 дэх заалт
11.	Бүсийн зөвлөл	Бүс нутгийн хөгжлийг дэмжих талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, бүсийн нийгэм, эдийн засгийн асуудлыг зохицуулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл байна. Зөвлөлийн даргын бүрэн эрхийг тухайн бүсэд багтах аймгийн Засаг дарга нараас үндэсний	Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 7.4 дэх хэсэг

	хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний томилсон аймгийн Засаг дарга хэрэгжүүлнэ.	
--	---	--

### 1.3. ЗАСАГ ДАРГА БАТЛАХ (ТОГТООХ)-ААР ХУУЛИАР ЭРХ ОЛГОСОН ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ЖАГСААЛТ

Засаг даргын эрх хэмжээг тогтоосон хуулиудад аймгийн Засаг дарга 19 хэм хэмжээний акт, сумын Засаг дарга 9 хэм хэмжээний акт батлах (тогтоох)-аар тус тус хуульчилсан байна.

Тиймээс Засаг дарга тус хэм хэмжээний акт батлагдсан эсэхэд нь эхлээд хяналт тавьж, батлагдаагүй тохиолдолд холбогдох чиг үүргийн байгууллагад нь тус актын төслийг боловсруулах, батлуулах үүрэг чиглэлийг өгч ажиллах нь зүйтэй. Түүнчлэн Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (66.2), Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж хүчин төгөлдөр үйлчлэлтэй болох мөн шаардлага тавигддаг. Энэ хэсэгт ямар хэм хэмжээний акт батлах ёстой талаар болон эрх зүйн үндэслэлийг тусгасан болно. Үүнд:

№	Захиргааны хэм хэмжээний актын нэр	Батлах (тогтоох) этгээд	Эрх зүйн үндэслэл
1.	Орон нутгийн чанартай авто замын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх, мэдээлэх журам батлах	Аймгийн Засаг дарга	Авто замын хуулийн 27.4 дэх хэсэг
2.	Орон нутгийн чанартай болон авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах үйл ажиллагааны журам батлах	Аймгийн Засаг дарга	Авто замын хуулийн 30.3 дэх хэсэг
3.	Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам батлах	Аймгийн Засаг дарга	Барилгын тухай хуулийн 35.1.5 дахь заалт
4.	Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журмыг батлах	Аймгийн Засаг дарга	Хог хаягдлын тухай хуулийн 9.3.2 дахь заалт
5.	Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журмыг батлах	Аймгийн Засаг дарга	Хог хаягдлын тухай хуулийн 9.3.12 дахь заалт
6.	Хот, суурингийн авто замын зурвас газрын өргөнийг тогтоох	Аймгийн Засаг дарга	Авто замын хуулийн 16.3 дахь хэсэг
7.	Орон нутгийн чанартай авто замын хяналт тавих зурвас газрын өргөнийг тогтоох	Аймгийн Засаг дарга	Авто замын хуулийн 16.4 дэх хэсэг
8.	Мөсөн замын тээвэрлэлтийг эхлэх, дуусах хугацаа, чиглэл, мөсний даацыг тухайн орон нутгийн ус цаг уур, орчны хяналт шинжилгээний байгууллага хамтран тогтоох	Аймгийн Засаг дарга	Авто тээврийн тухай хуулийн 7.1.6 дахь заалт

9.	Аймаг хооронд, орон нутаг, аймгийн төвийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чиглэлийг тогтоох, өөрчлөх шийдвэрийг гаргах	Аймгийн Засаг дарга	Авто тээврийн тухай хуулийн 8.4 дэх хэсэг
10.	Орон нутгийн тээвэрлэлтийн чиглэлд гамшиг, аюулт үзэгдэл болон аюул тохиолдсон нөхцөлд тээвэрлэлтийн ажлыг түр хугацаагаар зогсоох буюу хязгаарлах шийдвэрийг гаргах	Аймгийн Засаг дарга	Авто тээврийн тухай хуулийн 14.1.2 дахь заалт
11.	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг тогтоох	Аймгийн Засаг дарга	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 23.1 дахь хэсэг
12.	Гэмт хэрэг, зөрчил, гамшиг, ослын үед, эсхүл гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор орон нутгийн онцлогийг харгалзан согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг харьяа нутаг дэвсгэртээ хориглох шийдвэр гаргаж болно.	Аймгийн Засаг дарга	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22.2 дахь хэсэг
13.	Барилга байгууламжийн загвар зураг батлах	Аймгийн Засаг дарга	Барилгын тухай хуулийн 35.1.3 дахь заалт
14.	Нийтийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн явах чиглэл, зогсоолын байршлыг тогтоох, өөрчлөх	Аймаг, сумын Засаг дарга	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9.3.1 дахь заалт
15.	Замын хөдөлгөөний түгжрэл, саатлыг зохицуулах зорилгоор тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоосон захиргааны хэм хэмжээний акт гаргаж болно.	Аймгийн Засаг дарга	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9.5 дахь хэсэг
16.	Аймгийн Засаг дарга хот, суурин газарт орших түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын харагдах сүр барааг хадгалах зорилгоор түүний эргэн тойронд шинээр барих барилга байгууламжид өндрийн хязгаар тогтоох	Аймгийн Засаг дарга	Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16.1.9 дахь заалт
17.	Голомтын бүсийн хилийн зааг болон хорио цээрийн дэглэмийг тогтоох, цуцлах	Аймаг, сумын Засаг дарга	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17.2, 18.1 дэх хэсэг
18.	Орон нутгийн усан замын сүлжээнд усан замын тээврийн хэрэгслээр зорчигч, ачаа тээвэрлэх, аялах чиглэл, хөвөлтийн улирлын эхлэх, дуусах хугацаа, бүсийг усан замын тээврийн хэрэгслийн зориулалт, хүчин чадалд нийцүүлэн орон нутгийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага батлах	Аймаг, сумын Засаг дарга	Усан замын тээврийн тухай хуулийн 7.1.4 дахь заалт

19.	Нутаг дэвсгэртээ ургамлын хорио цээр тогтоох, цуцлах	Аймаг, сумын Засаг дарга	Ургамал хамгааллын тухай хуулийн 10.1.4 дахь заалт
20.	Дундын өмчлөлийн эд хөрөнгийн засварт орон нутгийн төсвөөс зээл олгох, хөрөнгө оруулалт хийх хэмжээг тогтоох	Аймаг, сумын Засаг дарга	Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 18.1.6 дахь заалт
21.	Голомтын бүсийн хилийн зааг болон хорио цээрийн дэглэмийг тогтоох, цуцлах	Аймаг, сумын Засаг дарга	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17.2, 18.1 дэх хэсэг
22.	Аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын цэг тогтоох	Сумын Засаг дарга	Байгаль орчныг хамгаалах тухай 2 дугаар зүйлийн 6 дахь заалт
23.	Нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдал, цас, мөсийг хариуцан цэвэрлэх 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газрын хилийн заагийг тогтоох	Сумын Засаг дарга	Хог хаягдлын тухай хуулийн 9.4.12 дахь заалт
24.	Мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн нутаг дэвсгэртээ хаягдал ус зайлуулах цэг тогтоох	Сумын Засаг дарга	Усны тухай хуулийн 13.1.4 дахь заалт
25.	Агаар хамгаалах зорилгоор нийтийн эзэмшлийн гудамж, талбайд тодорхой төрлийн тээврийн хэрэгсэл нэвтрэн орохыг хориглох буюу хязгаарлах шийдвэрийг гаргах	Сумын Засаг дарга	Агаарын тухай хуулийн 20.5 дахь хэсэг

---o0o---

#### 1.4. ЗАСАГ ДАРГА ТОМИЛОХ БОЛОН ХОЛБОГДОХ АЛБАН ТУШААЛТНААС ЗАСАГ ДАРГАТАЙ ЗӨВШИЛЦӨХӨӨР ЗААСАН АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ:

Хуулиар аймгийн Засаг дарга нийт 14 албан тушаалтныг, сумын Засаг дарга нийт 7 албан тушаалтныг тус тус томилохоор байна. Ингэхдээ зохих албан тушаалтнуудтай нь зөвшилцсөн байх шалгуур нөхцөлийг тогтоосныг анхаарах нь зүйтэй.

Харин эсрэгээрээ эрх бүхий этгээдээс нийт 10 албан тушаалтныг томилохдоо аймгийн Засаг даргатай зөвшилцсөн байхаар, 5 албан тушаалтныг сумын Засаг даргатай зөвшилцөх, санал авсан байх шаардлагыг заасан байна.

№	Албан тушаалын нэр	Үндэслэл	Хуулийн зүйл, заалт
1.	Аймгийн тээврийн албаны дарга	Аймгийн тээврийн албаны даргыг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж аймгийн Засаг дарга томилж, чөлөөлнө.	Авто тээврийн тухай хуулийн 7.2 дахь хэсэг
2.	Аймгийн архивын дарга	Аймгийн архивын даргыг тухайн шатны Засаг дарга архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр томилж, чөлөөлнө.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 19.3 дахь хэсэг
3.	Байгалийн нөөц ашигласны төлбөр хураах эрх бүхий албан тушаалтан	Сумын Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөр хураах эрх бүхий албан тушаалтныг томилон ажиллуулна.	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23.1 дэх хэсэг
4.	Аймгийн байгаль орчны албаны дарга	Тус албаны даргыг аймгийн Засаг дарга байгаль хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж томилох, чөлөөлөх	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 хэсгийн 6 дахь заалт
5.	Байгаль орчны хяналтын улсын байцаагч	Байгаль хамгаалагчийг сумын Засаг даргын саналыг харгалзан аймгийн байгаль орчны албаны дарга томилж, чөлөөлнө.	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 4 дэх заалт
6.	Аймгийн биеийн тамир, спортын газрын дарга	Тус газрын даргыг аймгийн Засаг дарга биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн томилж, чөлөөлөх.	Биеийн тамир, спортын тухай хуулийн 8.1.8 дахь заалт
7.	Аймгийн газрын албаны дарга	Тус албаны даргыг Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргатай зөвшилцөж аймгийн Засаг дарга, томилох, чөлөөлөх	Газрын тухай хуулийн 20.2.8 дахь заалт
8.	Сумын газрын даамал	Тухайн шатны Засаг даргын саналыг авсны үндсэн дээр сумын газрын даамал, дүүргийн газрын албаны даргыг томилох, чөлөөлнө.	Газрын тухай хуулийн 23.3.6 дахь заалт
9.	Олон нийтийн байцаагч	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн бус байгууллага болон багийн Засаг даргын саналыг үндэслэн сумын Засаг дарга	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 40 дүгээр зүйл



		харьяа нутаг дэвсгэртээ эргүүлийн үүрэг гүйцэтгэх олон нийтийн байцаагчийг томилон ажиллуулна.	
10.	Хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах төлөөлөгч	Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн болон хүүхдийн ашиг сонирхол хоорондоо зөрчилдөж байгаа нь тогтоогдсон бол сумын Засаг дарга хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах төлөөлөгчийг томилж болно.	Гэр бүлийн тухай хуулийн 25.4 дэх хэсэг
11.	Байцаагч	Тухайн орон нутгийн хэмжээнд мэдээлэл тараадаг мэдээлэх хэрэгслээр түгээсэн зар сурталчилгаанд аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний томилсон байцаагч хяналт тавих бөгөөд энэ хуулийн 24.4-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.	Зар сурталчилгааны тухай хуулийн 24.5 дахь хэсэг
12.	Аймгийн мал эмнэлгийн байгууллагын дарга	Тус байгууллагын даргыг аймгийн Засаг даргатай зөвшилцөн мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлнө.	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28.7.2 дахь заалт
13.	Мал эмнэлгийн тасгийн дарга	Тус тасгийн даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн аймгийн мал эмнэлгийн байгууллагын дарга томилж, чөлөөлнө.	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28.7.3 дахь заалт
14.	Сум дундын ойн ангийн дарга	Аймгийн Засаг дарга аймгийн байгаль орчны газрын харьяанд сум дундын ойн анги, байгуулж, бүтэц, орон тоог батлан, тэдгээрийн даргыг ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөн томилж, чөлөөлөх;	Ойн тухай хуулийн 17.2.8 дахь заалт
15.	Ойн ангийн дарга болон ойн асуудал эрхэлсэн албан тушаалтан	Сумын Засаг дарга ойн ангийн дарга болон ойн асуудал эрхэлсэн албан тушаалтныг томилох, чөлөөлөх	Ойн тухай хуулийн 18.2.9 дэх заалт
16.	Соёлын дурсгалт газрын гэрээт харуул	Сумын Засаг дарга Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 45.1-д заасны дагуу хамгаалалтын бүс тогтоосон түүх, соёлын дурсгалт газарт гэрээт харуул томилж ажиллуулна. Соёлын өвийн гэрээт харуулыг сумын Засаг дарга томилно.	Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 45.2, 58.5 дахь хэсэг
17.	Аймгийн соёлын газрын удирдлага	Тус газрын удирдлагыг аймгийн Засаг даргатай зөвшилцөн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.	Соёлын тухай хуулийн 18.2 дахь хэсэг
18.	Аймгийн соёлын байгууллагын удирдлага	Тус байгууллагын удирдлагыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлнө.	Соёлын тухай хуулийн 18.3 дахь хэсэг
19.	Сумын соёлын байгууллагын удирдлага	Сумын соёлын байгууллагын удирдлагыг аймгийн соёлын газрын удирдлагатай зөвшилцөн сумын Засаг дарга тус тус томилж, чөлөөлнө.	Соёлын тухай хуулийн 18.3 дахь хэсэг

20.	Аймгийн стандартчилал, техникийн зохицуулалтын байгууллагын дарга	Тус байгууллагын даргыг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулж аймгийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлнө.	Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 26.2 дахь хэсэг
21.	Аймгийн статистикийн газар, хэлтсийн дарга	Үндэсний статистикийн хорооны дарга аймгийн статистикийн газар, хэлтсийн даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлөх;	Статистикийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт
22.	Аймгийн татварын газар, хэлтсийн дарга	Аймгийн зэрэглэлтэй хотын татварын газар, хэлтсийн даргыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга тухайн шатны Засаг дарга, хотын Захирагчтай зөвшилцөн томилж, чөлөөлнө.	Татварын ерөнхий хуулийн 77.5 дахь хэсэг
23.	Татварын ажилтан	Сум, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны татварын ажилтныг тухайн аймаг, хотын татварын албаны дарга тухайн шатны Засаг дарга, хот, тосгоны Захирагчтай зөвшилцөн томилж, чөлөөлөх бөгөөд тухайн ажилтанд сахилгын шийтгэл оногдуулах эрхтэй байна.	Татварын ерөнхий хуулийн 77.8 дахь хэсэг
24.	Эрх баригч	Тухайн шатны Засаг дарга орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх баригчийг томилох	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалт
25.	Аймгийн Засаг даргын дэргэдэх худалдан авах ажиллагааны нэгжийн дарга	Аймгийн Засаг даргын дэргэдэх худалдан авах ажиллагааны нэгжийн даргыг тухайн аймгийн Засаг дарга Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргатай, зөвшилцөн томилж, чөлөөлнө.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 53.3 дахь хэсэг
26.	Ерөнхий нягтлан бодогч	Сумын төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн төсвийн ерөнхий нягтлан бодогчийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчтай, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн төсвийн ерөнхий нягтлан бодогчийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн нарийн бичгийн даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө.	Төсвийн тухай хуулийн 19.5 дахь хэсэг
27.	Дархан цаазат газар, байгалийн цогцолборт газарт хамгаалалтын захиргааны дарга	Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь зохих шатны Засаг даргатай зөвшилцөн тухайн дархан цаазат газар, байгалийн цогцолборт газарт хамгаалалтын захиргааны даргыг нь байгаль орчны	Тусгай хамгаалалттай газар нутгийн хуулийн 27 дугаар зүйлийн 10 дахь заалт

		мэргэжилтэй, тухайн салбарт 3-аас доошгүй жил ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасны дагуу сонгон шалгаруулж томилох;	
28.	Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний нэгжийн ажилтан	Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний нэгжийн албан хаагчийг тухайн шатны Засаг даргатай нь зөвшилцөн мэргэжлийн удирдлагаар хангах үүрэг бүхий байгууллагын дарга томилж, чөлөөлнө.	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 6.2 дахь хэсэг
29.	Аймгийн ус цаг уур, орчны шинжилгээний төв болон лаборатори, хүрээлэнгийн дарга, улсын сүлжээний нэгжийн ажилтан	Аймгийн ус цаг уур, орчны шинжилгээний төв болон лаборатори, хүрээлэнгийн даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, улсын сүлжээний нэгжийн албан хаагчийг Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж, тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн харьяалах төв, лаборатори, хүрээлэнгийн дарга томилж, чөлөөлнө.	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 6.2 дахь хэсэг
30.	Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын дарга	Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын даргыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29.3 дахь хэсэг
31.	Аймгийн ерөнхий архитектор	Аймгийн Засаг дарга нь аймгийн ерөнхий архитекторыг 4 жилийн хугацаагаар нээлттэй сонгон шалгаруулалт, нээлттэй сонсголын үндсэн дээр томилно.	Хот байгуулалтын тухай хуулийн 9.1.2 дахь заалт
32.	Ус хангамж, ариутгах татуургын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага	Аймаг, сумын Засаг дарга нь ус хангамж, ариутгах татуургын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад тухайн чиглэлээр мэргэшсэн хүнийг хот, суурины ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн томилж, чөлөөлнө.	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8.1.4 дэх заалт
33.	Асран хамгаалах, харгалзан дэмжих этгээд	Хохирогч хүүхдийн эцэг, эхийг олж тогтоогоогүй тохиолдолд түүнийг асран хамгаалах, харгалзан дэмжих этгээдийг тухайн сумын Засаг дарга томилно.	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2
34.	Аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан газар, хэлтсийн дарга	Тус газар, хэлтсийн даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18.4 хэсэг

		хангасан иргэнийг сонгон шалгаруулж томилж, чөлөөлнө.	
35.	Цагдаагийн байгууллагын дарга	Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын даргыг цагдаагийн төв байгууллагын дарга тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө.	Цагдаагийн албаны тухай хуулийн 7.2 дахь хэсэг
36.	Аймгийн эрүүл мэндийн газрын дарга	Аймгийн Засаг дарга аймгийн эрүүл мэндийн газрын даргыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн Төрийн албаны тухай хуулийн дагуу томилох, чөлөөлнө.	Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.6 дахь заалт
37.	Нэгдсэн эмнэлгээс бусад эрүүл мэндийн байгууллагын удирдлага	Аймгийн Засаг дарга тухайн шатны нэгдсэн эмнэлгээс бусад эрүүл мэндийн байгууллагын удирдлагыг томилох, чөлөөлөх асуудлаар эрүүл мэндийн газрын даргатай зөвшилцөх;	Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.9 дэх заалт
38.	Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн дарга	Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн даргыг тухайн шатны Засаг дарга, аймгийн эрүүл мэндийн газрын даргатай зөвшилцөж томилж, чөлөөлнө.	Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг
39.	Сумын эрүүлийн мэндийн байгууллагын дарга	Аймгийн эрүүл мэндийн газрын дарга нь тухайн шатны Засаг даргатай зөвшилцөж, харьяа нэгдсэн эмнэлгээс бусад эрүүл мэндийн байгууллагын даргыг хууль тогтоомжид заасны дагуу томилж, чөлөөлнө.	Эрүүл мэндийн тухай хуулийн 12.2 дахь хэсэг

---o0o---

## ХОЁРДУГААР ХЭСЭГ

### 2.1. ЗАСАГ ДАРГЫН ШИЙДВЭРИЙН МӨН ЧАНАР, ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран гуравдугаар зүйлийн 1, 2 дэх хэсэг, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66.1, 66.3, 77.1 дэх хэсэгт тус тус аймаг, сум, багийн Засаг дарга нь хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрт нийцүүлэн захирамж гаргах бөгөөд тус захирамж нь тус тусын нутаг дэвсгэртээ хүчин төгөлдөр дагаж мөрдөнө, түүнийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд заавал биелүүлнэ гэж хуульчилсан.

Тиймээс Засаг даргын үйл ажиллагааны хэлбэр болох шийдвэр (захирамж, албан бичиг) нь албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж, түүнд бүрнээ нийцэж байх ёстой юм. Энэхүү харилцаа дараах хууль тогтоомжоор зохицуулагдаж байна. Үүнд:

1. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;
2. Монгол хэлний тухай хууль;
3. Захиргааны ерөнхий хууль;
4. Цахим гарын үсгийн тухай хууль;
5. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль;
6. Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”;
7. Засгийн газрын 2021 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 226 дугаар тогтоолоор батлагдсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”;
8. Бусад.

Эдгээрээс дээрх 2 журмын зохицуулалтыг хэсэгчлэн авч танилцуулж байна. Үүнд:

Нэг. Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам” (цаашид “журам” гэх)-д заасны дагуу Засаг даргын шийдвэр нь баримтын бичгийн албан ёсны байдлыг хангахын тулд дараах шалгуур нөхцөлийг журамлаж өгсөн.

Засаг дарга, түүний тамгын газар дээрх журмын 2.1.2-д “Байгууллага бүр өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон албан хэрэг хөтлөлтийн журмыг энэ журамд нийцүүлэн баталж мөрдүүлнэ.” гэж заасны дагуу зохион байгуулалтын холбогдох арга хэмжээг авах боломжтой юм. Мөн тус журмын 2.1.3-д “Албан хэрэг хөтлөлтийг боловсронгуй болгох, арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангах, байгууллагын үйл ажиллагааг баримтжуулах ажлыг тухайн байгууллагын захиргааны асуудал хариуцсан нэгж (ажилтан) хариуцан гүйцэтгэнэ.” гэж заасан боловч Засаг дарга өөрийн гаргах шийдвэр албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцэж байгаа эсэхэд хяналт тавих үүрэг хүлээнэ. Үүнд:

Баримтын бичгийн зохион бүрдүүлэхэд тавигдах шаардлага болон бусад мэдэж байвал зохих асуудал	Журмын холбогдох заалт
1.1. Баримт бичигт тавигдах шаардлага (стандарт) :	

Бичвэрийн агуулга монгол хэлний өгүүлбэр зүй, найруулга, зөв бичих дүрэмд нийцсэн, энгийн, тодорхой, хоёрдмол утгагүй, аман ярианы болон нутгийн аялга хэлц, этгээд, бүдүүлэг үг хэрэглээгүй, санаагаа зөв илэрхийлсэн байх;	3.1.7.1.
Мэдээллийн эх сурвалж, хуулийн хүчинтэй байх шаардлагад нийцсэн байх;	3.1.7.2.
Байгууллагын нэр, албан тушаалын нэр, албан тушаалтны эцэг (эх)-ийн болон өөрийн нэрийг алдаагүй зөв бичих;	3.1.7.3.
Хөрөнгө, санхүүгийн болон бусад дүн тоон мэдээллийг дараахь байдлаар бичнэ: <ul style="list-style-type: none"> <li>▪ бичвэрийн дунд орох мөнгөн дүнг дугуй ( ) хаалт хэрэглэн тоо, үсгээр дараахь байдлаар бичнэ. Жишээ нь: 3,653,000 (гурван сая зургаан зуун тавин гурван мянга) гэх мэт;</li> <li>▪ бутархай тоог бүхэл тооноос тусгаарлаж цэг тэмдэг ашиглаж дараахь байдлаар бичнэ. Жишээ нь: 3,568.58 (гурван мянга таван зуун жаран найман бүхэл зууны тавин найм).</li> </ul>	3.1.7.4. (3.1.7.4.1-3.1.7.4.3)
Бичвэрийн дунд нэмэгдэх тайлбар, тодорхойлолт, нэмэлт үг өгүүлбэрийг дугуй ( ) хаалт дотор бичнэ.	3.1.7.5.
Бичвэрийн дунд нэг үеийг хоёр мөрөнд хувааж бичихгүй;	3.1.7.6.
Бичвэрийн дунд дараахь тохиолдолд том үсгээр бичнэ. <ul style="list-style-type: none"> <li>▪ оноосон нэрийн эхний үсгийг том үсгээр эхэлж бичнэ. Жишээ нь: Улаанбаатар хот, Хууль зүй, дотоод хэргийн яам, гэх мэт;</li> <li>▪ улс орны нэр болон олон улсын байгууллагын нэрийн үг бүрийн эхний үсгийг том үсгээр бичнэ. Жишээ нь: Оросын Холбооны Улс, Нэгдсэн Үндэстний Байгууллага гэх мэт;</li> <li>▪ байгууллагын болон зохион байгуулалтын бүтцийн нэгжийн нэрийг дараахь байдлаар бичнэ. Жишээ нь: Аймгийн Засаг даргын Тамгын газар, Архивын ерөнхий газрын Мэргэжил, арга зүйн удирдлагын газар гэх мэт;</li> </ul>	3.1.7.7. (3.1.7.7.1-3.1.7.7.4)
Баримт бичгийн бичвэрийн дунд орсон гарчиг, бүлэг, зүйл, хэсэг, заалт, дэд заалтын дугаарыг илэрхийлэх тооны ард цэг тавьж, эх бичвэрийг зай авахгүйгээр бичнэ. Жишээ нь: Нэг. Нийтлэг үндэслэл 1.1. Зөвлөмжийн зорилго нь ..... оршино. гэх мэт.	3.1.7.7.5.
Байгууллага нь үндсэн үйл ажиллагааны болон хүний нөөцийн чиглэлээр тус тусад нь тушаал, захирамж гаргана.	3.2.1
Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр буюу “А” дугаар олгох захирамжийн төрөл: <ul style="list-style-type: none"> <li><input checked="" type="checkbox"/> -орон тоо, бүтэц батлах;</li> <li><input checked="" type="checkbox"/> -байгууллагын нэр өөрчлөгдөх, байгууллага шинээр өөрчлөн зохион байгуулагдсантай холбоотой;</li> <li><input checked="" type="checkbox"/> -дүрэм, журам, заавар, бусад арга зүйн баримт бичиг батлах, хэм хэмжээ тогтоох, тэдгээрийг дагаж мөрдүүлэх;</li> <li><input checked="" type="checkbox"/> -салбарын болон байгууллагын үйл ажиллагааны нийтлэг асуудлыг зохицуулах, журамлах;</li> <li><input checked="" type="checkbox"/> -Комисс томилох, ажлын хэсэг байгуулах;</li> <li><input checked="" type="checkbox"/> -төсөл, хөтөлбөр батлах, хэрэгжүүлэх явц байдлыг сайжруулах;</li> <li><input checked="" type="checkbox"/> -албан тушаалын тодорхойлолт, ажил үүргийн хуваарь батлах;</li> <li><input checked="" type="checkbox"/> -хяналт шалгалт явуулах, дүн шинжилгээ хийх, тэдгээрийн мөрөөр авах арга хэмжээний тухай;</li> </ul>	3.2.1.1.

<ul style="list-style-type: none"> <li><input checked="" type="checkbox"/> -ажлын удирдамж, хуваарь, төлөвлөгөө батлах;</li> <li><input checked="" type="checkbox"/> -салбарын болон байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх үнэ, тариф батлах;</li> <li><input checked="" type="checkbox"/> -гадаад, дотоодод томилолтоор ажиллуулах;</li> <li><input checked="" type="checkbox"/> -тэмдэглэлт ой, түүхэн үйл явдлыг тэмдэглэн өнгөрүүлэх;</li> <li><input checked="" type="checkbox"/> -уралдаан, тэмцээн, аян зохион байгуулах;</li> <li><input checked="" type="checkbox"/> -төсвийн хөрөнгөөр гадаад, дотоодод сургах;</li> <li><input checked="" type="checkbox"/> -төрийн шагнал, салбарын дээд шагналаар шагнах;</li> <li><input checked="" type="checkbox"/> -байгууллагын үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой төсөв, зардал батлах, хөрөнгө зарцуулах зэрэг асуудалд холбогдох тушаал, захирамж хамаарна.</li> </ul>	
<p>Хүний нөөцийн чиглэлээр буюу “Б” дугаар олгох захирамжийн төрөл:</p> <ul style="list-style-type: none"> <li><input checked="" type="checkbox"/> -ажилд томилох, чөлөөлөх;</li> <li><input checked="" type="checkbox"/> -өөр ажилд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах;</li> <li><input checked="" type="checkbox"/> -гэрээгээр ажиллуулах;</li> <li><input checked="" type="checkbox"/> -мэргэшлийн зэрэг, дэв, цол, түүний нэмэгдэл олгох;</li> <li><input checked="" type="checkbox"/> -ажилтны ур чадварыг тогтоох, нэмэгдэл олгох;</li> <li><input checked="" type="checkbox"/> -ээлжийн амралтын хуваарь батлах, амралт олгох;</li> <li><input checked="" type="checkbox"/> -сахилгын шийтгэл ногдуулах;</li> <li><input checked="" type="checkbox"/> -төрийн шагнал, салбарын дээд шагналаас бусад шагналаар шагнах;</li> <li><input checked="" type="checkbox"/> -тэтгэмж олгох, туслалцаа үзүүлэх;</li> <li><input checked="" type="checkbox"/> -хувийн зардлаар сургалтад хамруулах;</li> <li><input checked="" type="checkbox"/> -цалинтай, цалингүй чөлөө олгох зэрэг асуудалд холбогдох тушаал, захирамж хамаарна.</li> </ul>	3.2.1.2
<p>Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол үндэслэл хэсэгт уг баримт бичгийг зохион бүрдүүлэх хууль зүйн үндэслэл, шалтгаан, зориулалт, зорилгыг тодорхой бичнэ.</p> <p>Жишээ 1: Архивын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалт, Архивын ерөнхий газрын даргын 2018 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А/97 дугаар тушаалаар баталсан “Архивын баримтад улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх журам”-ын 3.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь: гэх мэт;</p> <p>Жишээ 2: “Төрийн ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн Улсын үзлэг зохион байгуулах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 150 дугаар тогтоолыг үндэслэн ТУШААХ нь: гэх мэт.</p>	3.2.3.
<p>Захирамжлах хэсгийг зохион бүрдүүлэхэд дараахь шаардлагыг мөрдөнө:</p> <ul style="list-style-type: none"> <li><input checked="" type="checkbox"/> заалт бүр нь тодорхой хэм хэмжээ тогтоосон байх;</li> <li><input checked="" type="checkbox"/> заалт бүрийг араб тоогоор дугаарлах;</li> <li><input checked="" type="checkbox"/> авах арга хэмжээ, хариуцах эзэн, гүйцэтгэх хугацаа, биелэлтийг хариуцах болон хэрэгжилтэд хяналт тавих байгууллага, нэгжийн нэрийг тодорхой зааж, албан тушаалтны нэрийг ( ) хаалтад бичих;</li> <li><input checked="" type="checkbox"/> байгууллага, түүний бүтцийн нэгжийн болон албан тушаалтны албан тушаалын нэрийг товчлохгүй бүтэн бичих;</li> <li><input checked="" type="checkbox"/> агуулга нь учир зүйн дэс дараалалтай байх;</li> <li><input checked="" type="checkbox"/> хүний нөөцийн чиглэлээр гаргаж байгаа тушаал, захирамжийн эхний заалтад тухайн хүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэрийг бүтэн,</li> </ul>	3.2.4. (3.2.4.1-3.2.4.9)

<p>дараагийн заалтад эцэг (эх)-ийн нэрийн эхний үсэг, өөрийн нэрийг бичих;</p> <p><input checked="" type="checkbox"/> тухайн хүний эцэг (эх)-ийн нэрэнд харьяалахын тийн ялгалын нөхцөлийг залгаж бичих; Жишээ нь: Доржийн Оюун;</p> <p><input checked="" type="checkbox"/> захирамжлалын баримт бичгийн үндэслэл, захирамжлах хэсгийг 1-2 хуудсанд багтаан бичих;</p> <p><input checked="" type="checkbox"/> захирамжлах хэсгийн заалтуудыг үйл үгийн захиран тушаах хэлбэрээр бичих зэрэг болно.</p>	
<p>Тушаал, захирамжийг өөрчлөх, зарим заалтыг нь хүчингүй болгож байгаа бол захирамжлах хэсэгт энэ тухай дурдаж, хүчингүй болгож байгаа шийдвэр, түүний холбогдох заалтын дугаар, он, сар, өдрийг бичнэ.</p>	3.2.6.
<p>Захирамжлалын нэг баримт бичгээр тодорхой нэг асуудлыг шийдвэрлэнэ.</p>	3.2.9.
<p>Нэг удаагийн чиг үүрэг хэрэгжүүлэх зорилгоор ажлын хэсэг, комисс, зөвлөл байгуулах тохиолдолд тушаал, захирамжийн бичвэр хэсэгт дараахь байдлаар бичнэ.</p> <p>Жишээ нь:</p> <p>Ажлын хэсгийн ахлагч: Г.Наран (Мэргэжлийн удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)</p> <p>Гишүүд:</p> <p>Ц.Урантөгс (Санхүүгийн албаны мэргэжилтэн)</p> <p>Нарийн бичгийн дарга: Б.Ганзориг (Мэдээллийн технологийн хэлтсийн мэргэжилтэн)</p>	3.2.13.
<p>Байнгын үйл ажиллагаа бүхий ажлын хэсэг, комисс, зөвлөл байгуулах тохиолдолд томилогдох ажилтны албан тушаалын нэрийн дарааллаар, дараахь байдлаар бичнэ.</p> <p>Жишээ нь:</p> <p>Ажлын хэсгийн ахлагч:</p> <p>Мэргэжил, арга зүйн удирдлагын газрын дарга</p> <p>Гишүүд:</p> <p>Мэргэжил, арга зүйн удирдлагын газрын мэргэжилтэн</p> <p>Нарийн бичгийн дарга:</p> <p>Мэдээллийн технологийн хэлтсийн мэргэжилтэн</p>	3.2.14.
<p>Албан бичгийг 1-2 хуудсанд багтааж бичнэ. Тодорхой нотолгоо, үндэслэл, тайлбар, санал, дүгнэлт шаардсан асуудлаар харилцах бол баримт бичгийг тусад нь боловсруулж, албан бичгийн хавсралтаар дагалдуулан хүргүүлнэ.</p>	3.4.8.
<b>1.2. Мэдэж байвал зохих бусад асуудал.</b>	
<p>Ажлын хэсэг, комисс болон тусгайлан эрх олгогдсон албан тушаалтны дүгнэлт, шийдвэрийг акт хэлбэрээр зохион бүрдүүлнэ.</p>	3.6.1.
<p>Актад хэзээ, ямар шийдвэрээр, ямар бүрэлдэхүүнтэй комисс, зөвлөл байгуулагдсан болон түүний үүрэг, зорилт, явуулсан үзлэг шалгалт, хэрэгжүүлсэн арга хэмжээ, дүгнэлт, шийдвэрийн талаар тодорхой тусгаж, комисс, зөвлөлийн дарга, гишүүд гарын үсэг зурж, байгууллагын тэмдгээр баталгаажуулж, бүртгэл хөтөлнө.</p>	3.6.3.
<p>Тусгайлан эрх олгогдсон албан тушаалтны үйлдсэн актыг удирдлагад төслөөр урьдчилан танилцуулж зөвшөөрөл авсны дараа албан ёсоор хэвлэмэл хуудсанд буулгаж, гарын үсэг, тэмдгээр баталгаажуулж, бүртгэл хөтөлнө.</p>	3.6.4.



Хүчингүй болсон тамга, тэмдэг, баталгааны тэмдгийн дардсыг бүртгэлийн хамт архивт заавал шилжүүлсэн байна.	4.1.5.
Хоёр буюу түүнээс дээш байгууллага хамтран баталж буй захирамжлал, зохион байгуулалт, мэдээлэл-лавлагааны баримт бичигт хэвлэмэл хуудас хэрэглэхгүй.	4.2.10.
“Гарт нь” гэсэн бичгийн дугтуйг задлалгүй, бүртгэлийн тэмдэг дарж, гаднах хаягаар нь бүртгэн холбогдох ажилтанд шууд шилжүүлнэ.	5.4.7.
Бичиг хэрэгт бүртгэгдсэн баримт бичгийг өдөрт нь удирдлагад танилцуулна. Удирдлага баримт бичигтэй танилцаж, асуудлыг хариуцан болон хамтран шийдвэрлэх бүтцийн нэгж, албан тушаалтанд тодорхой хугацаатай үүрэг өгч, цохолт хийнэ. Цохолтод бүтцийн нэгж, албан тушаалтны нэр, өгч байгаа үүргийн тодорхой утга, гүйцэтгэх хугацаа зэргийг зааж гарын үсэг, он, сар, өдөр бичнэ.	5.5.3.
Албан хэрэг хөтлөлтийн программд бүртгэсэн баримт бичгийн бүртгэлийн нэгдсэн мэдээг сар тутам гарган удирдлагад танилцуулна.	5.6.5.
Баримт бичгийг шийдвэрлэх хугацаа - Хуульд өөрөөр заагаагүй бол баримт бичгээр тавигдсан асуудлын шийдвэрлэх хугацааг дараахь өдрөөс эхэлж тооцно: <input checked="" type="checkbox"/> цаасан болон цахим хэлбэрээр ирсэн баримт бичгийг бичиг хэрэгт бүртгэж, хүлээн авсан өдрөөс; <input checked="" type="checkbox"/> хариутай албан бичгийг удирдлага цохолт хийж, бүтцийн нэгж, ажилтанд шилжүүлсэн өдрөөс.	6.2.1 (6.2.1.2-6.2.1.3)
Баримт бичгээр тавигдсан асуудлыг дараахь хугацаанд шийдвэрлэнэ: <input checked="" type="checkbox"/> шийдвэрлэх ерөнхий хугацаагаар бол удирдлага цохолт хийсэн өдрөөс эхэлж тооцон ажлын 7 хоногт; <input checked="" type="checkbox"/> шуурхай шийдвэрлэж болох асуудлыг ажлын 1-3 хоногт; <input checked="" type="checkbox"/> шийдвэрлэх хугацааг баримт бичигт заасан бол дурдсан хугацаанд; <input checked="" type="checkbox"/> удирдлага танилцаад шийдвэрлэх хугацаа заасан бол дурдсан хугацаанд; <input checked="" type="checkbox"/> иргэдийн өргөдөл, гомдлын хариуг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд; <input checked="" type="checkbox"/> баримт бичгээр тавигдсан асуудлыг шийдвэрлэхэд нэмэлт судалгаа, тодруулга хийх, бусад байгууллагатай хамтран шийдвэрлэх шаардлагатай бол хуанлийн 30 хоногт тус тус шийдвэрлэнэ.	6.2.2. (6.2.2.1–6.2.2.6)
Баримт бичгийн шийдвэрлэх хугацааг зайлшгүй шалтгаанаар өөрчлөх буюу сунгах асуудлыг түүнд цохолт хийсэн албан тушаалтны зөвшөөрлөөр шийдвэрлэнэ. Энэ тухай шийдвэрлэх хугацаа дуусахаас 3 хоногийн өмнө ирүүлсэн байгууллагад мэдэгдэж, хуанлийн 30 хүртэл хоногоор сунгаж болно. Хугацаа сунгасан тухай бүртгэл-хяналтын картад тэмдэглүүлсэн байна.	6.2.3.
Албан бичгийн хариуг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас тогтоосон хугацаанд нь өгөөгүй бол нэгжийн даргын зөвшөөрснөөр хугацаа дуусахаас 1 хоногийн өмнө удирдлагад танилцуулан, хуульд заасан хугацаагаар сунгуулж, энэ тухай хариу өгөх байгууллагад мэдэгдэнэ.	6.2.4.

Хоёр. Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан "Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам" (цаашид "журам" гэх)-д

заасны дагуу Засаг дарга нь албан хөтлөлийн үйл ажиллагаандаа тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ. (Журмын 2.1.12, 2.2)

Дээрх журамд заасны дагуу Засаг даргын тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх хадгалахтай холбоотой дараах мэдээллийг хэсэгчлэн авч орууллаа. Үүнд:

Анхаарах асуудал	Журмын заалт
<b>2.1. Тамга тэмдэг хийлгэх, хэрэглэх</b>	
Байгууллагын албан ёсны баримт бичигт тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хувийн тэмдэг болон Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын 4.1-д заасан баталгааны тэмдгээс бусад тэмдэг хэрэглэх, гарын үсгийн дардас дарахыг хориглоно.	2.9
Засгийн газрын Хэрэг эрхлэх газар энэ журмын 2.1-д заасан төрийн байгууллага, албан тушаалтан болон нийтийн эрх зүйн этгээдэд тамга хийлгэх зөвшөөрөл олгоно.	3.9.
Тамга анх хийлгэх зөвшөөрөл авахад тухайн байгууллагыг байгуулсан шийдвэр, улсын бүртгэлийн гэрчилгээний гэрчилсэн хуулбарыг, тамга дахин хийлгэхэд зөвшөөрөл авахад ашиглалтын шаардлага хангахгүй болсон бол тухайн тамганы дардас, нотлох баримтыг, тамга гээгдсэн, алдагдсан тохиолдолд хуулийн этгээдийн эрх бүхий этгээдийн шийдвэр, өдөр тутмын сонинд зарлуулсан зар, цагдаагийн байгууллагад бүртгүүлсэн тухай тодорхойлолт, хяналтын дугаарыг хүчингүйд тооцсон тухай хяналтын улсын байцаагчийн дүгнэлт, оногдуулсан торгох шийтгэлийн хуудас (төлбөрийн баримт)-ын хуулбарыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт албан бичгээр хүргүүлнэ.	3.10.
Анхан болон дунд шатны төрийн байгууллага, албан тушаалтан, нийтийн эрх зүйн этгээд тамга хийлгэхэд 3.10-т заасан баримт, материалыг бүрдүүлсний үндсэн дээр Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын 2.1.4-т заасны дагуу хүсэлтээ дээд шатны байгууллага, албан тушаалтнаар уламжлуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	3.11.
Улсын бүртгэлийн байгууллага тэмдэг хийлгэх зөвшөөрөл болон тамга, тэмдгийн хяналтын дугаар олгож, бүртгэл хөтөлнө.	3.12.
Тамга, тэмдэг захиалах, хийлгэх, олгох, хураан авах, хүлээлцэх, хяналтын дугаарыг нь хүчингүй болгуулах, улсын бүртгэлийн байгууллагад хураалгах асуудлыг тухайн байгууллагын удирдлага эсхүл захиргааны асуудал хариуцсан нэгжийн дарга хариуцна.	3.15.
Бүх шатны Засаг даргын тамгыг Засаг дарга, түүний орлогчийн <b>гарын үсэг зурсан баримт бичигт</b> дарна.	4.9.
Төрийн архивын тамгыг <b>архивын даргын гарын үсэг зурсан баримт бичигт</b> дарна.	4.10.
Тусгайлан заагаагүй бол албан бичгийн гадаад улсад явуулах хувь дээр тамга, тэмдэг <b>дарахгүй</b> .	4.11.
Санхүүгийн баталгааны тэмдгийг <b>зөвхөн</b> санхүү, нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг баталгаажуулахад хэрэглэнэ.	4.14.
<b>2.2. Хэвлэмэл Тамга тэмдэг хийлгэх, хэрэглэх</b>	

Аймгийн төрийн архивт баримтаа шилжүүлдэг байгууллагуудын хэвлэмэл хуудасны эх загварыг аймаг, нийслэлд ажиллаж буй архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагч хянаж, баталгаажуулан, хэвлүүлэх зөвшөөрлийг олгоно.	5.11.
Энэ журмын 5.14-т зааснаас бусад байгууллага, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага нь хэвлэмэл хуудсаа архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хэвлүүлж болно.	5.16.
<b>2.3. Хадгалалт, хамгаалалт, хяналт</b>	
Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудсыг ажлын байранд цоожтой шүүгээ, сейфэнд хадгална.	6.1.
Тамга, тэмдгийг тамгын газрын дарга болон тухайн байгууллагын захиргааны асуудал хариуцсан нэгжийн дарга түших бөгөөд эрх бүхий албан тушаалтан шийдвэр гаргаж баталгаажуулна.	6.6.
Байгууллагын удирдлага өөрчлөгдөх болон тамга, тэмдэг түших албан тушаалтан солигдох, чөлөө авах, ээлжийн амралт авах, томилолтоор ажиллах, суралцах, эрүүл мэндийн шалтгааны улмаас эзэнгүй байх хугацаанд албан үүргийг түр орлон гүйцэтгэгч акт, бүртгэлээр тамга, тэмдгийг хамт хүлээлцэнэ.	6.8.
Тамга, тэмдэг алдагдвал цагдаагийн байгууллагад нэн даруй бүртгүүлж, дээд шатны байгууллага болон улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэж, тус тамга, тэмдгийн хяналтын дугаарыг хүчингүй болгосныг 3 хоногт багтаан хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлуулна.	6.12.
Алдагдсан, гээгдсэн тамга, тэмдэг олдвол тэдгээрийг хэрэглэхгүй бөгөөд цагдаагийн байгууллагад бүртгүүлж, улсын бүртгэлийн байгууллагад хүлээлгэн өгч, хэрэв төрийн байгууллага, албан тушаалтны тамга олдсон бол энэ тухай Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт мэдэгдэнэ.	6.14.
Хяналтын дугаарыг нь хүчингүй болгосон, гэмтэлтэй буюу анхны загвараас дардас нь зөрүүтэй тамга, тэмдэг, баталгааны тэмдгийг ашиглахыг хориглоно.	6.16.
Байгууллагын нэр өөрчлөгдөх, татан буугдах тохиолдолд үлдэгдэл хэвлэмэл хуудсыг тусгайлан томилогдсон ажлын хэсэг (ажилтан) хүчингүй болгож, акт үйлдсэний дараа устгана.	6.19.

---o0o---

## 2.2. ЗАХИРАМЖИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХАД АНХААРАХ АСУУДАЛ, ЗӨВЛӨМЖ, ЗАХИРАМЖИЙН ТӨСЛИЙН ЗАГВАР

Засаг даргын захирамжийн төслийг боловсруулахтай холбогдуулан дараах зөвлөмжийг хүргэж байна. Үүнд:

- ☑ Захирамжийн төслийг боловсруулахдаа захирамжаар тухайн зохицуулах асуудал нь аль хуулиар зохицуулж байгаа харилцаанд хамаарах бэ гэдгийг эхлээд судална. Үүний дараа тухайн хуульд заасан Засаг даргын бүрэн эрх, чиг үүрэгт хамаарах холбогдох зүйл, заалтыг үндэслэл болгох нь зүйтэй. Ингэснээр Засаг даргын шийдвэр нь “хууль дээдлэх”, “хуульд үндэслэх”, “шийдвэр нь үндэслэл бүхий байх” зэрэг хуулийн шаардлагад нийцэх юм. Тиймээс Засаг даргын эрх хэмжээтэй холбоотой энэхүү гарын авлагын хуулийн лавлагааг өдөр тутамдаа ашиглаж, хэвших;
- ☑ Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 19 дүгээр тогтоолоор “Төрийн өндөр албаны тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэл”-ийг баталсан бөгөөд Засаг дарга нь ТӨ-VA ангилал хамаарах зэрэг зиндааны албан тушаалтан тул захирамжийн үндэслэх хэсэгт Засаг даргаас томилогддог эсхүл ангилал зэрэглэл доогуур албан тушаалтны албан тоотыг үндэслэхгүй байх, “хүндэтгэсэн, ...” гэсэн нэр томъёог ашиглахдаа албан тушаалын зэрэг зиндааг анхаарах;
- ☑ Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг заасан тус хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтныг томилохдоо Авлигатай тэмцэх газарт заавал “хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг”-ийг хянуулж, дүгнэлт гарсны дараа томилгоо хийх;
- ☑ Захирамж болгонд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66.1-д “Засаг дарга энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өөрийн эрх хэмжээний хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн захирамж гаргана.” гэсэн зүйл, заалтыг “ҮНДЭСЛЭХ” хэсэгт заавал оруулдаг байх;
- ☑ Захирамжийн “ҮНДЭСЛЭХ” хэсэгт хуулийн зүйл, заалтыг бичихдээ Компанийн тухай хуулийн 9.1.3 дахь заалт, Төрийн аудитын тухай хуулийн 11.2 дахь хэсэг, 6.2.1 дэх заалт гэж бичихийг анхаарах;
- ☑ Захирамжийн төслийн хууль зүйн үндэслэлийг нь хууль, эрх зүйн ажилтнаар хянуулсны дараа албажуулж байх;
- ☑ Захирамжийн төслийг боловсруулахдаа болон хэвлэмэл хуудсанд буулгахдаа алдаа шалгагч [Монгол хэлний дүрмийн алдаа шалгагч \(spellcheck.gov.mn\)](http://spellcheck.gov.mn) ашиглаж, хэвшүүлэх;
- ☑ Захирамжийн төсөл боловсруулах, хянах, шийдвэрлэх процессын шат шатны хяналт, гүйцэтгэлийг сайжруулахын тулд “захирамжийн төслийн хяналтын хуудас” (загвар №4)-ыг үйл ажиллагаанд хэрэглэх. Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 3.2.10 дахь заалтыг анхаарах;
- ☑ Захирамж болгонд тухайн захирамжийн үндэслэлд дурдсан хуулийн зүйл, заалт нь ямар утга, агуулгатай зүйл, заалт болохыг мэдэж байхын тулд “захирамжийн төслийн хуулийн лавлагааны хуудас” (загвар №5)-ыг захирамжийн төсөл бүрд хийж хэвшүүлэх, ингэснээр хуулиар олгогдсон бүрэн эрх, чиг үүргийн хүрээнд тус шийдвэр гарч байгаа эсэхийг хянах боломж бүрдэхийн зэрэгцээ тус хуулийн талаар мэдээлэл сайжирна.

Засаг даргаас нийтлэг гаргадаг захирамжийн төслийг жишээ хэлбэрээр боловсруулан дараах хэсэгт оруулж өглөө. Тус төслүүдээс санаа авч, цаашид захирамжийн төслийг боловсруулах үг, өгүүлбэр, цэг, таслал, бүтэц, найруулга нь албаны ёсны талаасаа хэрхэн зохицуулалттай байдгийг шимтэн судлахын зэрэгцээ үйл ажиллагаанд хэрэгжүүлж, мөрдлөг болгон ажиллахыг **ЗӨВЛӨЖ** байна.



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААН-УУЛ<sup>2</sup> СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны \_\_\_ сарын \_\_\_ өдөр

Дугаар \_\_\_\_\_

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам”-ын 2.1.1, 4.1, 5.2 дахь хэсэг, сумын Онцгой комиссын ..... хуралдааны шийдвэр, Засаг даргын зөвлөлийн хурлын 2023 оны .... дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар (Ковид-19)<sup>3</sup>-ын дотоодын тохиолдол нэмэгдэж гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан халдвар хамгааллын дэглэм сахиулах үйл ажиллагаанд зарцуулагдах 798,000 (Долоон зуун ерэн найман мянган)<sup>4</sup> төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх 798,000 (Долоон зуун ерэн найман мянган) төгрөгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Батсүх)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Орлогч (Б.Болд)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.МӨНХБАТ

<sup>2</sup> Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 3.1.7.7.4-д “хоёр үгнээс бүтсэн оноосон нэрийн хоёр дахь үг эгшгээр эхэлсэн байвал хооронд нь зураас татаж хоёр дахь үгийг том үсгээр эхэлж бичнэ. Жишээ нь: Баян-Өлгий, Буян-Өлзий, Баруун-Урт гэх” гэж заасан.

<sup>3</sup> Мөн дээрх журмын 3.1.7.5-д “бичвэрийн дунд нэмэгдэх тайлбар, тодорхойлолт, нэмэлт үг өгүүлбэрийг дугуй ( ) хаалт дотор бичнэ.” гэж заасан.

<sup>4</sup> Мөн дээрх журмын 3.1.7.4.1-д “бичвэрийн дунд орох мөнгөн дүнг дугуй ( ) хаалт хэрэглэн тоо, үсгээр дараахь байдлаар бичнэ. Жишээ нь: 3,653,000 (гурван сая зургаан зуун тавин гурван мянга) гэх мэт” гэж заасан.

ЗАХИРАМЖИЙН ТӨСЛИЙН ХУУЛИЙН ЛАВЛАГААНЫ ХУУДАС

Хууль тогтоомжийн нэр	Хууль тогтоомжийн зүйл	Хууль тогтоомжийн заалт
Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль	59 дүгээр зүйл. Сумын Засаг даргын бүрэн эрх	59.1.1.хууль тогтоомж, Засгийн газар болон харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийг хэрэгжүүлэх;
	66 дугаар зүйл. Засаг даргын шийдвэр	66.1.Засаг дарга энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өөрийн эрх хэмжээний хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн захирамж гаргана.
Төсвийн тухай хууль	14 дүгээр зүйл. Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний бүрэн эрх	14.2.3.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;
	41 дүгээр зүйл. Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах	41.2.2.батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;
Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал	Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам	<p>2.1. Нөөц хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулна:</p> <p>2.1.1. хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин, хортон мэрэгчид тархах зэрэг байгалийн гамшигт үзэгдэл тохиолдсон, нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн осол гарсан үед түүний хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах, үр дагаврыг арилгах;</p> <p>4.1.Нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна.</p> <p>5.2. Тухайн шатны Засаг даргын Тамгын газрын санхүү, төрийн сангийн нэгж шийдвэрийн төсөл болон холбогдох тооцоог хянаж Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсний үндсэн дээр Засаг даргын захирамж гаргуулна.</p>

---o0o---



**МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны \_\_\_ сарын \_\_\_ өдөр

Дугаар \_\_\_\_\_

Мөрөн сум

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, 15 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нэр бүхий иргэний гаргасан өргөдөлд дурдсан мэдээллийг шалган, танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Л.Бат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд:

Ш.Батболд (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Ахлах мэргэжилтэн)

С.Болортуяа (Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, Дотоод аудитор)

Х.Чинзориг (Эрүүл мэндийн газрын Хуулийн зөвлөх)

Нарийн бичгийн дарга:

П.Нансалмаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)

2. Өргөдөлтэй холбоотой асуудлыг шалган, дүгнэлт гаргаж \_\_\_ оны \_\_\_ дугаар сарын \_\_\_-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсэг (Л.Бат)-т даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын дарга (Л.Бат)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ГАНБАТ



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны \_\_\_ сарын \_\_\_ өдөр

Дугаар \_\_\_\_\_

Мөрөн сум

М.Саранг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.2 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсэг, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, “Хүүхдийн Уран дөш зуслан” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрэм, “Хүүхдийн Уран дөш зуслан” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын Удирдах зөвлөлийн хурлын ...-ны өдрийн ... тогтоолыг үндэслэн тус тус ЗАХИРАМЖЛАХ<sup>5</sup> нь:

1. Авлигатай тэмцэх газрын 2023 оны \_\_\_ дугаар сарын \_\_\_-ны өдрийн \_\_\_ тоот дүгнэлтийг харгалзан “Хүүхдийн Уран дөш зуслан” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирлаар Мөнхөөгийн Саранг \_\_\_ оны \_\_\_ дугаар сарын \_\_\_-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. “Хүүхдийн Уран дөш зуслан” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирлын ажлыг хүлээлцэх комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын даргад:

С.Бат (Аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүд:

Ч.Болд (Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга, “Хүүхдийн Уран дөш зуслан” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын Удирдах зөвлөлийн дарга)

Л.Навчаа (“Хүүхдийн Уран дөш зуслан” ОНӨААТҮГ-ын Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга)

М.Батцэцэг (“Хүүхдийн Уран дөш зуслан” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын нягтлан бодогч)

<sup>5</sup> Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 3.2.2-т “Захирамжлалын баримт бичгийн бичвэр нь үндэслэл ба захирамжлах гэсэн 2 хэсгээс бүрдэнэ” гэж заасан.



Нарийн бичгийн даргад:

С.Од (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

3. “Хүүхдийн Уран дөш зуслан” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирлын ажил, эд хөрөнгийг холбогдох акт, журмын дагуу \_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор хүлээлцэхийг ажил хүлээлцэх комиссын дарга (С.Бат)-д даалгасугай.

4. Идэвх санаачилгатай, үр дүнтэй, бусдыгаа манлайлан хариуцлагатай ажиллаж, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу хөрөнгө орлогын мэдүүлгээ гаргаж, ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл байдалд мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж ажиллахыг “Хүүхдийн Уран дөш зуслан” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал (М.Саран)-д үүрэг болгосугай.

5. Шийдвэрийг албажуулснаас хойш ажлын 3 өдөрт багтаан мэдэгдэж, энэ талаар баримт бүрдүүлэн ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга (С.Бат)-д даалгасугай.

6. Энэхүү шийдвэрийг эс зөвшөөрвөл мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

7. Захирамжийн хэрэгжилтийг хангуулж, “Хүүхдийн Уран дөш зуслан” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээ, түүний гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (С.Дорж)-д үүрэг болгосугай<sup>6</sup>.

ДАРГА

П.БАЛДАН

---

<sup>6</sup> Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 3.2.4.3-т “авах арга хэмжээ, хариуцах эзэн, гүйцэтгэх хугацаа, биелэлтийг хариуцах болон хэрэгжилтэд хяналт тавих байгууллага, нэгжийн нэрийг тодорхой зааж, албан тушаалтны нэрийг ( ) хаалтад бичих;” гэж заасан байна.



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны \_\_\_ сарын \_\_\_ өдөр

Дугаар \_\_\_\_\_

Мөрөн сум

Д.Болдбаатарыг албан тушаалаас  
чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, 83.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсэг, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Ханх сумын Засаг дарга Д.Болдбаатарыг өөрийнх нь гаргасан хүсэлтийн дагуу 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөр тасалбар болгон албан тушаалаас нь чөлөөлсүгэй<sup>7</sup>.

2. Д.Болдбаатарын ажил хүлээлцэх комисс байгуулж, ажил хүлээлцэн дүнг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулахыг Ханх сумын Засаг даргын Тамгын газар (Т.Отгонцэцэг)-т даалгасугай.

3. Д.Болдбаатарын цалин, ээлжийн амралтын тооцоог холбогдох хууль тогтоомжийн дагуу тооцож олгохыг Ханх сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Болд -Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА

Т.БАЯСГАЛАН

<sup>7</sup> Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 3.2.4.9-д “Захирамжлах хэсгийн заалтуудыг үйл үгийн захиран тушаах хэлбэрээр бичнэ” гэж заасан байна.

## ГУРАВДУГААР ХЭСЭГ

### 3.1. ЗАХИРГААНЫ ХУВИЙН ХЭРЭГ БҮРДҮҮЛБЭР

Засаг даргын захирамж нь ихэнх тохиолдолд захиргааны акт<sup>8</sup> болохын хувьд захиргааны хувийн хэрэг үүсгэх шаардлага хуулиар тавигддаг.

Захиргааны ерөнхий хуулийн 29.1-д “Захиргааны байгууллагаас захиргааны шийдвэрийн хувийн хэргийг хөтлөх бөгөөд уг хувийн хэрэгт шийдвэр гаргах үйл ажиллагааны үндэслэл, үе шат, оролцогчийн санал, холбогдох баримт, сонсох ажиллагаа, уулзалт, хуралдааны тэмдэглэл, шийдэл, хүргүүлсэн, мэдэгдсэн баримт зэргийг бүрдүүлэн, архивт хадгална.” гэж заасан. Тодруулбал, захиргааны шийдвэр бүрт хувийн хэрэг үүсгэнэ. Хувийн хэрэгт шийдвэр гаргах хугацааг хэрхэн тогтоосон, сунгасан эсэх, [1] шийдвэр гаргах үндэслэл, нөхцөл байдлыг хэрхэн тогтоосон, [2] цуглуулсан нотлох баримт, [3] сонсох ажиллагаа хийсэн бол хүргүүлсэн мэдэгдэл, [4] тэмдэглэл, баримтжуулсан тэмдэглэл зэргийг хавсаргасан байх шаардлагатай.<sup>9</sup>

Эрх зүйн үр дагавар бүхий захирамжид хувийн хэргийг бүрдүүлэх нь тус захирамжийг гаргахтай холбоотой ажиллагаа буюу процессын хувьд зөрчилгүй байх юм. Тухайлбал, дараах процессыг хангасан байх үүргийг шийдвэр гаргаж байгаа этгээд хуулиар хүлээнэ. Үүнд:

✍ **Бодит нөхцөл байдлыг тогтоосон эсэх :**

Захиргааны ерөнхий хуулийн 24.1-д “Захиргааны байгууллага захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд хамаарах бодит нөхцөл байдлыг тогтооно.” 24.2-д “Энэ хуулийн 24.1-д заасан бодит нөхцөл байдлыг тогтооход ач холбогдол бүхий шаардлагатай ажиллагаа хийх, нотлох баримтыг цуглуулах, үнэлэх үүргийг захиргааны байгууллага хүлээнэ.” гэж заасан.

Өөрөөр хэлбэл тус захирамжийг гаргахдаа тухайн шийдвэрт хамааралтай үйл явдал, бодит байдлыг судлан тогтоох шаардлага гарна. Энэ нь Засаг даргын хуулиар хүлээсэн үүрэг юм. Бодит нөхцөл байдлыг тогтоосноор шийдвэр үндэслэлтэй, оновчтой болох, шийдвэр зөв гаргах ач холбогдолтой юм. Үүнтэй холбогдуулан Захиргааны ерөнхий хуулийн 24 зүйлийг судлах нь зүйтэй.

✍ **Шаардлагатай, хамаарал бүхий нотлох баримтыг цуглуулж, зөв үнэлж, дүгнэсэн эсэх :**

Захиргааны ерөнхий хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу захиргааны шийдвэр гаргах ажиллагааны нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай нотлох баримтыг захиргааны байгууллага дараах байдлаар цуглуулна: (ЗЕХ-ийн 25.1.1-25.1.7) Үүнд:

- ач холбогдол бүхий мэдээллийг цуглуулах;
- оролцогчийг сонсох, тайлбар гаргуулах;
- шинжээч оролцуулан дүгнэлт гаргуулах;
- гэрч, гуравдагч этгээдээс тайлбар гаргуулах;
- баримт бичиг болон хууль, бусад шийдвэртэй танилцах, хуулбарлах;
- шаардлагатай бол туршилт хийх;
- оролцогчийн хүсэлтээр зайлшгүй шаардлагатай нотлох баримтыг гаргуулан авах.

<sup>8</sup> Захиргааны ерөнхий хуулийн 37.1-д “Захиргааны акт гэж захиргааны байгууллагаас тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон амаар, бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг ойлгоно.”

<sup>9</sup> Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар (Судалгаа, хэрэглээний), 2017 он

Харин Захиргааны ерөнхий хуулийн 24.2-д заасны дагуу цуглуулсан нотлох баримтаа шийдвэр гаргахад ач холбогдолтой талаас үнэлэх үүргийг Засаг дарга хүлээнэ. Нотлох баримтыг үнэлэх гэдэг нь цуглуулсан баримтуудын утга агуулгыг судлан, харьцуулж бодит байдлыг зөв оновчтой тодорхойлон үнэлэлт, дүгнэлт гаргах үйл явц юм.<sup>10</sup>


*✍ Оролцогчийг сонгох, тус оролцогчтой сонсох ажиллагаа хийсэн эсэх:*

Энэхүү шаардлагыг хангасан байх шалгуурыг Захиргааны ерөнхий хуулийн 26, 27, 28 дугаар зүйлд тодорхой хуульчилсан. Нөгөө талаас Захиргааны ерөнхий хуулийн 27.7-д “Сонсох ажиллагааны үед гарсан саналыг захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд заавал тусгах үүрэг хүлээхгүй боловч тусгаагүй шалтгааныг тайлбарлах үүрэгтэй.” гэж заасан. Мөн хуулийн 28.1-д сонсох ажиллагаа хийхгүй байх тохиолдлыг тусгасан бөгөөд эдгээрээс бусад тохиолдолд заавал хийх ёстой. Үүнд:

- 28.1.1.нийтийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол;
- 28.1.2.гарцаагүй байдлын улмаас, эсхүл нийтийн ашиг сонирхлын үүднээс хойшлуулшгүй ажиллагаа явуулах шаардлагатай бол;
- 28.1.3.иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, гомдлыг ханган шийдвэрлэж байгаа тохиолдолд;
- 28.1.4.захиргааны шийдвэрийг техник хэрэгслийн тусламжтайгаар гаргаж байгаа бол;
- 28.1.5.захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж байгаа бол;
- 28.1.6.төрийн болон албаны нууцын тухай, байгууллагын нууцын тухай, хүний хувийн мэдээлэл хамгаалах хууль тогтоомжоор хамгаалагдсан бусдад дамжуулах боломжгүй мэдээлэлд хамаарах бол.

Нөгөө талаас дээрх хуулийн 28.2-д “Энэ хуулийн 28.1-д заасан сонсох ажиллагааг хийгээгүй шалтгаанаа захиргааны байгууллага нотлох үүрэгтэй.” гэж заасныг анхаарах нь зүйтэй.

Харин Засаг даргын шийдвэртэй холбоотой үр дагаврын асуудлыг дараах байдлаар хуульд зохицуулсан. Үүнд:

 **Төрийн албаны тухай хуулийн** 50.1-д “Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ.”, мөн хуулийн 50.2-д “Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана.” гэж тус тус заасан.

 **Захиргааны ерөнхий хуулийн** 101.1-д “Иргэний хуулийн 498.2-т заасны дагуу захиргааны байгууллагын гаргасан алдааны улмаас учруулсан хохирлыг төр хариуцна.” 101.2-д “Иргэн, хуулийн этгээд өөрт учирсан хохирлыг хохирол учруулсан захиргааны байгууллагаас нэхэмжилж, тухайн захиргааны байгууллагаас гаргуулна.”, 102.2-д “Хохирлын хэмжээний талаарх маргааныг захиргааны журмаар хамтатган нэхэмжлээгүй бол иргэний хэргийн шүүхээр хянан шийдвэрлэнэ.”, Мөн хуулийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ.”, 103.2-д “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна.”, 103.3-д “Энэ хуулийн 103.2-т заасан дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж байхгүй бол гэм

<sup>10</sup> Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар (Судалгаа, хэрэглээний), 2017 он 133-134 дэх талаас авав.

буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг төрийн аудитын байгууллага хариуцна.”

📖 **Иргэний хуулийн 498.2-д** “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ийн улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцан арилгана.”, 498.3-д “Хохирогч өөрөө санаатай буюу илтэд болгоомжгүй хандсан, эсхүл хууль тогтоомжид нийцсэн арга хэрэгслээр үүсч болох хохирлоос урьдчилан сэргийлэх оролдлого хийгээгүйгээс өөрт нь гэм хор учирсан бол энэ хуулийн 498.1, 498.2-т заасан байгууллагыг хариуцлагаас чөлөөлж болно.”, 498.5-д “Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй.” гэж тус тус заасан.

### **3.2. ЗАХИРГААНЫ ШИЙДВЭР ГАРГАХАД АШИГЛАГДАХ БАРИМТЫГ ХЭРЭГЛЭХ ШААРДЛАГА, ЗААВАР ЗӨВЛӨМЖ, ЗАГВАРУУД**

Захиргааны ерөнхий хуульд заасан “урьдчилан мэдэгдэх, оролцоог нь хангах” зарчмыг хангах, “оролцогчийн тайлбар, санал гаргах гаргах боломжийг олгох”, “захиргааны актыг мэдэгдсэн байх” зэрэг сонсох ажиллагаа болон мэдэгдэх ажиллагааны зөрчилгүй байх нь Засаг даргын шийдвэр хууль ёсны байх шаардлагад нийцэх юм.

**Сонсох ажиллагааны мэдэгдлийн талаар:** Захиргааны ерөнхий хуулийн 27.2-д заасны дагуу Засаг даргын эрх зүйн үр дагавар бүхий захирамжийг гаргахдаа урьдчилсан ажиллагаатай холбогдуулан эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдэд сонсох ажиллагааны мэдэгдлийг хүргүүлсэн байх шаардлага тавигддаг. Мөн цаашлаад хуулиар тус мэдэгдэлд тусгасан байх мэдээллийг хүртэл тухайлан зааж өгсөн. Гэвч практик төдийлөн хэрэгжүүлэхгүй байна. Тиймээс тус мэдэгдлийг үйлдсэн, мэдэгдсэн, гардуулсан буюу хүргүүлсэн гэдгийг баталгаажуулах баримтыг захиргааны байгууллага өөрөө бүрдүүлэх, үйлдэх нь чухал юм. Энэ нь шүүх, эрх бүхий байгууллагаас захирамжийн хууль ёсны байх шаардлагыг хянахад хамгаалалт, нотлох баримт болно.

**Сонсох ажиллагааны тэмдэглэлийн талаар:** Захиргааны ерөнхий хуулийн 27.4-д захиргааны шийдвэр гаргах урьдчилсан ажиллагаатай холбогдуулан сонсох ажиллагаа хийх арга, хэлбэрийг хуульчилж өгсөн. Уг арга, хэлбэрээр ажиллагааг хийсэн эсэхийг батлах, нотлохын тулд заавал тэмдэглэл хөтөлсөн байх шаардлагыг хуулиар хүлээлгэсэн. Тодруулбал, тус хуулийн 27.6-д “Сонсох ажиллагааны явц, үр дүнгийн талаар тэмдэглэл хөтөлж, гарсан саналыг захиргааны шийдвэрт хэрхэн тусгасан талаар мэдээлэл бэлтгэж баримтжуулна.” гэж заасан. Тиймээс сонсох ажиллагааны тэмдэглэл үйлдэж, баталгаажуулж, баримтжуулах нь шийдвэр гаргах ажиллагааг шүүх, эрх бүхий байгууллагын өмнө нотлоход үр нөлөөтэй юм.

**Захиргааны актыг мэдэгдэх талаар:** Практикт Засаг дарга захирамж гаргасан эсэхийг мэдээгүй, мэдэгдээгүй гэх асуудал нэлээд гардаг. Захиргааны ерөнхий хуулийн 43.1-д “Захиргааны актыг хаяглагдсан этгээд болон эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд хуульд заасан журмын дагуу мэдэгдэнэ. Захиргааны актыг мэдэгдэх ажиллагааг түүнийг гаргасан захиргааны байгууллага хариуцна.” гэж заасан. Мөн хуулийн 43.2-д захиргааны шийдвэрийг гардуулах арга хэлбэрийг тухайлан хуульчилж өгсөн. Тиймээс мэдэгдсэн, хүргүүлсэн (гардуулсан) гэдгийг гагцхүү “баримтжуулсан” байх нь чухал юм.

**Хяналтын дагалдах хуудасны талаар:** Захиргааны ерөнхий хуулийн 29.2-д “Захиргааны шийдвэр бүрд хяналтын дагалдах хуудас хавсаргах бөгөөд дагалдах хуудсанд

захиргааны шийдвэр боловсруулахад оролцсон албан хаагч бүрийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, оролцоо, гүйцэтгэлийн тухай дэлгэрэнгүй тэмдэглэсэн байна. Дагалдах хуудсанд албан хаагчийн захиргааны шийдвэр боловсруулахад оролцсон оролцоо, гүйцэтгэлийг тэмдэглэсэн байна.” гэж заасны дагуу загварын төслийг боловсруулж орууллаа. Тус загвараас санаа авч, зарим шаардлагатай мэдээллийг тусгах, өөрчлөх нь нээлттэй юм.

**Хуулийн лавлагааны хуудасны талаар:** Захиргааны ерөнхий хуулийн 4.2.1, 4.2.5, 40.2.3-т заасан үндэслэлийн хүрээнд захирамжийн төсөл болгонд “захирамжийн төслийн хуулийн лавлагаа” хийж хяналт тавих нь зүйтэй бөгөөд тус загвараас санаа авч, зарим шаардлагатай мэдээллийг тусгах, өөрчлөх нь нээлттэй юм.

### **ЗӨВЛӨМЖ:**

- Сонсох ажиллагааны мэдэгдэл болон Засаг даргын захирамжийг мэдэгдэхдээ доорх холбогдох загваруудаас санаа авч, боловсруулан үйл ажиллагаандаа хэрэглэх. Мэдэгдлийг хүргүүлэхдээ хуульд заасан арга хэлбэрээр хүргүүлсэн (баталгаат шуудан, биечлэн хүргэх, утсаар гэх ) байх. Түүнийг хүлээлгэн өгсөн, мэдэгдсэн гэдгийг нотлох баримтыг зайлшгүй бүрдүүлсэн байх;
- Сонсох ажиллагааны үйл явцыг баримтжуулахдаа тэмдэглэл үйлдэх. Тус тэмдэглэл нь Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 3.3-д заасан шаардлагыг хангасан байх;
- Зарим тохиолдолд сонсох ажиллагааны үйл явдлыг дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн техник хэрэгслийн тусламжтайгаар баталгаажуулж авч болно. Ингэхдээ үүний талаар сонсох ажиллагаанд оролцогч этгээдэд заавал өмнө мэдэгдсэн байх;

### **БАРИМТЫН ЗАГВАРУУД:**

1. Сонсох ажиллагааны мэдэгдлийн загвар №1;
2. Сонсох ажиллагааны тэмдэглэлийн загвар №2
3. Захиргааны шийдвэрийг мэдэгдэх /гардуулах/ хуудасны загвар №3
4. Засаг даргын захирамжийн төслийн хяналтын дагалдах хуудасны загвар №4
5. Захирамжийн төслийн хуулийн лавлагааны загвар №5

## СОНСОХ АЖИЛЛАГААНЫ МЭДЭГДЛИЙН ЗАГВАР №1

Захиргааны ерөнхий хуулийн 26, 27 дугаар зүйлд заасан Сонсох ажиллагааг явуулахаар энэхүү мэдэгдлийг хүргүүлж байна.

1. Сонсох ажиллагаа явуулах он, сар, өдөр, цаг: .....

2. Сонсох ажиллагаа явуулах газар: .....

3. Сонсох ажиллагаа явуулах дараалал:

3.1. Захиргааны шийдвэр гаргах болсон нөхцөл байдлын талаар тайлбарлах;

3.2. Захиргааны шийдвэр гаргах эрх олгогдсон хууль, захиргааны хэм хэмжээний актын зүйл, заалтын талаар тайлбарлах;

3.3. Захиргааны шийдвэр гаргахад ач холбогдох бүхий нөхцөл байдлын талаар тайлбарлах, саналыг сонсох.

4. Захиргааны шийдвэр гаргах тухай асуудлын талаарх мэдээлэл, үндэслэл:

.....  
.....  
.....  
.....

Иймд ..... овогтой ..... Та энэ мэдэгдэлд дурдсан Сонсох ажиллагаанд өөрийн тайлбар, саналаа гарган, ирж оролцохыг мэдэгдэж байна.

МЭДЭГДЭЛ БИЧСЭН:

/...../: ..... /...../  
/албан тушаал/ /гарын үсэг/ /гарын үсгийн тайлал/

МЭДЭГДЭЛ ХҮЛЭЭН АВСАН:

Огноо: 20... оны ... дугаар сарын .... өдөр

/...../: ..... /...../  
/албан тушаал/ /гарын үсэг/ /гарын үсгийн тайлал/

## СОНСОХ АЖИЛЛАГААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ЗАГВАР №2

1. Сонсох ажиллагаа явуулсан арга хэлбэр:

- а. Сонсгол зохион байгуулах
- б. Саналыг бичгээр авах
- в. Биечлэн уулзах
- г. Утсаар санал авах
- д. Цахим хэлбэрээр санал авах
- е. Төлөөлөгчөөр дамжуулан авах
- ё. Бусад

2. Сонсох ажиллагаа явуулсан хугацаа: .....

3. Мэдэгдэл хүргүүлсэн эсэх: .....

4. Сонсох ажиллагааны оролцогчид, тэдгээрээс гаргасан санал, саналыг шийдвэрт тусгасан эсэх талаарх мэдээлэл:

.....  
.....

№	Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны оролцогч	Оролцогчоос гаргасан санал	Саналыг шийдвэрт хэрхэн тусгасан
1.			
2.			

Тэмдэглэл үйлдсэн:

Албан тушаал: .....

Эцэг/эх/-ийн нэр: ..... Өөрийн нэр: .....

Гарын үсэг:.....

Огноо: .....

Газар: .....



**ЗАХИРГААНЫ ШИЙДВЭРИЙГ МЭДЭГДЭХ  
/ГАРДУУЛАХ/ ХУУДАС №3**

Огноо: .....

Хөвсгөл аймгийн ..... сумын Засаг даргын ..... оны ..... дугаар сарын .....-ны өдрийн ..... дугаар захирамжийг мэдэгдэж, гардуулав.

Мэдэгдсэн хэлбэр /мэдэгдсэн хэлбэрийг бичих/.....

.....  
.....  
.....  
.....

ШИЙДВЭРИЙГ ГАРДУУЛЖ ӨГСӨН: ..... /...../  
*(гарын үсэг) (гарын үсгийн  
тайлал)*

ШИЙДВЭРИЙГ ГАРДАЖ АВСАН: ..... /...../  
*(гарын үсэг) (гарын үсгийн  
тайлал)*

Жич:

1. Захиргааны шийдвэрийг мэдэгдэх ажиллагааг Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу хэрэгжүүлнэ.
2. Захиргааны актыг утас, факс, баталгаат шуудан, цахим болон бусад хэлбэрээр мэдэгдсэн бол холбогдох нотлох баримтыг хавсаргах
3. Оролцогч захиргааны актыг гардан авахаас татгалзсан, хаяглагдсан этгээд өөрийн хаягтаа байхгүй, хаягийн өөрчлөлтийг мэдэгдээгүй, эсхүл зориуд санаатайгаар хүлээн авахаас зайлсхийсэн тохиолдолд тайлбар бичүүлж авах бөгөөд мэдэгдэх ажиллагааг Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлд тусгайлан заасны дагуу хэрэгжүүлнэ.

**АЙМГИЙН/СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖИЙН  
ХЯНАЛТЫН ДАГАЛДАХ ХУУДАС №4**

№

\_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_ өдөр

1. Төслийн нэр

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

2. Хууль, эрх зүйн хэлтсээс шийдвэрийн төслийг хянасан санал, дүгнэлтийн тухай утга \_\_\_\_\_

\_\_\_\_\_

3. Засаг даргаас санал, дүгнэлтийг хүлээн авсан тухай тэмдэглэл:

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

д/д	Шийдвэрийн төслийг боловсруулж, хянасан албан тушаалтан	Гарын үсэг, Огноо	Гаргасан саналыг шийдвэрийн төсөлд тусгасан эсэх
<b>БОЛОВСРУУЛСАН:<sup>11</sup></b>			
1.			
<b>ХЯНАСАН:<sup>12</sup></b>			
2			
<b>ТАНИЛЦСАН:</b>			
3.			

**ЗӨВШӨӨРСӨН:**

ЗАСАГ ДАРГА ..... /...../  
(гарын үсэг) (гарын үсгийн тайлал)

<sup>11</sup> Албан хэрэг хөтлөлтийн журмын 3.1.8.1. төсөл зохиох: баримт бичгийн төсөл, эх нооргийг тухайн асуудлыг хариуцсан ажилтан боловсруулж, холбогдох удирдлагад танилцуулна;

<sup>12</sup> Мөн журмын 3.1.8.2. төслийг хянах, зөвшөөрөх: албан тушаалтны боловсруулсан төслийн хууль тогтоомж, эрх зүйн актын шаардлага хангасан эсэхийг холбогдох удирдлага ажлын 1-2 өдөрт хянаж, зөвшөөрөл олгон, гарын үсэг зурж, он, сар, өдрийг бичнэ;

3.1.8.4. хянах, гарын үсэг зурах: удирдлага баримт бичгийг батлан гарын үсэг зурна;

3.2.10. Бүтцийн нэгжийн удирдлага хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад үед захирамжлалын баримт бичгийн төсөлтэй ажлын 1-2 хоногт багтаан танилцаж, зөвшөөрсөн тухай тэмдэглэлийг албан тушаалын дарааллаар хяналтын дагалдах хуудас дээр үйлдэнэ.

**Жич: Захирамжлалын баримт бичгийн төсөлд шаардлагатай тохиолдолд танилцуулга хийж хавсаргах бөгөөд түүнд тухайн асуудлаар гарсан өмнөх шийдвэрүүд, тэдгээрийн хэрэгжилт, тушаал, захирамж шинээр гаргах болсон шаардлага, эрх зүйн үндэслэл, агуулгын талаар товч тодорхойлж бичнэ. (Албан хэрэг хөтлөлтийн журмын 3.2.8)**

ЗАХИРАМЖ/ТУШААЛЫН ТӨСЛИЙН ХУУЛИЙН ЛАВЛАГААНЫ ЗАГВАР №5

Хууль тогтоомжийн нэр	Хууль тогтоомжийн зүйл	Хууль тогтоомжийн заалт
Жишээлбэл, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль	Жишээлбэл, 66 дугаар зүйл. Засаг даргын шийдвэр	Жишээлбэл, 66.1.Засаг дарга энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өөрийн эрх хэмжээний хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн захирамж гаргана.
-	-	-
-	-	-
-	-	-

---o0o---

## ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ

### 4.1. НИЙТЛЭГ АШИГЛАГДДАГ ГЭРЭЭНИЙ ЗАГВАРУУД

📖 Хөдөлмөрийн гэрээ

📖 Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ

📖 Ажил гүйцэтгэх гэрээ

📖 Хөлсөөр ажиллах гэрээ

## ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭ

Дугаар\_\_\_

.... оны .... дугаар сарын ... өдөр

..... аймаг/сум

Энэхүү Хөдөлмөрийн гэрээ (цаашид Гэрээ гэх)-г

Нэг талаас ..... хаягт байрлах, ..... улсын бүртгэлийн дугаартай, ..... (байгууллагын нэр) түүнийг ..... үндсэн дээр төлөөлөн ..... (Төлөөлсөн хүний албан тушаалын нэр) (цаашид “Ажил олгогч” гэх),

Нөгөө талаас ..... оршин суух, ..... регистрийн дугаартай ..... овогтой ..... (цаашид “ажилтан” гэх) нар (Хамтад нь Талууд гэх) Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам болон хөдөлмөрийн харилцааг зохицуулсан бусад хууль тогтоомж, эрх зүйн актуудыг үндэслэн хэлэлцэн тохирч, энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

### 1. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү гэрээгээр Ажил олгогч болон Ажилтны хооронд үүсэх хөдөлмөрийн харилцааг зохицуулна.
- 1.2. Энэхүү гэрээний хавсралтууд болох Ажилтны зүгээс гаргасан нууцын баталгаа болон хөдөлмөрийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ, гэрээний сунгалт зэрэг нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

### 2. Хөдөлмөрийн гэрээний хугацаа

- 2.1. Хөдөлмөрийн гэрээний эхлэх хугацаа:
- 2.2. Гэрээний хүчинтэй хугацаа:
- 2.3. Талууд гэрээний хугацаа дуусахаас өмнө гэрээг цуцлах талаар хэн нэгэндээ санал тавиагүй бол энэхүү гэрээний хугацааг нэг жилийн хугацаагаар сунгагдсанд тооцно. Энэхүү нэг жилийн хугацаанд гэрээг талуудын аль нэгний саналаар цуцлаагүй бол уг гэрээний хугацааг дахин нэг жилээр сунгасанд тооцно.

### 3. Үндсэн нөхцөл

#### 3.1. Гүйцэтгэх ажил үүрэг

- 3.1.1. Ажлын байр: \_\_\_\_\_
- 3.1.2. Ажилтны албан тушаал: \_\_\_\_\_
- 3.1.3. Ажилтны хариуцах ажил, үүрэг: Ажилтны эрхлэх ажил, албан тушаал дахь ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийг гүйцэтгэхээс гадна шууд болон шууд бус удирдлагаас өгсөн бусад үүрэг, даалгаврыг хийж гүйцэтгэнэ.
- 3.1.4. Хөдөлмөрийн нөхцөл: \_\_\_\_\_
- 3.1.5. Ажлын цаг:
  - i. Ажлын өдөр\_\_\_ гарагаас\_\_\_ гараг хүртэл\_\_\_ хоног байна.
  - ii. Хоногт ажлын\_\_\_ цагаар тооцон долоо хоногийн\_\_\_ цаг ажиллана.
  - iii. Ажил эхлэх цаг\_\_\_ цагт байна. Үдийн завсарлага\_\_\_ - \_\_\_ цагт байна.
  - iv. Ажилтны ажлын цагийн хуваарь нь удирдлагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр хүний нөөцийн бодлогын дагуу уян хатан байж болно.
  - v. Ажил тасралтгүй явагдах зарчмыг хангах зорилгоор Ажилтан хоцрох, эрт явах, ажил дээр байхгүй байх цагуудыг удирдлагад урьдчилан мэдэгдэнэ.

#### 3.2. Цалин

- 3.2.1. Ажилтны нэг сарын үндсэн цалин \_\_\_\_\_Т/ \_\_\_\_\_ / байна.
- 3.2.2. Ажилтны үндсэн цалингаас Нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг суутгана.
- 3.2.3. Ажил олгогч нь Ажилтны үндсэн цалинг сар бүрийн \_\_ба\_\_ -ны өдрүүдэд 2 (хоёр) хуваан олгоно.Хэрэв цалин олгох өдөр нь баярын болон амралтын өдөр таарвал өмнөх ажлын өдөр олгоно.
- 3.2.4. Илүү цагаар ажилласан болон бүх нийтийн амралтын бусад өдрөөр ажилласан тохиолдолд нөхөж амраана.

### **3.3. Амралт**

- 3.3.1. Амралтын өдөр, бүх нийтийн баярын өдрүүдээр Ажилтан амралт эдэлнэ.Ажлын шаардлага, нөхцөл байдлаас шалтгаалан ажилласан тохиолдолд нөхөж амраана.
- 3.3.2. Ажил олгогчийн баталсан ээлжийн амралтын журмын дагуу ээлжийн амралт олгоно.Ажилтан ээлжийн амралтыг биечлэн эдэлнэ.

## **4. Ажилтны эрх, үүрэг**

### **4.1. Ажилтан дараах эрхийг эдэлнэ.**

- 4.1.1. Ажилтан нь Ажил олгогчоос ажлын байранд эрүүл, аюулгүй ажиллах нөхцөлөөр хангуулах, ажил үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай өрөө тасалгаа, техник хэрэгсэл, бичиг хэргийн материал зэрэг зүйлсээр бүрэн хангуулах эрхтэй.
- 4.1.2. Ажилтан нь Ажили олгогчоос гүйцэтгэх ажлын талаар заавар удирдамжаар хангуулах эрхтэй.
- 4.1.3. Ажилтан ажлын байран дээр ажил үүрэгтэй холбоотой асуудал болон түүний шийдлийн тухай шууд удирдлагад чөлөөтэй илэрхийлж, хэлэлцэх эрхтэй.
- 4.1.4. Гэрээгээр тохиролцсон цалин хөлсийг цаг тухай бүрд авах, амрах, “Хөдөлмөрийн тухйа хууль”, түүнд нийцүүлэн гаргасан Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ээлжийн амралтаа эдлэх, тэтгэвэр, тэтгэмж болон туслалцаа дэмжлэг авах;

### **4.2. Ажилтан дараах үүргийг хүлээнэ.**

- 4.2.1. Хөдөлмөрийн дотоод журмыг чанд сахиж, өөрийн ажил үүрэгтэй холбогдсон бүх шаардлагыг бүрэн биелүүлж, боломжит өндөр бүтээмжээр ажиллах үүрэгтэй.
- 4.2.2. ....хоног бүрээр ажлын төлөвлөгөө гарган батлуулж, хуваарийн дагуу ажил үүргээ гүйцэтгэнэ.
- 4.2.3. Мэргэжил, ур чадвара байнга дээшлүүлэн идэвх санаачилгатай ажиллах үүрэгтэй.
- 4.2.4. Хамт олны уур амьсгалыг эерэг байлгаж, дэг журмыг хангахад анхаарч, ёс зүйн минимум стандарт, харилцааны соёлтойгоор ажиллах үүрэгтэй.
- 4.2.5. Эрс илэн далангүй байх, энэрэнгүй байх зарчмыг баримтлан ажиллах үүрэгтэй.
- 4.2.6. Ажилтан нь байгууллагын дотоод дэг журмыг сахих ёстой бөгөөд байгууллагын нэр хүндийг унагасан үйлдэл хийхийг хориглоно.

## **5. Ажил олгогчийн эрх, үүрэг**

### **5.1. Ажил олгогч дараах эрхийг эдэлнэ.**

- 5.1.1. Хууль тогтоомжил нийцүүлэн “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг боловсруулан баталж, мөрдүүлэх ба хөдөлмөрийн сахилгыг бэхжүүлэх, ажлын хариуцлагыг дээшлүүлэх, ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах талаар холбогдох арга хэмжээ авч, түүний биелэлтэд байнга хяналт тавьж ажиллах эрхтэй.

- 5.1.2. Ажилтнаас Хөдөлмөрийн гэрээ, Ажлын байрны тодорхойлолтод заасан үүргээ зохих ёсоор биелүүлэхийг шаардах эрхтэй.
- 5.1.3. Хөдөлмөрийн хуульд заасны дагуу болон энэхүү гэрээгээр харилцан тохиролцсоны дагуу Ажилтанд хариуцлага хүлээлгэх эрхтэй.
- 5.2. Ажил олгогч дараах үүргийг хүлээнэ.**
  - 5.2.1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нийтлэг журмыг баримтлан ажилтныг ажлын аятай нөхцөлөөр хангах, албан үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай өрөө тасалгаа, техник хэрэгсэл, бичиг хэргийн материал, ажил үүргийн онцлогт тохируулан аюулгүй ажиллагаа болон бусад зүйлээр бүрэн хангах үүрэгтэй.
  - 5.2.2. Хөдөлмөр, цалин хөлсний норм, нормативыг тогтоох журам, аргачлал боловсруулж, хөдөлмөрийн хөлсний хэмжээг анх тохирсноос доошлуулахгүй, нэмэгдүүлэх бодлого баримталж ажилтны хөдөлмөрийн үр дүнд тохирсон цалин хөлсийг цаг хугацаанд нь олгох үүрэгтэй.
  - 5.2.3. Хөдөлмөрийн харилцааны хүрээнд Ажилтанд хууль тогтоомжид заасан эрхээ эдлэх, нийгмийн баталгаагаар хангагдах нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.
  - 5.2.4. Ажилтныг хууль тогтоомжийн дагуу нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд заавал даатгуулж, хуульд заасан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэлийг холбогдох журмын дагуу төлөх үүрэгтэй.
  - 5.2.5. Ажилтанд эзэмшсэн боловсрол, мэргэжил, мэргэшлийн төвшин, ур чадвараа дээшлүүлэх хичээл, сургалт болон бусад арга хэмжээнд хамрагдах бололцоог гаргаж өгөхөд ямагт анхаарах үүрэгтэй.

## **6. Талуудын хариуцлага**

### **6.1. Ажил үүргийн зөрчил**

- 6.1.1. Ажил олгогч нь Хөдөлмөрийн дотоод журам, холбогдох бусад заавар, журам болон энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсхүл зохих ёсоор биелүүлээгүй ажилтанд гаргасан зөрчлийн шинж чанар, түүний давтамж, учирсан хохирол, хугацааг харгалзан “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн 131 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулна.

### **6.2. Эд хөрөнгийн хариуцлага**

- 6.2.1. Өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас байгууллагад хохирол учруулсан ажилтан, албан тушаалтанд бусад төрлийн шийтгэл (сахилгын, захиргааны, эрүүгийн гэх мэт) оногдуулсан эсэхийг үл харгалзан “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн 132, 133, 135 дугаар зүйлд заасан журмын дагуу эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ.

- 6.3. Ажилтан нь байгууллагын нууцыг задруулсан тохиолдолд Хөдөлмөрийн гэрээг цуцлахаас гадна түүнээс үүдсэн хохирлыг Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээж барагдуулна.

## **7. Гэрээ дуусгавар болох, цуцлах**

- 7.1. Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан үндэслэлээр энэхүү гэрээг дуусгавар болгоно.

### **7.2. Хөдөлмөрийн гэрээг дараах үндэслэлээр цуцална:**

- 7.2.1. Ажилтан дараах байдлаар гэрээг хугацаанаас өмнө цуцлах санал гаргана:

- 7.2.1.1. Энэхүү гэрээг ажилтны санаачилгаар цуцлахаар бол ажил олгогчид 30 хоногийн өмнө гэрээг цуцлах тухай мэдэгдлийг хүргүүлэх ба эс тэгвээс ажилтан нь ажил олгогчид нэг сарын цалинтай тэнцэх цалинг буцааж төлснөөр гэрээг цуцалсанд тооцно.

- 7.2.1.2. Ажилтан хүндэтгэн үзэх шалтгаантай ба ажлаас чөлөөлөх хугацааг талууд тохиролцсон бол 30 хоногоос өмнө гэрээг цуцалж болно.
- 7.2.2. Ажил олгогч дараах нөхцөлүүдийн аль нэг бүрдсэн үед гэрээг хугацаанаас өмнө цуцална:
- 7.2.2.1. Хөдөлмөрийн тухай хуулийн 40.1-д заасан үндэслэлүүдийн аль нэг бүрдсэн тохиолдолд,
- 7.2.2.2. Хөдөлмөрийн тухай хуулийн 40.1.4-т заасан ноцтой зөрчил гэдэгт дараахийг ойлгоно:
- а) Мөнгө болон эд хөрөнгө хариуцсан ажилтан ажил олгогчийн итгэлийг алдсан буруутай үйлдэл, эс үйлдэхүй гаргасан нь нотлогдсон.
- б) Хөдөлмөрийн сахилгын болон дотоод журамд заасан зөрчлийг давтан гаргасан.
- с) Ажилтан нь үйлчлэгч, харилцагч болон хамтран ажиллагсадтайгаа бүдүүлэг харьцсан бөгөөд Ажлын байранд ёс зүйн хэм хэмжээг үл сахиж, аливаа зохисгүй үйлдэл гаргасан.
- д) Албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглаж бусдад зээл, бэлэн мөнгө олгосон, үнэ төлбөргүй үйлчилсэн. Байгууллагын хөрөнгө, нэр хүндээр хувийн бизнес хийсэн.
- е) Байгууллагын үйл ажиллагааны стратеги, хөтөлбөр, удирдлагын шийдвэрийг хэрэгжүүлэхээс татгалзан, хамт олны дунд болон бусад байгууллагад худал мэдээ, мэдээлэл, байгууллагын нууцыг тараасан нь тогтоогдсон.
- ф) .....

## **8. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах**

- 8.1.** Энэ гэрээнд талууд харилцан тохиролцсоноор нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба энэ тохиолдолд нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, гэрээнд хавсаргана. Ийнхүү оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд нь энэхүү гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 8.2.** Талууд харилцан тохиролцож, зөвшилцсөний үндсэн дээр энэ гэрээний сунгалт /Хавсралт1/-ыг бичгээр үйлдэх бөгөөд талууд гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөрт тооцогдоно.

## **9. Давагдашгүй хүчин зүйл**

- 9.1.** Гэрээний аль нэг тал гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт, цар тахал болон байгалийн бусад аюулт үзэгдэл, бослого, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт/-ийн зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлыг ойлгоно

## **10. Маргаан шийдвэрлэх**

- 10.1. Гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг талууд хамтран шийдвэрлэнэ.
- 10.2. Хэрэв маргаантай асуудлаар Талууд хоорондоо тохиролцоонд хүрч чадахгүй бол аливаа маргаантай асуудлыг шүүхээр эцэслэн шийдвэрлүүлнэ.

## **11. Бусад**

- 11.1. Энэхүү гэрээ нь Талуудын баталгаат гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болно.



- 11.2. Энэхүү гэрээнд тусгагдаагүй хөдөлмөрийн харилцаатай холбогдсон бусад асуудлыг Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон Ажил олгогчийн Хөдөлмөрийн дотоод журмын дагуу зохицуулна.
- 11.3. Энэхүү гэрээг Монгол хэл дээр 2 хувь үйлдэж талууд тус бүрд нэг хувь хадгалагдах бөгөөд эхүүд нэгэн адил хүчинтэй байна.

## 12. Талуудын хууль ёсны хаягийн мэдээлэл

### Ажил олгогч:

Хаяг: \_\_\_\_\_

Утас: \_\_\_\_\_

Факс: \_\_\_\_\_

### Ажилтан:

Хаяг: \_\_\_\_\_

Утас: \_\_\_\_\_

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

АЖИЛ ОЛГОГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

\_\_\_\_\_

(гарын үсэг, тамга, тэмдэг)

Нэр

Албан тушаал

АЖИЛТАН:

\_\_\_\_\_

(гарын үсэг)

Нэр

Албан тушаал

## ЭД ХӨРӨНГИЙН БҮРЭН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

№

20..оны...сарын...өдөр

..... аймаг/ сум

Энэхүү Эд хөрөнгийн хариуцлагын гэрээ /цаашид гэрээ гэх/ -г Хөдөлмөрийн тухай 129-134 дүгээр зүйлүүдийг үндэслэн,

Нэг талаас \_\_\_\_\_/цаашид ажил олгогч гэх/ ,

Нөгөө талаас \_\_\_\_\_ тоот хаягт оршин суугч \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_/цаашид ажилтан гэх, хамтад нь талууд гэх/ нар дор дурдсан нөхцлүүдийг харилцан тохиролцож, энэхүү гэрээг байгуулав.

### НЭГ.НИЙТЛЭГ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү гэрээ нь .....ажилтай .....-д эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх нэмэлт гэрээ бөгөөд 20 оны..сарын...-нд хэлэлцэн тохиролцсон \_\_\_\_\_ тоот хөдөлмөрийн гэрээний салшгүй хэсэг мөн.
- 1.2. Эд хөрөнгийн хариуцлагын энэхүү гэрээ нь ажилтан ажил олгогч нарын хооронд үүсэх эд хөрөнгийн харилцаатай холбоо бүхий л харилцааг зохицуулах үндэслэл болно.
- 1.3. Гэрээний хугацаа 20..оны...сарын...-нд хэлэлцэн тохирсон \_\_\_\_\_ тоот хөдөлмөрийн гэрээний холбогдох зүйлд зааснаар зохицуулагдана.
- 1.4. Байгалийн давагдашгүй хүчин зүйл болон гэнэтийн аюулын улмаас гарсан хохирлыг ажилтнаар төлүүлэхгүй.

### ХОЁР.АЖИЛ ОЛГОГЧИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 2.1. Байгууллага нь дараах үүргийг хүлээнэ.Үүнд:
  - 2.1.1. Ажилтан албан ажлаа бүрэн гүйцэтгэх бололцоогоор бүрэн хангасан зориулалтын ажлын байр, тоног төхөөрөмж, машин техник хэрэгсэл, мөнгө, үнэ бүхий зүйл, данс, бүртгэлийг хадгалах үл шатах шүүгээ, бичгийн сейф зэрэг картанд бичигдсэн эд хөрөнгөөр бүрэн хангаж, ашиглалтын шаардлага хангасан, эвдрэл гэмтэлгүй, ажилтны эрхэлсэн ажлын хүрээнд шаардагдах лиценз зөвшөөрөл бүхий программ хангамжаар хангах,
  - 2.1.2. Үндсэн хөрөнгө, эд материал хариуцсан нягтлан бодогч, нярав нь ажилтанд албаны зориулалтаар хүлээлгэн өгсөн эд зүйлийг эд хариуцагчийн картанд тусгаж өгөх,
  - 2.1.3. Байгууллагын дүрэм, журам, гарын авлага, аргачлалтай танилцах боломжоор бүрэн хангах,

### ГУРАВ.АЖИЛТНЫ ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 3.1. Ажилтан нь дараах үүрэг хүлээнэ.Үүнд:
  - 3.1.1. Байгууллагын өмч хөрөнгө, эд хогшилд ариг гамтай, аль болох зардал хэмнэх сэтгэлгээгээр хандаж, бүртгэлээр эзэмшүүлсэн хөрөнгийн ашиглалтыг бүрэн хаиуцна.
  - 3.1.2. Бүртгэлээр хариуцуулж олгосон эд хогшил, тээврийн хэрэгсэл, техник тоног төхөөрөмж болон бусад зүйлсийг албан бус зориулалтаар ашиглах, зөвшөөрөлгүйгээр бусдад хэрэглүүлэх, шилжүүлэх, ажлын байрнаас гадагш авч явахгүй байх, сүлжээний программ хангамжийг дур мэдэн өөрчилж засварлахгүй байх үүрэгтэй.
  - 3.1.3. Өөрийн буруугаас энэ гэрээний 3.1.1.-д заасны дагуу хүлээн авч ашиглаж эзэмшиж байгаа хөрөнгө, эд зүйлсээ дутаах, гээгдүүлэх, сольсон байх, эвдэж гэмтээсэн тохиолдолд өөрийн зардлаар 100% төлж байгууллагыг хохиролгүй болгоно.
  - 3.1.4. Ажилтны бусад үүрэг

---

---

## **ДӨРӨВ.БАЙГУУЛЛАГАД УЧИРСАН ХОХИРЛЫН ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙЛОХ**

- 4.1. Байгууллагад учирсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн үнийн ханшаар эд хөрөнгө, үнэ бүхий зүйлийн нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцлийн элэгдэл хассан өртгөөр тооцно.
- 4.2. Эд хөрөнгө, үнэ бүхий зүйлийг ашиглан шамшигдуулсан, санаатайгаар устгасан, гэмтээсэн, үрэгдүүлсэн үед хохирлын хэмжээг тухайн үеийн зах зээлийн үнийн ханшаар тодорхойлно.

### **ТАВ.БУСАД**

- 5.1. Эд хөрөнгийн хариуцлагын гэрээг зөрчсөн ажилтанд байгууллагын техникийн комиссын дүгнэлтийг үндэслэн хууль тогтоомж, дүрэм, журам, зааварт заасны дагуу эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэнэ.
- 5.2. Энэхүү гэрээ нь ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээний хүчинтэй байх хугацаанд үйлчилнэ.
- 5.3. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд хоёр тал харилцан тохирч шийдвэрлэнэ.
- 5.4. Гэрээтэй холбогдсон маргаантай асуудлыг хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэх ба эс тохиролцвол хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.
- 5.5. Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж нэг хувийг захиргаанд, нөгөө хувийг ажилтанд хадгалуулна.

### **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

Ажил олгогчийг төлөөлж:

.....  
.....

/Албан тушаал/

Ажилтан:

.....  
.....

/Албан тушаал/  
Регистрийн дугаар:

## АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

Дугаар\_\_\_\_\_

.... оны .... дугаар сарын ... өдөр

..... аймаг/сум

Нэг талаас .....(захиалагч байгууллага, иргэний нэр, хаяг)  
.....(цаашид “Захиалагч” гэх) түүнийг төлөөлж) .....(төлөөлсөн  
хүний нэр, албан тушаал)..... Нөгөө талаас ..... (ажил гүйцэтгэгч  
байгууллага, иргэний нэр, хаяг) (цаашид “Гүйцэтгэгч” гэх) түүнийг төлөөлөн .....  
(төлөөлсөн хүний нэр, албан тушаал) .....нар Монгол Улсын Иргэний хуулийн 343-358  
дугаар зүйлийг удирдлага болгон дараах гэрээг харилцан тохиролцож байгуулав.

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч нь Захиалагчийн ажлын даалгаврын дагуу түүний материалаар барилгын дээвэр засах ажлыг гүйцэтгэх, Захиалагч нь уг ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан ажлын хөлсийг төлөхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

### ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1. Гэрээний хугацаа: Гэрээ нь Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж ажлыг эцсийн байдлаар хүлээн авсан актад Захиалагч гарын үсэг зурж, Гүйцэтгэгчийн ажлын үлдэгдэл хөлсийг төлснөөр дуусгавар болно.
- 2.2. Ажил гүйцэтгэх хугацаа: Ажил гүйцэтгэх хугацааг хоёр тал харилцан тохиролцож тогтоох бөгөөд календарын тооллыг удирдлага болгоно.
  - 2.2.1 Ажил гүйцэтгэх ерөнхий хугацаа: .....
  - 2.2.2 Ажил эхлэх хугацаа .....
  - 2.2.3 Ажил дуусах хугацаа .....

### ГУРАВ.ТӨЛБӨР, ТООЦОО ХИЙХ ЖУРАМ

- 3.1. Гэрээгээр гүйцэтгэх ажлын нийт хөлс.....төгрөг байна. Үнийн дүнд НӨАТ болон бусад холбогдох хураамж, зардлууд орсон болно.
- 3.2. Ажлын үр дүнг бүрэн гүйцэтгэж, түүнийг хүлээлгэн өгөх үед хөлсийг төлнө. (Хэрэв ажлыг тодорхой хэсгээр, үе шаттай гүйцэтгэхээр тохиролцсон бол тухайн хэсгийн ажлын үр дүнгээр хөлсийг хэсэгчлэн төлөхөөр тохиролцож болно.)

### ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

Захиалагч дор дурдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

- 4.1. Захиалагч нь Гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх ажлыг эхлэхэд шаардлагатай заавар, зааварчилгаа, батлагдсан техникийн даалгаврыг ажил эхлэхээс хуанлийн 14 хоногийн өмнө бэлэн болгон Гүйцэтгэгчид хүлээлгэн өгнө. Шаардлагатай гэж үзвэл нэмэлт нарийвчилсан тайлбарыг Гүйцэтгэгчид өгч болно.
- 4.2. Захиалагч тал нь ажлын даалгавраас өөр нэмэлтээр ажил гүйцэтгүүлсэн тохиолдолд холбогдох хөлсийг төлөх үүрэгтэй.
- 4.3. Гүйцэтгэсэн ажлыг хүлээн авч хөлсийг саадгүй төлөх үүрэгтэй.
- 4.4. Ажлын гүйцэтгэлийг тухай бүрт хянах, ажлын явцтай танилцах, ажлын явцын талаар мэдээлэл авах, өөрийн саналаа оруулах, ажил дууссаны дараа ажлын акт, гүйцэтгэлээр хүлээн авах бөгөөд захиалгыг зөрчиж буруу, дутуу, чанар, стандарт, техникийн шаардлага хангаагүй ажлыг тогтоосон хугацаанд засах, гүйцээн хийхийг шаардах, уг шаардлагыг биелүүлэх хүртэл санхүүжилтийг зогсоох эрх эдэлнэ.

- 4.5. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй дараах тохиолдолд ажлын гүйцэтгэлийг хүлээн авахаас болон ажлын хөлс төлөхөөс татгалзан, гэрээг нэг талын санаачилгаар цуцлах эрхтэй.
  - 4.5.1. Гүйцэтгэгч удаа дараа буюу хоёроос дээш удаа ажлыг чанарын шаардлага хангахгүйгээр гүйцэтгэсэн;
  - 4.5.2. Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажил нь доголдолтой, захиалагчийн шаардлагад нийцээгүй.
- 4.6. Гүйцэтгэсэн ажилд ямар нэгэн доголдол байвал ажил хүлээн авснаас хойш 6 сарын дотор гомдлын шаардлага гаргах эрхтэй.
- 4.7. Хууль, тогтоомжид заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

#### ТАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

Гүйцэтгэгч дор дурдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

- 5.1. Гүйцэтгэгч нь ажлыг Захиалагчийн өгсөн батлагдсан зааварчилгаа, техникийн шаардлага, нөхцөлийн дагуу мэргэжлийн өндөр түвшинд тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэнэ.
- 5.2. Ажлын гүйцэтгэлийн явцад Захиалагчийн өгсөн төлөвлөгөө, зааварчилгаа, хяналт зэрэг нь хангалтгүй байна гэж үзвэл энэ талаар яаралтай арга хэмжээ авахыг Захиалагчаас шаардах эрхтэй.
- 5.3. Ажил гүйцэтгэх явцад байгаль, орчин, экологийг хамгаалах, эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, галын болон бусад аюулгүйн ажиллагааны талаарх холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг чанд сахих үүрэг хүлээх ба ажил гүйцэтгэх бүрд өөрийн ажилчдад холбогдох зааварчилгааг өгч, хөдөлмөр хамгааллын хувцас, тоноглол, багаж хэрэгслийг шалган галын бусад аюулгүйн ажиллагааг хангасны үндсэн дээр ажлыг гүйцэтгэнэ.
- 5.4. Гэрээгээр хүлээсэн үүргээ бусдад шилжүүлэх, туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхийг хориглох бөгөөд ажлыг туршлагатай, чадварлаг инженер, мэргэжлийн ажилчдаас бүрдсэн багаар гүйцэтгүүлнэ.
- 5.5. Ажил гүйцэтгэхээр захиалагчаас авсан материалын зарцуулалтын талаар захиалагчид тайлагнаж, үлдэгдэл материалыг ажил дууссаны дараа захиалагчид буцаан өгнө. (Гүйцэтгэгч нь ажлыг чанарын шаардлага хангасан өөрийн материал, техник хэрэгсэл, програм хангамжийг ашиглан хийж гүйцэтгэнэ.
- 5.6. Захиалагчийн өгсөн материал чанар, стандартын хувьд ажлын шаардлага хангахгүй бол түүнийг сольж өгөхийг шаардах эрхтэй.
- 5.7. Захиалагч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй дараах тохиолдолд ажлыг хүлээлгэн өгөхөөс татгалзан, гэрээг нэг талын санаачилгаар цуцлах эрхтэй.
  - 5.7.1. Захиалагч энэхүү гэрээний 4.2 болон 4.4-т заасан үүргээ ноцтой зөрчсөн, уг зөрчлөөс шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжгүй болсон.
  - 5.7.2. Захиалагч нь гүйцэтгэгчийн энэ гэрээний 5.2-т заасны дагуу гаргасан шаардлагыг удаа дараа биелүүлээгүй.
- 5.8. Захиалагч ажлын үр дүнг хугацаанд нь авах үүргээ биелүүлээгүй бол ажлын үр дүнг хүлээн авсанд тооцож хөлс төлөхийг захиалагчаас шаардах эрхтэй.
- 5.9. Хууль, тогтоомжид заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

#### ЗУРГАА. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 6.1. Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ аль нэг талынхаа албан ёсны зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд хэсэгчилсэн буюу бүрэн хэмжээгээр шилжүүлэх эрхгүй.
- 6.2. Ажлын гүйцэтгэлийн болон гэрээ дүгнэх үед Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажилд ямар нэг доголдол илэрвэл Гүйцэтгэгч доголдлыг өөрийн зардлаар арилгах үүрэгтэй.
- 6.3. Доголдол гэдэгт Гүйцэтгэгч нь ажлын батлагдсан заавар, техникийн даалгаврын дагуу гүйцэтгээгүйг ойлгоно.

- 6.4. Захиалагчийн буруутай үйл ажиллагаа шууд нөлөөгүй нь батлагдсан тохиолдолд, Захиалагчийн тогтоосон хугацаанаас хоцорсон, ажил дутуу, чанаргүй хийгдсэнээс учирсан хохирлыг Гүйцэтгэгч тал бүрэн хариуцаж, барагдуулах үүрэгтэй.
- 6.5. Гүйцэтгэгч ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй, Захиалагч нь төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд буруутай тал нь хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0.3 хувийн алданги нөгөө талдаа төлнө.
- 6.6. Алданги торгууль төлсөн нь Талуудыг үндсэн үүрэг болон учирсан хохирлыг нөхөн төлөхөөс чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 6.7. Учирсан хохирол гэдэгт үүрэг гүйцэтгүүлэгчээс гарсан зардал, эд хөрөнгийн алдагдал буюу гэмтэл, үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэсэн бол үүрэг гүйцэтгүүлэгчид гарахгүй байх байсан зарлагыг ойлгоно.
- 6.8. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.
- 6.9. Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ ямар ч тохиолдолд хүндэтгэлтэй хандах бөгөөд үндсэн болон дэд үүргээс үл хамааран аль нэг тал нь үүргээ биелүүлээгүйн улмаас нөгөө талд учирсан илүү зардал, нэмэлт төлбөрийг гэм буруутай тал хариуцна.

#### ДОЛОО. АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ

- 7.1. Гүйцэтгэгч нь Захиалагчийн төлөөлөгчид ажлын үр дүнг шалгуулан хүлээлгэн өгсөн тухай акт үйлдэнэ.
- 7.2. Ажил хүлээлгэн өгсөн актад гүйцэтгэсэн ажлын жагсаалт, холбогдох хөлсний дэлгэрэнгүй, ажлын шалгасан үр дүнг тусгана.

#### НАЙМ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 8.1. Гэрээний аль нэг тал гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт, цар тахал болон байгалийн бусад аюулт үзэгдэл, бослого, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт /-ийн зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлыг ойлгоно.

#### ЕС. НУУЦ ХАДГАЛАХ

- 9.1. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж мэдсэн байгууллага, хувь хүний нууцад хамаарах аливаа мэдээ, мэдээллийг бусдад задруулахгүй байх, өөрийн болон бусад этгээдийн эрх ашгийн төлөө ашиглахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.
- 9.2. Энэхүү гэрээний 9.1-т заасан нөхцөлийг аль нэг тал зөрчсөн тохиолдолд үүнтэй холбоотойгоор үүсэх аливаа хохирлыг бүрэн төлнө.

#### АРАВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ<sup>13</sup>

- 10.1. Талуудын хооронд маргаан гарвал талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл аливаа маргаантай асуудлыг шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### АРВАН НЭГ. БУСАД ЗҮЙЛ

- 11.1. Гэрээний гүйцэтгэлийн явцад аль ч тал гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргаж болох ба нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.

---

<sup>13</sup> Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 3.5.6-д “Гэрээнд “Маргаан шийдвэрлэх журам”, “Бусад нөхцөлүүд”, “Нэмэлт нөхцөлүүд” гэсэн заалтууд байж болох бөгөөд хуулийн этгээдийн хаяг, банк санхүүгийн байгууллагууд дахь харилцах дансны дугаарыг бичнэ гэж заасан.

- 11.2. Санал хүлээн авсан тал хариугаа ажлын 7 хоногийн дотор мэдэгдэх бөгөөд гэрээнд өөрчлөлт оруулах бол талууд хамтран бигээр үйлдэж гарын үсэг зурж баталгаажуулан гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна. Энэхүү нэмэлт гэрээ нь гэрээний нэгэн адил хүчинтэй байна.
- 11.3. Гэрээний хавсралт, техникийн даалгавар, ажлын зааварчилгаа зэрэг нь гэрээний салшгүй хэсэг болно.
- 11.4. Талуудын төлөөлөл өөрчлөгдсөнөөс үл хамааран энэхүү гэрээ нь үйлчлэх хугацааны туршдаа хүчин төгөлдөр байна.
- 11.5. Энэхүү гэрээг монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.

**АРВАН ХОЁР. ТАЛУУДЫН ГЭРЭЭ БАЙГУУЛЖ БАЙХ  
ҮЕИЙН ХУУЛЬ ЁСНЫ ХАЯГ, МЭДЭЭЛЭЛ**

12.1. Захиалагч тал:

Оршин байгаа газар: \_\_\_\_\_

Хаяг, индекс: \_\_\_\_\_

Утас: \_\_\_\_\_ телетайп: \_\_\_\_\_

Факс: \_\_\_\_\_

Банк дахь тооцооны дансны дугаар<sup>14</sup>: \_\_\_\_\_

12.2. Гүйцэтгэгч талын:

Оршин байгаа газар: \_\_\_\_\_

Хаяг, индекс: \_\_\_\_\_

Утас: \_\_\_\_\_ телетайп: \_\_\_\_\_

Факс: \_\_\_\_\_

Банк дахь тооцооны дансны дугаар: \_\_\_\_\_

- 12.3 Энэ зүйлд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухайд Талууд энэ тухай нөгөө талдаа бичгээр нэн даруй мэдэгдэнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

\_\_\_\_\_  
(гарын үсэг, тамга, тэмдэг)

Нэр

Албан тушаал

\_\_\_\_\_  
(гарын үсэг, тамга, тэмдэг)

Нэр

Албан тушаал

<sup>14</sup> Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 3.5.6-д “Гэрээнд “Маргаан шийдвэрлэх журам”, “Бусад нөхцөлүүд”, “Нэмэлт нөхцөлүүд” гэсэн заалтууд байж болох бөгөөд хуулийн этгээдийн хаяг, банк санхүүгийн байгууллагууд дахь харилцах дансны дугаарыг бичнэ гэж заасан.

## ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ

Дугаар\_\_\_\_\_

.... оны .... дугаар сарын ... өдөр

..... аймаг/сум

Нэг талаас..... (цаашид “Түрээслүүлэгч гэх”).....иргэн, хуулийн этгээдийн нэр)..... түүнийг.....(төлөөлсөн хүний нэр, албан тушаал)..... нөгөө талаас.....(цаашид “Түрээслэгч гэх “) ..... (иргэн, хуулийн этгээдийн нэр).....(төлөөлсөн хүний нэр, албан тушаал)..... бид дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгууллаа.

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Түрээслүүлэгч энэхүү гэрээний хавсралт болон тодорхойлолт-жагсаалтад заагдсан эд зүйлийг түр хугацаагаар эзэмшүүлэх, ашиглуулахаар, эсвэл түр хугацаагаар ашиглуулахаар Түрээслэгчид шилжүүлэх үүрэг хүлээнэ.

### ХОЁР ГЭРЭЭНИЙ ҮНЭ

- 2.1. Түрээслэгч эд хөрөнгийг хүлээн авч түрээсийн төлбөрийг.....хугацаанд нь төлөх үүрэгтэй.

### ГУРАВ. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- 3.1. Төлбөрийг \_\_\_\_\_ хийнэ.  
( Нэгэн зэрэг, үе шаттайгаар)
- 3.2. Төлбөрийг \_\_\_\_\_ хэлбэрээр хийнэ.  
(Төлбөрийн шаардлага, төлбөрийн даалгавар)

### ДӨРӨВ. ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА

- 4.1. Энэхүү гэрээний 1-д заасан эд хөрөнгийг гэрээнд гарын үсэг зурснаас хойш \_\_\_\_\_хоногийн дотор эд хөрөнгө хүлээн авсан, хүлээлгэн өгсөн актын дагуу Түрээслэгчид шилжүүлнэ.
- 4.2 Түрээслэгч төлбөрийг \_\_\_\_\_ төлнө.  
(Төлбөрийн хугацаа, нөхцөлийн дагуу)
- 4.3. Гэрээний үйлчлэх хугацаа:  
4.3.1. Эхлэх: \_\_\_\_\_  
4.3.2. Дуусах: \_\_\_\_\_

### ТАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 5.1. Түрээслүүлэгчийн хүлээх үүрэг:  
5.1.1. Гэрээний нөхцөлийг бүрэн хангасан эд хөрөнгийг Түрээслэгчид цаг тухайд нь шилжүүлэн өгнө.  
5.1.2. Эд хөрөнгөд \_\_\_\_\_ хугацааны дотор их засвар хийнэ.  
5.1.3. Түрээслүүлсэн эд хөрөнгийг аль болох ашигтай ашиглуулахаар зөвлөгөө өгөх буюу бусад туслалцаа үзүүлнэ.
- 5.2. Түрээслэгчийн хүлээх үүрэг:  
5.2.1. Эд хөрөнгийг гэрээнд заасан нөхцөл болон зориулалтын дагуу ашиглана.  
5.2.2. Эд хөрөнгийг эвдэж, гэмтээхгүй ашиглах, өөрийн зардлаар урсгал засвар хийнэ.  
5.2.3. Гэрээнд заасан хугацаанд түрээсийн төлбөрийг төлнө.



5.2.4. Гэрээ дуусгавар болмогц хэвийн элэгдэл хорогдлыг тооцон бүрэн бүтэн байдлаар эд хөрөнгийг буцаан өгнө.

#### ЗУРГАА. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 6.1. Талууд нь энэхүү гэрээний нөхцөлүүдийг биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүйн төлөө эд хөрөнгийн хариуцлага хүлээнэ.
- 6.2. Түрээслэгч гэрээнд заасан хугацаанд түрээсийн төлбөрөө төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд үнийн дүнгийн \_\_\_\_\_ хувийн торгууль хүлээнэ.
- 6.3. Хугацааг \_\_\_\_\_хоногоос дээш хоногоор хожимдуулсан бол Түрээслүүлэгч гэрээг цуцалж өөрт учирсан хохирлыг арилгахыг шаардана.
- 6.4. Тухайн гэрээнд заагдсан бусад үүргийг гэм буруугийн улмаас биелүүлээгүй тохиолдолд жилийн түрээсийн төлбөрийн \_\_\_\_\_хувиар торгууль төлнө.
- 6.5. Торгууль төлөх нь талуудын гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх болон зөрчлийг арилгахаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

#### ДОЛОО. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 7.1. Гэрээний аль нэг тал гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт, цар тахал болон байгалийн бусад аюулт үзэгдэл, бослого, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт/-ийн зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлыг ойлгоно.

#### НАЙМ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

- 8.1. Гэрээний явцад талуудын хооронд үүссэн бүх маргаан, зөрөлдөөнийг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэнэ.
- 8.2. Талууд тохиролцоонд хүрч чадахгүй бол энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан, түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой бүх маргааныг шүүхээр эцэслэн шийдвэрлүүлнэ.

#### ЕС. ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЖУРАМ

- 9.1. Гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 9.2. Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон хууль тогтоомжид заасан үндэслэлээр 2 тал харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

#### АРАВ. НЭМЭЛТ НӨХЦӨЛ

---

---

#### АРВАН НЭГ. БУСАД ЗААЛТ

- 11.1. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэнэ.Хууль зүйн хувьд тус бүр адил хүчинтэй байна.
- 11.2. Гэрээний хавсралт:

#### АРВАН ХОЁР. ТАЛУУДЫН ГЭРЭЭ БАЙГУУЛЖ БАЙХ ҮЕИЙН ХУУЛЬ ЁСНЫ ХАЯГ, МЭДЭЭЛЭЛ

- 12.1. Түрээслүүлэгч талын:  
Оршин байгаа газар: \_\_\_\_\_  
Хаяг, индекс: \_\_\_\_\_  
Утас: \_\_\_\_\_ телетайп: \_\_\_\_\_  
Факс: \_\_\_\_\_

Банк дахь тооцооны дансны дугаар: \_\_\_\_\_

12.2. Түрээслэгч талын:

Оршин байгаа газар: \_\_\_\_\_

Хаяг, индекс: \_\_\_\_\_

Утас: \_\_\_\_\_ телетайп: \_\_\_\_\_

Факс: \_\_\_\_\_

Банк дахь тооцооны дансны дугаар: \_\_\_\_\_

12.3. Энэ зүйлд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухайд Талууд энэ тухай нөгөө талдаа бичгээр нэн даруй мэдэгдэнэ.

### Гэрээ байгуулсан:

ТҮРЭЭСЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ТҮРЭЭСЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

(гарын үсэг, тамга, тэмдэг)

(гарын үсэг, тамга, тэмдэг)

Нэр  
Албан тушаал

Нэр  
Албан тушаал